Монголын улсын археологийн шинжлэх ухааны судалгааны бүтээлийн багагүй хувийг буган чулуун хөшөө, хөшөө чулуу, хүн чулуун хөшөөний судалгаа эзэлдэг билээ. Тухайлбал энэхүү сэдвээр 1950-иад оноос Н.Сэр-Оджаваар хүн чулуун судалгаа эхэлсэн бол В.В. Волков “Оленные камни Монголии. УБ., 1981. Москва, 2002, Д.Баяр. Монголын төв нутаг дахь Түрэгийн хүн чулуу. УБ., 1997. Д.Баяр Монголчуудын чулуун хөрөг УБ., 2002, Д.Баяр, Д.Эрдэнэбаатар нарын Монгол Алтайн хүн чулуу [2], Д.Цэвээндорж нарын Монголын археологи [5] зэрэг монголын болон оросын археологчдын томоохон нэгэн сэдэвт бүтээл эмхэтгэлийг нэрлэж болно. ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн Археологийн судлал, Үндэсний музейн Нүүдэлчдийн өв судлал, ХИС-ийн Түүхийн тэнхимийн тэнхмээс тус бүр эрхлэн гаргадаг Түүхийн товчоон зэрэг тогтмол цувралыг нэрлэж болохоор байна. Мөн тухайн дурсгалыг тусгайлан Увс аймгийн музейн эрхлэгч Т. Бямбадорж судласан байна. Гэсэн хэдий ч уг дурсгалын газар зүйн байршилыг GPS багажаар тогтоон, харьцуулан үзэх судалгаа Т.Бямбадорж асаны үед хараахан байгаагүй нь биднийг уг илтгэлийг хэлэлцүүлэхэд хүргэсэн билээ.

Увс аймгийн нутаг дахь буган чулуу хөшөө болон түрэгийн тахилгын байгууламж бүрэн судлагдаагүй, тэр дундаа өгүүлэн буй дурсгал ч нэгэн адил орчин цагийн арга зүйгээр тусгайлан нийтлэгдээгүй байна. Энэхүү илтгэлээр уг дурсгалд дэлгэрэнгүй эрдэм шинжилгээний тодорхойлолт үйлдэж, бусад судалгааны эх хэрэглэгдхүүнтэй харьцуулан үзхийг зорьлоо.

Тахилгын байгууламжийг баруун гар талаас нь эхлэн тодорхойлолт үйлдвэл:

1-р хөшөө чулуу: Хүрэн өнгийн боржин чулууг хавтгай хэлбэртэй болгож зассан ямар ч тэмдэглэгээгүй. Урт 90 см, өргөн 50 см тахилгын байгууламж нь 2.5х2.5м-ийн хэмжээтэй юм. Хөшөө чулуу нь тахилгын байгууламжийн урд хэсэгт байрладаг /2001 онд Увс аймгийн музейн эрхлэгч байсан Т.Бямбадорж үзэхэд босоо хөшөө чулуу байсан (зур. 5) хэдий ч, 2013 оны 6 дугаар сард унасан байдалтай байна/. Газарзүйн байршил нь хойд өргөрөгийн $49^{\circ}57'43.6''$, зүүн уртрагийн $91^{\circ}58'41.4''$ солбилцолд ДТД 986 м-т оршино (зур.1).

2-р хөшөө чулуу буюу буган чулуун хөшөө: Өндөр 160 см, өргөн 70 см, цайвар боржин чулуу байна. Толгойны боолтыг тодорхой дүрсэлж гаргажээ. Буган чулуун хөшөөний хүзүүний зүүлтийг урд талд 3, хойт талд 7 ширхэг нүх гарган хонхойлгон сийлбэрлэсэн байна. Нүүрэн хэсгийг илэрхийлэх 3 ташуу зураас нь хөшөөний зүүн талд дүрслэгдсэн байна. Түүний доод талд нэгэн урт зураас үзэгдэнэ. Энэ нь бүсийг илэрхийлэх гэсэн мэт. Түүнээс 20 см хирээний зайд хөндлөн, дүрслэл нь үл мэдэгдэх 2 урт зураас байна. Энэ нь магад хутга байж болох юм. Тахилгын байгууламж нь хүрэн чулуун дараастай дөрвөлжин 2х2 м-ийн хэмжээтэй юм. Буган чулуун хөшөө нь тахилгын байгууламжийн урд хэсэгт хүн чулуу эсвэл балбалын үүрэг гүйцэтгэж байгаагаар дахин ашиглагдсан бололтой. Сайхь буган чулуун хөшөө нь хэв шинжийн хувьд ЕвроАзийн буюу III дахь хэв шинжийн буган чулуун хөшөө байна. Газарзүйн байршил нь хойд өргөрөгийн $49^{\circ}57'43.6''$, зүүн уртрагийн $91^{\circ}58'41.4''$ солбилцолд ДТД 986 оршино (зур.2). Тахилгын байгууламжид буган чулуун хөшөөг анхны байрлалаас хөдөлгөж түүхий эд болгон ашигласан 149 тохиолдол байна [4. 115-116]. Түүнчлэн дөрвөлжин булшны өнцгүүдэд босгосон, хана болгон ашигласан хананд чигжээс дараас хашлаганд, болон дөрвөлжин тахилгын байгууламжийн өнцөг, хананд, дараас болгосон, өнцөгт ашигласан, Түрэгийн дурсгалд хүн чулуу болгон зассан, хүн чулуу болгон ашигласан, түрэгийн тахилгын хажууд буган чулуун хөшөөг ашигласан зэрэг олон зориулалтаар дахин хожуу үед хэрэглэсэн байна. Түрэгийн тахилгын байгууламжид буган чулуун хөшөөг ашигласан тохиолдол Монгол нутагт 14 байна [4. 117]. Өгүүлэн буй буган чулуун хөшөөтэй адил ашигласан дурсгалд Архангай аймгийн Батцэнгэл сум Шивэртийн ам, Архангай аймгийн Өндөр улаан сумын Шандын энгэрийн тал, Архангай аймгийн Өндөр улаан сум Урт булаг зэрэг [4.114] түрэгийн тахилгын байгууламжийг нэрлэж болохоор байна. Түүнчлэн Уулын Алтай болон Тувад буган чулуун хөшөөг дахин ашигласан тохиолдол 25 байна [6.114]. Судлаачид буган чулуун хөшөөг дараагийн дурсгалд дахин ашигласан байдлаар 6 төрөл болгож ангилсан байна [6.114]. Уг зургаан ангилалын тахилгын чулуун хашлаганы зүүн талд ашигласан хэмээх төрөлд бидний өгүүлэн буй дурсгал хамрагдана. Харин Баян-Өлгий аймгийн нутгаас 6 дахь буюу буган чулуун хөшөөг дахин хүн чулуун хөшөө болгон цоолборлон ашигласан шинэ тохиолдол [7.232] илэрсэн байна. Түүнчлэн Монголын баруун бүс нутгийн босоо замын тэнхлэгийн дагуу дээрх судлаачийн 5 дахь төрөл буюу балбал чулууны зориулалтаар түрэгийн тахилгын байгууламжид дахин ашигласан дурсгал Ховд аймгийн Мөст сумын Их хужиртын түрэгийн тахилгын байгууламжид 4 тэмдэглэгдсэн [8; 9] байна. Монгол Алтайд эрт үеийн дурсгалыг дараагийн түүхийн дурсгалд ашиглах нь хүний дүрслэлт хөшөө чулууны зэрэгцээ булш, хиргисүүрт тохиолддог. Энэ нь Алтайн бүс нутаг хүн төрөлхтний соёл иргэншил үүсэн хөгжиж асан онцлог бүс нутаг болхыг гэрчилнэ.

3-р хөшөө чулуу: Хамгийн жижиг нь бөгөөд хүрэн улаан өнгийн чулуу бөгөөд өндөр нь 70 см, өргөн нь 50см ямар нэгэн дүрслэлгүй. Хөшөө чулуу нь тахилгын байгууламжийн урд хэсэгт байрлаж байна. Тахилгын байгууламж нь чулуун дараастай дөрвөлжин 1,7х1,7 м-ийн хэмжээтэй юм. Тахилгын байгууламжууд

хоорондоо 50 см зайтай. Газарзүйн байршил нь хойд өргөрөгийн 49°57'43.1⁰ зүүн уртрагийн 91°58'41.4⁰ солбилцолд ДТД 985 оршино (зур.3).

4-р хөшөө чулуу буюу хүн чулуу: Баруун талаасаа 4 дэх нь бөгөөд өргөн 50 см, өндөр 70 см юм. Цайвар боржин чулуун дээр баатар эрийн нүүрэн хэсгийн дүрслэлийг маш тодорхой гаргажээ. Үсээ задгай тавьсан байдлаар нүд, ам, хамар, хацар, сахал эрүүний хэсгийг тодорхой дүрсэлжээ. Тахилгын байгууламж нь чулуун дараастай дөрвөлжин 1,5x1,5 м-ийн хэмжээтэй юм. Хойд өргөрөгийн 49°57'43.2⁰, зүүн уртрагийн 91°58'41.5⁰ солбилцолд ДТД 985 м-т оршино /зураг 4/. Хүний толгой нүүрийг цоолборлон урлаж ... хүнийг дүрслэхдээ гурван хэмжээт товгор барималын байдлаар нүүр царай, эрхтэнүүдийг товгойлгон цохиж гаргах [2.26] аргаар урлагдсан байна.

Дүгнэлт

ЕвроАзийн буган чулуун хөшөө нь он цагийн хувьд VII-III зуунд хамаарах ба дээр өгүүлэн буй хүн чулуун хөшөө нь 552-745 онд Түрэг улсын үед хамаарах заримдаг дүрслэлтэй хүн чулуун хөшөө юм. Энэ хоёр дурсгал өөр өөр он цагт хамаарагдах хэдий ч буган чулуун хөшөөг хожим уг тахилгын байгууламжид ашигласан байна. Энэ удаагийн бидний судалгааны ажил нь уг дурсгалын газар зүйн байршилыг тогтоон бусад ижил төрлийн дурсгалтай харьцуулснаараа онцлог билээ. Монгол нутагт буган чулуун хөшөөг хүн чулуун хөшөө болон балбал чулууны зориулалтаар ашигласан тохиолдолын нэг нь энэ юм. Монгол Алтайд эрт үеийн дурсгалыг дараагийн түүхийн дурсгалд ашиглах нь хүний дүрслэлт хөшөө чулууны зэрэгцээ булш, хиригсүүрт түгээмэл тохиолддог. Энэ нь Их Алтайн бүс нутаг хүн төрөлхтний соёл иргэншил үүсэн хөгжиж асан онцлог бүс нутаг болхыг бэлхнээ харуулна. Цаашид уг дурсгалын үнэмлэхүй он цагийн тогтоохын тулд археологийн өргөн хэмжээний малтлага явуулж, он цагийг байгаль шинжлэлийн аргаар бүрэн тодорхойлох шаардлагтай байна. Ингэж гэмээнэ Монголын эртний түүхийн бүдэг бүрхэг үе, түрэгийн тахилын онгоны учир холбогдол бүрэн тодрох боломжтой юм.

Резюме

Евразия Оленные каменный принадлежит VII-III веках в свое время /железный век/ и это памятник, который является частичным фигурный памятник, принадлежит периоду. Эти памятники относятся к различным периода, но они существуют места для поклонения. Это один момент, когда они использовали Оленные камни вместо изваяния в Монголии. Далее мы должны определить время полностью.

НОМЗҮЙ

1. Баяр Д. Монгол Алтайд шинээр олдсон зарим буган чулуун хөшөөний тухай. SA. Tomus XV, Fasc. 5. УБ.,1995. Т. 53–64.
2. Баяр Б., Эрдэнэбаатар Д. Монгол Алтайн хүн чулуун хөшөө. УБ., 1999
3. Бямбадорж Т., Лхагвадорж Х., Батсүх Н. Монголын Алтай-Соёны байгалийн өв археологийн дурсгалууд. УБ., 2001
4. Баярсайхан Ж., Сод Ц. Монгол нутагт буй хожим өөр дурсгалд ашигласан буган хөшөөдийн тухай. Нүүдэлчдийн өв соёл. Tomus XI, Fasc 9. УБ.,2011. Т. 113–118.
5. Цэвээндоржд., БаярД., ЦэрэндагваЯ., ОчирхуягЦ. Монголын археологи. УБ.,2003
6. Шелепова Е.В. К вопросу о «переиспользовании» «оленных» камней в памятниках тюркской культуры. Каменная скульптура и мелкая пластика древних и средневековых народов Евразии. Барнаул., 2007. С. 113–118.
7. Турбат Ц. Оленные камни Западной части Монгольского Алтая. Культура и народы Северной Азии и сопредельных территорий в контексте междисциплинарного изучения. Вып. 2. Томск., С. 223–233.
8. Ч.Мөнхбаяр. “Тэмээн хүзүү - Ховд” чиглэлийн хатуу хучилттай замын трасс дагуу орших түүх-соёлын дурсгалын хайгуул судалгааны эхний үр дүнгээс. ХИС-ийн НХУС-ийн эрдэм шинжилгээний бичиг. Том. II (14). Fasc 13. УБ., 2009. Т. 70–82.
9. Ч.Мөнхбаяр. Ховд аймгийн нутаг дахь түрэгийн тахилгын байгууламжийн төрөл, ангилал. Нүүдэлчдийн өв соёл. Том. X. F. 8. УБ., 2010. Т. 106 –124.

Хавсралт



Зур. 1. I хөшөө чулуу




Зур. 2. II хөшөө чулуу (хүн чулуун хөшөө?) буюу буган чулуун хөшөө



Зур. 3. III хөшөө чулуу



Зур. 4. Цагаан худгийн IV тахилгын байгууламжийн буюу Огзомын хүн чулуун хөшөө [3.76]



Зур. 5. Цагаан худгийн түргийн тахилгын байгууламж (гар зураг) [3.68]



Зур. 7. Цагаан худгийн түрэгийн тахилгын байгууламж (баруун талаас)

НЭГЭН ХҮРЭЛ ЭЭМЭГНИЙ ТУХАЙ

Ч. Мөнхбаяр

Магистр, ХИС, НХУС-ийн Түүхийн тэнхимийн багш,
99439348, e mail: munkh_boroldoi@yahoo.com

Монголын Баруун бүс нутаг хүрэл зэвсгийн үед холбогдох түүвэр олдвороор арвин баялаг билээ. Сүүлийн үед металл хайгч багажаар үнэт төмөрлөгийг ашиг олох зорилгоор иргэд өргөнөөр олборлон ашиглахын зэрэгцээгээр Алтайн аглагт орших эрт үеийн өнгөт төмөрлөг олдворыг үй олноор нь илрүүлэх болжээ. Түүний илрэл болох цуглавар олдвор үнэт эдлэл худалдаалагчдын гарт орж зарим нь төдийлөн үнэ хүрэхгүй байгаатай холбоотойгоор аажмаар мартагдах дахин хаягдаж гээгдэх болсон байна. Бид Монголын улсын баруун бүс нутагт илрээд буй өнгөт төмөрлөг эдлэлийг эрт үеийн түүхийн нөхвөрлөх ач холбогдолтой эх хэрэглэгдхүүн болгон цөөнгүй нийтлэсэн [Тишкин, 2009а, т. 105–111; 2009, с. 85–88; Мөнхбаяр, 2009, т. 70–82; Тишкин, 2009б, с. 336–339; Тишкин, 2010, с. 159–168; Тишкин, 2011а, с. 265–271] билээ. Түүний зэрэгцээ Монголын хүрэл зэвсгийн үеийн археологийн соёлын тархалтын хүрээг тогтоох зарим содон олдворыг өргөн олон уншигчдын анхааралд хүргэхээр хэвлэсэн зүйл ч [Мөнхбаяр, 2011б] бий.

Энэ удаад Увс аймгийн Улаангом сумын нутаг Чандмань уулаас түүвэр байдлаар олдсон нэгэн хүрэл ээмэгний талаар өгүүлхийг зорилоо. Уг ээмэг гадаад хэлбэрийн хувьд Монголын хүрлийн үеийн түүвэр олдворт тэр бүр тохиолдоод байдаггүй Өмнөд Сибирийн бүс нутагт өргөн тархсан Андроновын түүх соёлын нийтлэгт багтах морфологийн онцлогтой учир ихээхэн сонирхолтой юм. Уг ээмэгний талаарх харьцуулсан судалгааг хийх нь Монгол төдийгүй түүний хөрш зэргэлдээ орших хүрлийн үеийн археологийн соёлын тархалт, магадгүй тэдний угсаа соёлын харилцааг тогтоох судалгааны эхлэл болох ач холбогдолтой мэт санагдана.

Чингээд уг ээмэгний талаар тогтон өгүүлье. Мөнхүү хүрэл ээмгийг Ховд их сургуулийн Байгаль шинжлэл, технологийн сургуулийн Химийн нэгдүгээр ангийн оюутан Э. Эрдэнэдондог Увс аймгийн Улаангом сумын нутаг Чандмань уул орчмоос олжээ. Уг ээмэг 3.3 см урт нэг талдаа бүрээний ам мэт хошуутай (зур. 1 а.) нөгөө үзүүр нь угалз буюу цагираг хэлбэртэй бөгөөд тэрхүү бүрээ мэт хошууруу углуурагдан орж буй хэлбэртэй. Гэхдээ нарийн үзүүр нь хугарч унасан гэмээр ул мөртэй (зур. 1 б.). Уг ээмэгний нэг талд газрын хөрсөн дээр он удаан жил хэвтсэн гэмээр зэсний ногоон өнгийн хаг, нөгөө гадна талд газрын хөрсөнд удаан хадгалагдсан гэмээр бараан өнгөр тогтсон. Бүрээний хошуу мэт амсарын дотор талд гурван товоосон өлөг болон тахийсан талын амсрын хэсэгт унжиж тогтсон гэмээр ул мөртэй. Бүрээ хэлбэрийн амсарын гадна тал (амсрын хэсэгт унжиж тогтсон гэмээрхэсэг болон түүний эсрэг тал)–д түүнээс нарийсах нөгөө үзүүр хүртэлх цагираган хэсгийн хоёр талд хэвэнд цутгагдан үйлдэгдсэн гэдгийг батлах товгор нарийн ул мөр хадгалагдан үлджээ. Бүрээ хэлбэртэй амсарын диаметр 1,2 см. Бүрээ хэлбэрийн амсрын хэсэгт унжиж тогтсон гэмээрхэсэг хүрээний 0, 3 см (зур. 1 в.). Бүрээ хэлбэрийн амсарын уг хэсэгт диаметр 0, 3 см түүнээс нарийссан цагирагийн үзүүр хэсэгт 1, 3 мм хэмжээтэй хөндлөн огтлолтой (зур. 1 г.) ажээ.

Ийм цагираган хэлбэртэй нэг талын үзүүр нөгөө талын бүрээний хошуу мэт үзүүрлүү углагдан ордог (тогтоогурт түгжигдэн ордог) ээмэг андроновын соёлын гоёл чимэглэлийн зүйлсэд түгээмэл [Орозбаев, 1958, с. 255] тохиолддог. Оросын археологийн утга зохиолуудад уг ээмгийг нэгэн төрөл болгож амсар, хоолойтой ээмэг буюу «серьги с раструбом» [Уманский, 2007, с. 30; Демин, 2011, с. 48–50.] хэмээн нийтэлжээ. Судлаачид ийм хэлбэрийн ээмгийг дугуй болон зууван цагираг хэлбэртэй, нэгдүгээрх нь хурц амсартай, хоёрдугаарх нь түгжигдхэд зориулагдсан бүтэн амсар хэлбэртэй гэж [Аванесова, 1975, с. 67; Аванесова, 1991, с. 51; Демин, 2011, с. 30] хоёр ангилдаг. Түүнчлэн бидний илрүүлэн өгүүлж буй хоёрдугаар ангилалын хэлбэрт багтах цагираган хэлбэртэй, бүрээний хошуу мэт амсартай ээмгийг түүхий эдээр нь дараах дөрвөн хэв шинжид ангилжээ. Үүнд: хүрэл, холимог төмөрлөг, алт болон цагаан тугалаг [Демин, 2011, с. 32] зэрэг болно.


Цагираган хэлбэртэй, бүрээ хошуутай алтан ээмэг Баруун Өмнөд Сибирийн Кытмановогийн 4-р булшнаас хоёр ширхэг [Уманский, 2007, с. 50, 71. Цветная вклейка II.-12, 13, рис. 15.-2, 3, рис. 64.-18, 19] (зур. 2.-3, 4), Чекановын салаа Х - 4, 24, 113 булшнаас тус бүр нэг нэг [Демин, 2011, с. 4, 103, 105, 114. рис. 8, 12.-2, 14.-2, 25.-2, 3.] (зур. 2.-2, 12, 5, 6) олджээ. Дээрх алтан ээмэгтэй харьцуулах хоёр ээмэг ЦРК сангийн аж ахуй болон Волчиха хэмээх газар орших булшнаас гарчээ [Грязнев, 1956, с. 17.-20. рис. 1.1–1, 2]. Уг оршуулгын газрыг Рублево VIII хэмээн нэрлэсэн байсан [Кирюшин, 2006, рис. 1.-2–4]. Мөн хоёр алтан ээмэг Алтайн хязгаарын Кожзавод суурингийн булшнаас олджээ [Бородаев, 1983, с. 17; Уманский, 2007, с. 30]. Түүнчлэн Дорнод Казахстаны Кызыл тас, Предгорный болон Дундад Азийн Дашты-Козы [Исакова, 1989, с. 153. рис. 5.-6] булшнаас гарчээ.

Баруун Өмнөд Сибирийн Алтайн хязгаарын Депутатын гудамж [Бородаев, 1977, с. 14; Бородаев, 1983, с. 14], Кытмановогийн 23, 24, 26 дугаар булшнаас [Уманский, 2007, с. 94, 100, 119. рис. 38.-3, рис. 44.-

1, 3, рис. 63.-17, 18, 19.] (зур. 2.-7, 8, 9), Гилевын Березовкагийн 1-р булшнаас хүрэл (алгаар шармалдсан) цагираган хэлбэртэй, бүрээ хошуутай ээмэг [Демин, 2007, с. 10. рис. 9.-5; Демин, 2011, с. 94] (зур. 2.-1) олдсон байна.

Эдгээр хүрэл болон холимог цул төмөрлөгөөр үйлдэгдсэн ээмэгтэй харьцуулах хэрэглэгдхүүн Дорнод Казахстаны газар нутаг Березов [Ткачев, 1996, с. 80, рис. 2.-4], Бага Койтас [Грязнов, 1927, с. 14. рис. 25.-7; Черников, 1960, с. 14], Бага Хар ус [Ермолаев, 2001, с. 108] болон Зевакино [Арсланов, 1975, с. 75. рис. 2.-1, 3]; Хойт Казахстаны Боровое [Орозбаев, 1958, с. 287. Табл. V.-14; Маргулан, 1979, с. 320. рис. 231.-43–48]-гийн булшнаас олджээ.


Эдгээр хүрэл болон холимог цул төмөрлөгөөр үйлдэгдсэн ээмэгтэй харьцуулах хэрэглэгдхүүн Дорнод Казахстаны газар нутаг Березов [Ткачев, 1996, с. 80, рис. 2.-4], Бага Койтас [Грязнов, 1927, с. 14. рис. 25.-7; Черников, 1960, с. 14], Бага Хар ус [Ермолаев, 2001, с. 108] болон Зевакино [Арсланов, 1975, с. 75. рис. 2.-1, 3]; Хойт Казахстаны Боровое [Орозбаев, 1958, с. 287. Табл. V.-14; Маргулан, 1979, с. 320. рис. 231.-43–48]-гийн булшнаас олджээ.



Зур. 1. Увс аймгийн Улаангом сумын нутаг Чандмань уул орчмоос олдсон цагираг хэлбэртэй, бүрээ хошуутай хүрэл ээмэг: А, В. Баруун талаас; Б. Зүүн талаас; Г. Доод талаас.

Судлаачид одоогоор 40 орчим олдлоод байгаа уг ээмгийн талаар олон саналтай байдаг бөгөөд Андроновын соёлын Федоровын булшны онцлогийг харуулсан дурсгал гэдэгтэй санал нийлдэг байна [Аванесова, 1991, с. 53; Авдулганеев, 1996, с. 12; Кузьмина, 1966, с. 75 ба бусад]. А.А. Ткачев, Н.А. Ткачева нар он цагийн хувьд МЭӨ II жилийн хоёрдугаар хагасын эхэн үед холбон Проковкийн алт болон хүрэл цугтамал эдлэлээс нилээд эрт үед холбогдоно гэж байснаа сүүлдээ давтаж хийсэн эдлэл хэмээн [Ткачев, 1996, с. 81] дүгнэжээ. Мөн тэд уг дурсгал өргөн уудам газар нутагт тархсан явдлыг Эрчис мөрний дээд урсгалын Андронов – Канай аймгийн ард түмний нүүдэл суудалтай холбон тайлбарлажээ. Тэдний саналаар уг олдорын хэв шинж дорнод Андроновын аймгуудын угсаатанд тархсан тэр дундаа МЭӨ II жилийн хоёрдугаар хагасын эхэн үеийн Канайн соёлын Кызылташын шатанд холбогдох ба МЭӨ XIV болон XIV – XIII зууны үед Андронов – Канайн ард түмний хоёр дахь нүүдлийн давалгаанаар уг хэв шинжийн олдвор тархсанболлолтой гэж үзжээ [Ткачев, 1997, с. 17; Кирюшин, 2006, с. 35].

Цагираган хэлбэртэй, бүрээ шиг дэрвэгэр хошуутай ээмэгнийон цагийн дээд талын тархалтын хүрээ нь Кулундин талд өгүүлэн буй үед он цагийн хувьд холбогдох Саргарин – Алексеевын дурсгалд төдийлөн таардаггүй байна[Кирюшин, 2006, с. 35]. Тиймээс Саргарин соёлын дурсгалд уг олдвор илрэхгүй бол он цагийн талаарх дээрх судлаачдын саналыг эргэн харах шаардлагатай болж байна. А.А.Ткачев: ийм ээмэг хүрлийн хожуу үед бараг таардаггүй харин эрт үеийн дурсгалд үргэлжлэн тохиолдох нь бий [Ткачев, 2002, с. 180; Кирюшин, 2006, с. 35]. Энэ нь Дорнод Казахстан Измайловын булшны олдвороос [Ермолаев, 1987, с. 69. рис. 31.-2], Уулын Долоон усны Кулсайн соёлын Узунбулак I, Кызылбулак II, Кызылбулак I, Ой-Джайляу III [Горячев, 2001, с. 57. рис. 9.-3, 5, 6, 8–10, 12, 16, 21, 25–28; Горячев, 2008, с.48-49, 57, рис. 4.-5, 9; Марьяшев, 1993, с. 8. рис. 3.-3, с. 13. рис. 6.-5; Марьяшев, 1999, с. 49. рис. 5.-1–3, с. 53. рис. 9.-1–3, 11, 12, 16] (зур. 2.-10, 11) булшны олдворуудаар батлагддаг байна. А.Н. Марьяшев, А.А. Горячев нарын саналаар уг соёлын бүрдэлт Зүүн хойг бүс (Өмнөд Сибирь, Алтай, Дорнод Казахстан) нутгийн Федоровын бүлгийн аймгуудын шилжин суурьших үйл явцтай холбоотой ба тэдний нутгийн хүрэл зэвсгийн үеийн овог аймагтай зэрэгцэн оршиж байсны үр дүн гэж дүгнэжээ. Тиймээс Долоон усны газарт уг дурсгал МЭӨ XII – XI зуунаас эртгүй үед гарч иржээ [Марьяшев, 1999, с. 55]. Мөн цагираган хэлбэртэй, бүрээ хошуутай ээмэг Тамгалы IV он цагийг МЭӨ XIII–XII–X зуун хэмээн тогтоосон булшнаас [Рогожинский, 1999, с. 31] гарчээ. Энэ нь уг соёлын онцлогийг илэрхийлсэн олдворыг тээгч овог аймгийнхны оршин байсан он цагийн доод хилийг МЭӨ X зуун гэдгийг тов тодорхой зааж байна. Түүнчлэн М.А. Демин, С.С. Запрудский, С.М. Ситников нарын судлаачид “судлан тогтоовол, хүрэл зэвсгийн дунд үеийн Федоровын соёлд үзэгдэх уг эдлэл нь он цагийн тогтоосон хязгаарт байсангүй дараагийн үед (хожуу болон хүрлийн төгсгөлийн шатанд) ч үргэлжлэн тохиолдож байна. Гэвч Баруун Өмнөд Сибирьт бус харин Долоон усанд таарч байна” [Демин, 2011, с. 50] гэжээ.



Зур. 2. Өмнөд Сибир болон Дорнод Казахстан дахь цагираг хэлбэртэй бүрээ хошуутай ээмэгний харьцуулсан зураг. 1 – Березовка 1дүгээр були; 2 – Чекановын салаа Х– 4 були, 3, 4 – Кытмановогийн 4-р були; 5, 6 – Чекановын салаа Х– 113-р були, 7 – Кытмановогийн 23 дугаар були; 8 – Кытмановогийн 24 дугаар були; 9 – Кытмановогийн 26 дугаар були; 10, 11 – Ой-Джайляу; 12 – Чекановын салааны 24 дугаар були; 1 – хүрэл болон алтан шармал, 2, 3, 4, 5, 6, 12 – алт, 7 – 11 хүрэл.

Монгол Алтайгаас илэрсэн Чемурчек булшнаас олдсон хамрынх биш цагаан болон хар тугалган ээмэгний хэлбэр зууван цагираган хэлбэртэй [Тишкин, 2008, с. 85-92] байдаг. Уг зууван цагираган хэлбэртэй тугалган ээмэгний дараагийн хөгжлийн хэлбэр нь дугуй цагираг хэлбэртэй болж хувьсан өөрчлөгдөн үзүүр хэсгийн бондгор тогтоогуур нь хөндий болж улмаар юүлүүр, бүрээний хошуу мэт хэлбэртэй болж Андронов [Тишкин, 2011в] болон түүний хөрш орших хүрэл, төмрийн түрүү үеийнархеологийн соёлд уламжлагдсан хэмээн үзэж болно. Андронов булш болон түүний федеровын шатны булшны дөрвөлжин хавтан чулуун байгууламжийн онцлог ч үүнийг давхар батлаж байна гэж үзэж болно. Ялангуяа, Ой-Джайляубулшинд таарч буй дөрвөлжин оршуулгын чулуун байгууламжийг дундуур нь том хавтан чулуугаар тусгаарладаг [Горячев, 2008, с. 44-59] байгууламжийн онцлог Ховд аймгийн Ховд сумын нутаг Халзан үзүүрII-ын 4-р чемурчек булшинд тохиолдож байгаа [Тишкин, 2011б, т. 200–208] болно. Дашрамд өгүүлэхэд археологич Д. Эрдэнэбаатар, А.А. Ковалев нар монгол нутаг дахь чемурчек булшийг хэлбэрээр нь дөрөв ангилсан [Эрдэнэбаатар, 2011а, т. 70–84] байна. Уг ангилалын дөрөв дэх ангилалд уг дундуураа чулуун хавтангаар тусгаарласан булш дэд ангилал болж орох бүрэн боломжтой билээ.

Түүнчлэн ээмэг хийх түүхий эд нь эхлээд тугалга дараа нь хүрэл, холимог металл эцэстэй алт болон өөрчлөгджээ. Дорнод Казахстаны нутгаас хөндий амсарлуу углагдан ордог цагираган хэлбэртэй, цагирагийн дотор талдаа хоёр морь дүрслэн урлагдсан алтан ээмэг ийм төрлийн ээмэгний сонгодог төрөл гэж үзэж

болно. Уг алтан ээмэгт дүрслэгдсэн адуу нь бахим биетэй Төв Азийн уугуул Монгол адуу [Мунхбаяр, 2011а, с. 78–81; Мөнхбаяр, 2011а, т. 53–58; Членова, 1981, с.80-94] шиг урлагдсан нь ийм төрлийн ээмгийг Монгол Алтайгаас гаралтай гэдгийг батлах ажээ. В.Д. Кубарев нарын зэрэг зарим судлаачид булшны байгууламж дахь дөрвөлжин чулуун хашлаг Монгол нутгаас барууншласан гэж үзсэн [Төрбат, 2011, т. 107–138] нь бидний таамаглалыг нотлож буйн илрэл гэлтэй. Ер ээс чулуу болон хүрлийн түрүү үеэс Чемурачкын соёлоос дөрвөлжин хавтан чулуун оршуулгын байгууламж Монгол нутаг болон түүний хөрш зэргэлдээ орших археологийн соёлуудад уламжлагдсан бололтой. Бид зарим судалгаагаар чулуун эдлэл хийх технологи Тэвш болон Дөрвөлжин булшны соёлд уламжилсан [Эрдэнэбаатар, 2011б, т. 85–97; Мунхбаяр, 2011б] болхыг ямар нэгэн байдлаар тогтоосон билээ. Эдгээр баримтууд харилцан бие биедээ археологийн соёлын элементүүд түүхэн тэгшрэлийн хуулийн дагуу нэвтэрч байсныг батлах буюу.

Эцэст нь тэмдэглэхэд Увс аймгийн Улаангом сумын нутаг Чандмань уулаас түүвэр байдлаар олдсон хүрэл ээмэг нь археологийн харьцуулах аргаар он цагийг урьдчилсан байдлаар тогтоовол Андроновын соёлд холбогдох бололтой. Тэгэхдээ уг ээмэг хүрэл зэвсгийн сүүл үеийн ээмэг шиг давтах аргаас бус эрт үеийн технологи болох цутгаж хийх аргаар үйлдэгдсэн нь Андроновын соёлын Федеровын бүлэг буюу хүрэл зэвсгийн дунд үе МЭӨ XIII–XI зуунд холбогдох боломжтойг дээр өгүүлсэн харьцуулсан судалгаанаас харуулж байна. Монголын хүрлийн үеийн түүвэр олдворт тэр бүр тохиолдоод байдаггүй уг ээмэг Уралын нуруунаас Өмнөд Сибирийн бүс нутагт өргөн тархсан Андроновын түүх соёлын нийтлэгт багтах морфологийн онцлогтой. Уг ээмэг нь хэдийгээр тохиолдлын байдлаар Монгол Алтайгаас олдож байгаа нь Урал нуруунаас Өмнөд Сибирь хүртэлх бүс нутагт өргөн тархсан Андроновын угсаа соёлын нийтлэгтэй бидний өвөг дээдэс МЭӨ X зууныг хүртэл худалдаа арилжаа болон угсаа соёлын хувьд холбоотой байсангэдэг нь эсвэл Андроновын угсаа соёлын нийтлэгийн тархалтын зүүн өмнөд бүс нутаг Монгол Алтайн зүүн бие байсан эсэх нь ямар нэгэн байдлаар тодорхой байна. Андронов булшнаас гарч буй хүрэл хонгио, дусал хэлбэрийн гоёл чимэглэлийн зүйл болон ороомог цагираг [Уманский, 2007, с. 49,51. Цветная вклейка I, III, с. 111, рис. 55] зэрэг нь дөрвөлжин булшнаас цөөнгүй гарсан [Эрдэнэбаатар, 2002, т. 243, 251] байдаг билээ. Ганц хувь олдсон болон морфологийн хэлбэр адил байгаа нь зарим судлаачид үнэний хувьгүй мэт санагдах ч цаашид Монгол төдийгүй түүний хөрш зэргэлдээ орших хүрлийн үеийн археологийн соёлын тархалт, магадгүй тэдний угсаа соёлын харилцааг тогтоох харьцуулсан судалгааны эхлэл болж өгч байгаа юм. Уг ээмэгний хэлбэрийн судалгааг Монголын баруун бүс нутаг дахь археологийн соёлын ээмэгтэй харьцуулж, төмөрлөгийн химийн бүтцийн судалгаа(рентгенофлуоросцентный анализ)–гцаашид явуулах нь бидний дэвшүүлэн буй таамаглалыг тодруулах эсвэл няцаах эх хэрэглэгдхүүнийг өгөх нь дамжиггүй. Монгол Алтайгаас илэрсэн Чемурачек булшнаас олдсон ээмэгний хэлбэр түүний дараагийн хөгжлийн хэлбэр байж болох онцлог Андронов [Тишкин, 2011в] буюу бидний өгүүлэн буй Улаан гомын цагираган хэлбэртэй бүрээ шиг хошуутай хүрэл ээмэгт ажиглагдаж байна.

Резюме

По предварительной датировке бронзовая серьга, найденная у горы Чандмань на территории сомона Улаангом Увсунурского аймака, относится ко времени андроновской культуры. На основе проведенного нами анализа она датируется XIII–XI вв. до н.э.- серединой бронзового века, т.е. временем бытования федеровских изделий андроновской культуры, причиной чего является то, что она изготовлена не ковкой - технологией финальной бронзы, а литьём, технологией существовавшей в античности.

Местонахождения данного ювелирного изделия, с одной стороны, подтверждает, что наши предки, у которых единая общность с андроновской культурой, до X в. до н.э. имели торгово-культурную связь с андроновыми племенами, с другой, восток Монгольского Алтая был юго-восточной границей бытования андроновской культуры.

Рентгенофлуоросцентный и сравнительный анализы данной серьги с другими ювелирными изделиями, найденными в Западной Монголии позволит утвердить или отрицать предложенную нами гипотезу.

НОМ ЗҮЙ

Аванесова, Н.А. Серьги и височных подвески Андроновской культуры // Первобытная археология Сибири. Л, 1975. С. 67–73.

Аванесова, Н.А. Культура пастушеских племен эпохи бронзы Азиатской части СССР (по металлическим изделиям) / Н.А. Аванесова. Ташкент. Л, 1991. 200 с.

Авдулганеев, М.Т. Могильник развитой и поздней бронзы на Ближних Елбанах / М.Т. Авдулганеев, Ю.Ф. Кирюшин, С.Ю. Лузин, А.Б. Шамшин // Погребальный обряд древних племен Алтая. Барнаул, 1996. С. 11–20.

Бородаев, В.Б. Археологические памятники на территории Барнаула / В.Б. Бородаев, А.Л. Кунгуров, Ю.Ф. Кирюшин // Памятники истории и культуры Барнаула. Барнаул, 1983. С. 7–30.

Горячев, А.А. О погребальном обряде в памятниках кульсайского типа // История и археология Семиречья. Алматы, 2001, Вып. 2. С. 45–61.

- Горячев, А.А. О погребальных традициях племен поздней бронзы урочища Ой-джайлау в Чуилийских горах / А.А. Горячев // Мировоззрение населения Южной Сибири и Центральной Азии в исторической ретроспективе. Барнаул; Изд-во Алт. Ун - та, 2008. С.44-59.
- Грязнов, М.П. Погребения бронзовой эпохи в Западной Казахстане // Материалы особого комитета по исследованию союзных и автономных республик. Л., 1927. Вып 11. С. 172–221.
- Грязнев, М.П. История древних племен Верхней Оби по раскопкам близ с. Большая Речка / М.П.Грязнев. М.: Л, 1956. №48. 256 с.
- Демин, М.А. Материалы Гилевской археологической экспедиции / М.А.Демин, С.М.Ситников. Барнаул, 2007. Ч. 1. 274 с.
- Демин, М.А. Андроновские украшения Гилевского археологического микрорайона / М.А.Демин, С.С.Запрудский, С.М.Ситников. Барнаул, 2011. 128 с.
- Ермолаев, А.С. Погребения эпохи бронзы могильников Малое Карасу и Ковалевка левобережного Иртыша // История и археология Семиречья. Алматы, 2001. Вып. 2. С. 102–111.
- Исакова, А.И. Могильник племен эпохи бронзы в Таджикистане / А.И.Исакова, Т.М. Потемкина // СА. М, 1989. №1. С. 145–167.
- Кирюшин, Ю.Ф. Коллекция металлических украшений Кулундинской степи в эпоху бронзы / Ю.Ф. Кирюшин, О.А.Позднякова, Д.В. Папин, А.Б.Шамшин // Алтай в системе металлургических провинций бронзового века. Барнаул, 2006, С. 33–44.
- Кузьмина, Е.Е. Металлические изделия энеолита и бронзового века в Средней Азии / Е.Е. Кузьмина. АН СССР. М, 1966. Вып. 4–9. 151 с.
- Маргулан, А.Х. Бегазы-Дандыбаевская культура Центрального Казахстана / А.Х.Маргулан. Алма-Ата, 1979. 363 с.
- Марьяшев, А.Н. К вопросу типологии и хронологии памятников эпохи бронзы Семиречья / А.Н. Марьяшев, А.А. Горячев // Рос. Археология. М, 1993. №1. С. 5–19.
- Марьяшев, А.Н. Памятники кулсайского типа эпохи поздней и финальной бронзы Семиречья / А.Н. Марьяшев, А.А. Горячев // История и археология Семиречья. Алматы, 1999, Вып. 1. С. 45–56.
- Мөнхбаяр, Ч. “Тэмээн хүзүү - Ховд” чиглэлийн хатуу хучилттай замын трасс дагуу орших түүх-соёлын дурсгалын хайгуул судалгааны эхний үр дүнгээс. ХИС-ийн НХУС-ийн эрдэм шинжилгээний бичиг. Том II (14). Fasc 13. УБ, 2009. Т. 70–82.
- Мунхбаяр, Б.Ч. Изображения «Тагарских» лошадей в петроглифах Монгольского Алтая. Наскальное искусство в современном обществе. К 290-летию научного открытия Томской писаницы. Материалы международной научной конференции (22-26 августа 2011 г., Кемерово). Том 2, Труды Сибирской Ассоциации исследователей первобытного искусства. Вып. VIII. – Кемерово: Кузбассвузиздат, 2011а. С. 78–81.
- Мунхбаяр, Б.Ч. Каменные находки Чемурчекских курганов // Актуальные проблемы исследования этноэкологических и этнокультурных традиций народов Саяно-Алтая: материалы. III межрегиональной конференции с международным участием (Кызыл, 28 июня – 2 июля 2011 г.). Кызыл, 2011б. С. 265–271.
- Мөнхбаяр, Ч. Монгол Алтай дах Тагар хэв шинжийн адууны дүр // Природные условия, история и культура западной Монголии и сопредельных регионов. Тезисы докладов X международной научной конференции (20-21 августа 2011 г., г.Ховд, Монголия). Ховд-Томск., 2011а. С. 53–58.
- Мөнхбаяр, Ч. Нэгэн халбаган зүүлтний тухай // ЭШБ (Ховд их сургуулийн НХУС-ийн эрдэм шинжилгээний бичиг). Т. V (17). Ф. 14. УБ., 2012. Т. 72–81.
- Орозбаев, А.М. Северный Казахстан в эпоху бронзы / А.М. Орозбаев. Алма-Ата, 1958. Т.У. 156 с.
- Рогожинский, А.Е. Могильник эпохи бронзы урочища Тамгалы 1999 // История и археология Семиречья. Алматы, 1999, Вып. 1. С. 7–43.
- Ткачев, А.А. Серьги Андроновской культуры (проблема датировки) / А.А. Ткачев, Н.А. Ткачева // Сохранение и изучение культурного наследия Алтайского края. Барнаул, 1996. С. 96–100.
- Ткачев, А.А. Центральный Казахстан в эпоху бронзы. Тюмень: ТюмГНГУ, 2002. Ч. 2. 243 с.
- Тишкин, А.А. Археологическое изучение объектов эпохи бронзы в урочище Улаан худаг (Ховдский аймак Монголии) / А.А. Тишкин, С.П. Грушин, Ч. Мунхбаяр // Теория и практика археологических исследований. Барнаул, 2008. С. 85-92.
- Тишкин, А.А. Случайные находки предметов из цветного металла на территории Западной Монголии и изучение их с помощью рентгенофлюоресцентного анализа / А.А. Тишкин, Б.Ч. Мунхбаяр // Түүхийн товчоон (ХИС-ийн НХУС-ийн Түүхийн тэнхимийн эрдэм шинжилгээний бичиг) Том IV, Fasc 10. УБ, 2009. С. 105-111; Тезисы докладов IX международной научной конференции по теме “Природные условия, история и культура Западной Монголии и сопредельных регионов (16-20 сентября 2009 г., г.Ховд, Монголия). УБ, 2009а. С. 85–88.
- Тишкин, А.А. Находки из Монгольского Алтая / А.А. Тишкин, Б.Ч. Мунхбаяр // Древние культуры Монголии и Байкальской Сибири. Материалы меж. нар. науч. конф (Иркутск, 3-7 мая, 2011 г.). Вып. II. Иркутск, 2011а. С. 265–271.

Тишкин, А.А. Памятники ранней бронзы в долине Буянта (Монгольский Алтай) / А.А.Тишкин, Ч.Мунхбаяр, С.П.Грушин, Д.Эрдэнэбаатар // Известия Алтайского государственного университета. – 2011б. - №4/1 (72/1). С. 200–208.

Тишкин, А.А. Комплексное изучение монеты «у-шу» из сомона Алтай (Ховдский аймак Монголии). Роль естественно-научных методов в археологических исследованиях. Сборник научных трудов / А.А. Тишкин, Н.Н.Серегин, Ч.Мунхбаяр// Посвящается 125 – летию со дня рождения известного российского ученого Сергея Ивановича Руденко. Барнаул, 2009б. С. 336–339.

Тишкин, А.А. Коллекция случайных находок из Западной Монголии/ А.А.Тишкин, Ч. Мунхбаяр, Н.Цэнд-Аюуш // Түүхийн товчоон. Том Ү, Fasc10. УБ, 2010.С. 159–168.

Тишкин, А.А. Буянт голын ай сав дагуух Чемурчек булш (Ховд аймгийн нутаг дахь археологийн хайгуул,малтлага, судалгааны үр дүн)/ А.А. Тишкин, Ч.Мөнхбаяр, Д. Эрдэнэбаатар, С.П. Грушин// ЭШБ. Т. IV. Ф. XVII. УБ, 2011в. Т. 118–156.

Төрбат, Ц. Харганатын гол ба Сыргалийн талын Пазырыкийн үеийн булшнууд (Судалгааны урьдчилсан үр дүн) / Ц.Төрбат, Д.Батсүх, Н.Баярхүү, П.-Х.Жискаар // SA. Т.XXX. Ф. 7. УБ, 2011. Т. 107–138.

Уманский, А.П. Погребальный обряд населения Андроновской культуры Причумышья (По материалам могильника Кытманово) / А.П.Уманский, Ю.Ф.Кирюшин, С.П. Грушин. Барнаул, 2007. 132 с.

Черников, С.С. Восточный Казахстан в эпоху бронзы / С.С. Черников. МИА. М, Л, 1960. №88. 276 с.

Членова, Н.Л. Татарские лошади// О связях племен Южной Сибири и Средней Азии в древности и средневековые. М., 1981. С.80–94.

Эрдэнэбаатар, Д. Монгол нутаг дахь дөрвөлжин булш хиригсүүрийн соёл (Культуры херексуров и плиточных могил Монголии) / Д.Эрдэнэбаатар. УБ, 2002. 276т.

Эрдэнэбаатар, Д. “Чемурчекийн соёл” түүний тархалтын тухай зарим баримт / Д. Эрдэнэбаатар, А.А. Ковалев // Нүүдэлчдийн өв соёл. Том. XI. Ф. 6. УБ, 2011а.Т. 70–84.

Эрдэнэбаатар, Д. Чемурчек булшны чулуун олдвор / Д. Эрдэнэбаатар, Ч. Мөнхбаяр // Нүүдэлчдийн өв соёл. Том. XI. Ф. 32. УБ, 2011б. Т. 85–97.

«ВЕЛИКОЛЕПНЫЕ» КАТАФРАКТАРИИ ХАР-ХАД.

ТОЧКИ ЗРЕНИЯ

Ю.И. Ожередов

Кандидат исторических наук, Директор музея археологии и этнографий Сибири им. В.М. Флоринского, Томский госуниверситет, nohoister@gmail.com

На протяжении XX столетия наскальные изобразительные памятники стали надежными источниками вполне объективно иллюстрирующими историческую обстановку далекого прошлого. В данном контексте весьма важным научным событием стало открытие в 1973 г.² советско-монгольской экспедицией сцены с участием тяжеловооруженных конных катафрактариев на плоскости скалы Хар-Хад в Западной Монголии. Наскальные выбивки данного памятника настолько выразительны и достоверны, что их первооткрывательница Э.А. Новгородова назвала главных героев композиции «великолепными катафрактариями» [1986]. Но помимо внешней эффектности композиция содержит изобразительный текст, позволивший по иному взглянуть на военное искусство центрально-азиатских племен в начале-середине I тыс. н.э. [5. с. 119].

В 2008 г. международная экспедиция Томского и Ховдского университетов под руководством автора посетила Хар-Хад в рамках программы фиксации и научного описания археологических памятников Ховдского аймака. Памятник (рис.1) располагается на южном фесе одноименной скалы Хар-Хад (Черный Камень) под южным склоном хребта Цамбагарав уул (N48° 31' 412", E 91° 04' 417"). В ходе обследования было установлено, что объект значительно более многообразен, нежели это можно узнать из публикаций 1980-х гг. [6. с.102, 112, рис.7; 3. рис.7 а,б; 4. с. 127-134; 5. с. 116, 118-119]. Помимо плоскости с названными изображениями, отмечено еще не менее 14 других, в том числе с граффити, изображающими конного катафрактария в сопровождении пешего лучника, собаки, представителей местной фауны и предположительно мифологических персонажей [8. с. 89-96; 9. с. 149-150; 10. с. 103-104].

В упомянутых выше публикациях 1980-х гг. Э.А. Новгородова и ее соавторы анализируют «5 всадников в доспехах и шлемах» VI-VII вв. [6. с. 102, рис. 7]. В предложенном варианте композиция широко известна в отечественной и зарубежной литературе, в том числе в монгольской [1. с. 114-116, 129; 2. с. 103-105, 118; 12. с. 393-395].

Проведенное в 2008 г. обследование памятника подтвердило наличие лишь четырех катафрактариев и поставило под сомнение образ «пятого всадника», о котором сказано: «не выбита броня одного из воинов

2 В другой публикации годом открытия Э.А. Новгородова называет 1972 г. [3. с. 15].

и его коня, хотя показано копые, а фигуры человека и животного имеют такой силуэт, будто предполагалось изобразить броню» [6. с. 102, рис. 7]. Пятая фигура, на мой взгляд, не отвечает понятию всадник, а форма животного изображенного под ним не соответствует облику других коней композиции и в целом изобразительному стилю раннего средневековья. Допустить подобную форму коня можно лишь для эпох намного предшествующих временам катафрактариев. Следовательно рассматриваемые здесь персонажи не более чем псевдовсадник и псевдоконь [9. с. 149-150; 10. с. 103-104; Ожередов. 2012. с. 306-307].

Неоднозначность образа псевдовсадника в публикациях 1980-х гг. со временем инициировала вольные его интерпретации. Например, в работе монгольского исследователя рисунок после «уточнения» приобрел ультра фантазийный вид [1. рис. 54]. Еще далее в этом направлении пошел коллектив исследователей из Алтайского и Кемеровского университета в публикации доклада, озвученного в 2012 г. на «Международном конгрессе средневековой археологии Евразийских степей» [11. с. 225-226. рис. 1, 4]. По их мнению, они ввели «широко известную композицию в научный оборот» [11. с. 226]. Однако анализ данной публикации показал, что качество введенного в оборот продукта, не бесспорно.

В отечественных публикациях 1980-х гг. подробного описания спорной фигуры нет. Имеется лишь ее упоминание, цитированное выше и фото с ее участием [6. с. 102; 3; 4. Черно-белое фото; 5. Цветное фото].

На фотографиях контуры всадников видны много ярче остальных персонажей. Вероятно, в соответствие с принятой в те времена методикой фиксации, перед съемкой петроглифы были предварительно очерчены мелом. При сопоставлении черно-белых и цветной фотографий Э.А. Новгородовой [3; 4; 5] заметно, что меловые контуры на них несколько отличаются. Кроме того, на цветном фото дорисовано копые и левая сторона фигуры псевдовсадника (рис.2).

В 1980 г. была опубликована прорисовка данного персонажа (рис. 3, 5), основой которой, очевидно, послужил контур, очерченный мелом на цветном фото. На фото мелом, а на прорисовке черной заливкой отмечено, что правую сторону фигуры «человека» формирует голова и шея горного козла скифского типа [6. Рис.7; 3, фото;4, фото; 5. фото на с. 118]. Однако, уже на фото наблюдается ряд нестыковок. Например, копые, отмеченное на цветном фото [5. с. 118] отсутствует на черно-белых фотографиях [3. Рис. 7а; 4. фото].

Еще более отличается от фото прорисовка, недостаток которой кроется в одной ошибке. При реконструкции за основу образа человека была ошибочно принята изогнутая линия, продолженная по оси персонажа, через морду горного козла вниз на туловище псевдоконя. Точнее ошибкой стала подмена функции крючководного завершения на вершине этой линии (рис. 3, 4, 5-1). На прорисовке этот крючок трактован в качестве самостоятельного контура «головы» человека, опирающегося своими окончаниями на «плечи» справа и слева. В реальности слева крючок не соприкасается с «плечом», а справа имеет продолжение вниз. Средняя часть линии пропадает в заливке козла, но на выходе вверх (через заливку) она сможет сомкнуться не с правым окончанием контура «головы» как на фото, а с левым, что полностью противоречит фотоизображению. Таким образом, неверная трактовка линии с крючком проложенной между фигурами двух горных козлов породила ложную конструкцию всадника. В довершение неточностей на прорисовке появляется копые, которое появилось еще на цветном фото [6. рис. 7].

Моя позиция по поднятому вопросу изложена в трех статьях [2009, 2011, 2012 гг.] и озвучена на двух конференциях (Санкт-Петербург 2012 г., Томск 2012 г.). В рамках данного сообщения она изложена при разборе публикаций 1980-х гг., а в тезисном изложении выглядит следующим образом³:

1. Образ псевдовсадника складывается из трех фигур волею случая расположившихся над спиной псевдоконя (рис. 4, 5-2):

- горного козла скифского типа слева (рог стал правым плечом),
- стилизованного горного козла (?) в вертикальном положении справа (рог стал левым плечом и частью руки),
- изогнутой линии с крючком на вершине (голова) между козлами (далее, соответственно, левая и правая фигуры).

2. В режиме высокой контрастности на фото 2008 г. отчетливо видно, что линия с крючком сверху проходит по иной амплитуде (рис. 4), чем на рисунке 1980 г. (рис. 3). При негативной роли которую сыграла линия с крючком в деле имитации всадника, она же является антиподом этой идеи. При ее изучении заметно, что она выглядит ярче контура «коня» и фигурок горных козлов по сторонам, следовательно, нанесена не одновременно с ними, а позже и является вполне самостоятельным элементом.

3. Кони под реальными наездниками находятся в тесной стилистической близости между собой (рис. 2-3), чему не соответствует псевдоконь с его массивным туловищем, якобы обремененным доспехом. Однако нижний край брони на реальных конях свисает под брюхо, где ограничен горизонтальной кромкой пересекающей передние и задние конечности, выступающие из-под нее без перехода. У псевдоконя конечности переходят в туловище плавно в анатомическом порядке, а очертания фигуры явно не свидетельствует о надетом доспехе (рис. 4, 5-2).

³ Все иллюстрации представляют собой фотографии переведенные в черно-белый режим с высоким контрастом. Прорисовка (рис. 5-2) лишь отражает итог изучения натуры и фотографий. Авт.

Коллектив авторов, предложивших новую версию прочтения образа псевдовсадника, декларирует в вопросе пятого персонажа полную солидарность с позицией Э.А. Новгородовой [11. с. 227]. Однако на деле их трактовки заметно расходятся. Если прорисовка Э.А. Новгородовой отражает наличие комбинированного образа, то новая полностью таковой отвергает. На старом рисунке слева отчетливо видна фигурка горного козла [6. рис. 7]. В новом варианте голова, туловище и конечности животного из композиции тщательно вычищены. От них сохранились лишь рог и часть шеи [11. рис. 1, 4], послужившие для имитации правой половины туловища псевдовсадника (рис.6). И это при том, что козел отчетливо виден на фотографии авторов [11. рис. 5]. В тоже время, авторы вопреки своему рисунку пишут – «...со стороны спины линия доспеха частично нарушена изображением неопределенного животного» [11. с. 225]. Но они, видимо, забывают, что «неопределенное» животное – это «подчищенный» ими скифский козел. Следовательно, по их логике выходит, что изображение скифского времени нарушило средневековую фигуру всадника.

В отношении левой половины туловища «наездника» авторы поступают весьма просто: очертание спины стилизованного козлика, выбитого вертикально преобразуется в контур туловища человека, где рог составляет левое плечо и руку, а голова и конечности – поперечные полосы доспеха на теле «воина» (рис. 5-2, 6).

Изогнутую линию, проложенную между двумя фигурами горных козлов, авторы точно также как первые исследователи, используют для оформления «головы». Для этого у короткого отростка крючка, ее соединили с «плечом», а на длинном прервали на уровне «плеч». В результате повторился ложный эффект самостоятельного контура «головы», созданный, в свое время, Э.А. Новгородовой. В довершение образа воина в композицию внесли копье, заметив при этом, что «копье лишь намечено» [11. с. 225]. Однако при изучении фото таких наметок не обнаруживается, тем более за спиной псевдовсадника (рис. 4).

В итоге для создания правдоподобного образа воина, авторы вычеркнули из композиции две фигуры горных козлов – «скифского» слева и стилизованного стоящего вертикально справа, крючок на изогнутой линии между ними превратили в «голову» и дорисовали копье (рис. 6).

Что касается фигуры псевдоконя, то повторюсь лишь в одном утверждении – в эпоху средневековья данная фигура не может ассоциироваться с конем не при каких условиях. Рассуждения авторов о стриженной гриве и других подробностях на теле псевдоконя [11. с. 225], не более чем из области догадок, так как все они не имеют четкого, внятно зримого контура и системности (грива), а, следовательно, могут трактоваться произвольно.

При затруднениях с интерпретацией «темных» мест, авторы регулярно апеллируют к бессменному аргументу о незавершенности рисунка. Так, например, невнятный контур «попоны» находит следующее объяснение «...выполнен он менее искусно, чем у других коней» [11. с. 225-226]. Напрашивается вопрос, в чем причина столь «неискусного» облика одного в «...шеренге из трех всадников»? Далее, отсутствие панцирного доспеха на коне не более чем – «...внутреннее пространство корпуса коня не заштриховано».⁴ Аккуратно очертив контур головы на прорисовке, авторы пишут буквально следующее: «верх шлема всадника не прослеживается. Возможно, исполнители целенаправленно не уделили внимание данной детали» [11. с. 225]. Согласно таким толкованиям фактически все элементы спорного рисунка были одновременно начаты и, по непонятной причине, также в раз, брошены. Ни один не стал окончательно завершенным. Иногда мастер позволял себе изменять стиль и технику, игнорировать важные детали и т.п. А главное, странным образом оказались «не завершены» только те две «темные» фигуры, которые «...несколько отличаются по стилю или технике» [11. с. 225]. В контексте таких объяснений следует предположить, что мастер намеренно создавал загадки для будущих поколений.

Из-за регламента объема настоящей статьи у меня нет возможности проанализировать все прорисовки и персонажи, рассматриваемой публикации, поэтому ограничусь одним примером. Сравнивая изображение «пехотинца» на фото с предложенной авторами прорисовкой видим существенную разницу. На фото отчетливо виден стандартный М-образной формы лук с рукояткой в центре (рис. 8), а на прорисовке образец, состоящий из двух пересекающихся кривых (рис. 7) [11. с. 223-224, рис. 3]. Но при этом, на прорисовке не отмечен тонкий контур, очевидно, символизирующий горит расположившийся горизонтально вдоль левого бедра воина (рис. 8).

Интерпретация «шестого» персонажа (рис. 9), в качестве катафрактария, на мой взгляд, является скоропалительной и преждевременной. Несмотря на то, что контур данного животного имеет внешнее сходство со средневековыми изображениями коней в боевом облачении, фигура остается более чем спорной как в технологическом, так и в стилистическом отношениях. Во-первых, ее выбивка сильно отличается от использованной для изображения других всадников. В отличие от четкой и стабильной на всем протяжении линии абриса реальных коней, здесь она размытая, местами прерывистая и очень мелкая, буквально поверхностная. Во-вторых, неясный контур над спиной животного назвать человеком можно лишь с большими оговорками. Так называемый «всадник» не только не имеет четких очертаний, он совершенно не пропорционален габаритам животного. Реальные всадники имеют относительно своих коней точно рассчитанные и масштабированные формы и размеры. В этом случае форма и габариты более напоминают тук с грузом, нежели человека. При достижении своей цели авторы вновь приукрасили прорисовку

4 Речь, видимо, идет о конском панцире. Авт.

спорными или несуществующими деталями. В частности, на фото по иному выглядит фигура наездника и голова коня (рис. 9, 10). Даже принимая во внимание вариант «непроработанной заготовки», есть сильное ощущение, что делал ее другой человек и, возможно, в другое время.

В заключение отмечу, что в опубликованную авторами реконструкцию хархадской композиции внесены столь серьезные изменения, что памятник в таком варианте оказался практически фальсифицирован, а предложенная реконструкция не может использоваться в качестве достоверного источника.

ЛИТЕРАТУРА

1. Батмөнх Б. Ховд аймагийн нутаг дахь эртний туух соёлын дурсгал. – Улаанбаатар. 2000. – 160 с.
2. Батмөнх Б. Монгол алтайн нурууны төв хэсгийн археологийн дурсгалууд. – Улаанбаатар. 2008. – 141 с.
3. Новгородова Э.А. Памятники изобразительного искусства древнетюркского времени на территории МНР // Тюркологический сборник. 1977 г. – М. 1981. – С. 203-218.
4. Новгородова Э.А. Мир петроглифов Монголии. – М. Наука, 1984. – 168 с.
5. Новгородова Э.А. Великолепные катафрактерии // Человек открывает землю. – М. Мысль, 1986. – С. 114-119.
6. Новгородова Э.А., Горелик М.В. Наскальные изображения тяжеловооруженных воинов с Монгольского Алтая // Древний Восток и античный мир. – М. Изд-во Моск. ун-та, 1980. – С.101-112.
7. Ожередов Ю.И. Новые сведения об археологических изобразительных памятниках Северо-Западной Монголии // Культуры степной Евразии и их взаимодействие с древними цивилизациями. Кн. 1. – СПб. ИИМК РАН, Периферия, 2012. – С.304-311.
8. Ожередов Ю.И., Мунхбаяр Ч., Ожередова А.Ю. Новые находки археологических памятников в северных сомонах Ховдского аймака Западной Монголии. // Природные условия, история и культура Западной Монголии и сопредельных регионов.– Ховд-Томск, 2009. – С. 89-96.
9. Ожередов Ю.И., Ожередова А.Ю. Воины Черной Скалы // Известия лаборатории древних технологий. Вып. 7. – Иркутск. Из-во Иркут. гос. технич. ун-та, 2009. – С. 149-154.
10. Ожередов Ю.И., Мунхбаяр Б.Ч., Ожередова А.Ю. Граффити с воинами комплекса Хар-Хад // Эрдэм шинжилгээний бичиг № 4 (16). –Улаанбаатар, 2011. – С.103-110.
11. Тишкин А.А., Горбунов В.В., Мухарева А. Н. Катафрактерии Хар-Хада // История и культура средневековых народов степной Евразии: материалы международного конгресса средневековой археологии Евразийских степей. – Барнаул. Изд-во Алт. ун-та, 2012. – С. 221-226.
12. Монголын Говь-Алтайн хадны зураг. – Сеул. 2008. – 458 с.



Рис. 1. Хар-Хад. Общий вид большой композиции.




Рис. 2. Хар-Хад. Пятый «всадник». Прорисовка мелом на скале (цветное фото).




Рис. 3. Хар-Хад. Пятый «всадник». Прорисовка Э.А. Новгородовой в публикации 1980 г.



Рис. 4. Хар-Хад. Фото 2008 г..




Рис. 5. Хар-Хад. Пятый «всадник». Прорисовки – 1. Э.А. Новгородовой;
2. Ю.И. Ожередова



Рис.6. Хар-Хад. Пятый «всадник». Прорисовка – А.А. Тишкин, В.В. Горбунов, А.Н. Мухарева.




Рис. 7. Хар-Хад. Пеший воин. Прорисовка. – А.А. Тишкин, В.В. Горбунов, А.Н. Мухарева.



Рис. 8. Хар-Хад. Пеший воин. Контрастное фото.



Рис. 9. Хар-Хад. Шестой «всадник». Прорисовка – А.А. Тишкин, В.В. Горбунов, А.Н. Мухарева.



10. Хар-Хад. Шестой «всадник». Контрастное фото

ДӨРВӨДИЙН УЛАМЖЛАЛТ ШАГАЙН ТОГЛООМ

Л.Отгонбаяр
Магистр, ХИС-ийн НХУС-ийн Түүхийн тэнхимийн багш,
otgoo_77@yahoo.com

Шагай бол монголчуудын зөвхөн тоглоом наадмын хэрэглэгдэхүүн төдий зүйл биш. Монгол хүнийг эхээс төрөхөд угтаж эхнэр авах, эрд очиход мөн дагаж, ханан гэрт нь нэгэн насыг элээлцээд хадан гэрт нь дагалдан оддог бэлгэ дэмбэрэлийн сахиус юм⁵.

Дөрвөдийн шагайн тоглоомд хонь, ямаа, үхэр, аргаль, зээрийн шагайг голдуу хэргэлдэг байв. Үүний дотроос халуун хошуутай малын нэг хонины шагайг эрхэмлэн “Боди садва” хэмээн үзэж мэргэ төлгөнд хэрэглэнэ. Харин аргалын шагайг өлзий буянтай хэмээн үзэж хүндэтгэлийн зүйлд хэрэглэдэг байна. Шагай чөмөг идвэл шагайг эрхий хуруугаараа дарж бугалан авч махыг мөлжиж галд өргөөд найрч морь буулгаад хүүхдэд өгдөг байна.

Дөрвөдүүд шагайг зодог өвс, хадны хаг, сонгины хальс зэрэгт хийж усанд буцалган улаан хүрэн өнгөтэй болгох бөгөөд мөн өнгө бүрийн бөс даавуутай хамт буцалган будаад янз бүрийн тоглоом тоглосоор иржээ.

Дөрвөдүүдийн дунд шагайн тоглоомын олон төрөл зүйл уламжлагдан үлджээ. Үүнд:

Шагай харвах: Дөрвөд шагай харвах тоглоом нь халхын шагай харваатай адилгүй. Тэд хэд хэдээрээ цуглаж баг болж толохгүй ганц ганцаараа баг болон тоглоно⁶.

Шагай харвахдаа голдуу төв суурин газар мөн хөдөөд зун цагаар ширэг зүлгэн дээр нааддаг байжээ.

Дөрвөдүүдийн уг тоглоом нь нэн энгийн жишээ нь хавтгай модон дээр хонь ямааны жирийн шагайг “зээр” гэж нэрлэн өрдөг, харваж няслах сумыг малын шилбэний ясыг дундаас нь хомхой (долоовор) хурууны дунд үенээс хурууны үзүүр хүртлэх хэмжээтэй тайрч нүхэнд нь мод шааж гонзгой хэлбэртэй зассан бургасаар суман “шахаг” буюу “хашиг” (хашлага) хийдэг. Мөн зарим тохиолдолд шагайгаар шууд инцдаж /няслаж/ харвадаг байжээ.

Гэхдээ сүүлдээ хашлага сумны хэлбэр нь нэлээд сайжирч ч хашалганд яс нааж суулгах, хадны хаг, давууны будаг авч хүрэн улаан өнгөөр будах, сумыг дугираг хэлбэртэй хийдэг болжээ.

Дөрвөдийн дунд “Марал харваа”, “Зээр харваа”, “Буга харваа”, “Тугал харваа” байсан бөгөөд тэдгээрийг харвахдаа гурван тохой, таван тохой, есөн тохой газраас харавдаг байжээ.

Эрт дээр үеэс богийн шагайг сайтар мөлжөөд хоёр төөргөнтэй дөрвөн төө урттай хоёр төө гаруй өндөртэй тусгай бэлтгэсэн тавиур дээр зээрээ өрж түүнийг харван тоглодог байжээ⁷.

Дөрвөдөд тоглодог байсан бас нэг төрлийн шагай харвах тоглоомын тухай Г.Н.Потанин дурдсан байдаг. Түүний бичсэнээр зөвхөн хоёр хүн тоглодог ба хүн бүр дэргэдээ ес есөн шагай хавтгай модон дээр эгнүүлэн тавих бөгөөд есөн шагайны голын нэг нь ноён, хоёр талын дөрвөн шагайг цэрэг гэх бөгөөд тоглогч бүр дөрвөн шагайгаар харилцан харваж оносон шагайг хажуу тийш нь авч тавих ба эхэлж ноёныг оносон нь хожсонд тооцдог⁸ гэжээ.

Уг тоглоомоор хүүхдүүд харваж наадах бөгөөд заавал есөн шагай өрдөггүй байна. Мөн модөрөхгүй тоглодог юм. Тоглоом эхлэхэд хэдэн шагай өрж наадахаа хоорондоо ярьж тохиролцдог байна.

Морь уралдуулах: Морь уралдуулах тоглоомоор хэдэнч хүн тоглож болно. Тоглох хүмүүс тус бүр уралдах морьдоо нас насаар нь сонгон аваад тусгай уяанд уяна. Энэхүү шагайн хонхор тал нь зүүн тийш харсан байх ёстой. Уг тоглоомоор гүү уралдуулахгүй.

Ийнхүү тоглогчид уралдуулах морио сонгон авсны дараа морь уралдуулахад найрах дөрвөн шагай сонгон аваад есөн ширхэг утаа (зураас)-г хавтгай модон дээр юмуу аль эсвэл газарт зурж, энэ есөн утааны ард уралдуулахаар сонгон авсан морьдоо зэрэгцүүлэн тавиад, ээлж дарааллаар дээрх морь уралдуулахаар авсан дөрвөн шагайгаа найрч тоглодог.

Ингэж тоглохдоо найрсан дөрвөн шагайн хэдэн морь бууна түүний тоогоор ахиулдаг. Мөн тэмээ хонь ямаа дөрвөн ижил буувал нэг нэг утаа ахиулна. Дөрвөн зүс буувал дөрвөн утаа ахиулан тавина.

Есөн утаа бага гэж үзвэл хариу эргэж уралдаад барианд орж болдог. Тоглогчид уясан морьдоо насаар нь нэрлэхээс гадна хул, хээр, шарга, хүрэн, зээрд гэх мэтээр зүсэлж хэлдэг. Олон хүн тогловол уралдсан морьдыг айргийн тав болон түрүү магнай, аман хүзүү гэх мэтээр нэрлэж тоглодог байна.

⁵Түдэв Л. Монгол шагаа. // Тэргүүн дэвтэр. УБ., 2006. тал. 11.

⁶Аюуш Ц. Дөрвөд // БНМАУ-ын угсаатны зүй. II боть. Ойрадын угсаатны зүй (XIX-XX зууны зааг үе). Эрхэлсэн С.Бадамхатан. УБ., 1996. тал. 82.

⁷Катуу Б. Дөрвөд, баяд шагайн тоглоом // Ойрад товчоон-II. МУИС-ийн Ховд дахь салбар сургуулийн НУТ-ийн ЭШБ. УБ., 2001. тал. 57-58

⁸Аюуш Ц. Дөрвөд // БНМАУ-ын угсаатны зүй. II боть. Ойрадын угсаатны зүй (XIX-XX зууны зааг үе). Эрхэлсэн С.Бадамхатан. УБ., 1996. тал. 82.

Мөн зарим нутагт хавтгай урт модон дээр хөндлөн арван нэгэн зураас татаж, түүнийг “өртөө” гэж нэрлээд тоглогчид сонгож авсан “морио” зэрээгцүүлэн тавьж аяганд дөрвөн шагай орхиж, хэдэн “морь” бууна, тэр тоогоор урагш нь зураасан дээр ахиулж тавих бөгөөд хэн түрүүлж эцэст нь хүрнэ түүнийг түрүүлсэнд тооцдог⁹ байжээ.

Мянгатах: Энэ тоглоомоор хоёр буюу түүнээс дээш хүүхэд залуус болон бүхийл насны хэдэнч хүн тоглож болно. Тоглохдоо шагай найрах дэвжээ засаж дэвжээгээ тойрч суун дүүмэд настай нь эхлэж бүх шагайгаа найрч тоглодог.

Ингэхдээ тэмээ-1000

Морь-500 гэж бодно. Зөвхөн тэмээ морь хоёрыг цуглуулж тоглоно. Ийнхүү дэс дараалан найрч бүх шагайг авч дууссаны дараа хүн бүр тодорхой хэмжээний тэнцүү шагай нийлүүлэн тоглох бөгөөд ингэхдээ арван мянга нийлүүлэх болоход арван тэмээ өгч чадахгүй бол морио оролцуулан бодож нийлүүлэн тоглоно.

Шагайг тоглоомд оруулахдаа хамгийн сүүлчийн шагайг авч чадсан хүн эхлэх болно. Тоглолтын явцад шагай нь дууссан хүмүүс хасагдах бөгөөд эцэст нь бусдын шагайг бүрэн өөртөө цуглуусан нь хожно.

Энэхүү тоглоом нь хүүхдэд тоглоомоор дамжуулан бодуулж тооллын системд сургах гол арга байсныг давхар нотлож байна.

Шагай инцдэх: Шагай инцдэх /няслах/ тоглоомоор хоёроос дээш хэдэнч тооны хүн тоглож болно. Шагай инцдэхээр зассан дэвжээгээ тойрон суусан хүмүүсээс дүүмэд настайн бүх шагайгаа эхэлж найрна. Орхилтонд ижил буусан шагайг хооронд нь алдаагүй зөв цэвэр инцдсэн аль нэг шагайгаа авч цааш үргэлжлүүлнэ.

Инцдэхдээ дараах дүрмийг баримтлана. Үүнд:

- өөр шагай давхар инцдэх
- хоёр өөр төрлийн шагайг инцдэх
- инцдсэн гараараа авах
- инцдсэн хуруугаа солих
- инцдэхэд хялбар болгож тавих
- суудлаасаа хөдлөх зэргийг хориглоно. Жишээ нь: шагай инцдэхдээ суудлаасаа хөдөлвөл орчилон тойрохгүй хэмээн хориглодог.

Дээрх дүрмүүдийг зөрчвөл дахин няслах эрхээ алдаж дараагийн хүн орхино. Мөн тоглоом эхлэхийн өмнө “хатуу юу?”, “Зөөлөн үү?” гэж асуудаг энэ нь дээрх бүх дүрэм буюу шагай инцдэхэд баримталдаг бүх дүрмээр юу? Эсвэл зарим нэг дүрмээр тоглох уу? гэсэн үг юм. Зөөлөн гэхэд ихэвчлэн дараах дүрмийг баримталдаг. Үүнд:

- өөр шагай давхар инцдэх
- хоёр өөр төрлийн шагайг инцдэх
- инцдэхэд хялбар болгож тавих
- суудлаасаа хөдлөх зэргийг хориглоно.

Хэрэв хооронд нь зайлшгүй инцдэх шаардлагатай хоёр ижил шагайны хооронд нь өөр шагай таараад хаагдан инцдэх боломжгүй болсон бол нийт тоглогчдын зөвшөөрлөөр эрхий хуруугаараа тээж дундах шагайн дээгүүр өргөж нөгөө шагайг цохино. Хэрэв дүрэм зөрчиж буруудвал дараагийн хүн инцдэх болно.

Тоглоом дээрх журмаар үрэгжилсээр дөрвөн шагай үлдээд дөрвөн зүс буувал найрсан хүн авна. Харин дөрөв болон гурван шагай ижил буувал бүх тоглогчид булаацалдаж авдаг байна. Хоёр шагай үлдэв хоорондон инцдэж авах бөгөөд нэг шагай үлдэггүй байна.

Мөн лаг /хоорондоо наалданхай буусан шагай/ буувал өөр нэг шагайгаар цохиж унагаад үргэжлүүлэн тоголох бөгөөд заримдаа лагыг хөндөхгүй үлдээж тоглодог байна.

Эр, эм онх буусан тохиолдолд, эр онхыг ихээхэн бэлэгшээж авна бөгөөд эм онхыг заавал цохиж унагаана. Ингэхдээ ойролцоо газар цохиод уагаана. Энэ нь эм онх буухыг их муу гэж үздэгтэй хобоотой юм.

Эхний найрсан шагай дуусвал хамгийн сүүлчийн шагай авсан хүн дараагийн тоглолтонд эхэлж орхиод инцэднэ. Ийнхүү шагайгаа дахин нийлүүлэхдээ хамгийн цөөн шагай авсан хүний шагайны тоотой тэнцүү хүний шагайгаар хүн бүр нийлнэ эсвэл хамгийн сүүлийн шагайг авсан хүний санал болгосон тооны шагайгаар нийлж толоомыг үргэлжлүүлнэ. Ийнхүү бүх шагайг хураасан хүн хожно.

Хулт найрах: Энэхүү тоглоомийг гурван шагайгаар хэдэнч хүн найрч болно. Тоглохдоо:

- гурван шагайн ижил буюу хонь ямаа буувал- 3 оноо
- хонь ямааны хоёр нь ижил дүрс нэг нь сондгой буувал- 2 оноо
- ижлийг нь инцдэж нэг сондгой дүрсийг нь адилхан дүрс тусгавал- 3 оноо
- нэг моринд-2 оноо
- нэг тэмээнд-3 оноо
- гурван моринд-6 оноо
- гурван тэмээнд-9 оноо авах байдлаар тоглоно. Тоглоом эхлэхэд хэдэн оноогоор хожил авахаа тохиролцно.

⁹Аюуш Ц. Дөрвөд // БНМАУ-ын угсаатны зүй. II боть. Ойрадын угсаатны зүй (XIX-XX зууны зааг үе). Эрхэлсэн С.Бадамхатан. УБ., 1996. тал. 82-83.

Дөрвөн зүс найрах-I: Дөрвөн зүс найрах тоглоом нь дотроо 2 төрөлтэй.

I. Энэ тоглоомоор тоглогчид эхлээд байгаа бүх шагайг тэмээ, хонь, ямаа, адуу болгож тэгш тоогоор өрнө. Үүний дараа тоглогчид дөрвөн шагайг нар зөв эргүүлэн ээлж ээлжээр найрч, ямар дүрс тусна тэр дүрстэй адилхан нэг нэг шагайг өрсөн шагайнуудаасаа өмч болгон авах замаар бүх шагайнуудыг хуваан авч энэ тоглоомын эхний шат дуусна. Дараа нь өрсөн шагайнуудаас сүүлчийн шагайг авсан тоглогч өөртөө байгаа цөөн дүрсээ олшруулахын тулд тэр шагайнаасаа өөрийнхөөхүссэн тоогоор авч бусад тоглогчдоос мөн тийм тооны шагай авч нийлүүлэх замаар тоглон тоглосоор өмчгүй болсон тоглогч толоомоос хасагдан хамгийн сүүлд хэн бүх шагайг авна, тэр хүн тоглоомийн хожлийг авна. Гэхдээ гурван хонь ямаагаар нэг морийг хоёр хонь ямаагаар нэг тэмээг нөхнө.

Энэ тоглоомын өөр нэг хувилбар нь анхан өрсөн бүх дүрсээ эргүүлэн өрж дуусах замаар хэн түрүүлсэн нь өмч болгон авсан шагайгаа дууссан нь хожигдох зохих хөрөнгөтэй үлдсэн нь хожлийг авдаг байна¹⁰.

Дөрвөн зүс найрах-II: Дөрвөн зүс найрах гэдэг нь дөрвөн бэрхийг хэлдэг байна. Энэ тоглоомыг тоглохын тулд шагайнууд дотроос дөрвөн зүс босож чадах шагайг сонгон авна. Үүнд зөв эргүүлэг /дэл/-тэй шагай авч дөрвөн зүс болгон цувуулан тавиад тэр хэвээр нь дөрөв дахин тавихад дөрвөн зүс байдлаа алдахгүй байх тийм шагайг сонгон авдаг уламжлалтай

Дөрвөн зүс нь 35 өөр янзаар буулгаж болохоос зөвхөн нэг л тохиолдолд дөрвөн зүс буудаг нь ховор тохиолдол юм.

Энэ тоглоомоор хэдэн ч хүн тоглож болно. Тэгэхдээ дөрвөн шагайг ээлж дарааллаар найрч хамгийн түрүүнд дөрвөн зүс тусгасан нь хожил авдаг байна.

Дөрвөн зүс орхих нь шагайн тоглоомын нэгэн төрөл төдийгүй бас аз хийморь, өдрийнхөө болон цаашдын ажил үйлийн бүтээмжийг үзэх мэргийн нэгэн төрөл болж иржээ.

Бог малын зөв талын дөрвөн шагайг орхин талуудыг морь, тэмээ, хонь, ямаа хэмээн нэрийдэж талуудын буултын тоогоор болох үйл явдлыг тааж мэдэх гэсэн бэлгэдлийн шинжээр тодорхойлж ертөнцийг үзэх үзлийн нэгэн илэрхийлэл болгож ирсэн түүхэн уламжлалтай.

Шагай цахдах: Энэ тоглоомыг бусад ястнууд шагай шүүрэх, шагалцах, шагай атгах гэж өөр өөрөөр нэрлэдэг.

“Шагай хаях” нь нэлээд эртний хэлбэрээ хадгалж явсан шагайн тоглоомын нэг төрөл бөгөөд энэ нь сүүлдээ ч “шагай сахдах” /цахдах/ гэж нэрийдэх болсон байна.

Уг тоглоом нь дээр үед ганц шагай эсвэл хэлхээтэй шагай өөд нь хаяж дэвжээнд орхисон шагайнаас хөдөлгөлгүй хаясан шагайтайгаа хамт шүүрсэн шагайны олон цөөнөөр хожлоо тооцдог байжээ. Харин сүүлдээ “сах /зураг-12/” буюу хэлхсэн төдөг /гархи/ өөрөөр хэлбэл хөө хуяг буй болсноор “шагай сахдах” гэж хэлдэг заншил дэлгэрч, улмаар “шагай хаях” хэмээх нэртэй зэрэгцэн хэлэгдэх болсон ажээ¹¹.

Хэлхээтэй шагай нь дөрвөөс таван ширхэг байна. Энэ тоглоомоор тоглоход шагай нь олон байх тусам тоглогчдын тоо олон байна. Тоглохдоо шагай шүүрэх дэвжээ засаж дээр нь шагайгаа жигд тараан асгаад дэвжээгээ тойрон сөхрөн сууж дүүмэд настайн эхэлж цах /хөө хуяг/-аа дээш нь хаяж түүнийгээ дэвсгэрт унахаас өмнө хэсэг шагайг таслаад цахаа тосон аваад дахин цахаа дээш хаян өмнө тасалсан хэсэг шагайгаа шүүрэн авч цахаа тосон атгасан шагайн дээрээ буулгана. Алдаа гаргахгүйгээр шагай атгаж чадвал түүнийгээ өөрөө авна. Ийнхүү дэс дараалан атгасаар шагай авч дууссаны дараа хүн бүр тодорхой хэмжээний тэнцүү шагай нийлүүлэн тэнцүү шагай нийлүүлэн тоглоно. Үүнийг “сүрэг нийлүүлэх” гэнэ.

Шагайг тоглоомд оруулахдаа хамгийн сүүлчийн шагайг авч чадсан хүн эхлэх болно. Үүнийг “сүүл тогтоосон” хүн гэдэг.

Шагай цахдах тоглоом нь нэлээд нарийн дүрэмтэй. Шагайг дээрх дүрмээр авсаар байгаад 8-16 орчим шагай үлдвэл тоглогчдын нэг нь нэг мөсөн атгахыг “багцлан атгах” гэнэ. Багц авахад цах буусны дараа гураваас доош шагай газарт унах буюу үлдэж болдог. Үүнийг авахын тулд атгасан шагайтай гараараа цахаа дээш шидэн уг шагайнуудыг нэг нэгээр нь түүж авна. Үүнийг “сүвлэх” гэнэ.

Тоглосоор байгаад 3-8 шагай үлдвэл хоорондон тулгын гурван чулуу маягаар тавиад нэг удаагийн авалтаар товшин авна. Үүнийг “товших” гэнэ. Мөн 3-8 шагайг цувруулан тавиад хамж авна. Үүнийг “хамах” гэдэг.

Тоглолтын явцад шагайн дууссан хүмүүс хасагдах бөгөөд эцэст нь бусдын шагайг бүрэн цуглуулсан нь хожно. Шагай цахдахдаа цахаа тогтоох, цэвэрхэн авах шаардлагатай. цах гараас унах, атгасан шагайнаас унхад шагайг авахгүй дараагийн хүнд шилжүүлнэ.

Уг тоглоомыг монголын бусад ястнуудад шагай авах, шагай шүүрэх, шагалцах, шагай атгах, андрай авах, манж таах, сумлах, шаа дуундах, шаа мацах, шагай базах, хавлах гэхчлэн тус тусын олон нэрээр нэрлэж тархжээ.

Даага уралдуулах: Энэ тоглоомоор тоглогчид эхлээд хоёроос гурван шагайг нэг гараараа дээш уралдуулан шидэж газарт унгахгүй 5-10 удаа барьж авна. Ингэж барьж авч чадаагүй нь тоглоомоос хасагдаж

¹⁰Катуу Б. Дөрвөд, баяд шагайн тоглоом // Ойрад товчоон-II. МУИС-ийн Ховд дахь салбар сургуулийн НУТ-ийн ЭШБ. УБ.,2001, тал 54

¹¹Аюуш Ц. Дөрвөд // БНМАУ-ын угсаатны зүй II боть. Ойрадын угсаатны зүй (XIX-XX зууны зааг-ий) Эрхэлсэн С.Бадамхатан. УБ.,1996, тал 82

барьж авч чадсан тоглогчид дахин 4-5 ширхэг шагайг хоёр гараараа дээшээ солбицуулан шидэж тоглоод мөн л газарт нэг ч шагай унагахгүй тоглосон хүн энэ тоглоомын аваргаар шалгардаг байна. Энэ тоглоом циркийн жонгөлёртой адилхан тоглоом юм¹².

Шагай нуух: Энэ тоглоомоор хэдэн ч хүн тоглож болно. тоглох хүмүүс эхлээд тус бүр тэнцүү тоотой шагай авна. Тэгээд өөрт байгаа шагайнаасаа таслан авч далдлан нууж таалцана. Бүх тоглогчид нуун атгасан шагайг тооцоолон нийлбэр дүнг ээлж ээлжээр бүх тоглогчид хэлж дууссаны дараа нуун атгасан шагайгаа ил гарган тоолж, хэн таасан нь авч хэн ч таагаагүй бол буцаан хольж дахин атгаж үргэлжлүүлэн тоглосоор шагайгаа дууссан тоглогч нэг удаа эрхий хуруугаа нууж тааж чадвал үрэгжлүүлэн тоглоно. Тааж чадахгүй бол толоомоос хасагдана. Цааш тоглосоор хамгийн сүүлд бүх хүмүүсийн шагайг тааж авсан схүн энэ тоглоомын ялагч болдог. Мөн энэ тоглоомыг шагайгаар тоглохоос гадна хонь, ямааны хоргос /хоргол/ болон чулуу нууж тоглодог.

Дөрвөдүүд хоргол нууж тоглоод хожил авсан хүн

Хожил манайх

Хоргол танайх хэмээн хорголоо хожигдсон хүмүүсрүү цацдаг байна.

Бөх барилдуулах: Эл тоглоомоор их төлөв хоёр хүн тоглодог. тоглоом эхлэхийн өмнө аль шагайг бөх болгохоо өөрсдөө сонгоно. Олон хүүхэд д тогловол хоёр хоёроороо оноолтоор тоглож нааддаг байна. Тоглохдоо хэн эхлэж ашагай найрахаа шодно. Шагай найрхад морь буусан нь хаяасанд тооцно. Хонь, ямаа, тэмээ буувал унасанд тооцдог. Хоёр ижил буюу хоёр морь буувал хайнцсанд тооцно.

Адуужих: Уг тоглоомоор хоёроос дээш хэдэн ч хүн тшоглож болно. тогогчид бүх шагайгаа тэнцүү тоогоор хувааж аваад, нэг нэг шагайг сонгон авч түүнийгээ ээлжлэн “адуж” гэж хэлээд найрна.

Тэр найрсан шагай нь морь дүрсээр буухад өөрийн өмч болгосон шагайгаа морь дүрсээр өрөөд байна. Тоглогчдос хэн түрүүлж бүх шагайгаа морь болгон өрж дууссан нь уг тоглоомын ялагч болно¹³.

Тэмээ цохих:Тэмээ цохих тоглоомоор хоёроос дээш хэдэн ч хүн тоглоно. Тоглохдоо тоглогчдын хамгийн дүү нь эсвэл наран ургах зүгт суусан хүн бүх шагайгаа гартаа аваад тараан найрна. Найрсан шагайнаас морь, хонь хоёрыг хос хосоор нь авч харин харин тэмээг цохиж унаган тоглодог. Тухайлбал: Бүх найрсан шагайнд 10 хонь, 5 морь, 3 тэмээ бусдан ямаа буусан бол эхлээд 5 морьтой хамт 5 хонийг түүж аваад тэмээг нэг нэгээр нь хажуунаас нь цохиж унагана. Энэ мэтээр авсан нэг шагайгаар нэг тэмээг цохиж унагаадаг. Үүнийг “тэмээ цохих” гэнэ. Тэмээг цхьсон шагайнууд дотор хонь, морь хоёр хосоороо байвал хамтад нь авчны дараа дараагын хүн үлдсэн шагайг найрч тоглоно. Тэмээг заавал цохиж унагаадаг. Харин тэмээг бүгдийн цохиж унагаж чадахгүй гартаа байгаа шагайг дуусвал дараа тэмээний тоогоор нөхөж өгөхөөр өртэй үлдэнэ. Ингэж ээлжлэн орхиж тоглосоор хэн олон шагай /хонь, морь хосоор нь/ авч, авсан шагайгаа буцааж алдахгүй сайн тоглосон нь бүх шагайг авч хожих ба хэн шагайгаа дууссан нь хожигдоно. Энэ тоглоомыг дөрвөдүүд их тогловол өрөнд орон хэмээн хориглодог байна.

Айл гэр болох: Энэ тоглоом нь чулуугаар айл гэр болж тоглох тоглоомтой төстэй юм. Уг тоглоомоор хэдэн ч хүүхэд тоглож болдог. Тоглохдоо шагай, тойн, борвийн яс, сарлаг ясаар тоглодог.

- шагайгаар морь, тэмээ, хонь, ямаа
- тойноор эмэгтэй хүн
- борвийн ясаар эрэгтэй хүн
- шилбэний сарлаг ясаар үхэр, сарлаг хийж, тоглох бөгөөд мөн шагайгаар гэр барьж тоглодог.

Айл гэр болох тоглоом нь чулуугаар айл гэр барьж тоглодог тоглоомтой ижил боловч энэ тоглоомоор гэрт шагайгаар тоглодоогоороо онцлог юм. Айл өглөө хэрхэн босдог, тэгээд цайгаа чанах, адуу малаа саах, бэлчээрлүүлэхээс эхлэн нэг өдрийн бүхэл ажил, тэр айлууд бас хоорондоо хэрхэн зочлох, энэ бүх ажилд хүүхэд том хүн ямар үүрэгтэй байдаг тэр бүгдийг орлуулан нааддаг.

Андгайцах: Энэ тоглоомоор хичээнч хүн тоглож болно. Тоглох шагай нь хэд ч байж болно. Тоглохдоо тоглогчид тус тусынхаа шагайг бэлтгээд эхний тоглогчид өгнө. Ийнхүүөгөхдөө нэг хүн хэдэн шагай өгөхөө ярилцан тохиролцоно. Шагайг алган дээрээ тавиад дээш нь хаяж бууж ирэх тэрхэн хоромд гараа эргүүлж гарынхаа ар дээр цөмийг нь тогтоохыг хичээнэ. Дараа нь гарынхаа ар дээр байгаа шагайг дахин дээшээ хаях ба бууж ирэхэд нь заавал бүгдийг нь атгаж, атгасан шагайгаа тухайн тоглогч авна. Шагайгаа авч чадсан тоглогч тоглоомыг дахин эхлүүлж хэдэн шагайгаар нийлэхийг санал болгодог. Ингэж ээлжлэн тоглосоор шагай нь дууссан тоглогч тоглоомоос хасагдаж бүх шагайг авсан тоглогч ялагч болно.

Андгайцах тоглоом нь хүний гарын хурд овсгоо самбаа, нүдний хараа, мэдэрхүйг шалгасан тоглоом юм.

Мэргэ барих: Энэ тоглоомоор хэдэн ч хүн тоглож болно. Тоглоомын бэлтгэл болгон цэвэрхэн 13 шагай сонгон авна.

Сонгож авсан шагайгаа бүгдийг нь гартаа багтаан бариад найрах бөгөөд найралт бүрд морь буусан шагайг авч тавина. Ийнхүү найралт тус бүрээс буусан морийг авч үлдсэнийг нь найрсаар сүүлд нь хэдэн

¹²Катуу Б. Дөрвөд, баяд шагайн тоглоом // Ойрад товчоон-II. МУИС-ийн Ховд дахь салбар сургуулийн НУТ-ийн ЭШБ. УБ.,2001. тал. 56-57.

¹³Катуу Б. Дөрвөд, баяд шагайн тоглоом // Ойрад товчоон-II. МУИС-ийн Ховд дахь салбар сургуулийн НУТ-ийн ЭШБ. УБ.,2001. тал. 55.

шагай үлдсэн байна. Түүгээр нь мэргэлдэг ажээ. Эцэст нь шагай үлдээгүй буюу гурваас цөөн үлдсэн бол сайн, гурваас олон үлдсэн бол муу тааруу мэргэ буулаа гэж үздэг.

Дөрвөдүүд бага хүүхдийг мэргэн зөнч байдаг гэж үздэг бөгөөд “мэргэ барих” тоглоом нь нэг ёсондоо мэргэлэх явдал юм. Ийнхүү арвангурван шагайгаар тоглодог нь 13-ын тооны бэлгэдэл буюу алтайн 13 сан, 13 алтай 33 хөхий гэх мэт нутаг усны онцлогийг гаргасан байж болох талтай.

Ийнхүү дөрвөдийн шагайн төрлийн тоглоом нь тухайн ястаны оршин амьдарч буй ахуй нөхцөл, түүхэн хөгжлийн онцлогийг тусгасанөөрийн өвөрмөц онцлогтойн зэрэгцээнийг монголчуудын тоглоомын сангийн нийтлэг талыг ч өөртөө агуулжээ. Тоглоомын нэршил нь нутгийн хэл аялгууны онцлогийг тусгасан, тоглох дэг журам, билэгдэл, хорио цээрийн ёс нь өвөрмөц онцлогтойгоор уламжлагдан үлджээ.

Resume

A Variety of ankle bone games are herietated among Durvud ethnics. The game has a particular speciality which reflects historical period of Durvud ethnics. The game has its own established rule, simbol and prohibition against tradition.

ИЗУЧЕНИЕ АРХЕОЛОГИЧЕСКИХ ПАМЯТНИКОВ ГОРНОГО АЛТАЯ СОТРУДНИКАМИ СИБИРСКОГО ОТДЕЛЕНИЯ АКАДЕМИИ НАУК СССР В 1960-Е ГГ.

Т.С. Паршикова ФГБОУ ВПО «Алтайский государственный университет»,
кафедра археологии, 8(3852)298103, taty-parshikova@yandex.ru

История археологических исследований в отдельном регионе является составной частью не только становления и развития археологии России, но и истории археологии как научной дисциплины. Изучение истории археологии Алтая необходимо для выявления закономерностей её развития, оценки накопленного материала и определения перспектив дальнейших исследований.

Важным событием в истории археологии было создание в 1957 г. Сибирского отделения Академии наук СССР, и в частности, выделение в его структуре в 1964 г. Института истории, филологии и философии (ИИФФ СО АН СССР) под руководством А.П. Окладникова. В области археологии возникновение Института имело положительные последствия – усилился процесс подготовки профессиональных археологов через систему аспирантуры ИИФФ и Новосибирского государственного университета, расширился диапазон экспедиционных исследований, опирающийся на материальную базу Института, появилась дополнительная издательская база, а также постепенно ИИФФ сформировался как центр проведения научных конференций [10, с. 281–283].

Во главе Института стоял известный исследователь сибирский древностей – А.П. Окладников. К моменту своего первого приезда на Алтай в 1961 г. Алексей Павлович имел богатый опыт поиска и изучения древних культур Северной, Центральной, Восточной и Средней Азии.

Начало его работ в Горном Алтае было связано с открытием палеолитического местонахождения на р. Улалинка, в черте города Горно-Алтайска, которое А.П. Окладников впоследствии назвал одним из своих звездных часов наряду с исследованным палеолитическим поселением Буреть на Ангаре и погребением неандертальского человека в гроте Тешик-Таш в Узбекистане [6, с. 3, 245]. Отметим, что именно на Улалинке Алексей Павлович закончил свои профессиональные исследования, там состоялась его последняя экспедиция (1981 г.).

Некоторые детали открытия Улалинки описаны ученым в его книге «Открытие Сибири» в разделе «На крутом Улалинском холме» [11, с. 87–120], а также освещены в фундаментальном издании – первом томе пятитомной «Истории Сибири» [3, с. 41–43].

В 1969 г. на Улалинке проводились раскопки, которые дали материал, сходный, по мнению А.П. Окладникова, с галечными культурами Индии и Африки. В них принимал участие А.П. Уманский, начавший в это время свое сотрудничество с известным ученым. В последующем А.П. Окладников способствовал публикации материалов памятников Алтая, исследуемых преподавателем БГПИ [16, с. 198].

Южнее Горно-Алтайска, на р. Катунь, в устье р. Куюм, Е.М. Берс (под руководством А.П. Окладникова) в 1963 г. провела раскопки в том месте, где в 1930-е гг. исследовались могильник и погребение афанасьевской культуры [15, с. 304–306]. На памятнике выделено четыре различных литологических слоя, содержащих каменные орудия. Основными находками были нуклеусы, скребла, скребки, долотовидные орудия и проколки. А.П. Окладников рассмотрел каменный инвентарь как «единое, типологически выдержанное целое» и отнес поселение Усть-Куюм к наиболее позднему этапу палеолита [13, с. 66–79]. В этом же году было обследовано местонахождение каменного века на р. Баранголе [21, с. 19].

Стоит упомянуть еще одно открытие, связанное с именем А.П. Окладникова. В 1964 г. Олег Максимович Адаменко сделал интересную находку в отложениях левого берега р. Алей в Рубцовском районе Алтайского края у с. Бобково. Пластина (по определению А.П. Окладникова – леваллуа-мустьерская)

залегала вместе с древесными угольками, обломками бивней мамонта и двумя рогами бизона на глубине 5 метров. В своих воспоминаниях О.М. Адаменко описывал момент, когда он нашел артефакт вместе с множеством палеонтологических остатков (кости мамонта, шерстистого носорога, зубра). Главным была ножевидная пластина из рудноалтайского фельзит-порфира, длиной 9 и шириной 4 см., с явными следами обработки [12, с. 373–376]. Возраст этой находки стал предметом споров специалистов [1, с. 25–26]. Так сам О.М. Адаменко считал находку раннепалеолитической (60–70 тыс. лет назад). Специалист по геологии палеолита Северной Азии Семен Маркович Цейтлин [18, с. 157–157; 19, с. 67–73] высказал иное мнение, относя пластину к периоду позднего палеолита.

Аналогичная находка была сделана при производстве инженерно-геологических работ в верховьях левого притока Чарыша – на р. Белой. На глубине 8 м в лессовидных суглинках горного склона найдена массивная ретушированная пластина и обломки трубчатых костей млекопитающих [20, с. 101–102].

Так или иначе, открытие памятников каменного века геологами Западносибирского управления в 1960-е гг. носило планомерный характер. В указанный период ими было открыто еще 6 местонахождений, которые также датируются палеолитическим временем [1, 21 и др.].

Из крупных экспедиций, работавших в 1960-е гг. в Горном Алтае, стоит назвать работы Горно-Алтайского отряда Института истории, филологии и философии СО РАН под руководством Е.М. Берс, которая в 1964–1965 гг., 1969 г. возобновила исследования на Усть-Куюмском могильном поле, где ею же в 1963 г. изучалась стоянка каменного века. Отряд продолжал начатое в 1930-е гг. исследование могильника Усть-Куюм [2]. Археолог справедливо полагала, что памятник является разновременным, а погребения в каменных ящиках принадлежат более позднему времени [2, 17, с. 158–161]. Это удалось подтвердить в 1980-е гг. после раскопок могильников «раннескифского» времени [4]. Также были продолжены раскопки разновременного поселения [14, с. 11]. Публикуя часть своих находок из Усть-Куюма Е.М. Берс [2, с. 18–31] приводит краткие сведения об исследовании этого памятника, полученные ей из архива Г.П. Сосновского, а также из дневников Г.П. Сергеева и указывает на то, что погребальные конструкции в то время были изучены не полностью и детали их устройства плохо отражались в описаниях и на чертежах [2, с. 19]. Кроме этого, в статье изложены не только результаты полевых наблюдений, но и некоторые соображения по общим вопросам развития афанасьевской культуры. Весьма важен, к примеру, на тот период времени был вывод Е.М.Берс о том, что по обряду захоронения афанасьевская культура походит на культуру древнего населения Северного Кавказа [2, с. 28].

Некоторые новые материалы раскопок на Усть-Куюмском могильном поле в 1960-е гг. были опубликованы в монографии по эпохе энеолита и бронзы Горного Алтая [14, рис. 60–66]. В настоящее время Усть-Куюм является одним из наиболее исследованных по количеству погребальных сооружений памятников афанасьевской культуры. Он дал уникальный, во многом необыкновенный материал, поэтому перспективно дальнейшее его исследование [14, с. 137].

Большие по объему работы проводились в 1968–1969 гг. Акташским отрядом Алтайской экспедиции Института истории, филологии и философии СО РАН и Кемеровским педагогическим институтом в зоне предполагаемого затопления Чуйской ГЭС (на берегу р. Чуи в Улаганском районе Горно-Алтайской автономной области, в 12–17 км от поселка Акташ в сторону Кош-Агача). За два года в урочищах Боротал, Алагаил и Тербедек было раскопано 62 разновременных кургана (от «раннескифского» до тюркского времени) (47 в Алагаиле, 12 в Боротале и 3 в Тербедеке) из 292 зафиксированных. Общая характеристика исследованных в это время объектов была приведена в статье 1985 г. [9, с. 147–172]. Как отмечается, большинство курганов было разграблено еще в древности, поэтому авторы приводят описание только тех объектов, которые содержали определенный вещественный материал [9, с. 148–151]. Памятники отнесены к пазырыкскому времени.

Информация о курганах Боротала, Алагаила и Тербедека содержится в монографиях по скифскому времени [4, с. 25; 5]. Помимо этого, некоторые неопубликованные в 1985 г. материалы приводятся в монографии В.Д. Кубарева и П.И. Шульги [8].

Работы в данном районе в последующее время были также продолжены сотрудниками ИИФФ СО АН СССР.

С 1968 г. обширные исследования разнообразных памятников эпохи ранних кочевников начал производить В.Д. Кубарев (сотрудник ИИФФ СО РАН). В 1968–1969 гг. на Уландрыкском могильном поле и в урочище Туру-Алты (Кош-Агачский район) начали изучаться и позднее опубликованы курганы, большие керексуры, "оленные" камни и петроглифы. В 1990-е годы В.Д. Кубарев продолжил работы в этом районе совместно с Э.Якобсон, Я.А.Шером и А.П.Франкфором и др. [7].

Создание в Новосибирске СО АН СССР и выделение в его структуре гуманитарного отделения в виде ИИФФ существенным образом расширило диапазон археологических исследований как на территории Сибирского региона в целом, так и на Алтае в частности. Всего в 1960-е гг. от Института на данной территории начали проводить работы три крупных экспедиции, продолжавших свои изыскания в 1970-е–1990-е гг.

ЛИТЕРАТУРА И ИСТОЧНИКИ

1. Адаменко О.М., Гайдук И.М. О новых находках палеолита в предгорьях Алтая // Известия Алтайского отдела Географического общества Союза СССР. – Барнаул: Алт. кн. изд-во, 1967. – Вып. 8. – С. 24–28.
2. Берс Е.М. Из раскопок в Горном Алтае у устья р. Куюм // Бронзовый и железный век Сибири. – Новосибирск: Наука, 1974. – С. 18–31.
3. История Сибири с древнейших времен до наших дней. Т. I: Древняя Сибирь. – Л.: Наука, 1968. – 454 с.
4. Кирюшин Ю.Ф., Степанова Н.Ф., Тишкин А.А. Ч. II. Скифская эпоха Горного Алтая. – Барнаул: Изд-во Алт. ун-та, 2003. – 234 с.
5. Кирюшин Ю.Ф., Тишкин А.А. Скифская эпоха Горного Алтая. Часть I. Культура населения в раннескифское время. – Барнаул: Изд-во Алт. ун-та, 1997. – 232 с.
6. Конопацкий А.К. Прошлое великий следопыт: Академик А.П. Окладников. Страницы биографии. – Новосибирск: Сибирский хронограф, 2001. – 492 с.
7. Кубарев В.Д. Древние кочевники Восточного Алтая. Автореф. дис. ... канд. ист. наук. – Новосибирск, 1997. – 29 с.
8. Кубарев В.Д., Шульга П.И. Пазырыкская культура (курганы Чуи и Урсула). – Барнаул: Изд-во Алт. ун-та, 2007. – 282 с.
9. Мартынов А.И., Кулемзин А.М., Мартынова Г.С. Раскопки могильника у поселка Акташ в Горном Алтае // Алтай в эпоху камня и раннего металла. – Барнаул: Изд-во АГУ, 1985. – С. 147–172.
10. Матюшенко В.И. 300 лет истории сибирской археологии. – Омск: Изд-во Ом. гос. ун-та, 2009. – 550 с.
11. Окладников А.П. Открытие Сибири. – М.: Молодая гвардия, 1981. – 223 с.
12. Окладников А.П., Адаменко О.М. Первая находка леваллуа-мустьерской пластины в среднелепистоценовых отложениях Сибири // Четвертичный период Сибири. – М.: Наука, 1966. – С. 373–382.
13. Окладников А.П., Владыкин В.А. Древнее поселение на реке Куюме (Алтай) по раскопкам 1964–1965 гг. // Известия лаборатории археологических исследований. – Кемерово: Кем. кн. изд-во, 1967. – Вып. I. – С. 66–79.
14. Погожева А.П., Рыкун М.П., Степанова Н.Ф., Тур С.С. Эпоха энеолита и бронзы Горного Алтая. Ч. 1. – Барнаул: Азбука, 2006. – 234 с.
15. Сосновский Г.П. Ойротская автономная область // Археологические исследования в РСФСР 1934–1935 гг. – М.; Л.: Изд-во АН СССР, 1941. – С. 304–305.
16. Тишкин А.А. Встречи с А.П. Уманским // Вопросы археологии и этнографии Сибири: памяти профессора А.П. Уманского. – Барнаул: БГПУ, 2008. – С. 179–207.
17. Худяков Ю.С., Мороз М.В. Раскопки Куюмского могильника Е.М. Берс в 1969 г. // Хронология и культурная принадлежность памятников каменного и бронзового веков Южной Сибири. – Барнаул: Изд-во Алт. ун-та, 1988. – С. 158 – 161.
18. Цейтлин С.М. Геология палеолитического местонахождения Бобково (результаты новых исследований) // БКИЧП. – 1974. – № 41. – С. 157–159.
19. Цейтлин С.М. Геология палеолита Северной Азии. – М.: Наука, 1979. – 284 с.
20. Шиперович В.Я. Палеолитическая находка в юго-западном Алтае // БКИЧП. – 1960. – № 25. – С. 101–102.
21. Шуньков М.В. История изучения палеолита Алтая // Археологические исследования на Алтае. – Барнаул: Изд-во Алт. ун-та, 1987. – С. 9–32.

БАРУУН МОНГОЛЧУУДЫН ТҮҮВЭРЛЭХ АЖ АХУЙН УЛАМЖЛАЛ

Г. Пүрэвдорж
Доктор (Ph.D), дэд проф, ХИС-ийн НХУС-ийн
Түүхийн тэнхимийн эрхлэгч, e mail: purevdorj_73@yahoo.com

Хүн төрөлхтөн мал аж ахуй, газар тариалан эрхлэхээсээ өмнө байгалийн хатуулаг шинжтэй (чулуу, мод, яс гэх зэрэг) зүйлсийг ухамсартайгаар дүрс хэлбэрийг нь хувирган өөрчилж, ургамлын үндэс ухах, жижиг биетэй амьтад болон үр төлийг нь агнах гэх мэтийг үйлдэхэд өргөн дэлгэр ашиглаж байсныг анхдагч буюу өвөг аж ахуйн үндэс суурь тавигдсан гэж үздэг¹⁴. Монгол нутагт амьдрагсад лавтайяа шинэ чулуун зэвсгийн үеэс газар тариалан эрхэлж эхэлсэн болох нь археологийн судалгаагаар нэгэнт тодорхой болсон хэдий ч байгалийн эрс тэс байдал нь газар тариалан өргөн дэлгэр хөгжихөд төдийлөн таатай нөлөө үзүүлээгүй юм.

Харин <<түүх ажил>> буюу төрөл бүрийн ургамлыг өөрсдийн хэрэгцээнд зориулан түүн, боловсруулж, ашиглаж ирсэн уламжлалыг судлах явдал ихээхэн чухал бөгөөд манай тулгуур судалгааны бүтээлүүдэд Монголчуудын хоол хүнсэндээ түүн ашиглаж байсан ургамлыг зориулалтаар нь:

¹⁴ Эрт, дундад үеийн Монголчуудын аж ахуй, соёл. УБ., 2006. т- 27.

- хоол унд хийдэг ургамлын зүйлс
- хоол амтлах ургамлын зүйлс
- үр жимсний ургамал гэж ангилан авч үзжээ¹⁵.

Хоол унд хийдэг ургамлын төрлүүдээс суль, сульхирийг хэрэглэх явдал их баруун монголчуудын дунд түгээмэл. Ийм ч учраас Н.М.Пржевальский, П.К.Козлов, Э.Д. Мурзаев нарын нэрт судлаач эрдэмтэд говь нутгийн ардууд тариа орлох ач холбогдолтой суль, сульхирыг их хэмжээгээр түүн хураан хэрэглэж байгаа тухай <<говь нутгийнхны хийдэг цульхирын гурил найрлага, чанараараа манай Орос гурилаас эс дутна>> гэх зэргээр тэмдэглэсэн нь нэлээдгүй. Харин тэдгээрийг түүн боловсруулах, ашиглах арга ажиллагааны тухайд тусгайлан бичсэн зүйл ховор.

Монгол орны говийн элсэрхэг хөрсөнд хар суль(*psammochloa villosa*), цагаан суль (*leymus racemosus*), сульхир(*agrophillum pungeng*) их хэмжээгээр ургадаг нь амьжиргаанд гол нэмэр хандив болж иржээ. Хар суль(*psammochloa villosa*), цагаан суль (*leymus racemosus*) нь биологийн төрөл, түүрүүний өргөн нарийнаар ялгагдахаас биш ерөнхий хэлбэр төрхийн хувьд хоорондоо ихэд адилхан тул төдийлөн ялгагдаггүй нийтэд нь хар суль хэмээн нэрлэж хэвшсэн бололтой.

Хар суль түүх. Хар суль(*psammochloa villosa*)-ийг тарианы дээд өвөг, зэрлэг тариа гэж үздэг. Говийн элсэрхэг хөрсөнд ургадаг тариатай адилхан үет ургамал юм. Хар суль хөрсний хур чийгээр ургана. Иймээс намар оройхон бороо, өвөл нь цас ихээхэн орсон жил хар суль илүү сайн ургадаг. Намар наймдугаар сарын эхээр болц нь гүйцдэг. Болц гүйцэтлээ сүүн болц, аарцан болц, хар толгой татах гэсэн дамжлагатай. Сульны түүрүүнээс нэг тариа аваад шахаж үзэхэд сүү маягийн цагаан цэхэрдүү шингэн зүйл гарч байвал сүүн болцын үе, түүнээс арай өтгөвтөр аарцархуу цагаан зүйл гарч байвал аарцан болцын үе, харин толгойд хар түүрүү татсан байвал хар толгой татсан үе гэдэг.

Суль хар толгой татсанаас хойш тун удахгүй багцаагаар долоо хоногийн дотор болц бүрэн гүйцэх бөгөөд энэ үед түүнэ. Зарим тохиолдолд хар толгой татсан үед нь түүгээд юмаар хуучин хэд хонуулахад хүрэнгээд болц гүйцчихдэг. Гэхдээ ийн дарж болцыг нь гүйцээсэн суль нарийн шөвгөрдүү шуумгар нарийвтар, хоцор ихтэй байдаг.

Түүхдээ хутгаар ишний дунд байх нарийн үений дээгүүр тайрч авна. Тайрч авсан сулиа нөгөө гартаа тохойлдон хавчуулсаар дүүрч багтахгүй болсон үед нь газар тавина. Үүнийг нэг тохой гэнэ. Арван тохойг нийлүүлж нэг боз гэнэ. Сульны ургац сайн, идээ сайтай жил нэг бозоос нэг тогоо суль гардаг.

Хадсан сулиа дэвсгэр дээр дэлгэн тавих буюу үзүүрээр нь нийлүүлэн босгож наранд нэгээс хоёр цаг орчим байлгахад хатна. Хатмагц нь гартаа багтах хэмжээгээр ишнээс нь барьж, түүрүү хэсэг рүү нь цохиж дэвсгэр дээр үрийг нь унагана. Цохихдоо нарийн саваа мод, ташуур зэргээр зөөлөн тогших маягаар унагана. Ийн савантай сулийг ялгаж авсны дараа дэвсгэр дээр тараан 1 - 2 хоног дэлгэн сайтар хатаасны дараа модоор цохиж савангаас нь салгана. Саван гэдэг нь үрний гадна талын хамгаалагч хальсавч болох хөвсгөр зөөлөн эдийг хэлдэг. Ингэхдээ хэт хүчтэй цохиж сулиа хугалах няцлахаас болгоомжлон зөөлөвтөр цохих ба ялгарсан саванг буцаан суль руу сайтар хольж цохиж салгана.

Суль савангаасаа нь салж гүйцлээ гэж үзсэн үедээ салхинд хийсгэхэд саван нь хөнгөн учир хийсэж цэвэр хар суль нь дэвсгэр дээр унаж хоцорно. Хэд дахин хийсгэж сайтар цэвэрлэсний эцэст хар сулиа уутлан савандаа хийж авна. Хар сульнаас заавал бага зэрэг сайтар цэвэрлэгдээгүй буюу болц муутай хэсэг нь ялгарч үлддэг. Үүнийг хоцор суль хэмээн тусад нь уутлана.

Хар сулиар гурил хийхдээ юуны өмнө сайтар улайтгасан тогоонд хийн хуурна. Хуурахдаа савааны үзүүрт бөөрөнхийлөн уясан “бөмбөг”-өөр хутган хуурна. Тариа хуурагдаж гүйцсэн үедээ ерөнхийдөө хүрэнгэж зарим нь язарсан байна. Ингэмэгц тогоотой нь гарган саванд юүлээд дахин хийж хуурна. Хуурсан тариаг гар тээрмээр тээрэмдэн сульны гурил бэлэн болдог. Тээрэмдэхдээ хуурсан тариагаа хэт хөргөхгүй халуун дээр нь тээрэмдвэл хялбар байдаг.

Сульхир түүх. Сульхир(*agrophillum pungeng*) нь хур чийгтэй элсэрхэг хөрстэй газар ургадаг асар их өргөстэй хамхуулархуу ургамал. Өвөл цас сайн орсон бол зундаа сульхир сайн гадгийг ардууд олон жилийн туршлагаараа ажиглан мэджээ. Сульхирыг намрын дунд сард бор цагариг татан улайж ид боловсрох үед нь түүж эхэлдэг. Сульхир их түүдэг айлууд модчин дархан хүмүүсээр тусгай, урт шүдтэй савар хийлгэж бэлтгэсэн байдаг. Ийм савраар доод ёроолоор нь түрж ховхолж түүнэ. Саврын шүдэнд сульхирын бут дүүрмэгц хөлөөрөө гишгэж салгана. Учир нь сульхирын бут маш их өргөстэй байна. Нэг ийм том савар сульхирын бутыг бууз гэж нэрлэнэ. Нилээд түүсний дараа буузуудаа нэг дор цуглуулан тойруулан тавьж хатаана. Сульхир сулийг бодвол маш удаан хатдаг. Дор хаяж 2 - 3 хоногт, заримдаа чийг ихтэй үед 15 - 20 хонож байж хатаж гүйцдэг байна. Зарим салхи шуурга багатай, их гарсан жилээ сульхир хавар болтол үр нь унаагүй хэвээр байх тохиолдол байдаг гэнэ. Иймд энэ үед нь буюу хавар түүх тохиолдол хааяа гардаг байжээ.

Идээ нь хатаж гүйцмэгц цайруулж эхэлнэ. Цайруулахдаа том дэвсгэр дээр бууз буузаар нь хатаасан сульхираа авчран саваа модоор цохиж нүдэн иш хамхаг, өргөс зэргээс алгадаг. Ардын дунд <<янгиа>> хэмээн нэрлэдэг сульхир цохиж салгахад зориулсан тусгай модон хэрэгсэл хэрэглэгддэг байсан гэх боловч тодорхой мэдэх хүн үгүй болжээ. Сульхирны иш хамхаг, өргөс зэрэг нь салж гүйцлээ гэх үед жижиг савраар

¹⁵ БНМАУ-ын угсаатны зий.Халхын угсаатны зий (XIX –XX зууны зааг іе). I боть. УБ.,1987. т.89-100.

самрахад том хогууд нь хийсч арилна. Үлдсэн үрийг тусгайлан бэлдсэн нарийн шигшүүрээр хэд дахин шигшин шүүж хогоос нь бүрэн цэвэрлэсний дараа ууталж авна.

Сулхирын гурил хийх сульны гурил хийхтэй харьцуулбал нэлээд ажиллагаа ихтэй. Эхлээд шороолно. Шороолно гэдэг нь усаар сайтар угааж дээр нь хөвж буй хогоос нь салгахыг хэлдэг. Шороолж гүйцсэний дараа зөөлөн гал дээр буцалгана. Нэлээд буцалган дэвтээж усыг нь ширгээсний дараа хуурна. Хуурахдаа галыг нь сайн тааруулахгүй хэт их түлвэл сулхир түлэгдэж эвгүй амт ордог. Хуурсан сулхирыг тээрэмдэн гурил болгоно. Сулхирын гурил шаргал өнгөтэй байх агаад зуурахад маш их өсдөгөөрөө сульны гурилаас ялгаатай.

Суль сулхирыг гар тээрмээр тээрэмдэнэ. Тээрэм нь дээд, доод тээрэм, гол гэсэн үндсэн гурван хэсгээс бүрдэнэ. Тээрмийн нүхийг хир зэрэг зөв гаргаснаас хамааран зарамтай, нарийн бүдүүн гарах нь хамаардаг. Хуучин Засагт хан аймгийн Цэцэн сартуул хошуунд Бирваа дархан, Шагдар дархан, Уран Жанжаа зэрэг дархчуудын хийсэн тээрэм маш сайн нарийн ширхэгтэй “зарам”-гүй гурил гардаг, нэг бодын үнэ хүрдэг байжээ. Тээрэм хийх чулуу хэрхэн сонгодог байсан тухай Завхан аймгийн Дөрвөлжин сумын Онц багийн харьяат өндөр настан Ч.Лхагвийсүрэн <<Урьд манай нутгийн дархчууд Бага нуурын урд тал, болон одоогийн Ховд аймгийн Чандмань сумын нутаг Хоолойн гүүрний баруун тал зэрэг хоёр газраас чулуу сонгож тээрэм хийдэг байсан гэдэг. Яг газрынх нэрийг би сайн мэдэхгүй, мартжээ. Ерөнхий багцаалж байгаа нь энэ. Учир нь чулуу болгон тээрэм хийхэд тохиромжтой биш зөвхөн энэ газрын чулуу их сайн тээрэм болдог байжээ. Эндээс авсан чулуу улаан өнгөтэй, дундуураа бараг төө шахам хуурдаг онцлогтой. Нэлээд ухааж байж авдаг байсан гэдэг. Учир өнгөний ил чулуу амархан хагардаг. Тэр дархчууд гараараа бүгдийг цохиж хийнэ. Тэгэхээр тэр хүмүүсийн багаж зэвсэг гэж ямар ч лут юм байсан гэж боддог>> хэмээн хуучилсан билээ.

Суль сулхирын гурилыг дангаар нь зуурч, багсарч идэхээс гадна цай хайрах, махан хоолонд хөц болгох зэрэг олон янзаар хэрэглэх учир “сулхирын гурил хоол ихтэй” гэсэн үг гарсан бололтой. Мөн сулхирын гурилыг эмчилгээний зориулалтаар их хэрэглэдэг. Бөөр өвдсөн, давсаг султай хүнд сулхирын гурилыг шар тосоор багсарч зуураад бага багаар долоолгуулж хэрэглэвэл сайн байдгаас гадна шарласан, элэг томорсон зэрэгт сулхирын гурил байнга идүүлдэг байна.

Сартуул хошууныхан суль сулхирыг их хэмжээгээр түүж амьдрал ахуйдаа нэмэр нэмэр хамжаа болгож ирсэн иржээ. Завхан голын Сандагийн тохой, Бууралын Ширээгийн бөөрөг зэрэг газруудад суль сулхир их хэмжээгээр ургадаг тул жилд газар газраас хүмүүс олноор цугларан түүдэг байжээ. Завхан голоор нутагладаг олон хүүхэдтэй Жаахан Амаа гэгч амьдрал ядуу олон хүүхэдтэй айл жилдээ 70 гаруй тогоо суль сулхир түүн зөвхөн үүгээрээ амьдрал ахуйгаа залгуулдаг байсан мэдээ бий¹⁶. Тухайн үед нэг тогоо сулийг нэг охин төлгөөр, нэг тогоо сулхирыг хоёр охин төлгөөр арилждаг байсан гэх мэдээ бий.

Мөн алс хол аян жинд явах тэр ч байтугай дайн байлдаанд явах үед хамгийн сайн хоол хүнс нь суль сулхирын гурил болдог байсан аман мэдээ баримт олон бий. Үүнийг тэрлэгч миний эх Х.Ролжинжав <<намайг бага байхад миний авга лам Чойжоог эсэргүү хэмээн баривчилсан юм. Манай аав ээж өмнө нь барих гэж байгаа гэдэг сураг дуулчихсан байсан бололтой. Ингээд шоронд орох гэж байгаа хүнд ямар хоол унд өгч явуулалтай биш. Тэртээ тэргүй хураагаад авчих хойно. Гайхаж гайхаж нэг арга сэдэж. Тэр нь өмсөж явах дээлийнх нь хормой дагуулан шар тостой багсарсан сулхирын гурил хийгээд мэдэгдэхээргүй хавж оён бэлдэх арга байж. Дотоод яамныхан намар барьж авч яваад хавар нь суллаж тавьсан юм. Шоронд байхдаа өдөрт өл залгах хэмжээгээр ганц халбага хиртэй долоон иддэг байсан гэдэг. Сүүлд манай авга лам тэр сулхирын гурил л миний аминд орсон доо гэж ярьдаг байлаа >> хэмээн хуучилж байхыг олонтаа сонсож байлаа.

Эцэст дүгнэхэд байгалийн зэрлэг тариа болох суль сулхир нь эртнээс монголчуудын хоолны чухал төрөл зүйл болж ирсэн бөгөөд эдүгээ ч хэвээр байна.

БУХ НООЛДААН

Д.Цэрэндондог

Монголын үндэсний дээд сургуулийн багш

Монголын ард түмний эртний тулааны нэгэн төрөл болон биеийн тамирыг сайжруулах дасгал болох бух ноолдааны талаар энэ удаагийн илтгэлээ та бүхэнд толилуулж байгаадаа баяртай байна. Ямар учраас энэ сэдвийг сонгов гэж та бодож байгаа. Тийм учраас би та бүхэнд илтгэлийнхээ өмнө бяцхан оршил хэлбэ. Би үндэсний үзэлтэй хүн, эрт эдүгээн өвөг дээдсүүдээрээ бахархаж тэнгэрт ч гал газарт ч гал дүрэлзүүлж явсан одоо маргааш ч магад явах монгол хүн гэдгээрээ бахархаж явдаг. Харамсалтай нь өнөөдөр жирийн монгол хүнийхээ хувьд Монголоо боддоггүй зарим хүнийг харахад:

Амгалан нуурын галуу хэрээний сүргэн дотор үзэсгэлэнгүй

¹⁶ Пирэвдорж Г. Сартуулын угсаа-түүх, уламжлалт аж ахуй, соёл. (Түүхийн ухааны доктор /Ph.D/-ын зэрэг гортлсон зохиол) УБ.,2008. т-102.

Ажнайн хурдан хүлэг илжигний сүргэн дотор үзэсгэлэнгүй

Уулын цагаан арслан үнэгний сүргэн дотор үзэсгэлэнгүй

Ухаан саруул мэргэд тэнэгийн сүргэн дотор үзэсгэлэнгүй.

гэсэн Билгийн гал модон хэмээх шастираас эш татаж Монгол маань агуу шүү? гэдгийг зөвхөн Бух ноолдаан бөхөөр жишээ болгож илтгэл тавьж байгаа юм. Тэдгээр хүмүүс ойлгоосой л гэж бодож байна. Ингээд та бүхэндээ бух ноолдааны талаар товчхон илтгэлээ эхэлж байна.

Эрдэмтэдийн судалсанаар Дунху аймгийн холбоо оршин тогтнож байсан элэр балар цаг үед бух ноолдоон байсан бөгөөд барилдаж байсан нь Хүннү гүрий үеийн судалгаагаар тогтоогдож байгаа. Энэ нь 8000 жилийн тэртээг хэлэж байгаа юм. Ойрд Монголчууд овоо тахих, Даншиг наадам 10 засгийн наадам, Үрсийн наадамд бух ноолдооноор барилдсаар ирсэн түүхтэй юм. Өөлд, Урианхай, Захчин, Торгуудын 27 хошуу, Дөрвөдийн 16 хошуу, Баядын 10 хошуу нийлж наадахыг Үрсийн наадам гэж нэрлэдэг. Энэ наадам нь Ойрд Монголын хамгын том наадаан. Наадмын талбайг торгон элс, зөөлөн шороо элстэй зүлэг сайтай газрыг сонгож барилдана. Бөхийн толгойг 4 алд өргөн сайн элдэж зөөлрүүлсэн сураар ороож уяад хоёр засуул нэг үзүүрээс нь барьж чирэгдсэн дүр үзүүлэх нь буханд чирэгдэж явааг харуулна. Харин чирч яваа бөх дэвээ шаваагаа их сүртэй хийх бөгөөд асрын өмнө очиж гурван удаа шороо цацах үйлдэл хийх нь ороо нь орсон үедээ бухын урд хөлөөрөө шороо самардаж урамдаж байгаа үйлдлийг харуулж сүрийг үзүүлээд, гуяа алгалан учраа бөхтэйгээ барилдаж эхэлдэг. Судалгаагаар энэхүү бух ноолдоонд барилдах бөх зөвхөн шалбуур өмд өмсөж, цээж нүцгэлэн зууралдан, дал шороодуулан дийлсэн, дийлдсэнээ үздэг. Тийм ч олон бөх барилдахгүй бахлуур арван, дунд арван, адаг арван гэж 3 ээлж болгон барилддаг юм. Бөхчүүдэд өгөх хоол нь хүртэл ялгамжтай байдаг.

Тухайлбал: бахлуур аравны бөхөд дал дөрвөн өндөр, дунд аравны бөхөд сээр, хүзүү, адаг арваны өд шаант, богтос, чөмөг өгдөг ба өөр хошуу аймгаас ирсэн бөхчүүдэд дотор мах гэдэс голдуу өгнө. Өөр хошуу аймгаас ирсэн бөх давбал дараагийн арванд дэвшин барилдана. Өгсөх арваны барилдаанчдын дунд заавал сайн бөхчүүдийг тээг болгон тааруулдаг, эдгээр бөхчүүд нь шинэ бөх буюу өөр аймгийн бөхчүүдэд саад хийдэг учир Тээг бөх гэж нэрлэгддэг байсан. Шалбуур өмд болон шуумагыг бухын магнайн арьсаар хийдэг. Мөн бугын арьс, тэх, сэрхийн арьсыг ч элдэж хийдэг. Шалбуурын өнгийг заавал ухаа хонгор өнгөтэй болгодог. Шалбуурын дээд зах хоёр шуумгийг гадна талруу нь харуулан хоёр хуруу орчим нугалан оёод, дотор талаар нь эр хар сур гүйлгэн уяа бэлтгэдэг. Шуудгийг хоёр ташааны орчим суран оосороороо чангалан уядаг ба шалбуурын захыг урд талаас нь сураа чангалан уядаг юм. Шалбуурыг бэх бат болгохын тулд бүдүүн шөрмөсөн утсаар тойруулан хэрж бөхөлдөг. Энэ ноолдооны мэх болоод дэг ёс жаяг нь эртний утгаа нэг их алдаагүй болно. Энэ ноолдооны бодит түүхэн хүний нэг Очир овогтой Түгж заан юм. Энэ алдартай хүн 1908 онд Баатар Бээсийн хошуунд төрж, бага наснаасаа хүрээ хийдэд шавилан сууж, баруун Монголын өшиглөөн ба банди зодооноор хичээллэхээс гадна бух ноолдооноор барилдаж эхэлжээ. 1930 онд хар болж жин тээж Бээжингээс нутагруугаа олон ч удаа явсан байдаг. Нэг явалтандаа жин тээж яваад буудлаж суутал Османы 4 дээрэмчин дээрэмдэхээр ирэхэд нь 70 кг-ын 4 шуудай хэлхээтэй гурилыг нэг гараараа өргөөд нөгөө гараараа балиус бариад өөдөөс нь босоход 4 дээрэмчин зугтаж байсан гэдэг. Энэ алдарт бөх Арван баядын хошууны түрүү аваргыг олон удаа авч байсаныг гэргий Жавзан үр хүүхдүүддээ ярьж байсныг 8 дахь хүү Т.Отгонбаяр хуучилж ярьсан билээ. Мөн Баатар Бээсийн хошууны улаан гуят Жамбал нь Даншиг болон Үрсийн наадамд олон түрүүг авч байсан байдаг. Бух ноолдоон бол их харгис шинжтэй бөх юм. Эсрэг бөхийнхөө чихийг хуулах, хамрын арьсыг сөхөх, өчих, ачих, өшиглөх, өмсөх, өвдөглөх, сээрэн дунгуйдах, салтаадах, баглах гэх мэт харгис мэх ихтэй ба далаар нь цэвэр дарж ялдаг барилдаан байж. Хувьсгалын дараа анхны долоогийн нэг Ерөнхий сайд байсан Догсомын Бодоо очиж энэ бөхийн барилдааныг харгис байна гэж хориглосон. Үүнээс хойш 90 жил энэ барилдаан болоогүй. Барилдах ёс журам, засуул шүүгчид нь өөрийн гэсэн дэг жаягтай бөхчүүд сарын өмнөөс бэлтгэлээ эхэлдэг тусгай асар майханд хэд хэдээрээ гал болон орно. Хөлийн сайдууд гол асрын эсрэг талд эрэн асарт орж сууна. Засуулууд урьд нь барилдаж явсан хүмүүс байх ёстой. Барилдаан эхлэх цаг болоход хар шар бөхчүүд зодоглоод гэж хашиграна. Нэртэй том бөхийг хоёр хүн сураар оосорлон, хоёр талаас нь татаж явдаг. Уг бөх нь чирсэн хоёр хүнийг чирж татсан маяг үзүүлэн орж ирнэ. Баруун зүүн талын засуулчид бөхийн суран оосор нөмрөгийг авч тавихад төв асарлуу дэвээгээ хийж очдог дэвээ нь Өвөр монголын бөхчүүдийн дэвээтэй адил. Асрын өмнө очиж зүүн гараараа шороо авч дээш өргөж толгой дээрээ өргөн хойш цацаж ёс хийх нь ороо нь орсон бухын хөлөөрөө газар самардаж байгааг илтгэнэ. Үүны дараа гараа саравчлан эсрэг бөхөө хайж буй дүрийг үзүүлэн барилдаж эхлэнэ. Засуулчид атга барим уртаараа алганы гурван төө хулсан саваа барьж засна. Ялахдаа далаараа цэвэр тавих эсхүл гар хөлийг нь баглаж боогоод толгойгоор нь газарт хүргэн гурван мөч болгоод ялсанд тооцдог. Гэхдээ засуулууд нэг хоёр, нэг хоёр, нэг хоёр гэж гурван удаа хэлсэн байх шаардлагатай. Хэрэв бие биенээ дийлэхгүй тохиолдолд хоёр бөх бие биенээ толгой дээгүүрээ аргаш нь гурван удаа давуулан шиднэ, хэн нэгэн нь давуулж чадаагүй нь ялагдана. Эртний бидний энэ барилдаанаас Япон болон Оросын, дундад азийн бүх бөх үүсэлтэй Японы эртний Жюү жюү цү нь японы цэргийн эрдмийн нэг төрөл ба жүдогийн өмнөх үеийн барилдаан юм. Нүүдэлчин монголын бух ноолдоонтой адил чих, хамарыг нь хуулах харгис мэхүүдтэй байдаг. Уг барилдаан Монголоос японы аралд хүрсэн үү? Эсвэл японоос монголруу орж ирсэн үү? Гэдэг нь тодорхойгүй ч Японы түүхч зохиолч Кизо Хираяма /2002/ “Япон” гэсэн номондоо Бидний өвөг дээдэс тодорхойгүй гэхдээ хөх толбот Монголчуудаас гаралтай гэж үзэж байна гэжээ. Учир нь Япон хүүхдүүд хөх толботой гардаг. Гэхдээ одоогоос 20 мянган жилийн тэртээ геологийн өөрчлөлт болох тектоникийн

хөдөлгөөний нөлөөгөөр арлууд нь ондоо байсан. Ази тивтэй Сахалины арал салангад бус холбогдсон байсан нь хойд зүгийн нүүдэлчид чөлөөтэй нутагшдаг байж. Хэл шинжээчид айнү хэлийг Урал, Алтайн хэлний нэгэн аймагт нэг бүлэг нь Финно Уйгар язгуурын эртний аймаг гэж үздэг. Айнүчүүд иргэншлийн хувьд нүүдлийн соёлтой анчин буюу загасчин хүмүүс ба Сахалины арлаар дамжин 83,451 км 2, Хоккайдоо, 231, 045км 2, Хоншүү арлууд дээр эртнээс нутагласан анхны уугуул иргэд юм. Сахалины арал дээрх Орокчууд, Нивхи нартай соёл, антропологи шинжээрээ Монголиод төрхт нь маргашгүй үнэн юм. Ийм учраас бух ноолдоон нь Монголоос Японы арлуудруу очсон магадлал өндөр байна. Өөр ч олон жишээг гаргаж тавих боломжтой энэ удаагийнхаа илтгэлийг дуусгаад Монгол газар нутгаас нарны цацраг адил бусад улсруу түгэж цацарсан олон соёлын зөвхөн нэг ширхэг цацарсан туяа юм шүү гэдгийг та бүхэнд хэлэх ялдамд миний энэ итгэл үнэмшлийг таны оюун ухаан шүүж тунгаан бизээ? Миний хувьд өөрийн итгэл үнэмшилдээ итгэж байгаа бөгөөд өөрөөр бодох арга алга учир нь миний оюун ухаан хязгаартай юм байна. Анхаарал тавьсанд баярлалаа.





О. Түгж зааны шуудаг

ОСОБЕННОСТИ СНАРЯЖЕНИЯ РОССИЙСКИХ НАУЧНЫХ ЭКСПЕДИЦИЙ В МОНГОЛИЮ В ПОСЛЕДНЕЙ ТРЕТИ XIX В.¹⁷

Е.В. Шелепова
АГУ, Барнаул, Россия

Во второй половине XIX – начале XX в. большинство российских экспедиций в Монголию направлялись с целью геополитического освоения региона, выявления перспектив организации в стране стационарных торговых точек. В середине XIX в. китайские власти открыли русско-монгольскую границу. В этой связи исследования в регионе приобрели более интенсивный характер. Но конкуренция со стороны западных государств, отсутствие карт заставляли уделять внимание различным вопросам освоения Центральной Азии. Всем российским отрядам было поручено составлять подробные географические и топографические карты, описания разных районов страны, их географии и геологии. В последней трети XIX обозначились возможности и необходимость научного изучения Монголии, чему способствовало развитие отечественного востоковедения. Поэтому наряду с указанными задачами подразумевалось описание народов, этнографии, археологических памятников [1. с 11].

Нутагтаа хүнд бэрх үед хошуу нутагтаа чадамгай удирдан, ард түмэн, засаг төрдөө үнэлэгдэн БНМАУ-ын бага хурлын гишүүн, Монгол ардын намын гишүүн болж байсан нь ноён Чүлтэм да ламын бас нэгэн үнэлгээ болох бизээ. Хошуу ноёдын чуулган, Улсын их бага хуралд оролцож явахдаа хурц дайчин хэлэмгий чанараараа гайхагдан Урианхайн баруун амбаны энэ ноёныг “Махан хэлтэй хүн гүйцэж хэлэлцэшгүй болтой” гэхэд өөрөө ч зөвшөөрч “Ац 2 хэлтэй эс болжим, ганц хэлтэй хүнээр юунд даруулхав” гэж суусан гэдэг.

3. Ноён Чүлтэм да ламыг хувьсгалын эсэргүү бүлэг хүч түрэмгийлэн баривчилж хойшоо хил (Хятад) давуулсан тухай:

Ардын хувьсгалаар эрх ямбаа албан тушаалаасаа хасуулсан Урианхайн баруун бэйсийн хошууны Оорцог сумын Занги Даржаа, Мянгад сумын Занги Очирбат, Ах сумын Хүнд Очиржав, Ах сумын Занги Хөх, Хүнд маарамба Тая, Мээрэн Авирраа, Залан Батдэлгэр, Ловон лам Лувсан, Цорж нарын хувьсгалын эсэргүү бүлэг хүмүүс хягаар нутгыг үймүүлж янз бүрийн ятгалга хатгалга дэгдээж, 1930 оны зуны дунд сард нутгийн 40 гаруй өрх айлыг эх нутгаас нь дүрвүүлж хятад руу нүүлгэжээ. Ноён ламыг Улсын бага хуралд оролцож явах хойгуур нь: Ард (мухар)-ын Засаг хүүхдүүдийг сургуульд, эрчүүдийг толгой дараалан цэргийн албанд явуулж, тариа тарих, мал өсгөх, оростой нөхөрлүүлж улаан намд хүчээр элсүүлэх юм байна гэх мэтээр элдэв цуурхал дэгдээн, хуучин эрх мэдэл хэргэм цолоо хятадад очиж сэргээлгэн авах гэсэн дээрх хувьсгалын эсэргүү этгээдүүдийн хүчинд автагдан орхимжоороо хүлүүлэн байж эх нутгаасаа гарчээ.

Энэ үед Чүлтэм да лам ихэд хилэгнэн уурсаж: “Ардын Засаг тогтож, эсэргүү та нарын эрх ямба цолыг чинь аль хэдийнээ эвдчихсэн бишүү одоо юунд ард олныг үймүүлэн зовоож, ардын засагт тэрсэлнэ вэ?! Унасан газар, угаасан ус, удам дамжиж буурал өвгөдөө нутаглуулсан, идээшиж дассан өвөр алтай нутгаас нь салгаж, Урианхайн хошууг, хар хятадын боол болгох гээ юу, цаана чинь ачтай Ардын засаг төр тогтож, ард олондоо ээлтэй буянтай ажил үйлс хийгдэж байгааг мангуу мунхаг толгой та хэд мэдэж байна уу?” Хэмээн агсарсан ч тал талаас нь бүчин авч орхимжоор нь хүлэн моринд мордуулж хүчээр авч явжээ.

Хошуу ноёныг нь харьяат 40 гаруй өрхтэй нь хамт нутгаас нь таслан авч хил давуулсаны дараа Урианхайн баруун амбаны Дархан бэйсийн хошуу одоогийн Баян-Өлгий аймгийн Булган, Дэлүүн сум Ховд аймгийн Дуут, Мөнххайрхан сумын нутагт үлдсэн ардууд ёстой л “Эзэнгүй албат, ишгүй хугтатой адил” гэгчээр эргэлзэж цочирдсон түгшүүрийн дунд хоцорсон байна.

4. Чүлтэм да лам эсэргүү бүлгийн хүчинд автан хятадын нутагт очсон хойно 1930 оны цагаан морин жилийн намар Улсын бага хурлын гишүүн Б.Амарт хэлсэн үгнээс:

“Надад буцаад давах нэр нүүр байхгүй болсон хүн, үд хэвийсэн настай ч гэсэн үхэх төөргөө хүртэл, нартын нарыг харж эндээл нүгэлээ наминчилхаас цаашгүй боллоо. Ардын төр гэдэг чинь аргагүйл цагаа олсон төр юмсан. Энэ төрд үнэнч явахаа андгайлсан юмсан. Улсын бага хурлын гишүүн болсон юмсан. Хэдэн барлагууд намайг ийм гаслант байдалд хүргэлээ. Хэдэн айл тасалж, Алтай давуулчихаад, хятадын харьяанд хуучин эрх ямбаа сэргээн, шинэ засаг тогтоож авах юм гэнэ. Ийм мунхаг барлагуудтай юугаач ярих билээ. Манжийн дарлалын зовлонг гэтлэж амжаагүй байтал, хятадын шаахайн ул долоож амьдрах гэсэн харалган мунхагуудын албадлага хүчирхийллээр орхимжоороо хүлүүлэн байж хүчинд автсан миний биеийг өнө хожид цагаатгах зүйл биш!

Хувьсгалын эсэргүү бүлэгтэй сумын дарга Авирмэд шиг нэгээ үзэж, тэмцэн амиа алдсан бол миний өчүүхэн нэр төр ард түмэн ардын засгын өмнө цэвэр үлдэх байсан байх. Даан ч харамсалтай явдалд учрав. Ядарч зовсон миний урианхайн ард түмэн эх нутаг, алтайдаа амар тайван жаргаж суухыг л дотороо залбирч өдөр хоногоо өнгөрөөнөм” гэжээ.

5. Ноён Чүлтэм да ламын талаар нам төрийн удирдлага зарим хүмүүсийн дүгнэлт:

- **Маршал Чойбалсан:**

Улсын бага хурлын гишүүн Б.Амарыг хүлээн авч уулзаж байхдаа хэлсэн нь: Танай тэр Чүлтэм да ламыг би мэднэ. Юманд нилээд ултай суурьтай хандмаар тайван тогтуун хүн юм билээ. Хүнтэй ярьж хөөрөх үг нь ч цэгцтэй, дэвшилт үзэлтэй, шулуун шудрага хүн гэж бид харсан.

Гэтэл хувьсгалын эсэргүү, ангийн дайсан болсон цөөхөн хэдэн хүн бүхэл бүтэн хошуу нутгийг нь үймүүлээд хил давуулж байхад, ямарч арга хэмжээ авч чадалгүй, өөрөө хүчинд автан баривчлагдан явж байгаа нь харамсалтай байна гэжээ.

- **Улсын бага хурлын гишүүн Бөөрөөн Амар:**

Нутаг ахалсан Чүлтэм да ламыг “Ноён лам” гэж хүмүүс өргөмжилдөг. Ардын төрд элэгтэй, шулуун шудрага зан чанартай, нутаг нуруундаа асар их нэр хүндтэй хүн билээ. Энэ хүнд “Ноён” гэдэг нэр байхаас биш зон олныг ноёлохын төдий ч санаа сэтгэл байдаггүй. Өмч хөрөнгө гэвэл ганц халцархай цоохор морьтой, түүгээ унаад хасаг цоохор ширдэгээ эмээлийн хойгуур хуйлж ганзаглаад мордсон байхад тэр хүний хөрөнгө нь бүрдсэн байгаа нь тэр. Нутаг ахалсан ноён хүнд өв хөрөнгө их байх ёстой гээд хөрөнгө чинээг нь асуун бүртгэх үед бичээд бай, “Ар долоон хошуу Урианхай минийх, Алтай сайхан нутаг ус минийх” гээд инээгээд сууж байдаг, ховдог сувдаг сэтгэлгүй, хүнд тусархаг, хүүхдэд ээлтэй, эмийн ургамлаар голдуу хүмүүсийг эмчилдэг, эм барьдаг, өргөл барьц барьсан хүнд уурладаг хүн байлаа гэжээ.

- **Хошуу нутагтаа занги явсан Чүлтэм да ламыг баривчлан хил давуулсан эсэргүү бүлгийн гол төлөөлөгч Хөхийн дүгнэлт:**

Чүлтэм да ламын шадар туслах явсан Зээ дүү Дансрандаа 1930 оны зун хэлж байсан дурьдатгал ярианаас:

“Чамайг ноён ламтайгаа амь нэгтэй байдагд чинь ах нь баяртай байдаг шүү дүү минь! Цаад хүн чинь (Чүлтэм да ламыг хэлж байна) ёстой ноён нуруутай, ядарсан зүдэрсэнд тусархаг, холч гярхай харцтай, жинхэнэ цагаан ястай хүн байгаа юм. Энэ хүнийг гомдоож болохгүй. Манай хэдэн мангуу Занги, Залангууд шиг малгуу хүн биш, юмны учир утгыг ухааж чаддаг, уяа зангилааг тайлж чадах увидастай, урианхайд ховор заяасан амьтан шүү хөөрхий, амт чанар сайтай цай хоолоор таслахгүй халамжилж бай. Муу нагац нь хэдэн балдарыг дагаж навсагнахаа болье” гэж бодож байгаа Алтан нутаг, Ардын засгаас холдож юу ч хожсонгүй. Нутагтаа буцаж очиж ясаа тавья гэж бодож байгаагаа нулимсаа дуслуулан байж харамсан хэлж суусан гэнэ.

6. Нутаг ахалсан ноёдтой, ноён Чүлтэм да ламыг харьцуулан үзэхэд эрс ялгаатай хүн байлаа:

Үүнд: 1. Нутаг ахалсан ноёдууд суурь сууриар мал сүрэгтэй байхад манай ноён Чүлтэм да лам, нэг ч суурь малгүй байв.

2. Олон арван айл өрх, хүмүүсийг зарцалсан, эрх ямба үүсгээгүй.

3. Өргөө гэр, ордон босгоогүй

4. Энэ нутагт баячууд нь цөөхөн, ядуу тарчиг амьдралтай нь олон байсан ба зовж зүдэрсэн ядууст тусалж, зарга өгдөг байсан учир тэд эгэл даруу ноён ламаа ихэд хүндэтгэн хүрээлдэг болсон.

5. Хань ижил, эхнэр хүүхэдгүй ганц биеэр амьдардаг байв

6. Нутагтаа хамт өссөн, Дамиран(Дансран) гэдэг эгэл хар хүнтэй үерхэж нөхөрлөдөг. Шадар туслах нь болж хоол унд, бүхийл ажил үйлсийг нь өтөл насалтлаа гүйцэтгэж, хамт өтөлсөн гэдэг.

7. Зарга, Зайлхаа шийддэг түшмэд, тахар зарц барлагуудгүй, аливаа ажил үйлсийг ард нэг бүртэй биечлэн уулзаж, чирэгдэлгүй шууд шийддэг

8. Эрх дарх эдэлсэн, элч буухай довтолгосон гэхээр элдэв ааш зан, татвар гувчуургүй, эгэл ардын хайр хүндэтгэл хүлээсэн эрдэм, билиг авьяаст лам байв.

9. Улсын бага хурлын гишүүн болж Монгол ардын намын гишүүнээр элсэж, Ар долоон хошуу урианхай, арван хоёр хэрээ хасгийн дунд “Ноён лам”, “Төр лам” нэр зүүж, айл айл дамжин бадарчин байдлаар хоноглож явдаг эзэн ноёнтон байлаа.

10. Урианхайн 7 хошуу нутаг, хүн ард нь Хятад, Орос, Монгол 3 улсын хил тогтоох явцад эдгээр 3 улсад хуваагдсан байх ба ноён Чүлтэм да лам нь монголдоо байвал эх оронч болоод, Алтай давж Хятадад нутгийнхаа хагас ар нутаг, ардуудтайгаа очиж уулзахаар эх орноосоо гарч явсан “Урвагч” болох мэт хүнд асуудалд учирсаар байлаа.

Зүй нь одоогийн БНХАУ-ын ШУӨЗО-ны Чингэл, Цагаан гол, Хөх тохой, Буурал тохой сум нутаг манай улсын Ховд аймгийн Дуут, Мөнххайрхан сум, Баян-Өлгий аймгийн Булган, Дэлүүн сумын нутаг ардууд Урианхайн баруун амбаны “Дархан бэйсийн хошуу”-нд харъяалагдаж ноён Чүлтэм да ламын харъяанд захирагдаж явсан нэг л хошуу нутгийнхан билээ.

7. Долоо хошуу Урианхайн баруун амбаны Дархан бэйсийн хошууны ноён да лам Самбуу овогтой Чүлтэмтэй холбоо бүхий түүхэн газар

Булган сумын уугуул иргэдээс 1991 онд Булган сумын бахархал болсон түүхт хүмүүсийн талаар санал асуулга, судалгаа явуулхад хамгийн түрүүнд олонхийн саналаар С.Чүлтэм да ламыг нутгынхаа хамгийн “Эрхэм бахархалт хүн”-ээр тодруулж, нутгийн азай буурал дунд үеийнхэн энэ эрхэм хүний түүхэн яриа, дурсамж, түүхт газруудаар нь мэддэг болсон юм. Чүлтэм да ламын амьдарч ажиллаж байх хугацаандаа Баруун амбаны Дархан бэйсийн хошуу одоогийн Баян-Өлгий аймгийн Булган, Дэлүүн сум, Ховд аймгийн Дуут, Мөнххайрхан сумын нутагт холбогдол бүхий түүхт газар, тахилга шүтээнүүд олон байдаг билээ. Тухайлбал:

Да лам Чүлтэмийн ахалж байсан

- Дашчойнхорлин, Дашбалжирлан хэмээх их бага хүрээний туурь балгас болон дахин сэргээсэн хийдүүд нь Булган, Мөнххайрхан, Дуут суманд одооч байна.
- Түүний 100 гаруй лам хуврагаа дагуулан тахиж байсан овоо нь Дунд жаргалант, Их жаргалант хоёрын дунд орших Тахилт хэмээх газар буй Тахилтын овоог одоо хүртэл нутгийн уугуул иргэд тахин шүтсээр байна. Уг овоо нь 3 метр шоо дөрвөлжин хэлбэртэй 1.5 метр өндөр цайвар боржин чулуугаар босгосон овоо байх ба дөрвөн талдаа 3 гураваар өрсөн сангийн жижиг овоонуудтай.
- Тахилтын овооны дөрвөн зүгт орших Арц, Бажууна тэргүүтэн ургамлыг аравнайлан хамгаалж байсан уламжлал нь өнөөг хүртэл хадаглагдан нутгийн иргэд Тахилтын арцнаас зөвхөн эмчилгээ шүтлэгийн хэрэгцээнд л хэрэглэж байдаг. Мөн Хэцүү сай, Гүрт, Их түргэн, Рашаан Индэрт хэмээх газруудад лам нарын хамгаалан аригнайлсан арц, яргай, тавилхай зэрэг ургамал ургадаг юм.
- Долоо хошуу нутгийн ноёдыг урин тахиулж байсан, Алтайн алдарт 13 овооны нэг болох “Хэргийн овоо” нь Дэлүүн, Булган сумын нутгийн зааг Түвшин нуурын өмнө талд Дэлтийн нуруунд байдаг бөгөөд наран хэлбэрийн том цогцолбор овоог энэ жил 7 хошуу нутгаараа тахихад 400 орчим хүн оролцсон билээ.
- Хошуу нутгаараа тахиулж байсан овоо Булган сумын Сэрүүний улаан үзүүрт буй гал овоо, жил бүр тахигдаж байгаа.
- Нүүдлийн сүм хийд байгуулж шавь нараа бурхан номын эрдэмд сургах, нутаг усныхаа зон олныг буяны номоор тасалдуулахгүй гэсэн үүднээс айл өрхийн байршил зуслангийн дунд нь очиж гэр Дуган байгуулж байсан газар нь одоо “Дуганаа ширэг” хэмээн нэршисэн нь Булган сумын нутагт бий. Энэ нь орчин цагийн гэрийн боловсрол олголт буюу нүүдлийн номын сангийн онцлог хэлбэр гэлтэй үйлчилгээ байв.
- Хошуу нутгийн хоорондын газрын маргаантай асуудлыг шийдэж, 2 нутгийн хилийн заагт чулуун дээр Урианхайн “Нуман тамга”, Захчины “Дэгрээ тамга” сийлж, хилийн тэмдэг болгосон газрыг нь “Тамгат” хэмээн нэрлэгдсээр байгаа билээ.
- Тухайн үедээ байгаль эх дэлхий, хүн ардаа гэсэн сэтгэлийн үзүүрт “Хар усан тохой” хэмээх газарт Булган голоос усны эх гаргаж, 10-аад км шуудуу татуулан голын эх бий болгосноос өдий хүртэл тэнд хүмүүс хадлан газар тариалан эрхэлсээр байгаа.

Алтай гэдгийн даваа" нь гэдэг дууг Чүлтэм да лам өөрөө зохиосон гэдэг билээ.

Алтай гэдгийн давааг, албан хэрэгээр давлаа
Ардын засгийн зараалыг, арай гэж гүйцээлээ
Хангай гэдгийн давааг, халтархан хараараан давлаа
Харьяат төрийн зараалыг, харайхан гэж гүйцээлээ
Эндэхийн нэгэн давааг, эрдэнэт хүлгээрээн давлаа
Энэ төрийн зараалыг, энэхэн биедээ ахдуулна
Хойн майлхын давааг, холхидог шархалаараан давлаа
Холжис гэсэн зүркийг, хошуун тандаан даатганаа
Эрчис мөрөнгийн усыг, эргэдэг шархалаараан гатална
Эргэс гэсэн зүркийг, эзэн төрдөөн даатгана
Булган голын усыг, булгидаг шархалаараан гатална
Булжис гэсэн зүркийг, бурхан тандаан даатгана
Хом ханасын давааг, хонгорхон саарлаараан давна

1. Хотон Оросын хэргийг, хоосон болгаад буцлаа гэж өөрийн үзэл бодлоо уг дуунд шингээсэн байна.

8. 1924 онд хуралдсан Монгол улсын их хуралд Чүлтэм да ламын хэлсэн үгнээс

Язгуураас эдүгээ болтол... Урианхайн долоон хошууны газар завсардан хуваасан хилгүй, холилдон суусны дотор, манай нэгэн хошууны их төлөв ба тус аймгийн дундуур нь Хойт Алтай Чингэл, Үрэмч, Хирэн, Эрчис, Хав, Ханас, Аланбаг (өленбег) Бэлчиг голуудын зэрэг олон тариалан хадлан, ой мод, жимс

тэжээл, үст, эвэрт ан гөрөөс зэрэг дэлхийн баялаг үлэмж газраа 200 илүү онд нутаглан суусан нь дэлхийн шим, ан гөрөөс зэргийг гол болгон амьдран идээшлийг олсон бөгөөд бас ч Чин улсын үед хар хасаг цутган орж ирснийг хаан эзний зарлигаар манай нутагт багтаан суулгаж жил бүр өвс бэлчээрийн хөлс, тэмээ, адуу, үхэр, хонь тус бүр зуугаадаас нижгээдийг хураан авч, бас хасаг тариа тарихад тариалангийн хөлсийг зүй зохисоор тусгай хураан авч ядууг тэнхрүүлэх ба албанаа нийлүүлэн нутаг газрын шимд түшиж аж төрөн алба залгамжилж он уджээ.

Гэтэл Чин улс мөхөж манай Монголчууд тусгай тулгар төрийг байгуулсан учираа шажин үндэс, овог язгуураа эрхэмлэж нутаг үндэс бээр дагаар орохоор эрмэлзсэн атлаа, олноо өргөгдсний 3-аар онд 200 илүү цэрэг очиж Өрөнгө, Чингэл, Цэнгэл зэрэг газраа суусан манай нэг хошууны ардуудыг тамга, захирлын хамт нэгмөсөн шилжүүлэн нүүлгэсэнд даруй дагаж манай нутаг Булган, Дэлүүн, Сэнхэр зэрэг газраа нүүн хүрч нутаглан суусаар буй.

Үүнд: Энэ газруудад тариалан, хадлан жимс тэжээлгүй бөгөөд ой мод өвс бэлчээр, өвөлжөө, ан гөрөөс зэргээр нэн ховор тулд хавчигдан тус хошууны ардууд жил бүр торгуудын нутаг Шар хулсны зэрэг газраа цөөн өрх очиж, мал бэлчээрлэн бага саг ан агнан тариа тарьж авч ирэх ба 14-р он хүртэл тэрхүү нутаг газруудад суусан хасгуудаас өвс бэлчээр тариалангийн хөлсийг урьдын удааг мөрдүүлэн хураан авсан бүлгөө.

Одоо сууринсан хасаг этгээд газар тариалангийн хөлс өгөх байтугай хараат Урианхай хасаг нэгэнт хоёр улсад хуваагдан дагасан тул энэхүү нутаг газар Хятадын газар болох учир ан үл агнуулмой, тариа үл тариулмой хэмээн хүчэрхэхийн дээр хулгайлах, булаах зэргээр хохируулан гачигдуулж, ядуу нэгэн хошууны ардууд амьдралыг олоход бэрхэд хүрч байн байсаар тэрхүү нутаг газрыг бүрмөсөн гадаадад алдвал ер хүмүүжих аргагүй, тэрч байтугай манай Урианхай нутгийн баруун хойт хязгаар Оросын нутагт зах нийлсэн уудам их бөгөөд дэлхийн баялаг үлэмж боловч цөм хятад, хасаг этгээд эзэрхэж ашиглан бүхий учрыг илтгэж, тэрхүү шим өнтэй нутаг газрыг дотоодод хамгаалан авч, ядуу урианхай хэдэн хошууны ардуудыг хүмүүжүүлэн нутаг үндсээр бүрэн бүтэн болгож тэнхрүүлхийг хүсмой.

Ноён Чүлтэм да ламын тухай товч дүгнэлт:

1. С.Чүлтэм нь: Ойрад Монгол, Алтайн урианхайн 7 хошуу нутагтаа, хошуу ахалсан “Ноён”, шашин сүм хийдийн асуудал хариуцсан “Да лам” явсан, түүхэн бие хүн мөн.

2. Ардын Засаг төрд, хошуу нутагаа төлөөлсөн элчээр оролцож, Улсын бага хурлын гишүүн болж, хязгаар нутагтаа засаг төрийн төлөөлөгч нь болж ажиллаж байлаа.

3. Ардын нам, Ардын засгийн бодлого шийдвэрийг хошуу нутагтаа хэрэгжүүлэгч, зохион байгуулагч, ухуулагч нь болж, “Монгол ардын нам”-д гишүүнээр элссэн.

4. Алтайн Урианхайн 7 хошуу нутаг. Хүн ардынхан хамт Монгол алтайн нуруугаар Хятад, Монгол 2 улсад хуваагдаж тасарч хил тогтоогдсон нь олон үеэрээ идээшиж дассан газар нутаг, бэлчээр, ах дүү, амраг садангийн холбоо хэлхээг шууд таслах боломжгүй байлаа. Хил тогтлооч нэгэн хэсэгтээ харилцан заргалдаж байсан боловч сүүлдээ “Хил даван, эх орноосоо гарсан, урвагч”, “тагнуул, туршуул” гэх мэт нэр авч хардалт сэрдэлт, хяналтанд өртөх болж. Энэ байдлаасаа олон ард иргэд хэрэгтэн болж байв.

5. Ноён Чүлтэм да лам, хошуу нутгийнхаа урьдын хэргэм цол ямбаа хасуулсан нам хувьсгалын эсэргүү цөөн тооны этгээдүүдийн хүчинд автан хүлэгдэж, Хятадын нутагт очлоо ч дараа нь эх нутагтаа эргэн ирэх, хүчин чармайлт гаргасангүй! Өндөр нэр төрөө бодож. “Буцаад очих нэр нүүргүй болов” хэмээн дотороо эмзэглэн шаналсаар хятадын нутагт хорлогдон амиа алдсан байдаг.

6. Хошуу ноёны гол баталгаа нь Тамга байдаг. Гэтэл Алтайн урианхайн олон үеийн хошуу ноёд үе уламжлан хэрэглэж ирсэн Арслан бариултай алт, мөнгөн тамгуудыг нь Ардын Засаг хураан авч. Оронд нь зэс, гуулин тамга хэрэглүүлсэнд сэтгэл дундуур явдаг байсан байж болзошгүй. Яагаад гэвэл “Тамгаа алдвал, төрөө алддаг” гэдэг билээ.

7. Ард түмэн, ардын засгийнхаа төлөө чин шударгаар амь биеэ үл хайрлан зүтгэж байхад нь хошуу нутгийнхаа хагасыг Алтай давуулан нүүлгэсэн, эх орноосоо “Урвагч”, “Хутган үймүүлэгч” хэмээн гүтгүүлж, нэр төрөө хөөдүүлсэн болчимгүй үйлдэл, буруу ташаа ойлголтонд хариу өгч, хилс хэргээс цагаатган, тууштай эх оронч, түүхэн гавъяат, хошуу ноён да лам Самбуугийн Чүлтэмийн нэр төрийг сэргээн мөнхжүүлэх нь бодит үнэнд нийцнэ.

Ноён Чүлтэм да ламд эх орноосоо “Урвагч” хэмээн хилс нэр зүүсэнд хариу болох нэгэн түүхэн зохиолд бичигдсэн шүлгийг толилуулъя

Алтай давсан нь: (Зохиогч нь түүхч Амарын Нямжав байлаа.)

Харж ханашгүй сайхан нутгаа
Хаяад нүүсэн юм урианхай хошуу
Халзан даваа, туулайт, хар нуурын эхээр
Хамар хэншүүрүүлэн нулимас унаган
Хүй тасарсан эх нутгаа орхин
Хүчинд автагдан усан нүдтэй давсан юм.

Мал нь хүртэл эргэж ирэхгүйгээр мэдсэн юм шиг
Майлж хуйлран туугаад явахгүй зовоосон юм

Харийн нутгийн дээс алхан орсноосоо хойш ч
Халуун хошуут мал нь эргэж харан хэвтдэг байсан юм
Усан нүдтэй цусан зүрхтэй хүмүүн төрөлхтөн бүү хэл
Унасан газар угаасан усандаа мал нь хүртэл хоргодсон юм.

Мяндаг тушаал эрх ямбаа хасуулсан ноёд л
Миний жинс чулуу болно гэж горьдсон юм
Алтай давж шинэ засаг байгуулна гэж архайсан юм
Ардын төрөөс зугатахдаа ард түмнийг төөрөгдүүлэн авч давсан юм.



Зур. 1. Ноён Чүлтэм да ламын 1924 онд Хятад, Монголын хил орчмын хошуу ноёдын чуулга уулзалтанд оролцох үедээ авахуулсан фото зураг

ЖА ЛАМ ДАМБИЙЖАНЦАН-ҮНДЭСНИЙ ФРОНТЫН УДИРДАГЧ

Л. Лханям (Док, проф)
Б. Бат-Эрдэнэ (Докторант)

Нэг. XX зууны 20-аад оны Баруун (Ойрд) монгол

Халх-монгол манжид дагаар орж эзлэгдсэнээс хойш ч гэсэн Үндэсний тусгаар тогтнолыг хамгаалан 70 жилийн туршид манжийн түрэмгийлэн эзлэгчдийн эсрэг эрэлхгээр тулалдсан эх оронч монголчууд бол Ойрдууд. Галдан Бошогт хаан (1644-1697), Цэвээнравдан (1697-1927), Галданцэрэн (1727-1745), Амарсанаа (1718-1757) тэргүүтэй үндэсний удирдагчид харьяат нараа удирдан газар шорооныхоо төлөө харийн түрэмгийлэн эзлэгчдийн эсрэг тэмцэлд босч, халз тулалдсан.

Тэд зэрэг дэв, отго жинсэнд нь хуурталгүй, амь бие, үр удмаа тасдуулахыг үл харгалзан тэмцсэн. Түүнд нь өширхсөн манжийн түрэмгийлэн эзлэгчид ойрдын энгийн иргэн эхчүүд, хүүхэд хөгшдийг, хоморголон баривчилж цаазалдаг, заримыг нь амьдаар нь газарт булж байжээ. Гэвч ойрдуудын сэтгэлийн эрч хүч булшлагаагүй ээ. XX зууны 20-иод оны үеийн баруун монгол (ойрдуудад)-чуудын өвөг дээдсийн эх оронч тэмцлийн цог унтраагүй, харин ч дөл болон дүрэлзэхэд бэлтгэгдэн, гал асаагчийг хүлээж байжээ.

Хятадын дарангуйллын үнсэнд булагдаж шарын шашны хогт дарагдаж <унтарсан> мэт байсан нүүдэлчид анхны цог <цэнэгийг> 1911 оны хятадын хувьсгалаас олж авсан³¹ байна. Тусгаар тогтнолоо сэргээх гэж Манж хятадын ноёрхлын эсрэг аймшиггүй тэмцэж асан манлай баатар Дамдинсүрэн, Тогтох тайж, Хайсан гүн, Баяр тайж, Бавуудорж гүн, Удай ноён зэрэг Өвөр Монголын үндэснийхээ эрх чөлөөний төлөө тэмцэгчдийн шинэхэн үлгэр дууриалал Ховдын хязгаарын ард түмний эх орныхоо тусгаар тогтнолын төлөө эрс шийдэмгий тэмцэгч уламжлалыг өдөөн сэргээжээ.

Өөр нэгэн зүйл хүлээлт Ховдын хязгаарт бодитой байлаа. Тэр нь тэсрэлт. Аливаа юмс, үзэгдэлд оршихуйн тэсвэрлэх цэг байдаг. Ховдын хязгаарынхны нийгмийн харилцаанд тэрхүү тэсвэрлэх цэг ачааллаа даахгүй болжээ. Байдлыг нүдээр үзсэн хүний тэмдэглэлийг толилуулъя. Ховдын хязгаар манжийн эзэмшилд байсан 1911 он. Амбан захирагч Цзяньцзюнь хойд хилийн харуулаа шалгахаар Увс нуурын хойд талаар Тагнын нурууны өврөөр явжээ. Амбаны шаардсны дагуу явах замын 25-30 мод газар бүрт 20-30 ширхэг цагаан гэр барих, түүний дотроос 2-3 гэрийг дотор, гадаргүй цагаан даавуугаар бүрэх, улаан цэмбэ ба хивс дэвсэх ёстой. Амбаны дагуул, харуулд зориулж хэдэн зуун агт морьд бэлтгэх, улаачийн үүрэг гүйцэтгэх зуу гаруй хүн бэлэн байх, бараа бологчдын ачаа хөсгөнд зориулж хэдэн арван тэмээ гаргах ёстой болов. Буудал болгонд Цзяньцзюний зоог ундаанд хэрэглэх 1000-1500 лан³² мөнгийг орон нутгаас гаргах ёстой ажээ. .. Ноогдолт, мал, мөнгө, хүн хүчийг хошууд хоорондоо хэл ам болж арай чамай гаргаж бэлэн болгов. Гол бэрхшээл мөнгөнд байлаа. Худалдаа наймааны улирал өнгөрсөн, мал, түүхий эд, үс ноос нэгэнт худалдагдсан тул мөнгө хаанаас ч олдохгүй болсон цаг байлаа. Ганц зам бол хятадын Да Шэн Кү ба Юань Шэн Дэ пүүсүүдэд ирэх жил хонь, үхэр өгөхөөр өр зээл тавьж мөнгө олж болох байв. Гэвч мөнгө шууд олж чадаагүй билээ.

Хилийн харуул руу явуулсан морьт, тэмээ, гэр орноороо нүүж очсон хүмүүс Цзяньцзюнийг хүлээж дэмий суухдаа нэлээд олонх нь адуу тэмээгээ алдаж үрэгдүүлэв. Дутагдсан малыг нутгийнхнаас өндөр үнээр авч төлөх хэрэгтэй болов. Эцэст нь их Цзяньцзюнь морилж ирэв.

Энэ ажилд дайчлагдаад буцаж ирсэн хүмүүс Цзяньцзюний бараа бологчдын хулсан ташуур хөөрхий монголчуудын дал нуруун дээгүүр зугаалсан тухай их яриатай ирж билээ. Зарим монгол түшмэл малгайнхаа жинсийг нуусны ачаар л албан тушаалын хүн гэж илүү бэрээдүүлсэнгүй, харин нийтийн адил гайгүй өнгөрсөн гэлцэнэ. Ялих ялихгүй юм бүхний төлөө хятадын хулсан бэрээ монголчуудын ууцан дээгүүр тачигнах ба хар тамхи татчихаад мансуурч явсан хятадын морь бүдэрснийх гэж, тэмээний ачаа нурж унасных гэж, гэр хангалттай цагаан биш байсных гэж алхам бүрд л монголчуудыг занчдаг байлаа.

Унасан морь нь хатирах, жороолохдоо муу гэж, хятадын гараас цулбуур авахдаа мэхийн ёслоогүй гэж бас жанчуулдаг байсан. Ингэнэ гэдгийг мэдээд монголчууд зориуд зузаан нэхий дээл, үстэй малгай өмсөж явдаг байжээ. Хятадад жанчуулах занал тулгармагц монгол хүн өвдөглөн сууж, толгойгоо дээлнийхээ зах руу шургуулж, том нударгатай урт ханцуйгаараа толгойгоо халхлан, аль болох чанга дуугаар өршөөл гуйн чарлах буюу эсвэл мориндоо мордоод зугатан зайлах нь дээр гэлцэнэ. Зөрж эсэргүүцэх нь дараа нь их халтай байжээ.

...Монгол улаач, түшмэдийг зодохоос гадна тэдний сайн сайн агт морьдыг шууд булаан авах ба есөн шидийн арга заль хэрэглэж нутгийн ардуудаас үлэмжхэн хээл хахууль авдаг байв. Цзяньцзюний унд хоолны зардлын мөнгөн татварч тэр болгон улсын санд ордоггүй, харин хятадын түшмэдийн ашиг завшаан болдог байв.

³¹ А. В. Бурдуков. Шинэ ба хуучин монголд. Улаанбаатар, 2001. 27 дахь талд

³² Нэг лан 36,6 грамтай тэнцэх жингийн нэгж.

Мөнгө төлөөгүй хошууны төлөөлөгчдийг барьцаанд баривчлан Улиастайд аваачих ба нэгэнт ийм явдал болбол хошууны сандарсан түшмэд хятадын Даштафи пүүсэнд байгаа бүхнээ шавхан өгч тэгээд уул хошуунаас Цзяньцзюньд төлөх өр ширийг хятад пүүс түүгээрээ хариуцан төлөх болж харин хошуунаас пүүсэнд дараа жил нь амьд мал түүхий эдээр өр төлөх бөгөөд маш хямд үнээр, жишээ нь 3 рублийн үнэтэй зүйлийг 1 рублиэр өгдөг байв. Энэ өрийг монголчууд олон жилийн турш, тэр ч байтугай автономитын үед хүртэл төлжээ³³. Тэр нутагт ойрдуудын дунд амьдарч, үйл явдлыг нүдээр үзсэн, чихээрээ сонссон хүний тэмдэглэлд ингэж буужээ.

Ховдын хязгаарынхны нийгмийн харилцаанд оршихуйн тэсвэрлэх цэг ачааллаа даахгүй болсныг Амбаны аяллын үеийн үйлчилгээний дүр зураг зэрвэхэн ч гэсэн тодорхой харуулж байна. Энэ бичвэрт нэмэлт тайлбар хийх нь илүүц юм. Гал дээр тос нэмэв гэхчээр 1911 оны 12 дугаар сарын 30-нд Богд Жавзандамба хутагтыг Монголын хаанд өргөмжилж улсын нэрийг Монгол, оны цолыг олноо өргөгдсөн хэмээн нэрлэн, Их Хүрээг улсын нийслэл болгохоор тогтон, таван яамтай засгийн газрыг байгуулсан нь Ховдын хязгаарт Үндэсний чөлөөлөх хөдөлгөөний цогийг дөл болгон бадрахад нөлөөлжээ.

Хоёр. Жа Лам Дамбийжанцан баруун монголд

Нэгэн өдөр цагаан тэмээтэй, маузер буутай, хоёр лам өмнө зүгээс ирж буусан. ...Тэдгээр лам ирсэн өдрөөсөө эхлэн нутгийн хүмүүсийн дунд өөрсдийгөө ер бусын нууцыг мэдэгч, цаг үеийн үйл явдлын тухай их юм мэддэг гэсэн сэтгэгдэл төрүүлэхийг оролдож байна гэсэн аман мэдээлэл Хангилцагийн голд суурьшсан Оросын “Центросоюз” –ын төлөөлөгч А.В.Бурдуковт хэдэнтэй иржээ.

Хориод жилийн туршид Хангилцагт суурьшсан сониуч зантай А.В.Бурдуков тэр сургаар тэднийд хүрч очжээ. 1912 оны зун одоогийн Увс аймгийн Хиргис сумын нутаг Хангилцагийн голын өндөр дэнж дээр Түмэн гүнийхтэй айлсаж гол гэрийн нь баруун талд бариастай жижгэвтэр гэр мөнөөх ламынх байж. Тэднийд түүнийг тандахаар ороход лам байрын хоёр хүн байсны нэг нь хожмын Жа Лам Дамбийжанцан, нөгөөх нь түүний туслах лам Жимбэ байжээ.

Төрх байдлыг нь ажвал : Жа Лам (1912) гэхэд 40-45 эргэм насны, тарган, чийрэг бадриун биетэй, өргөн шанаатай, зоримог байрын дугуй нүүртэй, өндөр духтай, гялалзсан нүдтэй, багавтар эвдэрсэн хамартай, тийм ч учраас жаахан гуншаадуу дуутай нэгэн эр байжээ.

Хувцаслалт нь: Жа Лам хүрэн улаан өнгийн орос драпаар оёсон, хар захтай, өргөн ханцуйтай, нударгагүй дээлтэй байх нь төвд ламтай адил боловч орос, сайн бахиал савхин гуталтай, дээлийн захны цаанаас улаан эмжээртэй хар ногоон өнгийн хуучирсан цэрэг хажлага (мундирийн зах) цухуйж харагдана.

Ярианы аялгуу : Ламын ярианы аялгуу бол халх ч биш, ойрад ч биш, холимог янзтай аж.

Эд хогшил: Гэрийн хаяанд маузер буу өлгөөтэй байх ба гэрийн хаяанд хоёр ширхэг ширэн даалин болон тэмээий тохوش байна.

Төрх байдал, эрхэлдэг ажил нь - Лам ер бус хурдан, итгэлтэй ярих ба хөдлөх ажээ. Хүмүүс гэрт орон гаран их л хөлтэй байх бөгөөд зарим нь залбиран дөхөж адис хүртэх ба лам өврөөсөө жижиг ном гаргаж сурмаг гэгч нь аргагүй адис буулгана.³⁴

Нөхөрлөлсөн нь- Жа Лам А.В.Бурдуковынхоор ирдэг болжээ. Түүнд орос талх, цөцгийн тос, ер нь орос хоол таалагдаж байжээ. А.В.Бурдуковын эхнэрээр орос цамц оёулж өмсөж, тэдний халуун усанд орох дуртай болжээ.

А.В.Бурдуков мөн оны (1912 он) зун “Сибирская жизнь” сонинд бичсэн нийтэлдээ “Энэ хүн бол маш их аялж олон юм үзсэн бөгөөд Энэтхэг, Төвд бүр Орост хүртэл удаан хугацаагаар амьдарч байсан ер бусын хүн бөгөөд Бурхан шашны номлолоор мяндаг цолтой, машид ухаалаг, зориг төгс, сэтгэлийн тэнхээтэй, оросуудыг талархан бишрдэг “ гэж тодорхойлсон байна³⁵.

Сониучлах нь: Жа Лам Хангилцагийн голд байгаа А.В.Бурдуковын суурингаар орж тэднийхээр зочлонгоо тэнд арьс ноос нийлүүлэх, жин хөсөг тээх хүмүүстэй уулзан яриа үүсгэж, нутаг орны хүн амын аж байдал, хятадын захиргаа, пүүсүүдийн үйл ажиллагааны талаар сэтгэгдлийг олзуурхан сонирхож, танддаг байлаа.

Хүрээлэл- Нутгийн иргэдийн дунд Жа Ламд мөргөж сүжиглэх нь улам бүр нэмэгдэж улмаар Дэжээлэнгийн хийдийн Их унзад лам, Дөрвөдийн Зоригт хаан, Баядын Түмэн гүн, Зоригт сайд нарын зэрэг нийгмийн өөр өөр бүлгийн төлөөллүүд тэднийд морилж, түүнтэй уулзаж нөхөрлөдөг болжээ.

Хоёр. Баруун монголчуудын хүлээлт ба Жа Лам

Жа Лам бол Шадар ван Амарсанаагийн ач юм байх, манжийн дарлалаас биднийгээ аврахаар эрт орой хэзээ боловч нэгэн цагт эргэж ирнэ гэсэн нь үнэн байж. Эргэж ирж байгаа нь энэ хүн болж таарлаа гэсэн яриа айлаас айл дамжин хөвөрч эхэлжээ. Жа Лам бугай ч өөрийгөө ... Амарсанаагийн хойт дүр гэж хялбархан ойлгуулсан байна.³⁶

Үүнд дараах гурван хүчин зүйл онцгой нөлөөлсөн. Тэдгээр нь: *Нэгдүгээрт*, эдийн засгийн олон зүйл мөлжлөг, төрийн дарангуйлалд нухлагдан зовж зүдрэх нь туйлдаа хүрсэн баруун монголын ард түмэн манжийн түрэмгийлэгчдийг эсэргүүцсэн ээлжит тэмцэлдээ босоход бэлэн болсон ч удирдан зохион байгуулагч тодроогүй, манлайлагчийн хүлээлт болж байсан цаг үе байлаа. *Хоёрдугаарт*, Шадар ван

³³ А.В.Бурдуков. Шинэ ба хуучин монголд . Улаанбаатар. 2001.33-35 дахь талд

³⁴ А.В.Бурдуков. Шинэ ба хуучин монголд . Улаанбаатар. 2001.64 дахь талд

³⁵ Инесса Ломакина. Жа Ламын толгой . УБ.Монсудар.2011. 40 дах талд

³⁶ А.В.Бурдуков. Шинэ ба хуучин монголд . Улаанбаатар. 2001.66 дахь талд

Амарсанаа 1756 онд манжийн дайчдад хөөгдөж Орос руу зугатаж хил давахдаа даваан дээр зогсоод Би эргэж ирнэ. Дөнгөлсөн гинжийг чинь тас цохино гэдгийг мэдтүгэй гэж андгайлсан, хэзээ эргэж ирэх бол гэсэн зөн билэгдлийн домогт үнэмшсэн хүлээлт бодитой байжээ. *Гуравдугаарт* Жа Лам Дамбийжанцан авьяас чадвар мөхөс, сул дорой, эгэл нэгэн ард биш, үнэхээр олон улс орноор маш их аялж, олон юм үзсэн ер бусын хүн, бөгөөд Бурхан шашны номлолоор мяндаг цолтой, машид ухаалаг, зориг төгс, сэтгэлийн тэнхээтэй, олон түмнийг өөртөө татах эрч хүчтэй нэгэн байжээ.

Манжийн дайчдад хөөгдөж яваа Шадар ван Амарсанаагийн хүмүүсийн унаа цуцаж зүдэрчявахад нь Увс нуурт цутгадаг Нарийны голд (Увс аймгийн Зүүнговь сумын нутаг) нутаглаж асан баядын ноёд тэдний унааг юулж, сэлбэсэн. Гэхэд Шадар ван Амарсанаагийн унаж явсан морь ч эцэж зогссон учир 1920 –иод оны баядын Түдэв гүний дээд өвөг болох нутгийн нэгэн ноён түүнд хурдан удамтай соёолон үрээгээ барьж өгч гэнээ. Хариуд нь Амарсанаа баярлаж талархаад шийртэй буугаа дурсган үлдээж гэнэ. Энэ шүтээн болсон нандин зүйл үнэхээр ч Түдэв гүний гэрт 1911 он гэхэд хадгалаастай байсан. Амарсанаа соёолон үрээгээ унаад цааш явсаар Хар Хяраа ууланд хүрч очиход мөрдөн хөөгч түүнийг гүйцэж очоод жадалтал Тарбоджийн морь бүдэрч жадны илд Амарсанаагийн сугаар хий бүлэгдэж Амарсанаа тэр агшинд шалмаг амжиж морио давирхад морь нь ухас хийн холджээ. Үхлээс аврагдсан уулын оройд гарч эргэж зогсоод: Тарбоджи ванд хандаж: ” хараал идсэн чиний үр удам чинь тасраг! Би баатар цагаан хааны нутгийг зорилоо! Монгол чи сонс! Би эргэж ирнэ. Дөнгөлсөн гинжийг чинь тас цохино гэдгийг мэдтүгэй!” гэж хэлээд явсан юм гэнэ. Тэр цагаас 150 жил болоход монголын тусгаар тогтнолын төлөө тэмцсэн золгүй баатрыг дурсдаг юу ч гарсангүй. Гэхдээ Амарсанаа эрт орой алин боловч амалсанаа биелүүлнэ, монголыг хятадаас аврах гэж эргэж ирнэ гэсэн хатуу итгэл Ховдын хязгаарын зон олны дунд байсаар байх ажээ³⁷ гэж академич И. Майский Бүх Оросын Эд хэрэглэгчдийн Нийгэмлэгийн Төв Холбооны Эрхүүгийн салбарын захиалгаар хийсэн судалгааны тайландаа (1921) тэмдэглэжээ.

Академич И. Майскийн энэхүү тэмдэглэл үлгэр домог төдий биш, үнэний мөртэй ажээ. Увс аймгийн орон нутгийг судлах кабинетын эрхлэгч Б. Самбуу 1957 онд Увс аймгийн Зүүнговь сумын уугуул Баянмөнх ноёны удам Цэрэндэлгэр тайжийн эгч Минчээгийн гэрээс Амарсанаа вангийн Хөө Хуяг, Цэцэн Хавсарга бууг сурвалжлан олжээ. Цэцэн хавсарга буу нь Үндэсний түүхийн музейд, Хөө Хуяг нь Увс аймгийн музейд хадгалагдаж байна. Хөө Хуяг нь 16 кг юм.

Дөрөв. Жа Лам Дамбийжанцан Үндэсний фронтын удирдагч

1912 онд Улаангомд Жалханз гэгээн, Зоригт сайд хоёр толгойлж Ховд хязгаарын онц их хурал хуралдуулж түүнд Дамбийжанцан бас оролцов. Дөрвөдийн хоёр аймгийн олонхи ноёд, урианхайн төлөөлөгчид, хятад талыг баригч Нацаг бээс, Далай хаан хоёр ч ирж оролцсон.

Онц их хурал дөрвөдийн хоёр аймгийг Халхад нийлүүлэн бэхжүүлэх, Ховдыг хүчээр эзлэн авахаар шийдэв. Урьд хаа нэг газраас ирж нийлсэн бөгөөд язгуургүй агсан Дамбийжанцангийн байдал бэхжиж, түүнд захиа хэрэм зэргийг албан ёсоор олгов. Урьд хаа холоос ирж нийлсэн бөгөөд язгуургүй агсан Дамбийжанцангийн байдал бэхжиж, түүнд зохих хэргэм зэргийг албан ёсоор олгожээ. Ийнхүү Дамбийжанцан албан ёсны удирдлагын бүрэлдэхүүнд орж хурлын дараа Ховдын орчимд ирээд байгаа Магсаржавтай уулзахаар явжээ.

Дамбийжанцан Магсаржав руу явснаас хойш удалгүй Ховд хязгаарын захирагчаар Зоригт бээс, Улиастайн захирагч бөгөөд Баруун хойд монголын ерөнхийлөн командлагчаар томилогдсон Го бээс цэргийн хүн биш болохоор командлагч болж гавьсангүй.

1912 оны хавар ноёд дээдсийн чуулган дээр тэрээр хэдийгээр хажууд нь Богд хааны томилсон, Ховдын хязгаарын цэргийн ерөнхий даамал, тэндээс гамингуудыг хөөн гаргах шууд үүрэг бүхий Зоригт Цэрэн бээс сууж байгаа ч Дамбийжанцан л хятадуудтай хийх тэмцлийг толгойлох байх гэсэн найдлага өвөрлөж суулаа³⁸

Магсаржав Ховдын тойрог, Урианхайн хязгаарт цэрэг татлага зарласан ч дайчлага явцгүй, Далай хан амбантай холбоотой учраас Магсаржавт цэрэг гаргаж өгөхөөс эрс татгалзсан. Гэтэл Шар сүмийн захирагч Балт ван сайн зэвсэглэсэн ангийг Ховд руу мордуулах гэж байна гэсэн мэдээ ирж байдал ноцтой болсон цаг байлаа. Энэ хэцүү цаг мөчид цэрэг татлагыг шуудруулж 2500 цэрэг бүрдүүлэхэд хоёр хүний нэр хүнд нөлөөлсөн. Нэг нь Жалханз гэгээн Ховд руу айсуу гэнэ гэсэн аман цуу мэдээ, нөгөөх нь Дамбийжанцангийн нэхэл хадбó; шаардлага шаардлага нөлөөлжээ.

1912 оны 6-р сард Дамбийжанцангаас элч ирж хуваарьт цэрэг эрчүүдийг нэн даруй гаргаж Ховд руу явуулах тухай дөрвөд, баяд, урианхайн бүх ноёдод захидал бичгийг, хадгийн хамт гардуулав. Энэ нь ажил хэрэгт бас нөлөөлж, цэрэг дайчилгааг түргэсгэв³⁹.

Магсаржав, Дамбийжанцан хоёр Толбо нуурын тэндээс ирж буй харуул хамгаалалт бүхий хятадын жингийн цувааг угтан цохиж, хүмүүсийн олонхийг нь устгаж, бараа таваар, бусад зүйлсийг нь олзолсон. Хятадын амбаныг ар талыг сулруулж, өөрсдийгөө бэхжүүлэхэд маш тус дөхөмтэй ажиллагаа болжээ.

³⁷ И. Майский Орчин үеийн монгол. Улаанбаатар. 2001. 279 дахь талд

³⁸ Инесса Ломакина. Жа Ламын толгой. УБ. Монсудар. 2011. 52 дахь талд

³⁹ А. В. Бурдуков. Шинэ ба хуучин монголд. Улаанбаатар. 2001. 72-73 дахь талд

Монгол цэргийн бүслэлт хумигдсаар байж Дамбийжанцан, Магсаржав хоёрыг Ховдод хүрч ирэхэд хятадууд хэдийнээ хэрмийн хамгаалалтад орсон байв.

Дамдинсүрэн, Магсаржав, Дамбийжанцан нар цэрэг эрчүүдийн хүчийг хувиарлан зохион байгуулж шөнөжин нүд анилгүй өнгөрүүлсэн. Дамбийжанцан, Хатан баатар хоёр фронтыг байнга эргэн шалгаж давхиулж байжээ.

Шийдвэрлэх хүнд мөч цаг тулгарлаа. Сайн зэвсэглэсэн хятад цэргийн өөр нэгэн отряд ойртон Тал Хайрхан уулын цаана хотоос ердөө таван мод газарт хотын зүг ирж буйг тагнуул илрүүлэв⁴⁰. Гэтэл Монгол цэргийн тоо 3000 орчим ч бирдаан буу бүхий 200 цэрэгтэй, бусад нь цахиур буу, бороохой шийдэмтэй, хэдэн цахиур буунаас өөр зэвсэггүй болохоор байдал нэн таагүй байв.

Дайсны цэрэг айсуй яваа тухай мэдээг авмагцаа “Дамбийжанцан хүн гайхмаар сэтгэлийн тэнхээ, авхаалж самбаа гаргаж зоримог хөдлөн Ховдын амбаны хамгаалалтыг гэнэт эрчимтэй дайрсан юм. Хятадуудыг хэрмээс гадагш дайрч болзошгүй хэмээн Магсаржавыг арын халхлалт болгон үлдээгээд өөрөө халхчуудыг дайралтад оруулсан “ бөгөөд хүмүүсийнхээ ард маузер барин явж гэдрэг эргэх гэсэн болгоныг чичлэн сануулж байлаа⁴¹.

Ховдын хэрмийг (1912 оны 8-р сарын 07-ны өглөөний 05 цагт) гэв гэнэт морины хурдаар дайран ороход санаандгүй байсан хятадууд ширүүн галласан боловч бараг шагаалгүй барагцаагаар чиглүүлэн буудсан тэдний суманд нэг ч хүн өртөөгүй, хохирол бараг үзээгүй (энэ байлдаанд монголчуудын талаас нэг хүн алагдаж, дөрвөн хүн шархадсан).

Баруун жигүүрт байсан урианхай халх, эрчүүл гуравдах удаагаа урагшлан дайрч, зүүн жигүүрт байсан Гэндэн гүний гучин таван баатар эхний дайралтаар “бэхлэлтийг авчээ”. Зайгүй буудах нөхдийн халхавчийн дор тэд хэрмийн ханыг сүхэдсээр цоорхой гаргажээ. Энэ цоорхойгоор Дамдинсүрэн тэргүүтэй барга цэргүүд морьтойгоо худалдаачны гудамж руу дайран орсон байна. Энэ үед хэрмийн нөгөө талаас Жа Лам, Магсаржав нар дайран оржээ.

Ийнхүү дайралтыг гэнэт бөгөөд хурдтай, нягтаруулж хийсэн. Манай монголчууд зогсоож саатуулахын аргагүй урагшлаж байлаа. Хятадууд ширүүн галлаж байсан боловч онож шагайсан юмгүй харсан зүгтээ буудаж байсан болохоор манайхаас сүйдсэн хүн бараг гараагүй юм. Бид хятадууд руу маш ойрхон давхиж очоод бараг тулган буудаж эхэлснээр тэдгээр цэргүүд болон тэмээдийг цөмийг нь устгасан хэмээн Дамбийжанцан тэр явдлын халуун мөрөөр Ховдын Сангийн хотоор орж сурвалжлан, зураг авч яваа А.В. Бурдуковд ярьжээ.

1912 оны 8 дугаар сарын 20-нд А.В. Бурдуковын очиж үзэхэд хятадын (140 хятад) хүүр овоо мэт, эргэн тойрон олон тэмээ (70 тэмээ)- ний сэг, нэл муухай үнэр ханхалж байжээ. Ерөнхийдөө 500 гаруй хятадыг устгасан бөгөөд зөвхөн Да Шэн Күгийн пүүс л бүрэн бүтэн үлдэв⁴²

Хятадын олон пүүсийн байр, дэлгүүр, эд материал сүйдэж, амбаныг тэтгэх ар тал сүйрчээ. Их хэмжээний буу, сум, бусад зэвсэг олзлон авсан байна.

“Огонек” сэтгүүл 1912 оны намрын нэгэн дугаартаа “ Дамбийжанцан лам болон түүний хамтран зүтгэгчдийн чин халуун ухуулга сурталчилгаанд зоригжсон үндэсний мэдрэмжийн өрнөлт нь өшөөт Хятадыг эсэргүүцсэн зэвсэгт тэмцэл болон асав. Энэ намар Монголын цэргүүд багахан арми болон нэгдэж Ховдын хэрмийг дайран эзэлжээ.⁴³ хэмээн онцолсон байлаа.

Энэ нь хэдэн зууны туршид Ойрадуудын хүсэн хүлээсэн маш чухал ялалт байлаа. Манжийн түрэмгийлэгчдийн гинжийг тас цохиж болохыг олон нийтийн сэтгэл зүйд эргэлт буцалтгүй хоногшин тогтох бодит хүчин зүйл болсон.

Дамбийжанцан, Магсаржав нар хятадын нэмэлт хүч ирэхээс өмнө амбаны олзлогдосдыг устгах саналтай байсан боловч Жалханз гэгээн болон бусад хүмүүсийн саналаар Коч-Агачын боомтоор гаргаж оросын нутгаар хятадад шилжүүлэх нь зүйтэй гэж тогтжээ.

Жалханз гэгээн, Дамбийжанцан хоёр 1912 онд Ховдыг чөлөөлсний дараа амбаны гэр бүл, олзлогдод, худалдаачдыг Кош-Агачаар дамжуулан гаргах зэрэг асуудлаар А.В. Бурдуковыг Ховдын байдлыг Кузменскийд танилцуулахыг хүсч байв.⁴⁴

Хүсэлт ёсоор болж тэр ажиллагаа явагдсны үр дүнд... манжийн сайд түшмэд 27, цэрэг, иргэн 650 – ийг Орос улсын нутгаар дамжуулан хөөж зайлуулсан байна⁴⁵

Магсаржав, Дамбийжанцан хоёрын байгуулсан гавъяаг Жалханз хутагт Да Хүрээнд мэдээлснээр Магсаржавыг <<бээс>> зэрэг, <<хатан баатар>> цол хэргэмээр, Дамбийжанцаныг <<Эрдэнэ бишрэлт, хүчин төгөлдөр, ноён хутагт, номун хаан цол, тамга⁴⁶>> шагнасан байна. Жа Лам бол Монголын төр, шашны тэргүүнээс хүртээсэн тамгатай, хүчин төгөлдөр хутагт юм.

⁴⁰ А.В. Бурдуков. Шинэ ба хуучин монголд . Улаанбаатар. 2001.78 дахь талд

⁴¹ Инесса Ломакина. Жа Ламын толгой . УБ. Монсудар. 2011. 62 дахь талд

⁴² В. Бурдуков Хучин ба шинэ монголд УБ, 1987. 81 дахь талд

⁴³ Огонек .1912.4 (17) ноябр

⁴⁴ А.В. Бурдуков. Шинэ ба хуучин монголд . Улаанбаатар. 2001.88 дахь талд

⁴⁵ Улсын архив. Автономитын үеийн хуучин фонд. 1-1-22-р бүс

⁴⁶ Улсын архив. 1-33-35. Жамьян-Очир, Дамбийжанцангийн тухай тэмдэглэл. Улсын номын сан. Гар бичмэл.

1912 онд Ховдыг чөлөөлөх дайралтад оролцогдын нэг туульч хэмээн алдаршсан Парчин тайжийн зохиосон Ховдыг чөлөөлсөн тухай туулийг академич Б.Я.Владимирцов бичиж аван орчуулжээ. Тэр туульд Жа Ламын тухай мөрүүд дурайж байдаг ажээ⁴⁷

Дамбийжанцан хутагт бол хэдэн зууныг дамнасан манжийн түрэмхийлэгчдийн дарангуйллаас Баруун монголыг чөлөөлөхийн төлөө нэгдэж тэмцсэн Үндэсний фронтын удирдагч мөн.Тэрбээр 1912 онд Жалханз хутагтын удирдаж хийлгэсэн Баруун монголын ноёдын (Улаангомын) их хуралдайд оролцож Манжийн түрэмхийлэгчдээс Ховдыг чөлөөлөх, Баруун монголыг Халхтай нэгтгэх шийдвэрийг гаргалцсан, Ховдыг чөлөөлөх нийт цэргийн 80 гаруй хувийг Ховд, Урианхайн хязгаараас дайчлан гаргах ажиллагааг зохион байгуулалцсан, Ховдыг чөлөөлөх байлдааны бэлэн байдлыг хангах,байлдааны ажиллагааг Магсаржавын хамт биеэр удирдсан зүтгэлтэн юм.

Дамбий жанцан хутагт бол үндэсний тусгаар тогтнолын төлөө гэсэн нийтлэг эрх ашигт нийгмийн янз бүрийн давхаргыг нэгтгэж чадсан Үндэсний фронтын удирдагч мөн.

Ховдын тойрог,Урианхайн хязгаарын сүсэгтэн олон, Шадар ван Амарсанаагийн амлалтыг хүсэн хүлээсэн Ордын эх орончид, нутгийн хан,ноёд, сайд, гүн, бээсүүд төдийгүй, тусгаар тогтнолын төлөө гэсэн нэгэн чиг үзэл санаат Өвөр болон Ар монголын нэрт зүтгэлтнүүдтэй дотно холбоотой байж, хамтран ажиллаж байжээ.Жишээ нь :

1. Жалханц гэгээн – 35 орчим настай, ухаалаг байрын, цэвэрхэн царятай лам байсан, хожмын Монгол улсын Ерөнхий сайд.
2. Чин ван Ханддорж -50 эргэм насны, цэвэрхэн царятай, хөдөлгөөнтэй,ухаалаг байрын харцтай хүн байж, Автономит засгийн сайд.
3. Магсажав-30 эргэм настай, монголын цэргийн удирдагч,хожмын Дамбийжанцантай байлдааны талбарт нөхөрлөж байлдааны ажиллагааг хамтран удирдаж Ховдыг чөлөөлсөн, хожмын Монгол улсынцэргийн сайд. Тухайн үед Монголд ирж байсан гадаадын хүн болгон Магсажав, Дамбийжанцантай хоёрын харгис хатууг гайхдаг байлаа.⁴⁸
4. Дамдинсүрэн-өндөр нуруутай, 40 эргэм насны зоримог, өргөн нүүртэй, монгол хүн гэхэд өргөн хар сахалтай, энийн, ярианд дуртай, юмыг хурдан ойлгодог, маш шудрага гэж алдаршсан, тэвчээр хатуужилтай, гүн бодол ухаантай, эрэмгий дайчин, урьд хятадтай олонтой байлдаж явсан хүн (Дэжээлэнд-1914)
5. Хайсан гүн -50 эргэм насны, өнпөр нуруутай.буурал үстэй, хятад царятай, дорнод монгол аялгуугаар ярина.Харбинд гагаж байсан <<Монголын сонин бичиг>>-ийн редактор

Тав. Дамбийжанцан хутагт Ховдыг чөлөөлсний дараа

1912 Ховдыг чөлөөлсний дараахан Гурван салаа гэдэг газар байрласан Дамбийжанцангийн хуаранд А.В.Бурдуков иржээ.Тэхэд Дамбийжанцан багавтар гэрт, шадар хүмүүс нь хоёр хуучин майханд байжээ.Бараа бологч, шадар туслахууд нь баяд,халх хэдэн лам байна. Гэр дотор ч онцын эд хогшил гэх юм алга. Хананд өлгөсөн олон буу байна. Энэ үед Дамбийжанцан их алдар нэр олоод байсан боловч гэр хоосон байх нь ер бусын юм шиг санагдаж байв./ Төдөлгүй байдал өөрчлөгджээ/.

Дамбийжанцанд зүг бүрээс элч төлөөлөгчид мэдээ авчрах ба цэргийн жажингууд зөвлөлдөхөөр мөргөлчид адис авахаар ирнэ.*Сүсэгтнүүд өргөл барьц барих нь Жалханз гэгээнд барихаас дутуугүй болжээ.*⁴⁹

Ховдын ажиллагааны дараа Жа Лам өөрийн хошууг нэгтгэж авч, өөрийн гэсэн албадтай нутагтай хошуутай болж Мүнжиг (Шар цэх)- т төвлөрөн суурьшиж ,байр сууриа бэхжүүлжээ.

Дамбийжанцанд < Эрдэнэ бишрэлт, хүчин төгөлдөр, ноён хутагт , номун хаан цол, тамга>хүртээж, түүний баталгаа болгон Богдын өргөөнөөс ирүүлсэн мөнгөн тамга ба дошгин ноён хутагт номун хааны цаашдын хувилгаан дүрийг тэмдэглэж шар торгон дээр бичсэн бичиг, Богд хааны зарлиг, хааны тамгын хавсралтыг хүлээн авчээ.

Жа Лам ноён хутагт,номун хааны цол, тамгаар шагнагдсанд баяр хүргэх наадам хийжээ.Аврага том Шижигт уулын хойд хормойн Ховд гол руу түрж тогтсон улаан уулын бэл дэх улиасан дундах Мүнжигийн хийд байгаа үзэсгэлэнт нутагт нааджээ.

Хүрэлцэн ирсэн олон ноёд хэргэм зэргээ баримтлан цувран очиж Номун хаанд баяр хүргэн, бэлэг барьж ,сүм хийдийнхэн есөн цагааныг өргөж хүндэтгэлийн дээдийг үзүүлсэн .

Дөрвөдийн хан, нутгийн ноёд, сүсэгтний түүнийг бишрэн өргөл барьц барих, долигонох нь ч хэрээс хэтэрсэн мэт болжээ. (Жа Ламд зориулсан наадам хийхэд ганцхан Зоригт ван гэхэд л 17000 рубль,2500 лан мөнгө бэлэг болгон барьжээ.)

Ийм байдлаар төдөлгүй 2000 өрх айлтай болж аль сайн харваачид, бөхчүүдээ гэр бүлээр нь бэлэг болгон шилжүүлж байжээ. Шинээр барих Жа Ламын хүрээнд зориулан 3000 тэмээн ачаа, мод, чулуу, түлээ буулгах боллоо

⁴⁷Инееса Ломакина. Жа Ламын толгой .УБ.Монсудар.2011. 64 дахь талд

⁴⁸А.В. Бурдуков Хучин ба шинэ монголд УБ,1987. 58-59 дахь талд

⁴⁹А.В. Бурдуков Хучин ба шинэ монголд УБ,1987. 89 дахь талд

Газар газрын хүчит бөхчүүд барилдаж, хурдан олон зуун хүлэг уралдаж, сур харваачид цугларч цэцээ сорьжээ. Элстэй удам талын 15 мод газрыг туулан түрүүлсэн шилдэг хурдан морьдыг номун хаанд бэлэглэж байлаа.

Дамбийжанцан хутагт Ховдыг манжийн эзэмшлээс чөлөөлсны дараа бүтээн байгуулалтын шинэ санаа сэдэж байлаа.Одоогийн Ховд хот бол ойролцоо түлш, мод байхгүй, ойр орчиндоо хоосон, малын тэжээл байхгүй, айл амьтнаас зайдуу, байршлын хувьд зохистой биш нутаг юм. Иймд Ховд голын сав, модтой уулын энгэр Мүнжиг гэдэг газарт (Шар Цэхэд)- ийг Бүх Ховдын хязгаарын нийслэл хот байгуулах, моторт жижиг онгоцоор Ховд голоор Ачит нуур хүртэл ба түүнээс цааш ч усан замын тэвэр хийх санаа сэдэж, хэрэгжүүлэхийн төлөө зүтгэж байсан. Тэрбээр гадаад бодлогын хувьд Оросыг түшиглэх, оросоос модчин, төмөрчин, барилгачдыг гэрээгээр авч сургууль бариулах, түүний зэрэгцээ аж ахуйн эрх тэгш харилцааг хөгжүүлэх, Ховдод байгаа Орос цэргүүдийн түлээ түлш бэлтгэх тээвэрлэхэд төлбөрийн тариф тогтоох бодлого баримталж байлаа.

Оросын худалдаачид хөөгдсөн хятадын худалдаачдын байрыг эзлэн худалдаа аралжааны ажлыг өргөтгөхийн оронд барааныхаа үнийг нэмэхийн хойноос хөөцөлдөн байгаад эрс дургүйцэж байв. Тийнхүү Консул Люба, хурандаа Казаков хоёр Дамбийжанцан хутагтад илт дургүйцэж, таарамжгүй боллоо.

Түүний зэрэгцээ дэг журам, ариун цэвэр, сахилга, зохион байгуулалт, өндөр шаардлагад тэр бүр дасаагүй нутгийн хан, ноёд, хятадын талыг баримтлагчид Дамбийжанцан хутагтад битүүхэндээ дургүй байв. Өөрийн нь буруу ажиллагааг зааж, шарын шашны үндэсийг бузарлаж, доромжилсон хэмээн эсэргүүцсэн баядын даянч ламыг баривчилсанд шашныхан таагүй байлаа. Нөхцөл байдал иймэрхүү хандлагатай өрнөж, нэг талаас нь үзвэл Дамбийжанцангийн байр суурь асар бэхжиж, нөгөө талаас нь харвал сөрөг уур амьсгал бүрэлдэж байлаа.

Зургаа. Хаант оросын цэргийнхэн Жа Ламыг баривчилсан нь

Ховдод суугаа Оросын консул В.Ф. Любагийн мэдэллүүдийг үндэслэн Оросын эзэн хааны шийдвэрээр Сибирийн буудлагын 41 дүгээр хорооны ахмад Булатов нар 1914.02.08-нд Дамбийжанцан хутагт Ховдын нутаг Шажинбадрах дахь өргөөндөө байхад нь баривчилсан. Хууран мэхлэх аргаар түүнийг баривчилжээ.

Ховдын Орос цэргийн захиргаа Кош-Агачаас киргизүүдийг нүүлгэхэд туслах нэрийдлээр казак цэргийн ангийг Ховдоос Мүнжигт оруулжээ. Дараа нь Оросын цэргийнхэн Шажинбадрахад зураг авч яваа хүний дүрээр хутагтын харуул хамгаалалтыг тагнаж, яг Дамбийжанцангийн өргөөний орчинд хэдэн зэвсэгтэй цэрэг байгааг, тэдний буу зэвсэг хэрэглэл нь хаана яаж хадгалагдаж байгааг, нөөц сум зэвсэг хэрэглэл нь хаана хадгалагддаг, өргөөний байрлал, хамгаалалтыг нарийвчлан тогтоогоод гэнэдүүлж, дайран баривчилжээ.

Хутагт хамгаалалтын 12 цэрэгтэй ч, гэнэт Оросын 40 гаруй казах цэрэг ороод ирчихнэ чинээ санаагүй байжээ.

Баривчлагдсан Дамбийжанцанг Ховдод аваачиж, тэндээсээ хүч нэмэгдүүлсэн харуул хамгаалалттайгаар Бийск, дараа нь Томск хотын шоронд, тэндээс Якутад цөлөгджээ.

Дамбийжанцанг баривчлахыг Магсаржав саатуулах гэж оролдсон ч, “ван та мориндоо морд. Эс тэгвэл таныг баривчиллаа”⁵⁰ хэмээн тулгахад нь аргагүйн эрхэнд баргар царайлан дагаж хөдөлсөн байдаг. Дамбийжанцанг баривчлангуутаа Магсаржавыг хараа хяналтандаа хаашаа ч хөдөлгөхгүй барьж байгаад монгол цэргүүдийн зэвсгийг хурааж, хөдөлгөөнд орох чадваргүй болгосон.

Ийнхүү консулд таалагдаагүй төрийн зүтгэлтнүүдийг ч Оросын цэргийнхэн гадаад орны нутаг дэвсгэрт чөлөөтэй нэвтрээд өргөө гэрээс нь баривчилжээ.

Баривчлахдаа Монголын цэргийн жанжинг ч (Магсаржавыг) хүч хэрэглэн дарамталж өөрийнхөө ажиллагаанд татан оролцуулж байжээ. Оросын консулд таалагдаагүй л бол Өндөр дээдэс төрийн тэргүүн II Николай хаандаа мэдээлж, цэргийн анги оруулж ирүүлээд Төрийн тамгатай хутагтыг баривчлуулж (1912 онд) Томскийн шоронд илгээж, Якутад цөлүүлж, Хаганбаатар Магсаржавыг журамлаж, монголын цэргийн буу зэвсгийн хурааж байсныг юу гэж үзэх вэ? Түүнийг хууль ёсны үйлдэл, интернационалч үүргээ биелүүлжээ гэхдээ хүрдэг түүхчид, зохиолчид маань ч гэсэн эдүгээ э бодит үнэнийг хүлээн зөвшөөрөх биз ээ. В.Ф.Люба, ахмад Булатов нарын зэрэг Оросын консулынхны зохион байгуулсан ажиллагаа нь Монгол Улсын дотоод хэрэгт хууль бус, түрэмгийлэн оролцох ажиллагааны эхлэл байжээ.

Долоо. Хүмүүст амар жимэр амьдарч, тайван сайхан

хөдөлмөрлөх боломжийг цагаантан ч, улаантан ч олгоогүй.

Дамбийжанцан Орост цөллөгөнд байхдаа А.В.Бурдуковт бичсэн нэгэн захидалдаа... **Би эх орондоо сайн үйл бүтээж явснаас биш муу юм хийж яваагүй атал миний эх орон намайг арга ядаж байхад огтхон ч ойшоож, хамгаалж өмгөөлсөнгүй**⁵¹ Тэрбээр ийм өнгө аястай зүйл нэг биш удаа бичсэн. Түүнийг уншсан хэнд ч энэ хүн монголын төр засагт итгэлгүй болж эхэлж дээ, аргагүй юмаа гэхээр.

Жа Ламыг оросууд баривчлахад түүний хөрөнгө (250 000 рублийн)-⁵² ийг Монголын засгийн газарт шилжүүлсэн. **Харамсалтай нь Жа Ламыг оросууд зүй бусаар баривчлахад нь**

⁵⁰Инецца Ломакина. Жа Ламын толгой .УБ.Монсудар.2011. 97 дахь талд

⁵¹Инецца Ломакина. Жа Ламын толгой .УБ.Монсудар.2011. 203 дахь талд

⁵²Инецца Ломакина. Жа Ламын толгой .УБ.Монсудар.2011. 101 дахь талд

өмгөөлсөнчгүй, мөнгө гуйвуулсанчгүй, юу ч болоогүй юм шиг байжээ. Төр засаг тамгатай хутагт Дамбийжанцангаа өмгөөлж, хамгаалах нь буй хэл бүр эрүүл саруул ухаантай хүний санаанд ормооргүй зүлийг сэдсэн.

... Дамбийжанцан хэмээх нэгэн залт оргодол лам Ховдын хязгаараар тэнүүчлэн явж” Богд хааны шашин төрд туслах үүрэгтэй. Их Монголын Амарсанаагийн угсааны хүн⁵³ гэж өөрийгөө өргөмжлөн нэрлэж, ... *автономит Монголын хаан богд Жавзан дамбатай эрх мэдэл булаацалдах хорт санаа агуулж явсан байна...* Дамбийжанцан бол 1912 онд Ховд хотыг чөлөөлөхөд оролцогүйгээр үл барам Монголын ард түмний тусгаар тогтнолын заналт дайсан бөгөөд ардын хувьсгалын дараа Бодоогийн хувьсгалын эсэргүү хувилдаантай сүлбэлдэж явсан гадаадын тагнуул байжээ.⁵⁴ Д.Гонгор Ховдын хураангуй түүх (УБ. 1961. 107 дахь талд)-дээ энэхүү дүгнэлтийг ишлэл авч оруулсан байна.

Жа Ламтай оросын шоронд хоригдож байхад нь уулзаж амжаагүй ч Хангилцагаас Томск орж эргэхээр очсон ганц хүн нь А.В.Бурдуков юм. А.В.Бурдуков Жа Ламыг Сибирийн шорон, Якутийн болон Астраханы цөллөгөнд байхад нь түүнтэй захидлаар харилцаж, гадаад орчинтой холбож, хүний нутагт ядуурч явахад нь мөнгө гуйвуулж “ядрах цагт нөхрийн чанар “ харуулсан жинхэнэ хүн, анд бол А.В.Бурдуков байлаа.

Монгол улсын тусгаар тогтнол, хөгжил дэвшлийн төлөө тэмцэж, хүмүүс амар жимэр амьдарч, тайван сайхан хөдөлмөрлөх боломжийг мөрөөдөж асан энэ агуу хоёр хүний нэг - А.В.Бурдуковт ЗСБНХОУ –ын шүүх буудан алахаар ялласан боловч ” өршөөл ” үзүүлж Сибирийн хорих лагерт 10 жил хорих ялаар сольсон юм билээ. Тэрбээр 1943 онд Тайга өртөөний хорих лагерт ял эдлэж байхдаа нас баржээ. Нөгөөдөхийг (Дамбийжанцан хутагтыг) 1923 онд Түшээт хааны нутаг Ма-Цзун-шань уулын орчны Хар элсний дундах нэгэн Баянбүрд дэх өргөөндөө байхад нь монголын ардын засгийн тусгай” төлөөлөгчид очоод “ нөхөрсөг “ уулзалт зохион байгуулах үеэрээ түүнийг буудаж алаад, хүзүүг нь хэрчиж, толгойг нь салгаж аваад Улаанбаатарруу буцсан.

Хүмүүст амар жимэр амьдарч, тайван сайхан хөдөлмөрлөх боломжийг ийнхүү цагаантан ч, улаантан ч олгоогүй. Тийм цаг үе, хүмүүс байсан, түүхчид, зохиолчид нь ч бүтээлээ цаг үедээ нийцүүлэн “урлаж” байжээ. Төрийн эрх баригчдын бодлогыг дэмжихдээ цагааныг хараар, харыг улаанаар өнгөлж байжээ.

Түүхэн үйл явдлыг бичихдээ түүх гэдэг нэрэнд нь нийцүүлэх цаг ирж байна. Энэ зарчим нь Баруун монголыг манжийн түрэмхийлэгчдээс чөлөөлсөн тэмцлийн түүхийн судалгаанд ч хамаарна. Дамбийжанцан бол Баруун Монголыг манжийн түрэмхийлэгчдээс чөлөөлөх хөдөлгөөний тэргүүлэх зүтгэлтэн, тусгаар тогтнолын төлөө үндэсний фронтыг удирдагч мөн. Зөвхөн түүхэн үнэнийг сэргээхэд төдийгүй, нэгэнт тэр эх орончийн толгой нь хадгалагдаж байгаа болохоор удамшил зүйн судалгааг эсийн түвшинд хийж ДНК –г тодорхойлбол Увсын цэнхэр хязгаараас түүний ач жич нь тодрох ажиг байна.

⁵³ Улсын төв архив. 1-33-35 Жамьян –Очир Дамбий жанцангийн ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ. Улсын номын сан. Гар бичмэл

⁵⁴ Монгол ардын журамт цэргийн дурдатгал. 1961. 477-482, 616-621 –р талд

.. راجهٔ مستشرقان و مترجمان و نویسندگان و محققان در این باره نوشته‌اند.

این امر از جمله آن است که در 1696 . قمری است که در این باره نوشته‌اند و همچنین در 1688 . قمری است که در این باره نوشته‌اند و همچنین در 1671 . قمری است که در این باره نوشته‌اند و همچنین در 1307 . قمری است که در این باره نوشته‌اند .

و همچنین در این باره نوشته‌اند که در این باره نوشته‌اند و همچنین در این باره نوشته‌اند .

و همچنین در این باره نوشته‌اند که در این باره نوشته‌اند .

و همچنین در این باره نوشته‌اند که در این باره نوشته‌اند .

و همچنین در این باره نوشته‌اند که در این باره نوشته‌اند .

(کتابخانهٔ قزوین)

و همچنین در این باره نوشته‌اند که در این باره نوشته‌اند .

و همچنین در این باره نوشته‌اند که در این باره نوشته‌اند .

و همچنین در این باره نوشته‌اند که در این باره نوشته‌اند .

و همچنین در این باره نوشته‌اند که در این باره نوشته‌اند .

و همچنین در این باره نوشته‌اند که در این باره نوشته‌اند .

و همچنین در این باره نوشته‌اند که در این باره نوشته‌اند .

و همچنین در این باره نوشته‌اند که در این باره نوشته‌اند .

و همچنین در این باره نوشته‌اند که در این باره نوشته‌اند .

و همچنین در این باره نوشته‌اند که در این باره نوشته‌اند .

و همچنین در این باره نوشته‌اند که در این باره نوشته‌اند .

و همچنین در این باره نوشته‌اند که در این باره نوشته‌اند .

و همچنین در این باره نوشته‌اند که در این باره نوشته‌اند .

و همچنین در این باره نوشته‌اند که در این باره نوشته‌اند .

و همچنین در این باره نوشته‌اند که در این باره نوشته‌اند .

این کتاب در سال ۱۸۶۰ در لندن چاپ شد. در این کتاب، نویسنده به بررسی و تحلیل وضعیت اقتصادی و اجتماعی ایران در آن زمان پرداخته است. او به بررسی ساختار سیاسی و اداری ایران، نظام مالیاتی، نظام قضایی و نظام آموزشی پرداخته است. همچنین به بررسی وضعیت کشاورزی و صنعتی ایران و نقش دولت در اقتصاد پرداخته است. این کتاب یکی از مهم‌ترین منابع برای مطالعه تاریخ ایران در قرن نوزدهم است.

در این کتاب، نویسنده به بررسی و تحلیل وضعیت اقتصادی و اجتماعی ایران در آن زمان پرداخته است. او به بررسی ساختار سیاسی و اداری ایران، نظام مالیاتی، نظام قضایی و نظام آموزشی پرداخته است. همچنین به بررسی وضعیت کشاورزی و صنعتی ایران و نقش دولت در اقتصاد پرداخته است. این کتاب یکی از مهم‌ترین منابع برای مطالعه تاریخ ایران در قرن نوزدهم است.

1100 页，系按《新疆维吾尔自治区》载《新疆历史》：1947 年第 1 卷第 4 期（总第 4）。

[9] 田田《吐蕃王朝的崩溃》载《新疆社会》第 1 期（1992 年）。

[10] 田田《吐蕃王朝的崩溃》载《新疆社会》第 1 期（1992 年）。

[11] 田田《吐蕃王朝的崩溃》载《新疆社会》第 1 期（1992 年）。

[12] 田田《吐蕃王朝的崩溃》载《新疆社会》第 1 期（1992 年）。

[13] 田田《吐蕃王朝的崩溃》载《新疆社会》第 1 期（1992 年）。

[14] 田田《吐蕃王朝的崩溃》载《新疆社会》第 1 期（1992 年）。

[15] 田田《吐蕃王朝的崩溃》载《新疆社会》第 1 期（1992 年）。

[16] 田田《吐蕃王朝的崩溃》载《新疆社会》第 1 期（1992 年）。

区社会科学院民族研究所编：1985 年 8 月。

[17] 田田《吐蕃王朝的崩溃》载《新疆社会》第 1 期（1992 年）。

[18] 田田《吐蕃王朝的崩溃》载《新疆社会》第 1 期（1992 年）。

[19] 田田《吐蕃王朝的崩溃》载《新疆社会》第 1 期（1992 年）。

[20] 田田《吐蕃王朝的崩溃》载《新疆社会》第 1 期（1992 年）。

[21] 田田《吐蕃王朝的崩溃》载《新疆社会》第 1 期（1992 年）。

[22] 田田《吐蕃王朝的崩溃》载《新疆社会》第 1 期（1992 年）。

[23] 田田《吐蕃王朝的崩溃》载《新疆社会》第 1 期（1992 年）。

[24] 田田《吐蕃王朝的崩溃》载《新疆社会》第 1 期（1992 年）。

БУЛГАН ГОЛЫН ХОШУУДЫН УГСАА ГАРАЛ, ТҮҮХИЙН ЗАРИМ АСУУДАЛ

Б.Нямдорж
Доктор(Ph.D), проф,Ховд их сургууль,
НХУС, Түүхийн тэнхимийн багш,
Е.Дорж Хошууд судлаач,
хошууд судлалын нийгэмлэгийн тэргүүн,
А.ДэлгэрцэцэгХИС-ийн магистрант

Хошууд нарыг Чингис хааны дүү Хавт Хасарын үртэс /үр төл/ хэмээн эрдэмтэн судлаачид хүлээн зөвшөөрсөн байдаг. Үүнээс үзэхэд хошууд нар нэгдсэн Монгол улсыг байгуулахад болон Дөрвөн ойрадын түүхийг бүтээхэд асар их хувь нэмэр оруулсан ард түмэн мөн болохыг үе үеийн судлаачид, түүхчид өөрсдийн бүтээлдээ тэмдэглэжээ. Хошууд нарын дундаас Дөрвөн ойрад даяар алдаршсан Галдамаа баатар, үндэсний эрх чөлөөний анхны бамбарыг асаасан гэгдэх цогт тэмцэгч Амарсанаа, мөн Манжийн түрэмгийлэгчдийн эсрэг тэмцэгч домогт Ану хатан, Ойрад Монголчуудын дунд Шарын шашиныг түгээн дэлгэрүүлж, бурхан шашины нийгүүлсэнгүй зан үйлийг нэвтрүүлэхийн төлөө бүх насаа зориулсан төр шашины нэрт зүтгэлтэн, эрдэмтэн түүхч, орчуулагч Заяа Бандид Намхайжамц, Дөрвөн Ойрадын чуулганыг таван үе дараалан толгойлсон Бүүвэй Мирз, Хан Хонгор ноён, Байвгас баатар, Төрбайх Гүүш хаан, Очирт сэцэн хан зэрэг олон шилдэг хүмүүс түүхэнд мөнхрөн үлджээ. Өдгөө хошууд нарын дийлэнх нь БНХАУ-ын Төвд, Хөх нуурт мөн ОХУ-ын Халимагийн БНУ-д амьдарч байгаагаас гадна Монгол улсын Ховд, Увс, Баянхонгор, Архангай, Өмнөговь аймгуудын сум багаар тархан цөөнхийн шинжтэй амьдарцгааж байна. Үүнээс ажиглахад түүхэн янз бүрийн шалтаг шалтгаанаар газар газарт тархан суурьшсан Монгол угсаатны нэг нь гарцаагүй Хошууд нар юм. Хошууд нар XIY зууны эхэн үеэр Монголын зүүн хязгаараас нүүдэллэн Дөрвөн Ойрадын хязгаарт хүрч “Хошууд” хэмээх хүчирхэг ястан болон суурьшсан түүхэн замналтай. Хошууд нарын туулсан болон өдгөө туулж буй нийгмийн зам нь хэдий ээдрээтэй ч гэлээ олон зуун жилийн турш уламжлалт Монгол зан заншлаа мартаж гээгээгүй одоо болтол явж ирсэн нь бахархууштай юм. Гэвч бидний өмнө түүхэн гавьяатай хошууд нар өдгөө хаана, хэрхэн амьдарч, аж төрж байна вэ?, тэр дундаа Булган голын хошуудууд гэгч хэн бэ?, яагаад Ойрад Монголчуудын дунд очиж суурьших болов?, Хошууд нарын монголын түүхэнд гүйцэтгэсэн үүрэг эзлэх байр суурь юу вэ?, Булган голын хошуудуудын угсаа гарал юу вэ?, Хошуудууд ямар соёл, зан заншилтай вэ? гэхчлэн олон олон асуултууд урган гарч байна.

Манай улсын хувьд Хошууд нар нилээд олон аймаг, сум, суурин газруудаар бусад ястнуудын дунд тархан суурьшиж, амьдарч байгаа боловч өөрсдийн угсаа гарал, өвөг дээдсийнхээ түүхэн замналыг умартан мартаж, бусад ястанд уусах явдал ажиглагдсаар байгаа юм. Бид энэ байдалд сэтгэл чилээж, аливаа хүн өөрийн овог угсаа, гарал үүсэл болон өвөг дээдсийнхээ түүхэн гавьяагаар бахархаж, түүнийг хайрлан дээдлэж, хадгалан хамгаалж, цааш нь үргэлжлүүлэн үүх түүхээ баяжуулан залгамжлах ёстой хэмээн үзэж, Ховд аймгийн Булган сумын хошуудын жишээн дээр угсаа гарал, тархалт, түүхэн замналын асуудлыг судлан шинжлэх зорилго тавив. Гэвч энэ чиглэлийн судалгаа харьцангуй хоцрогдонгүй явж ирсэн билээ. Ялангуяа Монгол улсын орон нутгийн салшгүй хэсэг болсон Булган голын хошууд хошууны түүхийн судалгаа огт хийгдээгүй дашрамд цухас дурдагдах байдлаар хязгаарлагдаж иржээ.

Иймд сурвалж, судалгааны бүтээлүүд, архивын баримт, аман мэдээнүүдэд тулгуурлан хошууд хошууны түүхийн асуудлыг тусгайлан нухацтай судлах шаардлагыг зүй ёсоор төрүүлж байна.

Монгол улсын хүн амын тооллого, түүхийн болон хүн ам зүйн судалгааны материалууд, зарим эрдэмтэн мэргэдийн зохиол бүтээлүүдтэй танилцаж байхад Хошууд нар нилээд олон аймаг, сум, багаар тархан суурьшсан болох нь ажиглагдаж байна. Тухайлбал, Ховд аймгийн Булган, Эрдэнэбүрэн, Увс аймгийн Улаангом, Тэс, Өлгий, Сагил, Архангай аймгийн Өлзийт, Хотонт сум, Баянхонгор аймгийн зарим сумд, Өмнөговь аймгийн Хан хонгор сум, Нийслэл хот болон Дархан, Эрдэнэт хотуудад Хошууд овгууд цөөнгүй бүртгэгджээ. Увс аймгийн Улаангом, Тэс, Өлгий, Сагил, Ховд аймгийн Эрдэнэбүрэн суманд бүртгэгдсэн Хошууд нар нь Манжийн түрэмгийлэгчид Зүүн гарын хаант улсыг байлдан эзлэхээс өмнө Галдан бошготын шийдвэрээр Ховдын гол, Буянт гол, Тэс, Бөхмөрөн,Завхан голын хөндий, Увс нуурын сав дагуу нүүлгэн суурьшуулж цэргийн хүнс бэлтгэх зорилгоор газар тариалан, мал ахуй эрхлэж байсан хошууд нарын үр хойчис бололтой хэмээн А.Очир. “Монголын ойрадууд” номондоо тэмдэглэжээ. Баянхонгор аймгийн зарим суманд бүртгэгдсэн хошууд нар нь Заг, Байдраг, Түйн голын сав газраар, Мөн Галданбошготын шийдвэрээр Дөрвөд, Баяд нартаа хамт нүүж ирсэн цэргийн тариалан эрхэлсэн хошуудын үр хойчис ажээ.⁵⁵

Архангай аймгийн сумдад бүртгэгдсэн хошууд нар нь Манжийн түрэмгийлэгчдийн эсрэг Зүүн гарын хаант улсын явуулсан аян дайны уршгаар Зүүн гартаа буцаж чадаагүй зам зууртаа нутаглан суурьшсан хошууд нарын үр хойчис бололтой.Өмнөговь аймгийн Ханхонгор сумын нутаг дахь хошууд нар

⁵⁵Очир А. “Монгол Ойрадуудын түүхэн товч”, УБ., 1993. тал. 59.

нь Зүүн гарын Галдан бошготын эрхшээлд орохоос татгалзан Алшаан хязгаарт шилжин суурьшсан Баатар эрх жонон Хорлоогийн албат нараас тасран өдгөөгийн Өмнөговь аймгийн зүүн өмнөд хэсгээр орж ирэн тэндээ суурьшсан хошууд нарын үр хойчис ажээ.

Тэд хожим Богд хаант Монгол улсын бүрэлдхүүнд багтан 1940-өөд оноос Монголын засгийн газраас хэрэгжүүлж ирсэн аймаг сумын зохион байгуулалтаар Өмнөговь аймагт харьяалагдан Ойрадын Чуулганы Хан асан Хан хонгорын нэрээр сумаа нэрлэн суурьшжээ. Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Сэлэнгэ зэрэг аймаг хотуудаар суурьшсан хошууд нар нь 1950-1960-аад оны социалист бүтээн байгуулалтын үйл хэрэгт гар бие оролцохоор шилжин ирж, шинэ сангийн аж ахуй, үйлдвэр хотын суурь тавилцсан ажилчид бөгөөд их, дээд сургууль төгсөж нам төрийн байгууллагуудын томилолтоор очиж суурьшсан боловсон хүчнүүд тэдгээрийн үр хойчис болно.

Монгол орны хэмжээнд хошууд нар нь Ховд аймгийн Булган суманд Торгууд нартай хамт бөөндүү засаг захиргааны нэгж хэлбэртэй сууж байна. Энэхүү хошуудыг түүх шастирт Булган голын хошууд хэмээн нэрлэж байна. Тэдний түүхэн замналыг авч үзвэл:

ХҮИ зууны сүүлчээр Зүүн гарын хаант улс Манж Чин улсын эрхшээлд бүрэн орсон нь баруун Монголын ард түмэнд туйлын хүнд цохилт болжээ. Манжийн хааны харгислал газар бүр идэвхжиж ард иргэдийг боолчлох эр хүйстэйг нь цэрэг дайнд хүчээр дайчлах журам тогтоосон нь асар их дарамт болсны хамт цэрэг дайны дайчилгаанаас зайлсхийсэн эрчүүдийг толгой дараалан хядаж байлаа. Энэ нь эх нутагтаа эргэж ирээд удаагүй байсан Торгууд, Хошууд нарын хувьд болон бусад Монгол аймаг хошуунууд оршин тогтноход туйлын бэрхшээл учруулж байв.

Бас дайны хөлөөр дээрэм тонуул хийх, бие биенээ алж талах үйл ажиллагаа газар авч ард иргэдийн амгалан тайван амьдрах нөхцөл бүрмөсөн алдагджээ. Үүнээс шалтгаалан аймаг хошууны бүтэц, зохион байгуулалт алдагдаж, хэсэг бүлгээрээ зүг зүгрүү нүүн тарж, бутран дайны хөлөөс дүрвэж, амар амгалан амьдрах ая тухтай газар нутгийг эрж хайх болсон байна. 1771 онд Торгууд нартай хамт Ижилээс буцаж ирсэн Хошууд нарыг Манжийн Тэнгэр Тэтгэгч хаан хошуу сумын зохион байгуулалтанд оруулж Хошуудын Батсэтгэлтийн чуулганд багтаан Шинжианы Жултас хавьд нутаг олгон суулгажээ. Хошуудын Батсэтгэлтийн чуулган нь дан Хошуудаар бүрдсэн дундад замын дундад хошуу, дундад замын баруун хошуу, дундад замын зүүн хошуу хэмээх гурван хошуутай байв. Энэ гурван хошууны анхны ноён нь Хавт Хасарын угсааны Хан ноён Хонгорын гуравдугаар хүү Хөндлөн Убашийн үеийн Яримпил, Ноохай, Баярлах нар юм. Манжийн засгийн газар тэднийг 1771 онд дээрх хошууны ноёдоор өргөмжилж, 1775 онд засаг тамга олгож, 1783 оноос зарлигаар үе улираан хэргэм зэргийг нь залгамжлуулсан байна. Хошуудын Батсэтгэлтийн чуулган нь Ирид суусан Манж захирагчид захирагдаж байв. Энэ хугацаанд буюу 1775 -1776 онд Торгуудын Хо Өрлөгийн угсааны Шархүүхэн бэйл харьяат албатаа дагуулан нүүж, Монгол Алтайн өвөр бэлийн үзэсгэлэнт хөндий болох Булган голын сав дагуу ирж нутаглажээ.⁵⁶

Шархүүхэн бэйл, Хошуудын ноён Мөнгөний хатан Цээнэ хоёр төрсөн ах дүүс бөгөөд Хо өрлөгийн угсааны Баатар Убашийн үр хойчис юм. Манжийн түрэмгийлэгчдийн дээрх харгислал Хошууд нарт нэгэн адил нөлөөлжээ. Хошуудын ноён Мөнгөн дайны талбарт нас барж гайгүй гэсэн эрчүүд нь Манжийн цэрэгт дайчлагдаж, ард талд үлдсэн албат нар нь дайны хөлөөс зугтаан бусад аймаг хошууны нүүдэл даган ийш тийшээ тарж бутран алга болж, үлдсэн цөөн тооны албатууд нь хэрхэх учраа олж ядан тэвдэж байв. Урсан өнгөрөх цаг мөч бүр тэдний амь насанд аюултай байсны улмаас тэдэнд түшиг тулгуур болж явсан Мөнгөн ноёны авга Талаг Убаш, Бунай захирагч нар зөвлөлдөн Цээнэ хатанд эр нөхрийнхэн хувцас хунар өмсгөж, зэр зэвсэгийг нь агсуулан эр хүнд хувиргаж, Мөнгөний хүү Буянхишигийг /Буянхишиг нь 10-11 настай байсан гэдэг/ дагуулан дайны талбарыг орхиж, 1790 оны нохой жил Булган голын хойт хэсэгт орших “Их шар булаг” хэмээх газарт ирж суурьшжээ. Тэд Булганд далуулаа ирсэн бөгөөд тэдний дотор шилдэг дайчин зоригтой эрчүүд, сайн зурхайч оточ нар багтаж ирсэн гэдэг.

Тэд нар энд ирж суурьшаад нэг их удсангүй Шархүүхэн бэйлд элч зарж харьяалалдаа багтаахыг санал болгожээ. Шархүүхэн бэйл элчийн саналыг хүлээн авч мэрэгч төлөгч нараа цуглуулж, /Шархүүхэн бэйл Хятад, Монгол хоёр төлөөлөгчтэй байсан гэсэн мэдээ бий/ , тэдний айлдварыг сонсчээ. Мэрэгч төлөгч нар нь бэйлд хандан хэлсэн нь: Таны эгчтэй хамт ирсэн хүмүүс энгийн номхон албатууд биш байна. Яг үнэнээр нь айлдваас, тэдгээр хүмүүс “Далан /жидээн/ жадны уг” байна. Танд гай тарина уу гэхээс албат болох хүмүүс биш байна” гэжээ. Төлөгчдийнхээ айлдварыг сонсоод шадар туслахуудтайгаа зөвлөлдөн өөрийнхөө албат ардуудтай нийлүүлэхгүйгээр тусад нь бие даасан “Хондог” болгохоор тогтож, эзэмшил нутгаасаа гурван гол нутаг түр заан өгч элчийг буцаажээ. Талаг убаш, Цээнэ хатан, Бунай захирагч нар элчийн саналыг сонсоод албат нараа цуглуулан Талаг Убаш өгүүлрүүн:- Биднийг худ ураг барилцан, зэрэгцэн орших “Хондог” болгож, гурван гол нутгийг өөрийн эзэмшилээс түр эзэмшүүлж байхаар шийдвэрлэсэн саналыг ирүүлжээ.

Тэдний аясыг түр дагахаас өөр зам бидэнд алга. Харин цаашид “Хондог” хэвээр байх уу, аль эсвэл хошууны хэмжээнд хүрч, Монголын төрд данстай түмэнд хаягтай байх уу гэдгийг шийдэх хэрэгтэй. Одоо бид нар хуяг дуулга, зэр зэвсэгээсээ салж хүн бүр хичээн зүтгэж, айлын дайтай айл болж амьдрахын дайтай амьдрах цаг ирж байна гэжээ. Цээнэ хатан өгүүлрүүн:- Зулай зулайгаа дарж төрсөн билээ. Хазаглаж юунд

⁵⁶Тариа Р. нас 87, Булган сум Баянгол багт 2011 оны 8-сард, Аман мэдээ

түлхнэ бэ? Халуун амь бүлээн цус маань нэг билээ. Хажуудаа юунд эс багтаанам, зовохын цагт хүний чанар танигдана гэдэг л болж байгаа юм байна.⁵⁷

За тэр ч яах вэ? Миний хувьд та нарын ихэс дээдсийн залгаа болох хүүгийнхээ гарыг ганзаганд, хөлийг дөрөөнд хүргэхийн төлөө зүтгэнэ. “Хүнс хэдий хомс ч, нэгнээ барьж иддэггүй, хүч хэдий давуу ч хялбархан /дийлж/ ялж болдоггүй” гэсэн үг бий. Бид нар цөөн хэдий ч аливаа бэрхшээлд сөхрөшгүй билээ.

Талаг Убаш өгүүлрүүн: Эзэн хичээвэл заяа хичээдэг билээ. Хаад ноёдын зарилгаар ажиллаж амьдарч байсан бол одоо харц албатын нэгдэл нягтралаар ажиллаж амьдрах болж байна. Гэвч хүн ахтай дээл захтай гэдэг. Ургаа мод ч гэсэн дээрээ оройтой, доороо үндэстэй байдаг билээ. Буянхишиг хүүгээ ноёнд өргөмжилж, төр түмний албанд бид нар зүтгэе. Хатан ахайтан гэсэн ч зааж зааварчлагтун гэжээ. Ийнхүү Булган голд ирж суурьшсан Хошууд нар “Хондого” хэмээгдэн хэсэг хугацаанд явснаа Ховдын Манжийн амбанд бараалхан 1796 онд Хошуудын “засаг” хошуу болж, таван гол нутаг шинээр нэмэн авч, баруун зүүн дөчин гэсэн хоёр сумтай, захирагч занги нэг, Залан занги гурав, суман занги хоёртой, жил бүр Ховдын амбанд жасаалан очиж, албан татвар төлж цалин пүнлүү авдаг болсны хамт зах залгаа захчин, торгууд нарын дунд:

Найман гол нутагтай, Нарийн малиа тамгатай

Эзэн Богдын угшилтай, Эрэлхэг Хошууд хэмээн алдаршжээ.

Энд нүүдэллэн ирж суурьшсан Хошууд нарыг хожим хятад сурвалжид бичгүүдэд “Шинэ хошууд” хэмээн тэмдэглэсэн байдаг ажээ.⁵⁸

Ийнхүү ХҮП зууны эхний хагас болон ХҮШ зууны дундуур Ижил мөрөнд хэсэг хэсгээр очсон торгууд, хошууд нарын зарим хэсэг 1771 онд Шэйрэн, Уваши нарын ноёдоор тэргүүлүүлэн Алтай нутагтаа буцан иржээ. Манж нар тэднийг бүхэлд нь хошууны зохион байгуулалтанд оруулан хэд хэдэн хошууг нэгтгэсэн чуулганууд байгуулснаас Чин сэтгэлтийн чуулган нь Ховдын хязгаарт хамрагдах болов. 1750-иад онд Тарвагатайгаас нүүдэллэн одоод дахин буцаж ирсэн Эзнээ тайшийн угсааны ноёдын албат нарыг оруулан Чин сэтгэлтийн чуулган хэмээн нэрлэж, Булган, Чингэл, Цагаан гол, Хавтаг, Өрөнгө, Тарвагатайгаар нутаглаж, Ховдын манж сайдын газар захируулжээ.

1792 онд торгууд бэйсийн харьяанд явсан хошууд нарт торгууд урианхайн завсарт Алтайн Хамар даваанаас хойш нутаг олгон 1796 оноос тусгай хошуу болгон, ноёноор нь Буянхишигийг өргөмжилж, засаг тамга олгож, торгуудын Чин сэтгэлтийн чуулганд багтааж Ховдын манж сайдын газарт захируулав. Торгууд, хошууд нарыг албан татвар төлүүлэхийн зэрэгцээ цэрэг, өртөө, улаа, морины алба, түлш бэлтгэх алба гүйцэтгүүлж байв.

1771 онд Шинэ торгуудын Чин сэтгэлтийн чуулган байгуулж, 1773 онд чуулганы даргаар Шэйрэнг, чуулганы дэд даргаар Шархүүхнийг тавив. Чуулган нь тэр гарын/ хошуу/ дээд эрхийг барих газар юм. Чуулганаар эр төөлсөн /цэрэг эрийг бүртгэх/ ажлын дүнг гаргаж, түүнийгээ баримтлан хошуудаас гаргах өртөө, харуулын өрх, цэргийн зэрэг тэр гарын /хошуу/ доторхи бүхий л албыг тэгшилж хуваах, хошуудын газар нутгийн хилийг тогтоох, зарим зарга заалхай хэргийг нэгэн тийш болгон таслах зэрэг чуулган дарга, жанжин нараас дангаараа шийдвэрлэж чадахгүй олон хошуудтай холбогдсон асуудлуудыг зөвлөлдөн хэлэлцэх журмаар шийдвэрлэдэг байв. Чуулганаас тусгай тогтоол гаргахгүй зөвлөн хэлэлцэж шийдвэрлэсэн зүйлүүдийг тэмдэглэн бичдэг зарчимтай байлаа.

Шийдвэрлэж чадахгүй асуудлаа Ховд манж сайдын газарт эсвэл Улиастайн жанжны газар тавьж хариу авна. Чуулган нийлэхэд тэр гарын чуулганы дарга, жанжин, хошуудын бүх засаг ноёд, тэдгээрийг дагалдсан түшмэл, бичээч нар очно. Чуулганыг чуулганы дарга, дэд дарга, жанжин удирдана. Тэднийг чуулганы да, дэд да гэж товчлон нэрлэж байв. Тэднийг Гадаад монголын төрийг засах явдлын яамнаас баталдаг байв. Тэд яамнаас өгсөн тусгай тамга хэрэглэн өөрийн гарын шүүн таслах, өртөө харуул, албан татварын зэрэг хэргийг эрхлэн шийтгэж байлаа. Чуулганы да-гийн дэргэд Да-гийн жасаа ажиллана.

Хошуудын хошууг Засаг ноён захирах ба Засаг ноён нь хошуудын доторхи феодалууд ард иргэдийг нийтээр захиран, засаг захиргаа, цэргийн хэргийг удирдах, албан татварыг хуваан гаргуулах, шүүн таслах, асуудлыг шийдвэрлэх үүрэгтэй байв. Тэд нар Ховд манж сайд болон чуулган дарга нарт шууд захирагдах ба хошууг захирах тамга хэрэглэнэ. Засаг ноён хошуугаа захиран баримтлах ажлыг тамгын газрын тусламжтайгаар явуулна. Хошуу тамгын газар бүхэн өөрийн гэсэн аппараттай байв.

1907 онд Манж нар Ховдын хязгаараас Алтайн хязгаарыг таслан байгуулах үед хошууд хошуу Алтайн хязгаарт хамрагдан Алтайн Шар сүмд суугаа манж амбанд захирагдаж болжээ. Түүний харьяанд Ховдын хязгаарын баруун хэсгээс урианхайн 7 хошуу, хошуудын нэг хошуу, шинэ торгуудын 2 хошууг Өрөнгийн голын адгийн болон Бүрэн тохойн сангийн тариалангийн газрыг таслан захируулж, мөн Алтайн ар өврөөр шилжин ирж суурьшиж байсан хасагуудтай нийлүүлж, эл шинэ засаг захиргааг “Алтайн хязгаар” хэмээн нэрлэжээ. Энэ хязгаарт хасгийн 12 мянган өрх бүхий 13 отог, 600 өрх бүхий урианхайн 7 хошуу, 200 гаруй өрх бүхий торгууд хошуудын 3 хошуу хамрагдах болжээ.⁵⁹

⁵⁷Муучхаа М, нас 83, Ховд аймаг Булган сум Баянгол багт 2011 оны 07-р сарын 20-нд, Аман мэдээ

⁵⁸Зугдаа Ж, нас 69, Ховд аймаг Булган сум Баянгол багт 2011 оны 07-р сарын 20-нд, Аман мэдээ

⁵⁹Моисеев.В.А Образование Алтайского округа в Китае в 1905-1906 гг. и его положение накануне Синхайской революции. Алтайский вестник. №2. Барнаул., 2002. т. 45.

1911 оны 12 сарын 29-нд Жибзундамба хутагтыг Монгол улсын шашин төрийг хослон барьсан хаан ширээнд өргөмжлөн залах ёслол Их хүрээнд болж Олноо өргөгдсөн Монгол улс байгуулагдсаныг албан ёсоор даяар олноо зарлан тунхаглав. Шинэ тулгар байгуулагдсан Монгол улсын төрийн бодлогын нэг гол зорилт нь Чин улсын захиргаанд байгаа бүх нутгаа чөлөөлж Ар Монголоор төвлөсөн үндэсний улсаа байгуулах явдал байсан тул Жибзундамба хутагтыг хаанд өргөмжлөн, тусгаар улс болж тулгар төр улсаа байгуулах тухай бичгийг Ар, Өвөр монгол тэр дундаа Ховдын хязгаарын олон хошуудад явуулж, тэднийг Монгол улсад нэгдэн орохыг уриалжээ.

Эдгээрээс 1912 оны 6-р сарын 29-нд хошуудын засаг тэргүүн зэрэг тайж Дамдинцэдэн хошууны ардын хамт Шинэ тулгар Монгол улсад нэгдэн орохоо илэрхийлжээ.⁶⁰ Энэхүү бичигт “Зарлигаар зарсан баруун хязгаарыг сэргийлэн батлах сайд цэргийн хэргийг бүгд захиран шийтгэгч яамны дэд сайд Зоригт бэйс, зөвлөн хавсран шийтгэх Зарлигаар шагнасан түүгэмэл сайтай Номун хан Жалханз хутагт танаа өргөв. Батлан мэдүүлэх учир Мөнөөхөн манж хятадын сайд түшмэлүүд зүйл зүйлээр дарлан зовоосон учир Монгол овогтон бүгдээр нийлж Очирдарь богд Жавзандамбыг хаан өргөмжилж тулгар төр байгуулсан явдлыг Жалханз хутагт номун хан Эрдэнэ бишрэлт засаг лам Дамбийжанцан нараас сая сэнхэрүүлэн ухуулсан дор өчүүхэн засаг би тэргүүлж манай нэгэн хошуу бүгдээр маш сүсэглэн баярлан дуртайяа Богд эзэн гэгээний тулгар төр дор дагаар орох учрыг гаргаж олдбаас сайд Зоригт бэйс, номун хан Жалханз хутагт танаа өргөн мэдүүлээд гуйхуй нь уламжлан айлтгаж өршөөн шийтгүүлэх ажаамуу. Үүний тул батлан өргөв. Олноо өргөгдсөний 2-р он, 6 сарын 29” хэмээжээ.

Дагаар орохоо илэрхийлэн “Хүсэн батлах бичиг”-ээ барьсан Хошууд хошууны хүсэлтийг баруун хязгаарын сэргийлэн батлах сайд Зоригт бэйс Наваанцэрэн, Жалханз хутагт Дамдинбазар нар хүлээн авч Богд хаанд хүргүүлжээ. 1912 оны 10-р сард хүсэлтийг ёсоор болгожээ.

Дамдинцэдэн тэргүүтэй хошууд хошуу Монгол улсад дагаар орж нэгдсэн явдал нь Ховд хотыг Манж хятадын дарлалаас чөлөөлөх таатай нөхцлийг бүрдүүлснээс гадна цаашид монгол угсаатны эв нэгдэл, нягтралыг улам бэхжүүлж Монгол улсын үндэсний тусгаар тогтнол аюулгүй байдлыг гадны аюулаас хамгаалахад чухал ач холбогдолтой байв.

1921 оны ардын хувьсгалын үр нөлөөгөөр харийн түрэмгийлэгчдийг хөөн гаргаж, бие даан хөгжих болсны улмаас 1931 онд засаг захиргааны зохион байгуулалт, бүтцэд шинэчлэл хийж хуучин засаг захиргааны хошууны тогтолцоог аймаг, сум гэсэн тогтолцоогоор өөрчлөн зохион байгуулснаар Хошуудын “Засаг” хошуу, Торгуудын нэг хошуу тус тус татан буугдаж, Ховд аймгийн Булган сум хэмээх шинэ нэгжид нэгдэн оржээ.⁶¹

Тус суманд амьдарч байгаа Хошууд нар Бүрэнхайрхан, Далт, Алаг толгой, Баянгол багуудад тус тус тархан амьдарч байгаа ба үүнээс Баянгол багт нийт Хошууд нарын 70 гаруй хувь нь амьдарч байгаа ажээ.

Булган голын Хошууд нарын засаг хошуу ноён, тайж нарын угсаа залгамжийг сонирхон авч үзье. 1790 онд Булган голд ирж суурьшсан Хошууд нарын дотор Хавт Хасарын угсааны Талаг убаш, Дэндэг тайж болон Мөнгөн ноёны хүү Буянхишиг нар хамт хүрэлцэн ирж, шинээр Хошуудын засаг хошуу байгуулан захиран суужээ. Одоо тус Булган суманд Талаг убаш, Дэндэг тайж нарын угсаа залгасан Аюуш, Жиймээ, Сандаг тайж нарын үр хойчис болох Баярмагнай нь Бадай, Хийрэв, Гунанбайн Гонгор, Тая, Жанамхай, Хөх нарын, Улиастын Ерөөлт, Долдой, Жавкаа, Баяр нарын, Пунцагийн Гомбожав, Тангад, Оросоо, Баачаа нарын, Бадамын Шовгор, Шилэг, Когшгоо, нарын үр хойчис болох нэлээд олон айл өрх хүмүүс амьдардаг ажээ. Эдгээр хүмүүс өөрсдийн жинхэнэ овог болох Боржигон овгийг Манжийн түрэмгийлэгчдээс болгоомжлон хэрэглэхгүй нууж, Хасарын 16 дахь үеийн ач Хайртын нэрээр (Хайртынхан) шинэ овог авч хэрэглэснээр даруй 200 гаруй жилийн өнгөрөөжээ. Тус хошууны ноёноор Мөнгөний хүүхэд Буянхишиг болон түүний хүүхэд Аюурсэд /түүний нэрийг Хошууд нар бүтнээр нь хэлж ярьдаггүй голдуу Араа ноён хэмээн хүндэлдэг байсан гэдэг/ нар үе залгамжлан суужээ. Аюурсэд ноён тухайн үеийн улс төрийн байдал, мөн худ урагтай ойртох/ түүний хатан нь Ховог сайрын Он ноёны садан байсан гэдэг/ гэсэн шалтгаанаар 1925–1926 оны үеэр Эвгээн Мөнхжаргал /Балжины дүү/, Довжуугийн Зул /эхнэр хүүхдээ орхин явсан/ зэрэг шадар туслахуудын хамт, Үрэмчид шилжин суурьшсан байна. Булганд үлдсэн засаг хошууныхаа албыг хошуу захирагч Цагаан буу /Цагаан бухгэж нэрлэдэг/-гийн Пагмад хариуцуулан үлдээсэн гэдэг. Ийнхүү Буянхишиг ноён болон түүний хүү Аюурсэд ноёны угсаа залгамж Булган сумын Хошууд нарын дунд бүрэн тасарчээ. Хошуу захирагч асан Цагаан буу түүний хүүхэд захирагч Пагма нарыг Хошуудын хүрээний 20 гаруй ламтай хамт хувьсгалын эсэргүү хэрэгт холбогдуулан 1938 онд баривчлан Улаанбаатар хотод аваачин цаазлан хороожээ. Захирагч Пагмын үр хойчис болох Разан, Дамчаа, Батбаяр, Хээмчиг нарын үр хүүхдүүд одоо Булган, Үенч сумдад ажиллаж амьдарсаар байна.

Хожим 1940 оны эхээр Аюурсэд ноёны шадар туслахаар явсан Довжуугийн Зул нутагтаа эргэн иржээ. Зулыг ирэхэд түүний аваал Мягмарын Намжил хүү Идшээ, эцэг Мягмарт үрчлүүлж Хатаамдын эмгээн Зодовтой ханилан суусан байжээ. Ингээд Зул өөр эхнэр авч охин дүүгээсээ төрсөн зээ хүү Гэнсээг үрчлэн авч өсгөсөн гэдэг. Зултай хамт ноёны бие хамгаалагчаар явсан Мөнхжаргал буцаж ирээгүй учир түүний аваал Хандсүрэн хожим Намдагтай ханилан суусан байна.⁶²

⁶⁰ МУИА. Ф А-141, Д-1, ХН-5, НБ-7

⁶¹ Очир А. “Монгол Ойрадуудын түүхэн товч”, УБ., 1993. тал 93

⁶² Дорж Е, нас 67, Ховд аймаг Жаргалант сум Буянт баг, 2011 оны 8-сарын 23-нд, Аман мэдээ

Энэ бүхнээс үзэхэд Хошууд нар нь маш эрт цагт түүхийн тавцан дээр гарч ирсэн эртний сурвалжит Монголын томхон аймгийн нэг байсан бөгөөд 1771 онд Ижил мөрнөөс торгуудын хамт нүүж ирэн улмаар Манж Чин улсад дагаар орсонд тэднийг Манж нар засаг захиргааны зохион байгуулалтанд оруулж чуулган, хошуу, сум зохиосноор хошуудын засаг хошуу байгуулагдан Манж Чин улсад он удаан жил захирагдаж олон зүйлийн албыг чармайн залгуулж байв. Шинэ тулгар Монгол улсын үе нь хошуудын засаг хошууны түүхэнд онцгой байр суурь эзлэх бөгөөд хошууны ард олон засаг ноён Дамдинцэдэнгийн хамт Монгол улсад нэгдэн орж, Ховдыг чөлөөлөх хэрэгт хүчин зүтгэлцэж гавъяа байгуулсан нь хошууд хошууны түүхэнд шинэ хуудсыг нээжээ.

1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын үр дүнд байгуулагдсан Монгол ардын түр засгийн газраас явуулж байсан бодлого үйл ажиллагааг хошууны ард олон талархан дэмжиж баруун хязгаарыг гамин бароны цэргийн үлдэгдлээс бүр мөсөн чөлөөлөх тэмцэлд хошууд нар гар бие оролцож явжээ.

Ардын засгийн жилүүдэд орон нутгийн засаг захиргааг шинэчлэн байгуулж байсантай холбоотойгоор хошууд нарыг торгууд нартай нэгтгэн 1927-1931 онд Булганмандал Бүрэнхан уулын хошууг байгуулан Чандмань уулын аймагт харъяалагдаж байсан бөгөөд 1931 онд Ховд аймаг байгуулагдахад Булган сумыг байгуулсан байна.

Эцэст нь тэмдэглэхэд өгүүлэн буй үеийн хошуудын түүхийг тус бүрд тодруулан судлах зайлшгүй шаардлагатай бөгөөд ингэснээр монголын түүхийн тэр дундаа ойрад монголчуудын түүхэнд буй бүрхэг бүдэг олон асуудлыг нээн тодруулахад чухал хувь нэмэр болох нь дамжиггүй.

НОМ ЗҮЙ

Сурвалж бичиг

1. Монголын нууц товчоо УБ.,1990
2. Судрын чуулган УБ.,1994
3. “Ойрад Монголын түүхэнд холбогдох сурвалж бичгүүд”УБ.,2001
4. Ойрад Монголын түүхэнд холбогдох сурвалж бичгүүд УБ.,2002
5. МУҮА. Ф А-141, Д-1, ХН-5,НБ-7

Судалгааны ном зохиол

1. Бадамхатан.С “БНМАУ-ын угсаатны зүй.II боть” УБ.,1996
2. Далай.Ч “Ойрад монголын түүх”УБ.,2006
3. Дорги.Б “Алшаан хошууд” Хөх хот., 2001
4. Мөнхдэлгэр. “Хавт Хасар” ӨМ.,2009
5. Нямдорж.Б “Ховдын хязгаар” УБ.,2006
6. Нямбуу.Х “Монголын угсаатан зүйн удиртгал”УБ.,1992
7. Очир.А “Монгол Ойрадуудын түүхэн товч”УБ.,1993
8. Оюунбилэг.Б “Хошууд товчоон” Хөх хот.,1990
9. Очир.А нар “Монголчуудын овгийн товч лавлах” УБ.,1998
10. Очир.А нар “Ховдчуудын овгийн лавлах, овог, угын бичиг сэргээх зөвлөмж” УБ.,1994

Аман мэдээ өгсөн хүмүүсийн нэрс:

1. Р.Тариа нас /80 Ховд аймгийн Булган сум Баянгол баг/ 2011
2. М.Муучхай нас /83 Ховд аймгийн Булган сум Баянгол баг/ 2011
3. Ж.Зугдаа нас /69 Ховд аймгийн булган сум баянгол баг/ 2011
4. Е.Дорж нас /67 Ховд аймгийн Жаргалант сум Буянт баг/ 2011
5. Т. Цамбаасүрэн нас /74 Ховд аймгийн Булган сум Баянгол баг/ 2011
6. Э.Гагаа нас /67 Ховд аймгийн Булган сум Баянгол баг/ 2011
7. Т.Шовгоон нас /73 Ховд аймгийн булган сум баянгол баг/ 2011
8. Т. Анкаа нас /68 Ховд аймгийн Булган сум Баянгол баг/ 2011
9. Б. Сүхтэй нас /63 Ховд аймгийн Булган сум Баянгол баг/ 2011
10. Ж. Алтангэрэл нас /50 Ховд аймгийн Булган сум Баянгол баг/ 2011
11. Б.Монтоо нас /65 Ховд аймгийн Булган сум Баянгол баг/ 2011
12. Л.Бадам нас /72 Ховд аймгийн Булган сум Баянгол баг/ 2011
13. У.Сүхтэй нас /62 Ховд аймгийн Булган сум Баянгол баг/ 2011
14. Б.Пирэнз нас /69 Ховд аймгийн Жаргалант сум Цамбагарав баг/ 2011
15. Ц.Энэбиш нас /60 Ховд аймгийн Булган сум Баянгол баг/ 2011
16. Б.Хүрэлцол нас /55 Ховд аймгийн булган сум баянгол баг/ 2011
17. Б.Алтангэрэл нас /46 Ховд аймгийн Булган сум Баянгол баг/ 2011
18. А.Жаргалсайхан нас /63 Ховд аймгийн Булган сум Баянгол багийн дарга/ 2011
19. Т.Замба нас /84 Ховд аймгийн Булган сум Бүрэнхайрхан баг/ 2011
20. П.Өлзий нас /55 Ховд аймгийн Булган сум Бүрэнхайрхан баг/ 2011
21. Ф.Баачаа нас /76 Ховд аймгийн Булган сум Баянгол баг/ 2011

БАЯДЫН ДУНДАД ӨМНӨД ХОШУУНЫ НОЁДЫН УГ ЭХ

Б.НямдоржДоктор(Ph.D), проф, Ховд их сургууль,
НХУС, Түүхийн тэнхимийн багш,
Б. Батцэцэг. Ховд, политехник коллежийн
Түүх нийгмийн ухааны багш, магистр
Б.Ууганцэцэг. ХИС-ийн магистрант

Товч утга: Эл өгүүлэлд Баядын дундад өмнөдхошууны ноёдын уг гарвал, угсаа залгамжилсан он цагийн дарааллын талаар өгүүллээ.

Түлхүүр үг: Баядын дундад өмнөдхошуу, хошууны ноён, цорос овог, засаг улсад туслагч гүн, өргөмжлөх, залгамжлах, Тэнгэр тэтгэгчийн, Төр гэрэлтийн, Бадаргуулт төрийн

Хошууны ноёдын уг эхийг судалснаар хойч үе нь өвөг дээдэс овог нэгтнийхээ алдар гавьяагаар бахархах, тэдний нэр төрийг хугалахгүй эрхэмлэн хайрлах үзэл санааг төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтойн дээр түүхэн бие хүний үзэл бодол, хүмүүжил төлөвшилд нөлөөлсөн хүчин зүйлсийг тодруулах, түүхийг эзэн биетэй болгох, тухайн угсаатны бүлгийн гарал үүслийн зарим асуудлыг судлан шинжлэх нэн чухал хэрэглэгдэхүүн болдог. Түүгээр ч үл барам эх түүхийн судалгаанд ч ач холбогдолтой гэрч баримт болж үлдэх нь дамжиггүй.

Баядын дундад өмнөдхошууны эх суурь Тэнгэр Тэтгэгчийн арван есдүгээр онд /1754/ тавигдсан бөгөөд энэ хошууны ноёдын дээд өвөг нь Ойрадын Эсэн хааны (тайш) ууган хүү Борнагалын удмын ноёд болох Бу Илдэнгийн залгамжрууд юм.

Эсэн хаан (тайш) Цорос овогтой тул түүний үр хойчис болох баядын дундад өмнөдхошууны ноёд нь цөм цорос овогтой болно.

Баядын дундад өмнөд хошууны ноёдын язгуур болох Ган нь Дөрвөдийн Цэрэн ханы холын хамаатан байсан {Цэрэл, 1997.т.69} гэж “Дөрвөн Ойрад ба Ойрадын холбоонд багтах үндэстэн ястнуудын угсаа түүхийн зарим асуудал” зохиолд бичсэн бол “Монголын хошуу нутгийн тэмдэглэл”-д “Хан Цэрэнгийн төрлийн дүү Ган нь Тэнгэр тэтгэгчийн арван наймдугаар онд /1753/ Манж чин улсад дагаар орсон {Чжань-Му, 1992.т.38} гэсэн байна. Тэгвэл “Чин улсын үеийн Монголын хошуу нутгийн чуулган” хэмээх бүтээлд “Ган бол Төгс хүлэг далай ханы төрлийн дүү болно. Гангын эцэг Үлэмж бол Бадамдоржийн ач мөн. Үлэмж хоёр хөвгүүнтэй. Ахмад хөвгүүн нь Ган билээ” {Намсрай,1984.т.354} гэж тэмдэглэжээ. Энэ бүхэн нь уг хошууны анхны ноён болох Ган нь Цэрэн ханы төрөл садан байсан гэдгийг нотлож байгаа боловч чухам ямар холбоотой болох талаар дурдсангүй. Гэхдээ эцгийн талын ясан төрлийн холбоотой буюу Цорос овогтой гэдэг нь тодорхой байна. Тодруулбал, уг хошууны ноёдын язгуур болох Ган нь Тэргэт тайшийн хоёрдугаар хүү Бу Илдэнгийн үр хойчис болохыг мэдэж болно. Учир нь Бу Илдэн Дөрвөд аймгийн нэг хэсгийг захирч явсан бөгөөд түүний харьяат дотор баядууд ихээр оролцсон байна. Бу Илдэн 4 хүүтэй, эдгээр нь Орлус, Бадамдорж, Эрдэнэбаатар, Бабуш нар юм. Түүний хоёрдугаар хөвгүүн Бадамдорж нь Мунхуйдай, Залаа гэдэг хоёр хүүтэй. Ахмад хүү Мунхуйдай нь Далай, Батмөнх, Үлэмж гурав бөгөөд Мунхуйдайн гуравдугаар хүү Үлэмж нь 2 хөвгүүнтэй ахмад хөвгүүн нь Ган болно.

Ган тэнгэр тэтгэгчийн арван наймдугаар онд /1753/ гурван Цэрэнг дагалдаж, Манж чин улсад дагаар орсонд Манжийн хаан түүнд засаг улсад туслагч гүн өргөмжилж, Бинт цол шагнаан олгуулжээ {Монгол., 1997.т.10}

Хошууны анхны ноён Гангийн талаар сурвалжид тэмдэглэгдсэн нэг зөрөөтэй мэдээ байна. **Үүнд :** “Монголын хошуу нутгийн тэмдэглэл”-д түүнийг Тэнгэр тэтгэгчийн 33-р онд /1768/ үгүй болсон хойно, түүний хөвгүүн Занбагат залгамжлуулсан гэж бичсэн бол “Монгол улсын шастир”-т Тэнгэр тэтгэгчийн 30-р онд /1765/ үгүй болжээ гэж бичжээ.

Ган ноёны нас барсан он цагийн асуудлыг “Монгол улсын шастир”-т зөв тэмдэглэсэн бололтой. Учир нь нэгд, “Монголын хошуу нутгийн тэмдэглэл”-ээс бусад өөр ном зохиол сурвалжид Ган ноёныг Тэнгэр тэтгэгчийн 33-р онд /1768/ нас барсан гэж бичээгүй, хоёрт Ган ноёны ахмад хүү Занабага нь уг хошууны ноёноор Тэнгэр тэтгэгчийн 30-р онд /1765/ өргөмжлөгдсөн гэдгийг бусад бүх сурвалжуудад нэгэн адил зөрөөгүй тэмдэглэжээ.

Ганг нас эцэслэсний дараа анх удаа Тэнгэр тэтгэгчийн 30-р онд /1735/ түүний ахмад хөвгүүн Занабага хошуу ноёноор өргөмжлөгдөж засаг улсад туслагч гүн залгамжилжээ. Сурвалжуудын мэдээгээр түүнийг хошууны ноён байх үед буюу Тэнгэр тэтгэгчийн 47-р онд /1782/ зарлигаар хошууг үе улиран тасралтгүй залгамжлуулах эрх олгожээ. Урьд нь хэдийгээр хошуу ноёдын үр хүүхэд нь эцгийн тушаал хэргэмийг залгамжилж байсан боловч албан ёсны хуулийн баталгаагүй [Очир, 1993.т.15] байв.

Тус хошууны ноёныг анх удаа залгамжилсан Гангийн ахмад хүү Занабагыг Тэнгэр тэтгэгчийн 30-р онд /1735/ уг хошууны ноёноор өргөмжлөгдөж, Тэнгэр тэтгэгчийн 50-р онд /1785/ насан өөд болсон гэж сурвалжуудад тэмдэглэснийг иш үндэс болговол Занабага нь 1765-1785 он хүртэл 20 жил уг хошууны хошуу ноён байсан байна.

Занабагыг нас эцэслэсний дараа Тэнгэр тэтгэгчийн 50-р онд /1785/ Занабагын ахмад хөвгүүн Чимэдбал хошууны ноёноор өргөмжлөгдөж, засаг улсад туслагч гүн залгамжилжээ.

Чимэдбалын нас барсан оныг “Монгол улсын шастир” хэмээх сурвалжид Төр гэрэлтийн 23-р онд /1843/ үгүй болов [Монгол., 1997.т.10] гэж бичсэн байна.

Чимэдбал нь тус хошууны хошуу ноёноор Тэнгэрийн тэтгэсний 50-р онд /1785/ өргөмжлөгдөж, Төр гэрэлтийн 23-р онд /1843/ насан эцэслэх хүртлээ хошуу ноён байсан гэж “Ховдын засгийн хэргийн бүгд цэс” , “Монгол улсын шастир” зэрэг сурвалжуудад тэмдэглэснийг үндэслэвэл Чимэдбал нь уг хошууны хошуу ноёныг хамгийн урт удаан хугацаанд залгамжилж, 1785-1843 он хүртэл 58 жил хошуу ноён байсан байна. Түүний талаар үүнээс өөр тодорхой мэдээ сурвалжуудад алга байна.

Уг хошууны 3 дахь ноёноор Чимэдбалыг насан өөд болсны дараа түүний төрсөн ач хөвгүүн Дагдан өргөмжлөгдөж, Төр Гэрэлтийн 23-р онд /1843/ засаг улсад туслагч гүн зэрэг залгамжилжээ. Дагдан нь Төр гэрэлтийн 24-р онд /1844/ нас барсан ажээ [Монгол., 1997,т.10].

Тэрээр дээрх хошууны хошуу ноёныг 1843-1844 он хүртэл нэг жилийн хугацаанд залгамжилсан бөгөөд мөнхүү хошууны хошуу ноён залгамжилсан ноёдын дотроос хамгийн богино хугацаанд хошуу ноён байсан хүн юм.

Дагданг нас барсны дараа баядын дундад өмнөд хошууны дөрөв дэх ноёноор Дагдангийн төрсөн дүү Дугарба өргөмжлөгдөж, Төр гэрэлтийн 24-р онд /1844/ засаг улсад туслагч гүн залгамжилжээ. Дугарба нь Бүрэн засагчийн 8-р онд /1869/ нас барсан бөгөөд түүний талаар сурвалжуудад үүнээс өөр тодорхой мэдээ алга байна.

Харин бидний авсан аман мэдээнүүд уг хошууны дөрөв дэх засаг ноён Дугарба нь хошууны засаг ноён залгамжлах үр хүүхэдгүй хүн байсан тул хошуу засаг ноёнгүй олон жил болсноос төрлийнх нь ах дүү нарын дотор хошууны засаг ноён болохын төлөө тэмцэл гарах шинжтэй болсон. Иймээс нутгийн нөлөө бүхий хүмүүс баядын бусад ноёдын тусламжтайгаар төвдөөс лам залан Дугарба ноёны хойд дүрийг тодруулах үйл ажиллагаа явуулж түүний үеэл авга Лувсанг тодруулсан байна. Ингэснээр 1869-1888 он хүртэл 19 жилийн хугацаанд засаг ноёнгүй байсан хошуу засаг ноёнттой болсон.

Дугарбагийн дараа уг хошууны тав дахь ноёноор Дугарбагийн үеэл авга Лувсан өргөмжлөгдөж, Бадаргуулт төрийн 14-р онд /1888/ засаг улсад туслагч гүн залгамжилжээ.

Лувсанг сурвалжид Бадаргуулт төрийн 20-р онд /1894/ нас барж, түүний ор сууринд нь Түмэнбаяр суужээ гэж бичсэн байна.

Баядын дундад өмнөд хошууны дээрх хошуу ноёдын талаар сурвалжуудад тодорхой зүйл дурдаагүйг үзэхэд ямар нэг томоохон гавьяа шагналгүй хүмүүс байсан бололтой.

Тус хошууны зургаа дахь буюу хамгийн сүүлчийн хошуу ноёноор Лувсангийн ахмад хүү Түмэнбаяр Бадаргуулт төрийн 21-р онд /1895/ өргөмжлөгдөж, засаг улсад туслагч гүн залгамжилжээ (Зураг-1).

Түмэнбаяр нь Лувсангийн ахмад хүү бөгөөд Бу Илдэнгийн тав дахь үеийн ач, Ганы зургаа дахь үеийн ач юм [Сүхбаатар.На, 2000.т.104].

Түмэнбаяр нь баядын дундад өмнөд хошууны 6 ноёны дундаас Монголын хаадаас хамгийн олон удаа шагнал урамшил хүртэж байсан бөгөөд тухайн үедээ Ховдын хязгаарын Дөрвөд 2 аймгийн ноёдын дотор нөлөө бүхий ноёдын нэг байжээ. Тэрбээр хошууныхаа болон баруун хязгаарын улс төрийн зарим хэрэгт идэвх зүтгэлтэй оролцож байсан тухай мэдээ Үндэсний төв архивын баримтуудад хадгалагдаж байна.

1911 онд Богд Жибзундамба хутагт хаанд өргөмжлөгдөж, монголын төрийн тусгаар тогтнолыг сэргээсний дараа гүн Түмэнбаяр Монгол улсын тулгар төрд дагаар орсон учир Олноо өргөгдсөний хоёрдугаар онд /1912/ Богд Жибзундамба хаан түүнд хишиг хүртээж, нэгэн зэрэг дэвшүүлж, үе улиран засаг улсын Түшээ гүнгийн хэргэмийг залгамжлуулж, Саруул цол олгон харьяат засгийн тамгийг үсэгт оруулан цутган үйлдүүлж үүрд шагнаан хүртээжээ. Мөн 2-р онд зарлигаар засаг улсын түшээ гүн Түмэнбаярыг Дөрвөдийн Зүүнгарын Төгс хүлэг далай хан аймгийн цэргийн туслагч жанжинд (өөрсдийн гарын цэргийн хэргийг эрхлэн шийтгэх үүрэгтэй) тохоон томилсон байна. 4-р онд /1914/ Түмэнбаяр гүн их цэргийн хэрэглэлд хувиасаа гучин лан мөнгө тусалсанд нэг тэмдэглэсэн зэрэг шагнаан олгожээ.

Түүнчлэн хутагт Дамбийжанцаны сүр хүчийг тэсвэрлэн хүлээж чин батыг барьсан учир 4-р онд /1914/ зарлигаар 2 нэмсэн зэрэг, 2 тэмдэглэсэн зэрэг, 5-р онд /1915/ орд сүмийн үйлдвэрт мөнгө 30 ланг тусалсанд нэг тэмдэглэсэн зэрэг шагнажээ [Баруун..., 2003. т. 33].

Түмэнбаяр гүн гурван жилийн дараа Олноо өргөгдсөний 8-р /1918/ онд Цогчин дуганы үйлдвэрт мөнгө туслан барьсан учир айлтгаад нэг тэмдэглэсэн зэрэг, мөн 8-р /1918/ онд улсын санд мөнгө хариулан өргөсөн учир айлтгаад 2 нэмсэн, 2 тэмдэглэсэн зэрэг шагнаан хүртээжээ [Монгол., 1997.т.10].

Саруул засаг улсын Түшээ гүний хошууны сүүлийн ноён Түмэнбаярын тухай ийнхүү авч байсан гавьяа шагналыг нь сурвалжуудад тодорхой тэмдэглэсэн боловч нас барсан он цагийн талаар тодорхой мэдээгүй зөвхөн “Увс аймгийн тайлбар толь”-д түүнийг 1895-1924 онд хошууны засаг ноён байсан гэж бичжээ. Бид энэ мэдээг үндэслэн түүнийг 1924 онд нас барсан гэж үзэж байна. Үүнээс гадна Түмэнбаяр гүнийг 1924 онд хошууны засаг ноён байх үед ардын шинэ засаг төр тогтоохтой холбоотой бичиг ирж хошуу захирч байсан ноёдын эрх ямба хасагдах болсонд сэтгэл таагүй байж байгаад удалгүй нас барж Хачиг уулын оройд нутаглуулсан гэдгийг аман мэдээнүүд давхар нотолж байгаа юм.

Ийнхүү Түмэнбаяр гүн нь Бадаргуулт төрийн 21-р /1895/ онд хошууны засаг ноёноор өргөмжлөгдөж засаг улсад туслагч гүн залгамжилснаас хойш 1924 он хүртэл 29 жил хошууны засаг ноён суужээ. Хошууны сүүлчийн засаг ноён Түмэнбаяр нь Чулуунгомбо, Шунгаагэнэн, Дахаа, Тоодор, Бумаа гэсэн 5 хүүхэдтэй байснаас бага охин Бумаа нь одоо 88 настай Увс аймгийн Баруунтуруун суманд амьдарч байна (Зураг-2).

Архивын баримтаас үзэхэд түүний ахмад хүү Чулуунгомбо нь 1904 онд төрсөн, 1938 онд Гэндэн, Дэмид нарын бүлэгт оролцсон, цуурхал тараасан зэвсэгт бослогод бэлтгэсэн гэж хилс хэрэг хүлээлгэн ШЦБ-ийн 43, 44-р зүйлд зааснаар буудан алж хөрөнгийг нь хураах ялаар шийтгэгдэн ОБЭК-ын 12-р хуралдаанаар 1938 оны 04 сарын 01-нд цаазлагдаж хожим 1992 оны 08 сарын 20-нд ДШЦК-ын 148-р магадлалаар цагаатгагдсан бол отгон хүү Шунгаагэнэн нь 1908 онд төрсөн, 1937 онд Цогоод элсэн Гүрийг элсүүлж бослого гаргахад бэлтгэсэн, дотоод яамны ажилчдыг алж хорлохыг оролдож байсан гэж ШЦБ-ийн 43, 44-р зүйлд зааснаар буудан алах ялаар шийтгэгдэн ОБЭК-ын 29-р хуралдаанаар 1938 оны 08 сарын 19-ны өдөр цаазлагдан ДШЦК-ын 90-р магадлалаар 1989 оны 08 сарын 01-нд цагаатгагджээ.

Хошууны ноёдын угсаа залгамжилсан он цагийг дарааллаар нь авч үзвэл Ган ноён 1754-1764 он хүртэл 11 жил, Занабага 1765-1785 он хүртэл 20 жил, Чимэдбал 1785-1843 он хүртэл 58 жил, Дагдан 1843-1844 он хүртэл 1 жил, Дугарба 1844-1869 он хүртэл 25 жил, Лувсан 1888-1894 он хүртэл 6 жил, Түмэнбаяр 1895-1924 он хүртэл 29 жил тус тус хошууны засаг ноён залгамжилжээ.

Хошууны ноёдын нэр, угсаа залгамжилсан оныг доорх хүснэгтээр үзүүлжээ.

Д/д	Хошууны ноёдын нэр	Хошууны ноён суусан он	Тайлбар
1.	Ган	1753-1765	Цорос овогт тайж, түүнийг Дөрвөдийн “Дундад өмнөд хошууны” засаг ноён болгож улсад туслагч гүнгийн хэргэм “Бинт” цол олгожээ.
2.	Занабага	1765-1785	Гангийн ахмад хөвгүүн засаг улсад туслагч гүнг залгамжлав
3.	Чимидбал	1785-1843	Занабагын ахмад хөвгүүн засаг улсад туслагч гүн залгамжлав
4.	Дагдан	1843-1844	Чимэдбалын ач засаг улсад туслагч гүн залгамжлав
5.	Дугарба	1844-1869	Дагдангийн төрсөн дүү засаг улсад туслагч гүн залгамжлав
6.	Лувсан	1888-1894	Дугарбагийн үеэл авга засаг улсад туслагч гүн залгамжлав
7.	Түмэнбаяр	1895-1924	Лувсангийн ахмад хөвгүүн засаг улсад туслагч гүн залгамжлав. 1912 онд Богд хаанаас түшээ гүнгийн “Саруул” цол олгожээ.

1922 онд Баянмандал хэмээх газар тэр үеийн Дөрвөд далай хан аймгийн Зүүн гарын баядын арван хошууг (Саруул гүн, Дайчин ван, Баатар бэйс, Түшээ гүн, Эрдэнэ гүн, Раши гүн, Жанжин гүн, Паньдаа бэйл, Жонон бэйл, Вангаа бэйл) хамарсан нутгийн захиргааг “Баянмандал уулын хошуу тамгын газар” нэртэйгээр байгуулж, хошууны даргаар Саруул жанжин гүний хошууны ядуу ард Магнайгийн хүү Биньээ гэгч сонгогдон ажиллаж байжээ.

Эцэст нь дүгнэхэд баядын дундад өмнөд хошуу байгуулагдаад 170 жил оршин тогтноход цорос угсааны 6 засаг ноён тэргүүлжээ. Хошууны засаг ноёд нь хошууг Ган ноёноос эхлэн Дугарба хүртэл тасралтгүй угсаа залгамжилсан боловч Дугарбаг Бүрэн засагчийн 8-р онд /1869/ нас барсны дараа түүний үеэл авга Лувсан Бадаргуулт төрийн 14-р онд /1888/ засаг улсад туслагч гүн залгамжлах хүртэл 19 жилийн хугацаанд засаг ноёнгүй байсан байна. Саруул гүний хошууны ноёдоос Монголын хаадаас олон удаа шагнал урамшил хүртсэн Дөрвөд 2 аймгийн ноёдын дотор нэр хүндтэй нөлөө бүхий ноён нь Түмэнбаяр гүн байжээ. Түүний үр хүүхдүүд 1930 оны сүүлээр монгол орныг нэлэнхүйд нь нөмөрсөн улс төрийн хилс хэрэгт баривчлагдан хэлмэгдсэн эмгэнэлт хувь заяаг туулсан байна.



Баруун гар талаас орос цэргийн хувцас өмссөн Дамбийжанцан, ар эгнээнд Түмэнбаяр гүн (А.В. Бурдуковын авсан гэрэл зураг)



Зураг-2 Түмэнбаяр гүний бага охин Т.Бумаа үр хүүхдүүдийн хамт

Резюме

В течении 170 лет своего существования хошуном Саруул гуна управлял 6 дзасаки- князи цоросского происхождения. Дзасаки –князи хошуна начиная с дзасака Гана до Дугарба неперемменно управляли хошуном, после смерти Дугарба /1869/ в течении 19 лет хошун был без управителя до того, как его кузин по отцовской линии Лувсан стал управлять им. Из гунов хошуна Саруул заяата Түмэнбаяр гун много раз был награждён Монгольскими ханами и имел авторитет среди гунов дурбетских 2-х аймаков. Дети Түмэнбаяр гуна прожили трагическую жизнь, что были подвергнуты политическим поклёпкам, происходящим в 30-ые годы в Монголии.

НОМ ЗҮЙ

1. [Баруун..., 2003] "Баруун Монголын хан, хэргэмтэн, засаг тайж, түшмэд, ямба олсон лам, суусан газар орныг байцаасан цэс оршив" УБ., 2003 /Хэвлэлд бэлтгэсэн Г.Дашням, Ц.Гантулга, На. Сүхбаатар/
2. [Монгол..., 1997] Монгол улсын шастир. II дэвтэр /хэвлэлд бэлтгэсэн А.Очир, З.Лонжид, Ц.Төрбат/. УБ., 1997
3. [Намсрай, 1984] Намсрай. "Чин улсын үеийн Монголын хошуу чуулган". Хөх хот., 1984
4. [Нямаа, 1999] НямааА. "Увс аймгийн тайлбар толь", УБ., 1999
5. [Очир, 1993] ОчирА. "Монголын Ойрадуудын түүхийн товч". УБ., 1993
6. [Ховдын..., 1799] "Ховдын засгийн хэргийн бүгд цэс". 1799. ГБС. УТНС
7. [Цэрэл, 1997] ЦэрэлБ. "Дөрвөд Ойрад ба Ойрадын холбоонд багтах үндэстэн ястнуудын угсаа, түүхийн зарим асуудал", 1997
8. [Чжань-Му, 1992] Чжань-Му. "Монгол хошуу нутгийн тэмдэглэл". Доорд дэвтэр. Хөх хот., 1992

XX ЗУУНЫ ЭХЭН ҮЕИЙН МОНГОЛ-АМЕРИКИЙН ХАРИЛЦААНЫГҮҮХЭНД ХОЛБОГДОХ НЭГЭН БАРИМТ БИЧИГ

Л.Нямсүрэн
Ховд Их Сургууль. Нийгэм хүмүүнлэгийн
ухааны сургууль. Түүхийн тэнхим

Өгүүллийн товч утга: 1918-1920-иод онд Монгол-Америкийн засгийн газрын төлөөлөгчдийн хооронд улс төр, худалдаа арилжааны харилцаа тогтоох асуудлаар албан ба албан бус нууц уулзалтууд болж байсан бөгөөд тэдгээрт холбогдох нэгэн баримтыг хуулбар эхээр нь судалгааны эргэлтэд оруулахыг оролдсон болно.

Түлхүүр үг: Монгол улсын өөртөө эзэрхэн захирах эрх, тусгаар тогтнол, үндэсний эрх ашиг.,

XX зууны I хагаст Төв Азид Англи, Герман, Франц, АНУ зэрэг орнуудын капитал Хятадын худалдаачид, мөнгө хүүлэгчдээр дамжин орж ирэх болсон. Энэ үед АНУ-ын элчин, консулын газар Бээжин, Хаалганд байгуулагдсан нь Монголчуудын хувьд тэдэнтэй харилцаа холбоо тогтоох анхны гүүр болсон юм. Америкчууд ч гэсэн Монгол орны зах зээлийг ихэд сонирхож Монголд болж буй үйл явдлыг ажиглан түүнд нөлөөлөх боломжийг эрж хайх болжээ. Гэвч дэлхий ертөнцийн эсрэг хоёр талд нэг нэгнээс хамгийн алс оршигч огт өөр түүх, хэл, соёл, зан заншил бүхий Монгол улс, АНУ-ын хооронд харилцаа холбоо тогтоож, хамтын үйл ажиллагаа явуулах нь ихээхэн ээдрээтэй үйл явц байсан боловч хоёр улсын харилцаатай холбогдох цөөнгүй баримт бичиг бидний үед уламжлагдан хадгалагдаж үлдсэн байна.

Өдгөө Монгол улсын Үндэсний архивт АНУ-ын Үндэсний архивын NARA дахь салбарын Төрийн яамны архивт буй 1911-1922 оны хооронд Хятадад АНУ-аас сууж байсан Төлөөлөгчийн газар, Консулын алба, Хэргийг түр хамаарагч, Консул, төлөөлөгч нараас Төрийн яамны сайдад явуулж байсан Монгол улс, Өвөр Монголтой холбоо бүхий бүс нутаг, олон улсын ач холбогдол бүхий албан бичиг, цахилгаан мэдээ, нот, тайлан, шифрэлсэн мэдээ, сонин хайчилбар зэрэг нийт 434 хуудас архивын баримт бичиг хуулбар⁶³ байдлаар хадгалагдаж байна. Эдгээр бичиг баримт дотроос АНУ-ын сайдын орлогч Арт Руддокын 1920 оны 09 сарын 09-ны өдөр Төрийн нарын бичгийн даргад илгээсэн "Европоос буцаж явсан АНУ-ын цэргийн атташегаар дамжуулан АНУ-ын ард түмэнд Монгол улсын ноёд түшмэдээс Богд хааны тамгаар баталгаажуулсан өргөх бичиг"-ийн англи орчуулга анхаарал татсан юм.

Тус өргөх бичиг нь "Statement of facts" хэмээх нэртэй ба түүний монгол эхийн хуулбартай миний бие Америкийн судлаач Campi.Alicia Jean-ны /1988. *The political relationship between the United States and Outer Mongolia. 1915-1927, The Kalgan Consular records. Doctoral dissertation, INDIANA UNIVERSITY*/ бүтээлээс танилцсан бөгөөд тус баримт бичгийг энэхүү өгүүлэлээр тодруулан цаашид судалгааны эргэлтэд оруулахыг зорив.

XX зууны эхэн үед Монгол улсын гадаад дотоод байдал ихэд хүндэрч, өөртөө засах эрх алдагдах аюул нүүрлэмэгц тус улсын засгийн газар дан ганц өөрсдийн хүчээр бүхнийг шийдвэрлэхэд хүчин мөхөсдөх учраас гуравдагч орноос дэмжлэг туслалцаа авахыг оролдон янз бүрийн арга сүвэгчилж байв. Энэ үед /1920 оны 4 сар/ Хятад дахь Америкийн консул Чарлез Эберхард Монголын байдлыг туршин үзэх аялалаар Хүрээнд ирсэн нь Монголын төрийн лам, ноёд язгууртнуудад томоохон хувь завшаантай хэрэг болсон төдийгүй АНУ-аас тусламж хүссэн Богд Жибзундамбын тамгатай бичгийг гардуулан өгчээ.

⁶³Бодонгууд овогтой И.Бямбабаатар АНУ-ын Вашингтоны их сургуульд сурч байхдаа АНУ-ын Үндэсний архивын NARA дахь салбарын Төрийн яамны архивт сууж дээрх баримтуудыг түүх судлал, олон улс судлалын үнэтэй баримт бичиг хэмээн үзэж хувиран авч 2003 оны 07 сарын 03-ны өдөр Монгол улсын Үндэсний архивт хүлээлгэн өгчээ.

Дилав хутагтын дуртгалд “Хаврын дунд сард Мэй улсын түшмэл Ибархард Монголын явдлыг үзэхээр Хүрэнээ ирээд Ларсангийн хамт Жалханз гэгээнд очиж уулзсанд Бээжинд явах төлөөлөгч нар ба ихээхэн ноёд нар уулзаж тусламж эрэх учраа сэмээр илтгэсэн ба Мэй улсаас тусламж гуйсан Богд хааны тамгатай бичгийг Жалханз гэгээн түүний буудалд очиж тушаан өгөв. Энэ тухай Ларсан хэлмэрчлэв,[Ариун сэтгэл авралын үндэс.УБ.,2000 тал 107-108,167] гэж тэмдэглэжээ. Мөн Дилав хутагтын намтарт ...тэр үест Америк улсын албаны хүн ирж манай монголыг тусалж болох мэт үг хэлсэнд Богд хаанаас Жалханз багшийг түүн лүгээ уулзаж хэлэлц хэмээсэнд багш түүн лүгээ уулзан хэлэлцэхэд тэр мөн туслахаар хэлж бичиг авч явах болсонд нэг шөнө дайчин ван Жалцан, мөн түүний хошууны Түвшин захирагч, Хатанбаатар бид нар нийлж тусламж гуйсан бичиг бичиж бэлгийн хамтаар Жалханз багш биеэр аваачиж өгсөн”[Г.Дүйнхэржав.УБ.,1991 тал 22], тэрчлэн ...уг бичигт Гадаад Монголын автономийг сэргээх үндэслэлийг тодорхойлсон болно[Ариун сэтгэл авралын үндэс.УБ.,2000 тал167] хэмээн өгүүлжээ.

Жалханз хутагтаас Монголчууд АНУ-ын хамгаалалыг эрж, Хятадын эрхшээлээс чөлөөлөгдөхийг хүссэнийг сонсоод Эберхардт “ямар нэгэн материаллаг үр дүн хүлээх хэрэггүй” гэдгээ илэн далангүй өгүүлээд АНУ Монголыг дэмжих ямар ч үйл ажиллагаа явуулж чадахгүй нь харамсалтай. Учир нь Хятадтай нөхөрсөг харилцаатай тул хэрэв Монголыг дэмжвээс Хятадын талд найрсаг бус хандсан хэрэг болно гэжээ. Гэсэн хэдий ч Монголчууд Эберхардт гурван баримт бичиг өгсөн байна. Нэг нь “Statement of facts” нэртэй Монголчуудыг Хятадын эрхшээлээс ангижруулахад дэмжих АНУ-ын цэргийн тусламж хүссэн өргөдөл, нөгөө хоёр нь 1915 оны Хиагтын гурван улсын гэрээний хуулбар ба 1919 оны 11 сард генерал Ху[Сюй Шүжан] ба Монголчуудын гарын үсэг зурсан Монголын автономит төрийг цуцласан бичиг байв.[Mongolia Survey...1999 тал 50-51]

Энэ баримт бичигтэй ...Хиагтын гурван улсын гэрээ, Сюй Шү жаны хүчээр тулгаж, Автономийг устгасан бичгийн хуулбарыг дагалдуулан илгээсэн нь ...Монголын тусгаар эрхийг устгасныг баримтжуулан олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрүүлж улс төрийн дэмжлэг олох гэсэн [Л.Нямсүрэн.УБ.,2006 тал 56] оролдлого байсан гэж үзэж болох юм.

АНУ-аас тусламж хүссэн бичигт мөр тэтгэх ёсоор “Үнэнийг илтгэх нь”, “Өргөн толилуулах нь” хэмээн бичээд улмаар Монголын тусгаар эрхийн талаарх Хиагтын 3 улсын гэрээ, Сюй Шүжан Монголын Автономит эрхийг хүчээр устгасан тухай өгүүлэн “...манай Богд хаанаас Да жунтунд баяр бэлэг хүргүүлэх ялдарт танай эрхэм улсад учрыг нэвтрүүлж тус хамгаалалыг өргөхүй хүмүн явуулах хэмээсэнд Иргэний яамнаас зүй өргөхүйг цаазлан хорисонд арга буюу боогдож, ...эдүгээ хүртэл хоригдсоор буй тэд нар ямар зүйлийн сайнаар эхлэвч итгэхүй бэрх тул эл учрыг Их улсад мэдэгдэх тэнхрүүлэхүйг хүсэвч нэвтэрч хүрэх зам сүвийг олох үгүй арга мөхөж мэгдүүрэн бүхүйд Эрхэм улсын өршөөнгүйт Засгийн газраас тусгайлан томилон ирсэнд бид бүгдээр баярлалдаж эл бүхүй үнэн байдал дүрсийг товчхоноор тодорхойлон бичиж, “Их улсын засгийн газар нэвтэргүүлснийг хүрмэгц манай монголчуудыг гүн хамгаалалд багтааж одоогийн харгис хатуу, хүчирхэг этгээдээс нэн хурдан хэрхэн ангижруулж сүр хүчээр батлан хамгаалж, урьдын ёсоор Автономит засгийг байгуулж, Богд хааныг хэвээр хаанд өргөмжилж элдэв эрх мэдлийг өөрөөн засаж шаашин үндэснийг бататгаж газар орныг ариутган тохиуулж аль ч улсаас тэмцэл хямралыг өдөөлж халдан зовоох үгүй болгож, амар цэнгэлд оруулбаас бидний Монголчуудад маш гайхамшигтай хэмээх ч байтугай Их улсад ашиг буй. Иймийн тул их найрамдлын ёсоор гуйсугай”[Campi.Alicia Jean.1988 page 276] хэмээн өгүүлжээ.

An English club is a group experience that occurs three times a week for eleven-year-old children. It is less formal than a regular course at the primary school level. The emphasis of the English club is on exposure to the English language rather than the development of a strict set of English language skills. The types of activities found in an English club are more like the types of hands-on activities found in a Girl Guide or Boy Scout meeting than the teacher-centered activities found in a regular fifth or sixth grade class. If you were to visit an English club, you would notice learners making things, singing songs, and doing other enjoyable activities in English. During English club time, children are engaged in hands-on fun activities in keeping with the overall spirit and aim of the Club. Children do word snake puzzles, linking words together. Learners also make things, such as puppets or pictures, related to the topics they are learning about in English. Children are also encouraged to have fun singing songs during English club time. English club teachers are trained to lead singing activities that encourage children to be actively involved by clapping hands to the rhythm of the song, using body actions, or singing in rounds.

By law, Tunisian schoolbooks must be produced locally. This means that educators can develop their own materials that are in keeping with the local needs and goals. Educators created their own student books for English clubs. These materials could be considered resource books more than textbooks. The student books provide learners with vocabulary and the context of the vocabulary and are used as a resource for the songs and hands-on activities that students engage in during English club. Additional materials for the English clubs were donated by the American Cultural Center and the British Council. All of the English clubs were provided with picture dictionaries and a cassette and CD of favorite children's songs. Some of the English clubs were given supplementary commercial textbooks that included picture cards.

Worldwide it is very difficult to implement young learner English language teaching (ELT) programs because there are not adequate numbers of teachers who (1) have the necessary skills to work with young learners and (2) are proficient in the English language. The decision was made in Tunisia to staff the English clubs with primary school teachers who received focused English language instruction. Prior to the widespread introduction of the English clubs, primary school regular education teachers underwent a two-year program of language improvement. Primary school teachers attended courses, in their regions, led by the best secondary school English language specialists. These courses provided primary school teachers with the basic English language skills required to conduct the English clubs. In order to create state of the art programs, the Tunisian Ministry of Education put together a teacher training program with two components. Primary school teachers received English language improvement classes (described above) as well as training in teaching English as a foreign language.

Appropriate methodologies for use in the English clubs were modeled as part of the English language improvement classes. In addition, at regular intervals the teachers received methodology training. The methodology seminars were held in regional teacher training centers during the academic year and also in national English Language Villages held in summer. English Language Villages provide an innovative way to expose primary school teachers to the English language. English Language Villages were set up as six-day camps for primary school teachers. Everything about the camp, from food service to evening activities, was conducted in English. All of the

signs of the camp were in English. The music played during breaks was all in English. Primary school teachers attended language improvement sessions as well as methodology workshops as part of the camp.

Other countries wishing to embark on English language study in the primary schools could learn from the Tunisian program. Listed below are specific recommendations for others considering the development and implementation of young learner programs.

1. Consider the context

Although it may be easy to merely adopt a textbook and curriculum being used in a neighboring country, it is important that the Ministry of Education and regional authorities determine what is most appropriate for a particular group of young learners. The entire context should be considered, including the primary language of learners, the level of literacy of learners, their exposure to one or more than one language, learners' exposure to the Latin writing system, and, finally, the resources available to implement a young learner program. Local education officials shouldn't bow to pressures from international agencies and international publishers to merely adopt what has been created for another country or even another region within the same country.

2. Develop goals

It is important to have clear and realistic goals. It is impossible to create and implement a quality program without knowing the aim of the program. It is also necessary to have realistic goals that can be met with the available resources. For example, the top officials may want every child in every school to become completely bilingual within a period of three years, but if there are not enough teachers who can speak English and are trained to work with young learners, this goal cannot be met.

3. Create a comprehensive multi-year plan

A quality young learner ELT program cannot be implemented overnight. Quality programs should be developed and implemented over a number of years. The comprehensive plan should address every aspect of program implementation, including teacher training, resources, and the impact on the total primary curriculum. For example, if English is offered for 100 minutes a week, the number of minutes available for other subjects or activities may have to be decreased, and this cannot be done without careful planning and involvement of individuals from different departments within the Ministry of Education.

Conclusion

The Tunisian English program for young learners has been extremely successful for several reasons. First of all, it was developed based on local needs and conditions. Second, realistic goals were formulated that could be met with available resources. Based on the conditions and resources in Tunisia, the goals of the young learner program are to sensitize children to the English language and also to help children develop a positive attitude towards the English language. The best way to achieve the goals was by establishing English clubs instead of traditional English language classes. Third, the program was not developed and implemented overnight but rather over several years. Other countries wishing to develop or modify English language instruction for young learners might want to consider setting up English clubs in place of formal classes. English clubs are an alternative to traditional classes that focus on paper and pencil tasks. If the focus of the first or first two years of English language instruction of a young learner program is on providing children with an enjoyable, stress-free exposure to English, then it is worth considering instituting English clubs.

REFERENCES

1. Birdsong, D. 1999. *Second language acquisition and the critical period hypothesis*. Mahwah, NJ: Lawrence Erlbaum Associates.
2. Krashen, S. 1986. *The input hypothesis: Issues and implications*. London, UK: Longman,
3. Marinova-Todd, S., D. Marshall, and C. Snow. 2000. Three misconceptions about age and L2 learning. *TESOL Quarterly*, 34 (1): 9–34.

THE CURRENT SITUATION OF TEACHING OFFICIAL LANGUAGE TO KAZAKH ETHNIC MINORITIES IN MONGOLIA

Kh. Byeibitgul Khovd State University

Mongolia is a relatively homogenous country in Central Asia with a population of 2.7 million (the map see figure 1.1)land located between China and Russia. Accordingly Population and Housing census of Mongolia (NSO, 2011) there are estimated 14 ethnic groups such as Buriyat, Durvud, Uuld and etc. However majority of those ethnic groups considered to be not ethnically distinct, but well integrated groups experiencing

relatively similar language and cultural heritage such as religious practice, dwellings, writing system with mainstream Mongolians.

Amongst them, Turkic speaking Kazakhs are the largest ethnic minority group in the country. Unlikely above-mentioned ethnic groups, Kazakhs have different language, religion and are more culturally diverse than other inhabitants of Mongolia. In terms of religious practice, Kazakhs are Sunni Muslims, hence main cultural events such as wedding; funerals and so on are mostly held according to Islamic practice. Immigrating from the Xinjiang Uighur province China in the late of XVIII century (Frinke, 1999 as cited in Barkus & Werner, 2010) Kazakhs soon officially accepted as the citizens of the country in 1912 (Jukey, 2008 p.49). From that time, Kazakhs enjoy their rights given by the Constitution and other legal provisions to ‘use their native language in education and communication, and pursuit of cultural, artistic and scientific activities’ (Paragraph 8.2, The Constitution of Mongolia, 1994). In 1940, due to the request from Kazakh and Urianhai ethnic minorities ‘to maintain their linguistic and cultural heritage’ (Shinay, 2008, p.125) a Kazakh administrative unit “Bayan-Ulgii” was established in Western part of Mongolia. As 2011, Kazakhs constitute 3.6 % of the total population (NSO, 2011) of Mongolia and 90% of them live in Bayan-Ulgii province (For the number of Kazakhs see table 1.1)

Table 1.1. *The distribution of Kazakhs in Mongolia*

Provinces	Number of Kazakhs	Percentage of Kazakhs in respective provinces
Bayan-Ulgii	88578	87%
Khovd	9932	9.4%
Other	3016	2.6
Total	101526	100%

Source: PHC of Mongolia, NSO (2011), Ulaanbaatar, 2011

Geographically Bayan-Ulgii is the furthest province, which is situated 1760 km far from Ulaanbaatar the capital of Mongolia and along the slope of Altai Mountains. Its location that is highly isolated from the capital, yet on the border of Russian federation and China brings advantageous cultural and commercial ties with these countries. In addition widely used Islamic practice has been increasing number of Turkic speaking youth in Bayan-Ulgii, which is not very common in any other provinces. At the same time, Bayan-Ulgii is one of primary tourist destination center because of its both a lively ethnical culture and an attractive nature on the highest peak of the country. Thus Bayan-Ulgii is strikingly affected by the influences of such linguistic, cultural and socio-economic peculiarities, which characterizes the region as ‘the state within a state’.

However, Bayan-Ulgii, a Kazakh dominated province has been considered to be one of the most underdeveloped regions in the country (see table 1.2). Main social indicators such as poverty, unemployment and illiteracy rates are respectively higher than the national average. Bayan-Ulgii province is more likely being behind by educational indicators as well. School dropout rate is 4.7% three times higher than the national average 1.1%. As of 2009-2010 academic year one of 4 out of school children aged 6-14 years, is in Bayan Ulgii province.

Table 1.2. *Main social indicators in Bayan-Ulgii with the national average*

Social indicators	Bayan-Ulgii	National average
Poverty rate	46%	36%
Illiteracy rate	6.8%	4.6%
Drop out rate	4.7%	1.1%

Source: Bayan-Ulgii Statistical Office. (2011). Aimag population and household statistics. Ulgii

Although overall illiteracy rate is not much higher than the national average, if it is looked through ‘literacy’ as being defined “ability to read and write a short simple statement in Mongolian or any other language with understanding” (Batchuluun, 2008), this indicator shows percentage of above ‘15 years old’ Kazakhs who even cannot read and write simple statement in their mother language, but it does not reveal how many Kazakhs are illiterate in terms of official language Mongolian.

The socio-economic vulnerability among Kazakhs community is considered to be affected by the extremely far location of the province, poorly developed infrastructure and less opportunity for employments like in many other remote provinces Mongolia rather than their ethno-cultural diversity (ADB, 2008). Nevertheless Mongolian Kazakhs enjoy their ‘cultural autonomy in the certain territory’ (Barcus & Werner, 2009) saying that they are proud of having kept their language and tradition “better than any other Kazakhs who live all around the world” (Badelkhan, 2010).

The new political reform, so called ‘democratic revolution’ in 1990’s in the country has brought significant improvement for both Mongolians and Kazakhs to strengthen their identity, culture, language and religion that have been debilitated by the socialist regime for more than 70 years. Consequently, Mongolian Kazakhs have re-established cultural connections with Turkish speaking Islamic countries. Many Kazakhs families started sending their children to the both local and overseas religious schools, where mostly taught in Turkic and Arabic languages (Shinay, 2009).

Over the same period the republic of Kazakhstan has got its independence due to the collapse of Soviet Union. At the time of independence population of Kazakhstan was heavily “Russianized” in terms of language and culture and percentage of Kazakh population was relatively low comparing to non-Kazakh population. Hence the government of Kazakhstan conducted a policy to call the Kazakhs out of the country by offering economic and social incentives, which were attractive Mongolian Kazakhs who maintained their culture and language greater extent than the Kazakhs in Kazakhstan (Barcus & Werner, 2009).

Starting from early 90’ the continuous immigration process to Kazakhstan caused substantial decrease of Kazakh population in Mongolia. The immigration process from early 90s to up until now has involved almost half of them. Some scholars refer to main push factors of this immigration as desire of ‘return to homeland’ (Zardikhan, 2006), others attributes to the ‘better economic and educational opportunities for their children’ future’ (Barcus & Werner, 2009).

The immigration of Mongolian Kazakhs to Kazakhstan brought not only a great deal of increasing ethnic identity among Kazakhs in Mongolia, but also changes in their cultural behaviors such as life style, food and interpersonal communication skills and more and less on their language preference, especially among youth. On the other hand,

geographical peculiarity of the province, commercial ties with Russia and Kazakhstan and religious connections with Islamic countries such as Turkey, Arabic and Egypt have appealed Kazakh youth to commit learning Kazakh, English, Russian and Turkish languages. Even at

present, it has been a concern that Mongolian language (ML) recede its status of an official language in the Kazakh administrative province. In spite of legal frameworks where clearly estimated to ‘Mongolian language is an official language in the country’(paragraph 8.1, The Constitution of Mongolia, 1994) usage of official language Mongolian less likely to be disseminated among social services in Bayan-Ulgii province, where Kazakhs constitute 90 percent of provincial population. Media and information are in Mongolian throughout the country, TV channels and newspapers in ML are highly accessible, as well, in Bayan-Ulgii province. However most of local residents reported the preference on usage of broadcast channels from Kazakhstan and Xinjian Uighur, China in their native languages (NFE, 2010). As consequences people in Bayan-Ulgii province have almost no environment to use Mongolian unless they learn it at school. However, teaching and learning Mongolian language at Kazakhs schools rather seems to be problematic without having “no clear policy” (Huang, 2005) whether to use Mongolian as a language of instruction or teach it as a L2.

During socialist period when Mongolian education system was highly dependent on Soviet Union style, textbooks and learning materials in Kazakh schools used to be brought from Kazakhstan as the content of the curriculum at that time less significantly differed from Mongolian curriculum. But the changed curriculum content of Mongolian educational system due to failure of Soviet dependent schooling in 90’s has brought difficulties for Kazakh schools in terms of relevance of curriculum content and textbooks. In addition to the barriers caused by “irrelevant curriculum and textbooks content” (Huang, 2005), the Kazakh schools lack of support to learn official language Mongolian (Tuya & Khanat, 2011), which has long time importance on their further development. Teachers are trained as same as those who teach in Mongolian schools, textbooks used in Kazakh schools are as same as the ones which are used in mainstream schools and taught by oral translation of the instructors. Due to these challenges faced by Kazakh schools, Mongolian education sector encounters with the need to provide appropriate schooling to Kazakh students in order to give them equal opportunity to receive quality education. Consequently, the government of Mongolia has started taking step-by-step actions to improve the educational service for Kazakh students. In recent years, the education for Kazakh students has undergone some noteworthy legislative reforms (UNESCO, 2008). From 2005 textbooks that are used in Mongolian schools started being translated into Kazakh. In 2010 the action plan to improve quality of educational service for Kazakh students was approved by MECS. As consequences an advisory authority was established under the MECS addressing the educational problems experienced by the Kazakh minority. Unfortunately, despite these advancements, there is no systematic nationwide policy whether to choose bilingual schooling or continue to keep Kazakh as a language of instruction (LoI) for Kazakh school yet in the country and the transition to Mongolian language as a LoI differs from school to school.

At present in majority of Kazakh schools, until grade 9 all subjects are taught in mother language Kazak and they take Mongolian as a compulsory subject from grade 2. Then LoI transfers to the ML from grade 9, which means all subjects started to be taught in Mongolian (see table 1.3). Students continue to take Mongolian as a compulsory subject until grade 11. In addition ML is offered as one of elective subjects to the students at the grade 10th and 11th. The purpose of such elective courses stands for preparing for the national examination to tertiary education institutions offering additional 4 hours.

Table 1.3. *The commonly used schooling model in Kazakh schools*

Grades	Kazakh language	Mongolian language
Grade 11	L1+Elective subject	LoI+L2+Elective subject
Grade 10	L1+ES	LoI+L2+Elective subject
Grade 9	L1	LoI
Grade 8	L1+LoI	L2
Grade 7	L1+LoI	L2
Grade 6		
Grade 5		
Grade 4		
Grade 3		
Grade 2		
Grade 1		

Note:
The model was designed by author.
Nevertheless, according to the current

ly used curriculum in Kazakh schools, at the time of the graduation for secondary school one supposed to be studied Mongolian for a minimum 10 years. Even though their proficiency on ML assessed to be extremely poor and causes various problems on their education (Huang, 2005; Mira, & Oyuntsetseg, 2008).

The report for Save the Children, UK highlighted that Kazakh students face “unique and significant challenges caused by language barriers” (Huang, 2005). Besides 3 folds high drop- out rate than national average (Erdenechimeg, 2009), they are challenging by poor skills on official language. When students take national university exams, they don’t understand the test materials due to low proficiency in the ML and perform poorly (Mira, 2008). The National school leaving examination result (EEC, 2010) demonstrates that Bayan-Ulgii has scored significantly less well than the national average scores. Bayan-Ulgii achieved the worst or second worst provincieranking in every subject and score for ML subject was worst in the whole country (Mira, 2008). A lack of ML competence is not only a matter that is encountered by the secondary school Kazakhs students, but also it is affecting on further development such as achievements in tertiary education, participation in social activities and access to information about health and welfare. A study found about 70 % of Kazakh college students do not fully comprehend the lectures by their professors at their 1st and second year in tertiary education (Amandikh, 2009).

In spite of importance of learning official language Mongolian, there seemed to be lack of awareness to its importance among Kazakh students, indeed they are likely giving more importance to learn foreign languages such as English and Russian than the official language Mongolian. In the school leaving examination score ranking among 21 provinces and 9 districts, Kazakh students performed 120 lower than the national average in the ML subject ranking in the last. While scores for Russian and English languages among Kazakh students were relatively higher than mainstream students ranking 2th and 7th places in the whole country (EEC, 2009).

Table 1.4. School leaving examination score among 24 provinces

Subjects	Score	Rank at national level
----------	-------	------------------------

Mathematics	488	25th
Mongolian language	373	30th
Social Science	435	30th
English	498	7th
Russian	542	2nd
Geography	434	29th
Physics	487	20th
Biology	443	29th
Chemistry	476	30th
History	481	29th

Note: 1st place reflects to the best, 30th reflects to the last performance

Source: Statistical bulletin, Education Evaluation Center, 2010

Furthermore, the lack of awareness to learn Mongolian among Kazakh students can particularly be noticed in their choice on the tertiary education. Every year about 40% of Kazakh high school graduates leaves to study to the higher educational institutions in Kazakhstan, Russia, Turkey and other countries. On the selection of additional 14 elective courses offered to 10th and 11th grade students more choices on Russian and English, less on Mongolian language courses are found among Kazakh students (EB in Bayan Ulgii, 2011).

Through this literature review, our examination on the teaching practice of official language Mongolian in Kazakh schools, it can be assumed that a large gap exists between the official language policy of Mongolia and its practice in Bayan Ulgii, Kazakh administrated province. The provisions stated in the Constitution of Mongolia and in legal frameworks seem to be absent from the daily life of minority groups. Kazakhs as the national minorities are facing challenges from inappropriate language program and the lack of qualified bilingual teachers. Therefore, there seems to be more needs to be done to strengthen the quality of teaching official language to national minorities. The teaching of Mongolian language in Kazakh secondary schools needs to be re-considered taking in to account the needs of the local community distinguishing Kazakh schools from the ML as a first language schools.

Резюм

There have been concerns on the lack of Mongolian language literacy, low educational achievements, and inequities in educational opportunity among Kazakh minority children in Mongolia. The paper discusses the current status of teaching official language Mongolian to Kazakh minorities taking account the legal frameworks, practices and the various literatures related with this issue.

References

Amandikh, B. (2009). *Казак сурагчдын хэлний бэрхшээл сурах үйлд нөлөөлөх нь* [Influences of language barriers on the Kazakh students' learning achievement] (Unpublished master's thesis). Academy of Management, Mongolia.

- Baker, C. (2006). *Foundations of bilingual education and bilingualism* (4th ed.) Clevedon: Multilingual Matters
- Dayar Mongol (2009, March 12). Interview by Badelkhan. Кх Дэлхийн Казахуудаас хамгийн сайхан амьдарч байгаа нь Монголын Казахууд [Mongolian Kazakhs are the most happiest Kazakhs among all the Kazakhs around world].
- Ball, J. (2011). *Enhancing learning of children from diverse language background: Mother tongue based bilingual or multilingual education in the yearly years*. France: UNESCO Education Sector
- Batchuluun, Ye. (2008). *National report on the situation of adult learning and education-Mongolia*. Retrived from website:
http://www.unesco.org/fileadmin/MULTIMEDIA/INSTITUTES/UII/confintea/pdf/National_Reports/Asia%20-%20Pacific/Mongolia.pdf
- Bayan-Ulgii Statistical Department (2011) Bayan-Ulgii aimag: Socio-economic status as of 2010. Retrieved from <http://www.nso.mn/bayan-ulgii>
- Barcus, H., & Werner, C. (2010). The Kazakhs of western Mongolia: Transnational migration from 1990-2008. *Asian Ethnicity*, 11(2), 209-228.
- Erdenechimeg, Ts. (2011). *Social assessment report on Bayan Ulgii subcomponent of preschool education project*. Retrieved from World Bank website:
<http://www.worldbank.org/en/country/mongolia/>
- Huang, S. (2005) *Education of Kazakh children: A situation analysis*. Save the Children UK, Ulaanbaatar, 12-14.
- Jukye, G. (2009). *Mongolian Kazakhs in XXI century*. Bayan Ulgii, Mongolia
- Khanat, A., & Туяа, В. (2011). Казак хэлээр сургалт явуулдаг сургуулийн сургалтын төлөвлөгөөг боловсронгуй болгох асуудалд [On the issue of improving currirucla of Kazakh schools]. *Educational research*, 03(81), 47-51
- Mira, N., & Oyuntsetseg, N. (2008). *Language education issues in the Kazakh community of Mongolia*. Paper presented at the 5th conference: South East Asian minority education issues. Bangkok, Thailand.
 . Ulaanbaatar, Mongolia. Retrieved from <http://www.parliament.mn>
- UNESCO Office Beijing. (2008). *National education support strategy*. Retrieved from website:
<http://unesdoc.unesco.org/images/0015/001599/159959eo.pdf>
- Zardikhan, K. (2002). *Нулмстай жилүүдийн гунигтай шастур* [The grief tract of the teary years] Ulaanbaatar: Soyombo Printing
- <http://www.collinsdictionary.com/dictionary/english/second-language>

ЯЗЫК И КУЛЬТУРА НАРОДОВ РЕГИОНА

БҮС НУТГИЙН АРД ТҮМНИЙ ХЭЛ, СОЁЛ

МОНГОЛ ХЭЛНИЙ АВГАЙЛГА НЭРИЙН ҮҮСЭЛ ГАРВАЛ

МУГБ, доктор, профессор Батчулуун Д.
Ховд их сургууль

Түлхүүр үг: Авгайлга нэр, авгайлга нэрийн бүтэц, богино үгс, хүүхдийн хэл, ердийн нэр, оноосон нэр, хүний эш, гуайлга нэр, авгайлга нэрийн хувилбарууд, гийгүүлэгч, сэтгэц хэлшинжлэл, авиан утгазүй.

Авгайлга нэр нь монголын хүн амын бараг 85%-ийг эзэлдэг халхуудын дунд өргөн хэрэглэгддэг яригчийн хувьд өөрөөс насаар ахимаг таньдаг болон садан төрлийн хүмүүсээ хүндэтгэн дууддаг оноосон нэрийн нэг төрөл юм. Авгайлга нь тухайн хүнийхээ оноосон нэртэй ямагт хамт хэрэглэгддэг ба нэг гэр бүлийн гишүүд, ойрын садан хүмүүсийн нэрийг орлон дангаар хэрэглэгддэг (Батчулуун, 2009. I).

Бүтцийн хувьд авгайлга-нэр голдуу нэг (Ааж, Ах, Айд, Жүнж, Жүүж, Бааж, Баа, Буж, Дайд гэх мэт) ба хоёр (Баавай, Будгаа, Жаажаа, Гаагаа, Ааниа, Амбаа, Жуужаа, Дайдаа, Доолио, Маамаа, Наниа,

Настоящая статья написана и опубликована при финансовой поддержке гранта РГНФ-МинОКН Монголии “Национально-специфические реалии русской и монгольской культуры в языковом сознании жителей Западной Монголии: Лингвокультурологические исследования”, проект № 124003000 а/Г

Сооёо гэх мэт) үеэс бүтсэн, гэхдээ хоёр үеэс бүтсэн нь илт давамгайлсан, хэмжээгээр богино үгс юм. Цөөн тооны гурван үеэс бүтсэн үг бий (Бандигаа, Ламбагай, Үзэнгээ, Эмбэгээ). Баруун халхуудын дунд бидний бүртгэсэн 596 үгнээс 527 буюу 88,4% нь хоёр үетэй үг байна. Энэ нь авгайлга-нэр бүтэхдээ аман ярианы хэлний хэмнэлийн зарчимд захирагдсан, бага хүчин чармайлт гаргаж их зүйлийг бүтээх эрмэлзлэлтэй байдаг хүний организмын уг чанартай холбоотой юм (Нотманн, 1971, р. 84). Олон үеэс бүтсэн урт үгийг бодвол ганц хоёр үетэй богино үгийг хэлэх нь хэлэгч хүнд хялбар байдаг билээ.

Ламбагай, ламх, бандигай зэрэг авгайлга-нэр нь лам бугай, лам ах, баньд гуай гэсэн нийлмэл үгийг хэлний хэмнэлийн дагуу нэг энгийн үг болгон дуудсаны үндсэн дээр үүсжээ.

“Ах” авгайлга-нэртэй холбоотойгоор үүссэн хэд хэдэн нийлмэл нэр бий. Эдгээр нь холбоо үгийг санагдуулах боловч нэг хүнийг авгайлан дуудсан нийлмэл үг юм: Том Ах, Дунд Ах, Өндөр Ах, Бага Ах, Жаах (Жаахан Ах), Жоохон Ах, Бичгэн Ах, Бүдүүн Ах, Бүдээ Ах, Бондгор Ах, Настай Ах, Шинах (Шинэ ах). Эдгээр нь нэг гэр бүлийн хүрээнд дүү нар нь ах нараа ялгаатайгаар дууддаг нэр байснаа тухайн нутгийнхны дунд хэрэглэгддэг авгайлга-нэр болон хувирчээ. Мөн “ээж” гэдэг үгтэй холбоотойгоор үүссэн Өндөр Ээж, Сайхээж зэрэг үг байна. Авгайлга-нэрийг зээлдэн авсан Ховд аймгийн Дөргөн сумын өөлд хүмүүсийн дунд Бичгэн Ах авгайлгыг хэрэглэдэг байна. Харин Бага Ах, Дунд Ах, Өндөр Ах, Жаах зэрэг авгайлга Говь-Алтай аймгийн Тонхил, зэргэлдээ орших Дарви суманд мэр сэр тааралдана. Жаах, Ламх зэрэг нэр жаахан ах, лам ах гэдгийг хураангуйлан дуудсан нь билээ. Өөрөөр хэлбэл, “ах”-тай холбоотой бүх үг болон Ламбагай, Бандигаа, Банди Ах, Өндөр Ээж, Сайхээж зэрэг нь оноосон авгайлга-нэр болон хувирсан ердийн нэр юм.

Гарлын хувьд авгайлга-нэр нь хүүхдийн хэл ярианаас үүсэлтэй, манж-хамниган, түрэг, төвд, хятад зэрэг хэлнээс “зээлдэж” авсан болох талтайн гадна үг үүсэхүйн талаасаа, нэгдүгээрт, бие биеэс авиа сэлгэх замаар үүссэн, хоёрдугаарт, тухайн хүнийхээ оноосон нэрнээс үүссэн, гуравдугаарт, тодорхой зүй тогтолд захирагдахгүйгээр тохиолдлын чанартай, аяндаа үүссэн гэж ангилж болохоор байна.

Бие биеэс авиа сэлгэх замаар үүссэн авгайлга-нэрийг авч үзье.

1. Ах, Агаа, гэдэг нэр нь монгол хэлийг оруулаад түрэг-алтай язгуурын гаралтай юм. Энд “Ах”-аас “Агаа” “үүссэн ба энэ хоёр үг хоёулаа орчин цагийн түрэг хэлэнд “ака”, “ага” хэлбэрээр хэрэглэгдэж байна. Бага насны хүүхдүүд ахыгаа “агаа” гэж дууддаг нь энэ авгайлга-нэр хүүхдийн хэлтэй холбоотой болохыг өгүүлж байна. Ах, Агаатай холбоотойгоор Ахаа, Ахан, Ака, Аагаа, Ааг, Аагий үүссэн байхаас гадна бидний дээр өгүүлсэн Жаах (жаахан ах), Ламх (лам ах), Банди Ах, Бага Ах, Бүдүүн Ах, Бичгэн Ах, Бүдээ Ах, Бондгор Ах, Том Ах, Дунд Ах, Жаахан Ах, Жоохон Ах, Настай Ах, Өндөр Ах, Шинах (Шинэ Ах) зэрэг нийлмэл нэр үүссэн байна.

Авгайлга-нэр зөвхөн аман ярианд хэрэглэгддэг тул тухайн орон нутаг, хувь хүний хэлэх онцлогоос болж Ах, Агаа гэдэг үг Ахаа, Ахан, Ака, Аагаа, Ааг, Аагий хувилбартайгаар хэлэгдсэн байна. Иймэрхүү аман аялгууны хувилбартай хэлэгдэж байгаа бусад авгайлга-нэрийг хойно дурьдах болно.

Хүний эшийн нэр нь аливаа хэлний үгийн сангийн барагтай бол өөрчлөгддөггүй, тогтвортой хадгалагдаж байдаг хэсэг нь учир (Батчулуун, 2009 II, х.123) Ах, Ахаа авгайлга нэр эртний гаралтай, монголчуудын дунд олон зуун жил хэрэглэгдэж ирсэн байх ба түрэг хэлтэй холбоотойг нь бодоход ҮП-ҮШ зууны үед одоогийн монгол нутагт оршин тогтнож орхон-түрэг хэлний дурсгалыг үлдээсэн Зүүн-түрэгийн хаант улсын үетэй холбоотой байгаа ба наанадаж ҮП-ҮШ зууны үе болон түүнээс ч аль эрт хэрэглэгдэж байсан бололтой байна (Левин, 2001, с.3, 63).

Судлаач Г. Г. Левин эгшиг+гийгүүлэгч+эгшиг гэсэн бүтэцтэй ака (насаар ах садангийн хүн) орхон-түрэг хэлэнд, а а (эцэг, ахмад хүн) якут хэлэнд байдгийг тэмдэглэжээ (Левин, 2001, с.63). Тэгэхээр энэ нь өдий хүртэл өөрчлөгдөөгүй хадгалагдаж ирсэн нэн эртний үг болох нь харагдаж байна.

Монгол хэлний “ах” гэдэг энэ үг түрэг-алтай язгуурын олон хэлний түгээмэл хэрэглэгддэг үг ба энэ хэлбэр болон утгаараа хамниган, манж, солон, эвен, орооч, уйгар, хакас, узбек, удей, ульч, нанай, киргиз, түрэг, татар, туркмен, казах, тува зэрэг хэлэнд хэрэглэгддэг байна.

Дашрамд тэмдэглэхэд “ах”, “агаа”, “ака”, “ахаа” зэрэг бидэнд бүртгэгдсэн халхуудын авгайлга-нэр энэ хэлбэрээрээ бидний иш татан авсан түрэг-алтай язгуурын бусад хэлнүүдэд ч байдаг нь сонирхолтой юм.

Нэг гэр бүлийн болон ойрын садан төрлийн хүнийг нэрлэсэн “ах”-аас гадна манж-хамниган, түрэг, төвд, хятад, орос хэлнээс “зээлдэж” авсан байж болзошгүй зарим үгс хүний эшийн нэр болохын хувьд өнө эртнээс хэрэглэгдсээр ирсэн байна. Монголчуудын соёл-түүхийн талаас эртнээс холбоотой байсан ард түмнүүдийн хэлнээс “зээлдэж” авсан байх магадлал, нэгдүгээрт, өнөө хүртэл монголчуудын дунд хэрэглэгдсээр ирсэн түгээмэл зарим авгайлга-нэр дуудлагын хувьд тэдгээр хэлний зохих үгстэй төсөөтэй, хоёрдугаарт, утгын хувьд нэг гэр бүл, ойр төрлийн хүндлэн дээдэлдэг хүмүүсийг заасан нэр учраас зохих үндэслэгээтэй байна. Эдгээр үг нь тухайн гадаад хэлнүүдэд ч, монгол хэлний авгайлга-нэрийн хувьд ч гарал үүслээр хүүхдийн хэлтэй холбоотой байж болох талаар бид хойно өгүүлэх болно. Энд бид “зээлдэх” гэдэг үгийг хашилтанд бичсэний учир нь зарим авгайлга-нэр бүтцийн хувьд гадаад бусад хэлний үгстэй тохирч байгаа нь угаасаа аль ч үндэстний хүүхдийн хэлний хөгжлийн зүй тогтолтой холбоотойгоор авиан ижил бүтэцтэй байгааг онцлон хэлэх гэсэнд оршино. Гэхдээ зарим үгийн хувьд үнэхээр зээлдсэн байхыг үгүйсгэх аргагүй юм.

Ер нь авгайлга-нэр утгазүйн талаас хүн ойлгоход төвөгтэй, “утгагүй” үг мэт байдаг нь ахмад насны хүнийг хүндэтгэсэн авгайлга-нэр буюу хоёрдахь нэрийг өгөхдөө хүний албан ёсны нийтлэг оноосон нэрийг давтан хэрэглэх шаардлагагүй байдаг, үгийн сангийн утга бүхий ердийн нэрийг хэрэглэдэггүй зэргээс болж нэрийн ер бусын шинжийг хадгалахын тулд, нэгдүгээрт, хүүхдийн хэлийг ашиглах, хоёрдугаарт, хүн болгонд төдий л ойлгомжгүй “гадаад” үгийг сонгох, гуравдугаарт, тухайн оноосон нэрийн бүтцийн нэг хэсгийг ашиглах, дөрөвдүгээрт, тохиолдлын чанартай үг бүтээсэн байна гэж үзэж болно. Хэрэв монгол хүний нийтлэг оноосон нэр, үгийн сангийн утга бүхий ердийн нэрийг ашиглавал тэр нь авгайлга-нэрийн шинжээ алдах болно.

Авгайлга-нэр Ах-ыг гуайлга-нэр “ах”-аас ялгаатай авч үзэх ёстой. Энэ хоёр нэрийн хооронд зарчмын том ялгаа оршдог. Манай оронд хотжих үйл явц болон хүн амын шилжин суурьших хөдөлгөөн эрчимтэй явагдаж байгаатай холбоотойгоор хүмүүс гуайлга-нэр “ах”-ыг өдөр тутмын харилцаандаа өргөн хэрэглэх болов. Энэ үг авгайлга-нэр Ахын адил тухайн хүний нэртэй хамт байнга хадагдсан үг биш, нэг гэр бүлийн болон садан төрлийн ба танил хүмүүсийн хүрээнд хэрэглэгдэхээс гадна ор танихгүй, насаар ах эрэгтэй хүнд хандсан болон нэрлэн заасан үг юм. Энэ үг насаар ах эмэгтэйчүүдийг “эгч” хэмээн дууддаг бүх тохиолдолд зөвхөн эрэгтэйчүүдийн хувьд хэрэглэгдэнэ. “Эгч” гэдэг үг авгайлга-нэр болон хэрэглэгддэггүй, харин тун цөөн тохиолдолд Эгчээ гэдэг авгайлга хэрэглэгддэг.

Ах авгайлга-нэр Эгчээг бодоход хавьгүй олон хэрэглэгддэг нь эрэгтэйчүүдийг илүү эрхэмлэн дээдэлсээр ирсэн дорнын ард түмнүүдийн ёс заншилтай холбоотой байсан бололтой юм.

Бид дор аман аялгуутай холбоотойгоор нэг авгайлга-нэр хэд хэдэн хувилбараар дуудагдах болсон жишээг цаашид үргэлжлүүлэн тоочих болно. Эдгээр авгайлга-нэрийн дуудлагад гарсан өөрчлөлт зөвхөн эгшиг авианы хүрээнд явагдсан байх ба мэдээллийг хамгийн ихээр агуулах чадвартай байдаг гийгүүлэгч авиаг (Normann, 1971, p. 14) хөндөөгүй болохыг ажиглаж болно.

2. Дайд, Дайдаа, Даадаа, Дадаа, Дээд, Дээдээ, Дэдээ, Дөдөө, Дөөдөө, Доодоо, Додио гэх мэт. Манай нутагт (Ховд аймгийн Цэцэг сум) Ердээн Дайд гэдэг настай буурал амьдарч байсан ба нутгийнхан нь түүнийг Дайд, Дээд, Дайдаа гэж аль нэгээр нь авгайлан дууддаг байж билээ. Дайд, Дээд зэрэг нь дээрэх авгайлга-нэрийн аман ярианы товчилсон хэлбэр юм. Баруун халхын аман аялгуунд голдуу ай хос эгшигтэй үгийн хэлний дундуур хэлэгдэх а авиаг урагшлуулан э авиагаар дуудах нь элбэг байдаг. Тэд “айл”, “аймаг”, “сайн байна уу” гэхийг /эйл, эймэг, сэйн бэйнэ үү/ гэж дуудна. Энэ нь хэлэхүйн явцад зэрэгцэн орших авианууд бие биеийн дуудлагыг өөрчилж байдаг авиазүйн нөлөөтөн хувьсах үйл явц юм. Өөрөөр хэлбэл хэлэхүйн явцад авиаг хэлэх үйл явц эхлэл-тогтоц-төгсгөл гэсэн гурван шатыг дамжиж нэг авиаг хэлэх өгүүлэх эрхтний төгсгөлийн байрлал нь дараагийнхыг хэлэх эхлэл рүү шилжиж байдаг (Батчулуун, 2009, х.20). Ай хос эгшигийн хувьд хэлний урьдуур хэлэгдэх и авиан нөлөөгөөр а авиа урагшлан хэлэгддэг байна. Жишээлбэл, Дайд, Дайдаа-Дээд-Дээдээ, Найнаа-Нээнээ-Нэнээ-Нийнээ, Адиа-Эдээ- Айдаа, Андиа-Эндээ-Эндаа, Айнаа-Ээнээ гэх мэт.

Авиазүйн нөлөөтөн хувьсах үйл явцын оролцоогүйгээр ч эгшиг ондоошсон болохыг гийгүүлэгчийн бүрэлдхүүн нь ижил мөртлөө эгшгээсээ болоод өөрөөр дуудагдах олон авгайлга-нэрээс мэдэж болно. Нэг авгайлга-нэрийн хэд хэдэн хувилбарт эгшигийн бүрэлдхүүн нь өөрчлөгдсөн мөртлөө гийгүүлэгч нь хэвээр үлдсэн байгаа нь гийгүүлэгч авиа үгийн авиан бүтцэд нэн чухал үүрэгтэй байдгийг харуулж байна. Эрдэмтэн Данзандагва 1728 онд бичсэн “Зүрхэн тольтын тайлбар” хэмээн алдаршсан бүтээлдээ “...Юуны тул гийгүүлэгч хэмээвээс, үгс, утгасыг тодруулахын тулд тийн хэмээн өгүүлбэй” (Пагба, 1976, х.20) гэж бичсэн нь тун учиртай үг юм. Гийгүүлэгч авиа үгийн бүтцэд хамгийн их мэдээллийг агуулагч бөгөөд хэрэв гийгүүлэгчийг хасвал үг танигдахгүй болдог байна. “Үзэгдэл” гэдэг үгийн хоёр гуравдугаар үеийн богино

эгшгийг авч хаявал “үзгдл” болох ба монголоор яригч хэн ч “үзэгдэл” гэж ойлгох ба харин аль нэг гийгүүлэгчийг нь хасвал ойлгомжгүй “үг” болох билээ. Их эрдэмтэн Данзандагвын дээрх үг хичнээн үнэн болохыг орчин үеийн сэтгэц-хэл шинжлэлд хийсэн туршилт харуулж байна. Хэлний авиан физик шинжийг механикаар өөрчлөн хамгийн их хүчдэл агуулсан эгшгүүдийг төлөөлсөн хэлбэлзлийн оргилыг тайрч хаяад гийгүүлэгчийг агуулсан хэлбэлзлийн төв хэсгийг хөндөлгүй үлдээхэд үг ойлгогдож байжээ. Харин хэлбэлзлийн төв хэсгийг авч хаяад оргил хэсгийг сонсоход ойлголт бараг тэг түвшинд байжээ (Hogmann, 1971, p. 70). Орчин цагийн халимаг хэлэнд өргөлтгүй үеийн эгшгийг ихэвчлэн тэмдэглэдэггүй. Монгол хэлэнд үгийн нэгдүгээр үеэс хойш тохиолдох богино эгшиг хэт балархайшиж хэлэгдэхгүй шахам болдог нь эгшиг авиан мэдээлэл бага агуулдагтай холбоотой гэж үзэж болно. Иймээс ч аливаа хэлэнд гийгүүлэгчийн тоо эгшинхээс ямагт олон байдаг. Дэлхийн анхны авианых болох финик цагаан толгой 22 гийгүүлэгчээс бүрдсэн дан гийгүүлэгчийн цагаан толгой байсныг үүнтэй холбон тайлбарлаж болно. Хүний хэлэхүйг гадаад, дотоод хэлэхүй хэмээн хоёр заагладаг ба дотоод хэлэхүй нь (дотоод хэлдэг) нь эгшиг авиангүй байдаг нь үүнийг давхар нотлох билээ. Бидний энд дурдсан болон дор дурдах д...д... бүтэцтэй авгайлга-нэрүүд болон хойшид тохиолдох олон авгайлга-нэр дээр өгүүлсний нэг жишээ болох юм. Энэ шалтгаанаар олон тооны авгайлга-нэрийн дуудлага гийгүүлэгчийн бүтцээ хадгалан (г...г..., ж...ж..., н...н..., л...л...б...б/в..., м...м...) хувилбарт орсон байдаг.

Түрэг хэлэнд өвөөг “dede”, орос хэлэнд өвөөг “дед”, нагац ах, авга ахыг “дядя”, англи хэлэнд аавыг “dad”, хинди хэлэнд эгчийг “didi”, авга өвөөг “dada”, авга эмээг “dadi”, Хойт Америкийн Черокий омгийнхны индиан хэлэнд аавыг “da do” хэмээн дууддаг.

3. Найнаа, Нээнээ, Нэнээ, Наниа, Нүүнээ, Нийнээ, Нөөнөө, Нойноо, Ноноо гэх мэт.

Түрэг хэлэнд эмээг “nine”, “nene”, испани хэлэнд ээж, эмээг “nana”, орос хэлэнд асрагч эхийг “няня”, англи хэлэнд асрагч эхийг “nanny /нэни/”, хүмүүжүүлэгч, гэлэнмааг “nun” /нан/, герман хэлэнд гэлэнмааг “none”, хинди хэлэнд нагац эмээг “nani”, авга эмээг “nana” хэмээн дууддаг.

4. Дүүмээ, Дүмээ, Дээмээ, Даймаа.

5. Доолио, Доолой.

6. Даньдаа, Даниа, Дэндээ, Дондио.

7. Дагаа, Дигаа, Даагаа,

8. Дэнээ, Динаа.

9. Догоо, Догио, Доогий.

10. Даазай, Дазаа.

11. Айдаа, Адиа, Айд, Аадаа.

12. Ааяа, Аяа, Аахүү, Ааяажав.

13. Аажаа, Ааж, Ажаа.

Манж хэлэнд “аав”, “эв эе” гэсэн утгатай “Ажаа” гэдэг үг байхаас гадна монголчууд лам эцгийг “ажаа” хэмээн дуудна (Цэвэл, 1966).

14. Ажий, Ажин.

Манж хэлэнд “ууган” гэсэн утгатай “ажий”, “аварга” гэсэн утгатай “ажин” гэдэг үг бий.

15. Ааниа, Аниа, Энээ, Анай.

Манж хэлэнд “нас”, “он жил” гэсэн утгатай “аниа” гэдэг үг, түрэг хэлэнд “ээж” гэсэн утгатай “anne”, “ana”, казах хэлэнд “ээж” гэсэн утгатай “ана” гэдэг үг бий.

16. Амаа, Ама, Аймаа.

Манж хэлэнд эцэг болон эцэг эхийг “амаа”, араб хэлэнд ээжийг “yamma”, солонгос хэлэнд ээжийг “omma” гэж нэрлэнэ.

17. Алиа, Аалиа.

18. Анжаа, Анжий, Анж, Анжхүү, Анжваа.

19. Ажгаа, Ажга.

20. Андиа, Андаа.

21. Амбаа, Умбуу.

“Амбаа” гэдэг нь манж хэлний “их”, “том” гэсэн утгатай үг юм. Энэ хоёр нэрийг сольж дууддагийн жишээг дурьдвал, манай нутагт Харуулчин овгийн Пунцаг Амбаа гэж хүндлэн дуудуулдаг, хятадаар ярьдаг, тохитой тулхтай сайхан өвөө амьдарч байсан ба Амбааг зарим хүн Умбуу гэж авгайлдаг байж билээ.

22. Баавай, Баабаа, Баба, Баваа.

Түрэг хэлэнд эцэгийг “baba”, хятад, кабил (аравын семит-хамит язгуурын бербер хэлний аялгуу), хаус (семит-хамит язгуурын чад хэлний бүлгийн хэл) зэрэг хэлээр аавыг “баба” гэж нэрлэдэг.

23. Боовоо, Бообоо, Бовоо, Бобо.

24. Баажаа, Баажий, Бажаа, Баажуу, Бааж, Бажу.

25. Балиа, Баалиа. Түрэг хэлээр бурман сарыг “balayi” хэмээдэг ажээ.

26. Гоогоо, Гогоо.

27. Гаагаа, Гагаа.

28. Гээдээ, Гэдээ.

29. Жүүжээ, Жуужаа, Жууж, Жийжээ, Жийж, Жижээ, Жүжээ, Жуужуу, Жүүжүү, Жүүж. Төвд хэлээр номын багшийг “жүүжээ”, хятадаар эгчийг “жие жиеэ”, японоор аавыг “чичи” гэнэ.

30. Жаажая, Жааж, Жоожоо, Жоож, Жөөжөө, Жөөж, Жажаа.

31. Жүнжээ, Жүнж, Жинжээ.

32. Инжээ, Инжүү.

Хятадаар дарханыг “инжээ(н)” гэнэ.

33. Маамаа, Маам, Маамуу.

Ээжийг оросоор “мама” /маамаа/, хятадаар “мама” /маамаа/, англиар “mom”, “mamma”, “mama”, “mam”, “mummy”, францаар “maman”, германаар “mama”, испанаар “mama”, эмээг испанаар “mamamama” гэнэ.

34. Мөөмөө, Мөөм.

35. Мээмээ, Мээм.

36. Моомоо, Моом.

37. Оожоо, Оож, Оожуу, Ожоо.

38. Оомоо, Омоо.

39. Оогоо, Огоо.

40. Онио, Ооноо, Ойноо.

41. Умбаа, Умбуу.

42. Уужаа, Ууж, Уужий.

Авгайлга-нэрийн нэлээд хэсэг тухайн хүний албан ёсны оноосон нэрэнд тусгай дагавар залгах замаар үүссэн байна. Монгол хэлний үг нэгдүгээр үндээ өргөлттэй, тод хэлэгддэг учир хүний нэрнээс үүссэн олонхи авгайлга нь нэрийн эхний үеийн авиан шинжийг давтсан нэг, хоёр үетэй үг байна. Уламжлалт авгайлга-нэрийн дотор ч тухайн хүний нэрийн эхний үеийг давтан дуурайх замаар үүссэн авгайлга үе үе тааралддаг. Жишээлбэл, Долгор гэдэг нэртэй хүний авгайлга-нэр голдуу Доолио байдаг билээ. Ийм жишээ олног дурьдаж болно.

Тухайн хүний нэрнээс үүссэн авгайлга нэрийн дотор хоёр зүйл ажиглагдаж байна. Энэ нь, нэгдүгээрт, тухайн хүний нэр, авгайлга-нэр хоёрын эхний үеийн авиан шинж (ялангуяа эгшиг авиа) давтагдаж байдаг. Хоёрдугаарт, эдгээр үүсмэл авгайлах үгс нь уламжлалт авгайлга-нэрийн төгсгөлийн бүтцийг авгайлга-нэр үүсгэх дагавар болгон авсан байна. Мөн тэдгээр нь бие биесийн авиан бүтцийг хадгалан шинээр үг үүсгэсэн болох магадлалтай байна. Жишээлбэл, Найнаа, Нээнээ, Нэнээ гэх мэт.

Хэдийгээр хүний оноосон нэр, авгайлга-нэр хоёрын эхний үеийн авиан шинж олон тохиолдолд ижил байдаг боловч энэ нь зөрчигдөх тохиолдол багагүй байдгийг тэмдэглэх хэрэгтэй.

Хүний нэрээс үүссэн авгайлга-нэр ихэнхдээ бие бие нөхөрсгөөр нэрлэн дуудах үг байснаа авгайлга-нэр болон хувирсан байдаг. Үүнтэй уялдуулан нэг хүн хэд хэдэн нэртэй ч байдаг. Жишээлбэл:

Оноосон нэр: Жигмэддорж

Нөхөрсөх нэр: Жийгээ, Жийеэ

Авгайлга нэр: Амбаа.

Ер нь хүний эшийг нэрлэсэн м...м..., б...б..., г...г..., н...н..., д...д... зэрэг бүтэц дэлхийн бусад хэлнүүдэд ч байдаг нь хэлний түгээмлийн шинжтэй хүүхдийн хэлтэй холбоотой юм. Хүүхдийн өгүүлэх эрхтний хөгжил хэлд орж байх үедээ дэлхийн аль ч үндэстний хэлийг сурах дэвсгэртэй байдаг ба зургаа орчим сартай байхдаа “ба-ба-ба”, “ма-ма-ма”, “бамама” найм орчим сартайдаа “баб-баб”, “аб-аб” мэтийн гийгүүлэгч+эгшиг,эгшиг+гийгүүлэгч, гийгүүлэгч+эгшиг+гийгүүлэгч гэсэн бүтэцтэй үеийг хэлж чаддаг (Finegan, 1994, p. 451), гийгүүлэгч авиа дотроос хамгийн түрүүнд дуутай хамжихгийгүүлэгч **б, д, г, м, н**-ийг эзэмшдэг болохыг англи хэлний жишээн дээр гаргажээ (Finegan, 1994, p. 457).

Бидний дээр хэдэнтээ дурдсан болон дор бусад хэлний баримттай зэрэгцүүлэн харуулах жишээ монгол хэлний авгайлга-нэрийн нэг хэсэг нь хүүхдийн хэлээс үүсэлтэй болохыг харуулна. Зарим хэлний толь бичигт ч хүүхдийн үг болохыг онцлон тэмдэглэсэн байдаг. Жишээлбэл, англи хэлний толь бичигт “mummy” (ээж) (The New Penguin English Dictionary, 2000, p. 912) герман хэлний толь бичигт “Mutti (ээж) (Никонова, 1973, с.352)”, япон хэлний толь бичигт “Каа” (Зарубин С. Ф и др., 1988, с. 325) (ээж) гэдэг үгийг “хүүхдийн яриа” хэмээн тэмдэглэсэн байдаг.

Дээдээ-Дэдээ-Дайдаа-Даадаа-Дадаа-Дайд-Дүүдээ (монгол авгайлга-нэр), dede (түрэгээр “өвөө”), дед (оросоор “өвөө”), дядя (оросоор “авга ах”, “нагац ах”, насаар ах танихгүй эрэгтэй хүнийг хүндэтгэн дуудсан үг), dad, daddy (англиар “аав”).

Маамаа-Мөөмөө-Мээмээ-Мээмээ-Моомоо-Мөөм-Моом-Маам-Маамуу (монгол авгайлга-нэр), мама (оросоор “ээж”), мама (хятадаар “ээж”), mom, mamma, mama, mam, mummy (англиар “ээж”), maman (францаар “ээж”), mama (германаар “ээж”), mama (испанаар “ээж”), mamamama (испанаар “эмээ”).

Найнаа-Нээнээ-Нэнээ-Наниа-Нойноо-Ноноо-Нүүнээ-Нийнээ-Нөөнөө-Наанаа (монгол авгайлга-нэр), няня (оросоор “асрагч эх”), nina (англиар “асрагч”, “хүмүүжүүлэгч”, “гэлэнмаа”), papa (испанаар “эмээ”, “ээж”), Nonne (германаар “гэлэнмаа”), Neina /нэна/ (з авиаг хэлж сураагүй байгаа хоёр настай америк хүүгийн Zeina /зэна/ гэдэг хэлдэг жишээ (Finegan, 1994, p. 457).

Жүүжээ, Жуужаа, Жууж, Жийжээ, Жийж, Жижээ, Жүжээ, Жуужуу, Жүүжүү, Жүүж, Жоожоо, Жоож (монгол авгайлга-нэр) жие жиеэ (хятадаар “эгч”). Үүнээс гадна төвд хэлээр номын багшийг “жүүжээ” гэж хэлдгийг дээр дурдсан билээ.

Дээр нь нэмж хэлэхэд дэлхийн бусад хэлнээс жишээ болгон авсан дээрх үгс балчир насны хүүхдийн хамгийн ойр дотнын хүмүүсийн өдөр болгон хэдэнтээ давтагдаж байдаг сайн мэдэх нэр юм. Эдгээр нь монгол хүнд үгийн сангийн тодорхой утгагүй мэт санагдаж байгаа боловч “мээм”, “мөөм” гэдэг үг нь нялх балчир хүүхдийн хувьд ач холбогдлоор ээжтэй нь эн тэнцэх хөхийн сүүтэй холбоотой чухал зүйлийн нэр билээ. “Мээм”, “мөөм” гэдэг үгийг эх нь хөхүүл үрдээ “мээм”, “мөөм”, “мээмээ хөх”, “мөөмөө хөх” зэргээр байнга давтан хэлж байдаг учир хүүхдийн ой ухаанд хоногшин анхны хэлдэг үгийн нь нэг болсон байдаг. Өгүүлэх эрхтний нь хөдөлгөөн, байрлал бүрэн цэгцрээгүй балчир насны хүүхдийн хувьд эгшиг сэлгэгдэж “мээм”, “мөөм”, “моом”, “мээмээ”, “мөөмөө”, “мөмөө”, “мэмээ”, “мэмээ”, “мамаа”, “маамаа”, “моомоо”, “маамуу” хэмээн хэлэгдэх болжээ. Испани хэлний “mama” /мама/ гэдэг үг нэгэн зэрэг “ээж”, “мээм”, “мөөм” гэсэн утгыг илэрхийлдэг нь учиртай юм.

Өөр өөр хэлээр ярилцагч үндэстнүүдийн хэлэнд байдаг хүүхдийн хамгийн түрүүнд хэлж сурдаг үе, үг монгол хэлний авгайлга-нэртэй тохирч байгаа эдгээр жишээ нь тэдгээр үгсийг монгол авгайлга-нэрэнд зээлдэж хэрэглэсэн гэхээсээ энэ нь аль ч үндэстний хүүхдийн анхлан хэлдэг үг учир хоорондоо тохирч байгаа юм гэж хэлэх нь илүү зүйтэй болов уу гэж дахин тэмдэглэхийг хүсэж байна. Гэхдээ Ах, Агаа зэрэг үгсийн хувьд хэлнүүд бие биеэс зээлдэж авсан нь тодорхой юм. Бусад зарим үгийн хувьд (Амбаа, Жүүжээ, Ажин гэх мэт) манж, хятад зэрэг бусад хэлээс зээлдэж авсан байж болох талтай юм.

Авиан утгазүйн (фоносемантик) талаас “а” авиа нь бусад авиа, тухайлбал, “и”-тэй харьцуулбал “их”, “том” гэсэн сэтгэгдлийг хүнд төрүүлдэг тухай, монгол хэлэнд “их”, “том”, “хүчтэй”-г илтгэсэн тун олон үгийн авиан бүтцэд “а” авиа орсон байдаг тухай, хүнийг хүндэтгэн дээдэлдэг олон тооны авгайлга-үг энэ авианаас бүтсэн байдаг (Батчулуун, 2010).

Бидэнд бүртгэгдсэн 596 авгайлга-нэрийн 14,4% нь буюу 86 нь “а” авиагаар эхэлсэн, нийтдээ 264 нэр буюу бүх нэрийн 44,3% нь бусдаас илүү тод хэлэгдэж, эгшиг зохицох дүрмийн дагуу бусад үеийн эгшигийг өөртэйгээ ижилсүүлж байдаг нэгдүгээр үеийн эгшиг нь “а” байна.

“А” авианы хэмжээ далайцаар том гэсэн утганд хүч оруулж байдаг уртаар дуудагдах “аа”-тай авгайлга-нэрээс жагсаан бичье.

Аадаа, Аажая, Адиа, Ажаа, Айдаа, Амбаа, Ахаа, Агаа, Аагаа, Аак, Аниа, Анай, Ааяа, Ааяахүү, Ааяажав, Ажгаа, Ангиа, Ааниа, Амаа, Анжаа, Алиа, Ааж, Андиа, Аймбаа, Айд, Аяа, Аабаа, Авьдаа, Аагий, Амбажаа, Адгиа, Ааш, Аахиа, Адишбаа, Ажваа, Аалиа, Айдуудаа, Айлгаа, Амбагай, Андаа, Анжгаа, Амьдаа, Аабуу, Аазаа, Анжваа, Араа, Ааг, Азаа, Аймаа, Ангаажай, Андгиа, Адлиа, Алжаа, Авиа.

Бааваа, Баажая, Батгаа, Баажий, Баабаа, Бажаа, Баажуу, Бааж, Бааяа, Балиа, Будгаа, Бандигая, Бужаа, Бубаа, Баалиа, Буужаа, Бадгиа, Баядаа, Бадаа, Балдиа, Балгаа, Бангаа, Багаа, Баашаа, Бумаа, Баагий, Бувай, Банжгай, Буниа, Бамбуурай, Бийдаа, Бадиа, Баадай, Бужаахай, Бадиа, Бидаа, Баагаа, Баниа

Гаагаа, Гагаа, Гангаа, Гаамаа, Гааяа, Гааюу, Гайлаа, Гаажая.

Дайдаа, Дандаа, Дайд, Дайлаа, Дамаа, Даньдаа, Дадиа, Дааяа, Данигаа, Даниа, Дандаа, Дигаа, Дагаа, Даагаа, Даймаа, Дазаа, Дулигаа, Дундаа, Дуваа, Дудгай, Дунжаа, Данзаа.

Жаажая, Жааж, Жуужаа, Жанжиа, Жаах, Жажая, Жаахаа, Жаахан Ах, Жаагий, Жаа, Жаавай, Жаазай, Жанай, Жайжав, Жаамай, Жаагаа, Жигаа, Жийзаа, Жугаа, Жумаа.

Ламбагай, Лалиа, Лаалав, Лааяа.

Маамаа, Маажая, Мадиа, Маньдаа, Маам, Мамбаа, Маагаа, Маа, Муужаа, Манжаа, Маамуу, Магаа, Мадгиа, Мунжаа, Майндаа.

Найнаа, Наниа, Нааяа, Нангиа, Нангаа, Наагий, Нандгаа, Налай, Наамай, Нандиа, Нантаа.

Хаагаа, Хаазаа, Хуугаа, Хумбаа, Хайгаа, Хааяа, Хамбиган, Хуушаа, Хуунаа, Хагаа, Ханжаа, Хуваа, Хаадай, Хамбаа, Хундагаа.

ЛИТЕРАТУРА

1. Батчулуун Д. Монгол хүний нэрийн хүндэтгэл. Улаанбаатар. 2009
2. Батчулуун Д. Хэлшинжлэлийн удиртгал. Улаанбаатар. 2009
3. Батчулуун Д. “А” хийгээд авиан утгазүйн холбогдол. Ховд их сургуулийн эрдэм шинжилгээний бичиг. №3 (15). Улаанбаатар. 2010
4. Зарубин С. Ф., Рожецкий А. М. Русско-японский словарь. Москва. 1988
5. Левин Г. Г. Лексико-семантические параллели орхонско-тюркского и якутского языков. Новосибирск. 2001
6. Никонова О. И. Русско-немецкий словарь. Москва. 1973
7. Пагба Т. Хэл шинжлэлийн удиртгал. Улаанбаатар. 1976
8. Цэвэл Я. Монгол хэлний товч тайлбар толь. Улаанбаатар. 1966.
9. Finegan E. Language: Its Structure and Use. Fort Fourth. 1994
10. Hornmann H. Psycholinguistics. An Introduction to Research and Theory. New York. 1971
11. The New Penguin English Dictionary. Harmondsworth. 2000

Резюме

ПРОИСХОЖДЕНИЕ И ОБРАЗОВАНИЕ ИМЕНИ-АВГАЙЛГА В МОНГОЛЬСКОМ ЯЗЫКЕ

Имя-авгайлга является широко употребляемой среди халхасцев-основной этнической группы в Монголии почтительной формой имени и обращения по отношению к людям, старшим по возрасту. Сфера его употребления уже чем официальное личное имя. Оно употребляется в кругу семьи и знакомых людей как повседневной речевой этикет. Этот монгольский этикет вежливости сохраняет свою специфичность и самобытность, не имея аналога во многих мировых языках.

В статье рассказывается о безуффиксальном образовании и происхождении имен-авгайлга (О суффиксальном их образовании речь пойдет в отдельной статье в этом же сборнике. Д. Б.).

По структуре это односложные и двусложные короткие слова с ничтожным количеством трехсложных, причем частотность двусложных намного выше по сравнению с остальными. Среди собранных нами среди западных халхасцев 596 имен-авгайлга 596 слов т.е. 88,4% составляют двусложные. Такая короткость по объему продиктована законом экономии в языке, позволяющим говорящему затратить мало энергии при произнесении слов. Экономность более характерна для устной речи, где исключительно используются имена-авгайлга.

Встречаются еще и сложные слова, имеющие в своем составе термины родства, главным образом со словом “ах”(старший брат). Это - имяобразование типа “Том Ах”(старший среди старших братьев), “Дунд Ах (средний среди старших братьев)”, “Бага Ах (младший среди старших братьев)” и т.д. Это нарицательные имена, которые давали младшие братья и сестры их старшим братьям, впоследствии превратившиеся в имена-авгайлга и вошедшие в обиход речи родственников и знакомых.

Абсолютное большинство имен-авгайлга лишено каких либо лексических значений. Это “пустые слова” с точки зрения семантики и из-за этого создается какая-то завеса тайственности, усиливая эффект уважительного отношения к людям, носящим эти имена, и их происхождения неясны. По структуре они близки к детской речи и немногие из них наталкивают на мысль об их иностранном заимствовании, в частности, заимствования из тунгусско-манчжурского, тибетского, турецкого, китайского и русского, с носителями которых наши предки имели непосредственные контакты и других языков таких как английский, французский, немецкий и испанский, с которыми наши предки мало имели контакты. Но при более близком рассмотрении эти слова-омонимы оказываются очень похожими на детскую речь, структурно состоящими из двух открытых слогов с повтором одних и тех же звуков типа: ма-ма, ба-ба, нэ-нэ, да-да и т.п.

Мы предполагаем, что основным источником их происхождения является детская речь с характерными для нее звуко- и слогаобразованием, общим для детей любой национальности. Среди имен-авгайлга встречаются многие “слова”, которые мы слышим с уст маленьких детей, начинающих произнести их первые слова и словоподобные звуко сочетания типа: *маамаа, маамуу, агаа, баавай, жаажжаа, жуужжаа* и т.д. И недаром младшие дают имена-авгайлга их старшим братьям и сестрам.

Многие из имен-авгайлга имеют свои звуковые соответствия в детской речи в других языках. Это в основном названия близких для маленьких детей людей: отец, мать, няня и т.д. Например, аналогичные к именам-авгайлга *маамаа, маамуу, маам* слова мы находим в других языках, вошедшие в словари с пометкой “детская речь”. Это русское “мама” и его эквиваленты в китайском “*tama*”, английском “*mom*”, “*tatma*”, “*tama*”, “*tat*”, “*tittu*”, французском “*tatman*”, немецком “*tama*”, испанском “*tama*”. Также в испанском бабушку называют “*tatatama*”.


Мы классифицируем имена-авгайлга как: а/ образованные друг от друга: *Найнаа, Нээнээ, Нэнээ, Наниа, Нүүнээ, Нийнээ, Нөөнөө, Нойноо, Ноноо*; б/ образованные от официальных личных имен носителей имен-авгайлга: *Долгор*→ *Доолио, Думаа* → *Дууяа, Аюуш*→ *Ааяа*; в/ случайные образования: *Юүдмаа, Жүнжэр, Давилаг*. В статье дается развернутый список имен-авгайлга, образованных друг от друга посредством чередования гласных.


МОНГОЛ ХЭЛНИЙ НЭГЭН БҮТЭЭВРИЙН ТУХАЙ

Д.Батчулуун МУГБ, доктор, профессор
Ховд их сургууль

Түлхүүр үгс: бүтээвэр, язгуур, залгавар, дагуур, дагавар, нөхцөл, холбовор, оруулбар, захалбар, дамжвар, бүтээврээр үлдэгдэлгүй хуваах зарчим, бүтээврийн жийргэвч, хоосон бүтээвэр, бүтцийн бүтээвэр, тогтворгүй “н”, жийрэглэх гийгүүлэгч, гээгдэх эгшиг, гээгдэхгүй эгшиг.

Бүтээвэр нь үгийн хэлбэр, бүтцийн салшгүй хэсэг болж, үг үүсгэх, хувиргах үндсэн хэрэгсэл болохын хувьд бүтээвэрзүй хэмээн нэрлэгдэх хүний хэлний нэг үндсэн түвшинг бүрдүүлж байдаг билээ. Монгол хэлний үгийн бүтцийг бүрдүүлж байдаг үндсэн бүтээврүүдийг дараах бүдүүвчээс харж болно.





Монгол хэл нь бүтээвэрзүйн залгамал хэвшинжийн алтай язгуурын хэл учраас залгаврыг бүрдүүлэхэд оролцдог угтвар бүтээвэргүй ба язгуурын ард байрлах постфикс (лат. *postfixus-араас залгагдсан*) буюу дагууртай байдаг. Монгол хэлний язгуур бүтээврийн дараа байрлах үндсэн бүтээвэр болох дагуур нь дотроо дагавар, нөхцөл хоёрыг агуулж байдаг. Монгол хэлний бүтээвэр бие биеийн араас орж тасралтгүй үргэлжилсэн бүтэцтэй байдгаараа (*үз-вэр-ийн*) зарим хэлний оруулбар, захалбар, дамжвар зэрэг тасалданги бүтэцтэй бүтээврүүдээс ялгаатай юм (Батчулуун, 2009, х. 64).

Бидний дээр дурдсан бүтээврүүд нь үгийн утга бүхий цаашид задардаггүй хамгийн бага нэгж гэсэн бүтээврийн үндсэн тодорхойлолттой нийцэж байгаа юм.

Үг бол гагцхүү бүтээврээс бүрдэнэ. Үүнтэй уялдуулан хэлшинжлэлд америкийн судлаачдын оруулж ирсэн үгийг бүтээврээр үлдэгдэлгүй хуваах зарчмыг дурдах нь зүйтэй. Энэ зарчмаар бол үгийг бүтээврээр хуваахад цаана нь үлдэгдэл гарах ёсгүй юм. Хэлшинжлэлд нийтээр хүлээн зөвшөөрсөн бүтээврүүдийг үгнээс хасахад үлдсэн тэр хэсэг нь мөн л нэг төрлийн бүтээвэр юм (Хроленко, 1989, х. 42).

Үгийн сангийн болон хэлзүйн аль алины утгыг агуулаагүй мөртлөө үгийн бүтцэд орон бүтээврүүдийг холбох үүрэг гүйцэтгэж байдаг элемент алив хэлэнд байх ба үүнийг холбовор бүтээвэр буюу интерфикс (лат. *inter-хооронд,fixus - байрлуулсан*) хэмээн нэрлэдэг. Энэхүү бүтээврийг хэлшинжлэлд бүтээврийн жийргэвч, холбогч, хоосон бүтээвэр, структем буюу бүтцийн бүтээвэр, залгаврын тогтворгүй элемент гэх зэргээр нэрлэсээр иржээ (Хроленко, 1989, с. 42; “БЭС. Языкознание”, 1998, с. 312).

Эндээс харахад холбовор бүтцийн утгатай байж бусад бүтээврүүдийг хооронд нь холбоход тохиолдох завсрын байрлалтай байдаг ба нийлмэл үг бүтээхэд хоёр үндсийг, үг хувиргахад үндэс, нөхцөлийг хооронд нь холбох үүрэгтэй байдаг. Энэхүү үүргийг гүйцэтгэдэг завсрын шинжтэй бүтээвэр монгол хэлэнд байгаа эсэх нь сонирхол татсан асуудал болно.

Энэ нь юуны өмнө холбоворын дээрх хоёр үүргийг хоёуланг нь, эсвэл аль нэгийг дангаар гүйцэтгэж байдаг тогтвортой/тогтворгүй хэмээн нэрлэгдэх **-н-**, үгийн тийн ялгалын хувиралд гарч ирдэг жийрэглэх хэмээн нэрлэгдэх **-г-** тэй холбоотой юм. Чухамдаа монгол хэлний үгийг үндсэн бүтээврүүдэд хуваахад **-н-, -г-** нь үлдэгдэл болон үлдэх ба эдгээрийг бүтээврийг үлдэгдэлгүй хуваах зарчмын үүднээс авч үзвэл зайлшгүй бүтээвэр байх ёстой агаад эдгээр нь холбовор бүтээврүүд юм (Батчулуун, 2006, 2009, х. 65, 67, 2013 х. 29, 62-63, 222).

Монгол хэлшинжлэлд **-н-** холбовор бүтээр нь нууц “**н**”, тогтвортой/тогтворгүй“**н**”, “**-н**” үндэс гэдэг нэрээр нэрлэгдэн судлагдсаар ирсэн ба эдгээр нэрээр сурах бичгүүдэд орж, судлаачдын анхаарлыг татсаар ирсэн ба тусгай бүтээлүүдийн сэдэв болсоор иржээ (Лувсанвандан¹, 1961, х. 5-20 Ринчин, 1966, х. 68, Базаррагчаа, х. 71-92, 2002, Жамъян¹, 2012, х.145-151, Бямбадорж, 2013, х. 42-46 г.м). Дээрэх бүтээлүүдэд **-н-** -ийг бие даасан бүтээвэр болохыг дурдаагүй, цухас дурдсан хэдий ч (Ринчен, 1966, х. 68);чухамдаа ямар нэртэй бүтээвэр болохыг нэрлэлгүй явсаар ирсэн ба монгол хэлний бүтээвэрзүйн сурах бичиг зохиогчид, судлаачид тогтворгүй хэмээгдэх **-н-** бүтээврийг хэрэглэгдэх нөхцөл, утгазүй, зөв бичихүйн талаас голчлон анхаарсаар иржээ.

Холбовор бүтээвэр **-н-** нь хоёр үндсийг холбогчийн хувьд нийлмэл үг бүтээхэд оролцож байдаг. Энэ нь угаасаа энэ авиа эртний монгол хэлэнд үгийн үндсийг бүрдүүлж байдаг гол авианы нэг байснаа яваандаа хэлний цуваа цагийн хувьсах хөгжлийн явцад зарим нь гээгдэж, үлдсэн хэсэг нь нийлмэл үг бүтээхэд болон харьяалахын тийн ялгалын хувирал зэрэгт тодотголын үүрэгтэй хэрэглэгддэг нэрийн аймгийн үгсэд идэвхтэй хэрэглэгдэж, холбоворын үүрэг гүйцэтгэх болсонтой холбоотой юм: *наранцэцэг, хонин гүрвэл, нугасан хошуут, морин тэрэг,*

Академич Ш. Лувсанвандангийн 1961 онд хэвлэгдсэн *Монгол хэлний үгийн эцсийн тогтворгүй “н”-ийн тухай асуудалд*, профессор Г. Жамъянгийн 2005 онд хэвлэгдсэн *Монгол хэлний тогтворгүй “н”-ийг зөв хэрэглэе* өгүүлүүдийн сүүлхэн үед эмхэтгэсэн бүтээлүүдээс нь ишлэл авав. Д. Б.

шороон туулай жил, тэмээн хүзүүвч (газар усны нэр); *адууны шир, галууны мах.*

Ийнхүү холбовор **-н-** орчин цагийн монгол хэлэнд, нэгдүгээрт, нийлмэл үг бүтээхэд хоёр үндсийг, хоёрдугаарт, үгийн тийн ялгалын хувиралд үндэс, нөхцөл хоёрыг холбогчийн үүрэг гүйцэтгэж байна.

Монгол хэлний өөр нэгэн холбовор **-г-** үгийг тийн ялгалаар хувиргахад тохиолддог юм. Энэхүү холбовор нь **-н-** холбоворын нэгэн адил нэрийг харьяалах, гарах, үйлдэх, өгөх оршихын тийн ялгалаар хувиргахад гарч ирдэг: *хүүгийн, дүүгийн, тэмээнээс, тэмээгээр, хонинд, усанд, тэмээнд, хонины, хошууны* г.м. Холбовор **-н-, -г-** хоёрыгмонгол хэлнийбүтээвэрзүйн сурах бичигт жийрэглэх үүрэгтэй гийгүүлэгч гэж үзсэн нь бий (Өнөрбаян, 1998, х. 148, 153). Энэ нь эдгээр нь холбовор бүтээвэр болохыг дам хэлж буй явдал юм.

Холбовор **-н-, -г-** нь олон тохиолдолдурт, хос эгшгээр төгссөн үгэнд элбэг тохиолдоно: *ямаанаас, тэмээгээр, хүүгийн, дүүгийн, хажуугаар, хатуугаар, Болдоогоос, алтайгаар*. Энд эдгээр холбоворын, ялангуяа **-г-** холбоворын жийрэглэх үүрэг илт байна. Учир нь урт, хос эгшгээр төгссөн үгэнд урт эгшгээр эхэлсэн нөхцөл заалгахад дараалсан дөрвөн эгшгийг ялган хэлэх хэлэх эрхтний бололцоо хязгаарлагдмал байдаг.

Хэлэх эрхтний хязгаарлалтай холбогдуулан хэлэхэд монгол хэлний олон тооны залгавар бүтээвэр **-ууд, -үүд** -ийн хувилбар **-нууд, -нүүд, -чууд, -чүүд**-ийн **-н-, -ч-** нь, нэгдүгээрт, эгшгээр төгссөн үгэнд залгахад, хоёрдугаарт, тэдгээрийг хэлний угийн **-н** авиагаар төгссөн үгэнд залгахад хамрын гийгүүлэгчийн шинжийг хадгалахад жийрэг болгон хэрэгдэг учраас холбовор гэж үзэж болохоор байна. Жишээ нь: *өрөөнүүд, туулайнууд, багачууд, Архангайчууд; байшингууд, үсчингүүд, япончууд, германчууд*. Харин *моднууд, томчууд* зэрэг эгшиг болон хэлний угийн бус гийгүүлэгчээр төгссөн үгэнд залгасан залгавар нь **-нууд, -нүүд, -чууд, -чүүд** залгаврын нөлөөгөөр адилтгах аргаар хэрэглэгдэж байна. Эндээс харахад монгол хэлэнд үндэс, залгаврыг холбох **-ч-** холбовор бас байгаа бололтой байна.

Холбовор **-н-, -г-** нь жинхэнэ нэрээр зогсохгүй нэрийн болон нэрийн бус бусад үгийн аймгийн үгсийг тийн ялгалаар ялгаллахад тохиолддог: *миний, түүний, түүгээр, түүнд, түүнээс; тэрүүний, тэрүүнээс, тэрүүнд, тэрүүнтэй, тэрүүгээр, тэрүүн рүү* (аман ярианы хувилбар), *байгаагийн, дотогшоогоо г. м. Жишээ нь: Үүнийг би мэдэхгүй, тэрүүнээс асуу. Зочид дотогшоогоо (дотогш) оров.*

Холбовор **-н-** эртний монгол хэлэнд энэ бүтээвэргүй байсан үгэнд өргөн хэрэглэгдэх болсон нь орчин цагийн монгол хэлэнд улам бүр идэвхтэй үүрэг гүйцэтгэх болсныг харуулж байгаа хэлний хувьсах хөгжлийн бодитой нэгэн жишээ гэж үзэх хэрэгтэй.

Харьяалахын тийн ялгалын **-ий, -ы** болон өгөх оршихын нөхцлийн өмнө жийрэглэн орж хэрэглэгдэх болсон **-н-** холбоворын утга ялгах үүргийг хэл судлаачид тэмдэглэж, тодорхой жишээн дээр тайлбарлажээ: *цагийн байдал -цагны оосор, хий морийн сан - морины дэл, хоёрын тоо - хоёрны нэг, гэрийн хоймор - гэрэнд нь хийх, хуулийн заалт - хуулинд заах, номын хуудас - номонд дургүй* (Лувсанвандан, 1981, х. 157, Жамъян, 2012, х. 146-147).

Холбовор **-н-, -г-** ньбүтцийн үүргээс гадна хоорондоо авиалбарын эсрэгцэлд орж,үгийн утгыг ялган утгазүйн үүрэгтэйгээр (Өнөрбаян, 1998, х. 148,) хэрэглэгдэж байна: *Хараагийн гол – харааны шил, Даваагийн охин – давааны цаана, Хөдөөгийн Пэрэнлэй – хөдөөний хүн* г.м. Академич Ш. Лувсанвандан **-н-, -г-**холбоворын утга ялгах үүргийг тэмдэглэж, *Хоёр тэмээгээр дөрвөн морь авав=Танай тэмээнээр миний нэг тэмээ явчжээ* гэсэн жишээн дээр “...тэмээгээр гэсэн нь бодот юм, хэрэглэгдэхүүнийг зааж, тэмээнээр гэсэн нь зөвхөн орныг заасан утгатай болох мэт” хэмээн бичжээ (Лувсанвандан, 1981, х. 158).

Холбовор **-н-** нийлмэл тооны нэр үүсэхэд болон үндсэн тоо жинхэнэ нэр, орон цагийн нэр зэрэгтэй хамт холбоо үг үүсгэхэд идэвхтэй оролцдог: *таван тавын хорин тав, тавны нэг, таван ямаа, зуун тэмээ, гурван шөнө, таван өдөр*.

Эртний болон дундад үеийн монгол хэлэнд харьяалахын тийн ялгалд дан **-н-** нөхцөл байгаагүй байсан (Төмөртоогоо, 1992, х. 44, Лувсанвандан, 1961, Орчин цагийн монгол хэл, 2010, х. 135) бөгөөд энэ нь цуваа цагийн хувьсах хөгжлийн явцад хожуу холбоворын үүрэг гүйцэтгэх болсон байна гэсэн дүгнэлтэнд хүрч болохоор байна. Үүнтэй уялдан академич Ш. Лувсанвандан “Тогтворгүй “n”-ээр төгссөн үгс тодотголын үүрэг гүйцэтгэхдээ эцсийнхээ “n”-ийг заавал хадгалдаг нь монгол хэлэнд харьяалахын тодотголыг арвин хэрэглэдгийн дээр түргэн хэлэлцэхэд түүнийг хэлбэржүүлэх харьяалахын тийн ялгалын - in гэсэн хэлбэрийн урт i нь богиносож балархай эгшиг болох буюу “n”-ээр төгссөн үндсэнд залгадаг урт i нь мөн балархай болж бүрмөсөн гээгдэн, зохих үгийн үндэсний “n” мэтчилэн ерийн “n”-ээр төгссөн үгийн адил болж, “n”-ээр төгссөн бодот нэр тодотгол олширсны улмаас адилтгахын ёсоор болсон байж болно. Жишээ нь *usani san, usan san.*” гэсэн дүгнэлтэнд хүрснийг дурдах нь зүйтэй (Лувсанвандан, 1961, х. 154).

Энд харьяалахын тийн ялгалын холбоворын үүрэгтэй “n” нөхцөл нь хоёр үндсийг холбон нийлмэл үгийг үүсгэн цэвэр холбоворын үүрэг гүйцэтгэдэг талыг нь онцлон тэмдэглэмээр байна. Монгол хэлэнд бусад зарим хэлнээс ялгаатай нь нийлмэл үгийг бүтээж байдаг үндсүүд хамтаар бичигдэхийн зэрэгцээ тусдаа бичигддэг нь олонтаа билээ. Үүнтэй нэгэн адил англи мэтийн хэлэнд нийлмэл үгийн үндсүүдийг хамтад нь бичихийн зэрэгцээгээр тусад нь бас бичдэг. Жишээ нь *мөхөөлдөс* гэдэг үгийг *icescream, icescream* гэж хоёр янзаар бичдэг. Энэ мэтчилэн **-н-** холбовороор үүссэн хамтдаа болон тусдаа бичигддэг нэг ухагдахууныг илэрхийлсэн нийлмэл үгийн олон жишээг дурдаж болно: *наранцэцэг, Саранцэцэг, Улаанбаатар; хонин гүрвэл, модон морь, усан үзэм, нохойн хошуу* г.м. Холбовор **-н-** бүтээврээр үүссэн газар усны нийлмэл нэр олон байдаг: *Хонин ус, Модон овоо, Тэмээн хүзүүвч, Усан эх, Таван толгой, Гучин ус* г.м.

Монгол хэлний холбовор бүтээвэр **-н-, -г-** нь дангаар хэрэглэгдэхийн сацуу давхарлан хэрэглэгдэх ёс бас байна: *хоёулангаар, тавуулангийн, тавуулангаар, тавуулангаас, тавуулантай, тавуулан руу*.

Бидний дурдсан **-н-, -г-, -ч-** холбовор нь холборын ил хэлбэр юм. Харин далд холбор буюу тэг холбовор олонтаа тохиолдоно. Жишээ нь: *Хосөбаяр, Арвхангай, явoola, явoмагц, явoсугай* г.м.

Академич Ш. Лувсанвандан “монгол хэлний ерийн урт, хос урт эгшгийн дараа урт, хос эгшиг тохиолддоггүй, хэрэв тохиолдвол хоёр биеэ даасан фонемынхоо чанарыг алддаг тул тийм газар завсар нь гийгүүлэгчээр жийрэг хийж тус тусдаа хоёр фонем байгааг ялган заадаг юм” гээд дараа – аар –дараагаар, суу – аад – суугаад г.м жишээ дурджээ (Лувсанвандан, 1967, х. 103). Ш. Лувсанвандан цааш нь үргэлжлүүлэн монгол хэлний халх аялгууны хэлний угийн **п** гийгүүлэгч эгшгийн өмнө тохиолддоггүй учир адууныхаа, нөхрийнхөө г.м үгэнд жийрэглэн орсон х гийгүүлэгч нь

п гийгүүлэгчийг дараах урт эгшгээс нь салгах үүргээр нэмэгдэн гарч ирдгийг дурджээ (Лувсанвандан, 1967, х. 103). Энд Лувсанвандан гуай авиалбар-бүтээврийн талаар дурдаагүй боловч түүний жишээ гаргасан г, х гийгүүлэгч нь хоёр өөр бүтээврийг ялгахын зэрэгцээгээр холбох үүргээр орсон болох нь харагдаж байна.

Ийнхүү орчин цагийн монгол хэлэнд үгийн дунд тохиолдож, нийлмэл үгийг бүрдүүлэгч хоёр үндэс болон үндэс, нөхцлийг холбож байдаг үгийн бүтцийн салшгүй хэсэг болсон холбовор бүтээвэр байгаа нь бодит үзэгдэл бөгөөд ил холбор нь **-н-**, **-г-**, **-ч-** хэлбэрээр, далд холбовор нь **-н-**, **-г-**, **-ч-** -ээр хязгаарлагдахгүй элбэг тохиолдох магадлалтай байна.

Бид энэхүү өгүүлэлдээ монгол хэлэнд холбовор эгшиг бүтээвэр байгаа эсэхийг зориуд авч үзсэнгүй. Үгийг бүтээвэрээр нь үлдэгдэлгүй хуваах зарчмыг хэрэглэхэд мэдээж холбовор эгшиг монгол хэлэнд байна. Жишээ нь, сурагчид гэдэг үгийг бүтээвэрээр задлахад язгуур бүтээвэр *сур-*, залгавар бүтээвэр *-гч* хоёрыг холбосон **-а-**, залгавар бүтээвэр, олон тооны нөхцөл хоёрыг холбосон **-и-** холбовор бүтээвэр энд байна: *сур-а-гч-и-д*. Энэ мэтийн жишээ олныг дурдаж болно. Монгол хэлний зөв бичихүйд жийрэглэх эгшиг хэмээн тогтсон нэр томъёо ч бий. Мөн зөв бичихүйд гээгдэх ба гээгдэхгүй эгшгийн тухай дүрэм ч бий. Гэхдээ үгийн нэгдүгээр үеэс хойш тохиолдох богино эгшиг бараг хэлэгдэхгүй хүртлээ балархайшдаг нь асуудлыг хүндрүүлэх талтай. Монгол хэлний зөв бичихүйн нэг голлох зарчим нь авиазүйнх учраас гээгдэх/гээгдэхгүй эгшиг тогтвортой/тогтворгүй **“н”** –тэй адилгавал ил, далд хэлбэртэй холбовор бүтээвэр байж болох юм. Гэхдээ энэ нь язгуур мэтийн уламжлалт бүтээврээс гадна байгаа гээгдэх/гээгдэхгүй эгшигтэй холбоотой юм. Жишээ нь: *сурагчид* – *сурагчидын*, *үзэл* – *үзөлийн* г. м. Энэ бүхнийг тодруулахын тулд өгүүлүүрийн авиазүй, сонсолзүйн авиазүйн нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай байна.

НОМ ЗҮЙ

1. Базаррагчаа М. Орчин цагийн монгол хэлний нэрийн эцсийн “н”-ийн тухай. // Базаррагчаа М. Утгын чуулган. Эрдэм шинжилгээний өгүүлүүд. Улаанбаатар. 2002. х. 71-92//
2. Батчулуун Д. Хэлшинжлэлийн удиртгал. Улаанбаатар, 2009
3. Батчулуун Д. Существуют ли в монгольском языке интерфиксы? В сб.: Общетеоретические и типологические проблемы языкознания. Труды II международной научно-практической конференции. Бийск, 2006. с. 10-12.
4. Batchuluun D. A Contrastive Grammar of Mongolian and English. Second extended edition. Ulaanbaatar. 2013
5. Большой энциклопедический словарь. Языкознание. Москва, 1998. с. 197, 311-312
6. Бямбадорж Б. Хэл шинжээч Г. Жамъяны тогтворгүй “и”-ийн талаарх үзэл баримтлал. //Г. Жамъян-80. Тод бичиг судлал. Улаанбаатар. 2013 х. 42-46//.
7. Жамъян Г. Монгол хэлний тогтворгүй “н”-ийг зөв хэрэглэе. //Жамъян Г. Тод бичиг судлалын өгүүлүүд. Улаанбаатар. Улаанбаатар. 2012. х. 145-151//.
8. Лувсанвандан Ш. Монгол хэлний үгйн эцсийн тогтворгүй “н”-ийн тухай асуудалд. //Лувсанвандан Ш. Монгол хэлшинжлэлийн асуудлууд. Улаанбаатар, 1981. х. //.
9. Лувсанвандан ш. Орчин цагийн монгол хэлний зүй. Монгол хэлний авианы бүтэц. Тэргүүн дэвтэр. Улаанбаатар. 1967.
10. Өнөрбаян Ц. Орчин цагийн монгол хэлний зүй. Улаанбаатар. 1998
11. Ринчен Б. Монгол бичгийн хэлний зүй. Гутгаар дэвтэр (Хэлбэр судлал). Улаанбаатар. 1966
12. Хроленко А. Т. Общее языкознание. Москва. 1989.

Резюме

ОБ ОДНОЙ МОРФЕМЕ МОНГОЛЬСКОГО ЯЗЫКА

В статье рассказывается о звуках-морфемах **-н-**, **-г-**, в частности, **-ч-**, которые встречаются в языке на стыке двух основ (*наранцэцэг*, *Чулуундорж*, *Хатанбаатар*, *хонин гурвэл*) или основы и словоизменяемых суффиксов (*хөдөөний*, *номонд*, *тэмээгээр*, *хажуугаар*, *залуучууд*) в качестве соединяющих элементов. В отличие от традиционных морфем, являющихся наименьшими значимыми единицами языка, они лишены явных лексических и грамматических значений, зато они наделены определенными структурными, а иногда структурно-семантическими значениями.

Впервые в отечественной лингвистике автор настоящей статьи считает эти звуки-морфемы, не иначе как интерфиксами и аргументировал это в нескольких своих публикациях.

Исследователи мало обращали внимание на морфемные функции этих звуков.

Они больше всего интересовались звуком **“н”**, который в древнемонгольском языке занимал конечную позицию в слове и в современном монгольском языке исчезал во многих словах и в определенных условиях вновь появляется, а иногда встречается в интерпозициях в словах, где этот звук раньше отсутствовал. И данный звук назывался в научной литературе и школьных учебниках по-разному как **“н-основа”**, скрытый **“н”**, регулярный/нерегулярный **“н”**. Исследователи в основном интересовались условиями появления, семантикой и орфографическими вопросами слов с **“н”**

Когда речь идет о **-н-** и **-г-**, встречающихся в интерпозициях в словах, исследователи называли их как согласные-прокладки, что косвенно указывает на их роль как интерфиксы.

Основным условием появления интерфиксов **-н-**, **-г-**, также **-ч-** является тот факт, что они появляются в интерпозициях в словах на стыке двух морфем, каждая или одна из которых имеет долгие гласные, что нуждаются в прокладке-согласных, чтобы сделать возможным их членораздельное артикулирование: *ямаагаар*, *тэмээнээс*, *залуучууд*. По этой же причине автор считает суффиксы множества *-нууд*, *-нүүд*, *-чууд*, *-чүүд* алломорфами морфем *-ууд*, *-үүд*, состоящих из интерфиксов **-н-**, **-ч-** + *-ууди* *-үүд*.

В данной статье мы не затронули гласных-прокладок, называемых таковыми главным образом в орфографии. Однако, если принять принцип безостаточной членимости слова на морфемы, предложенный американскими исследователями, в монгольском языке, несомненно, существуют гласные-интерфиксы. Например, возьмем слово *сурагчид* (*ученики*) и членим его на морфемы: *сур-*(корневая морфема) **-а-** (интерфикс) *-гч* (морфема-аффикс) **-и-** (интерфикс) *-д*(морфема-аффикс). В данном слове элементы **-а-** и **-и-** являются остатками членения, т. е. интерфиксами. Также так называемые беглые/не беглые гласные, стоящие за пределами корневой морфемы можно считать интерфиксами маркированными и немаркированными: *сурагчид* (*ученики*) – *сурагчидын* (генитив от *сурагчид*), *үзэл* (*взгляд*)-*үзөлийн* (генитив от *үзэл*).

Гласные, особенно краткие гласные непервых слогов в монгольском языке подвергаются сильной редукции, почти не произносятся и зависят от манеры проговаривания индивидуума, поэтому не обладают постоянной акустико-артикуляционной характеристикой. Сказанное означает, что гласные служащие как интерфиксы нуждаются в дополнительном исследовании.

В монгольском языке кроме выше названных нами маркированных интерфиксов, существуют множество немаркированных интерфиксов: *Батөжаргал*, *уулочин*, *Арөхангай*, *явөлаа*, *явөмаги*, *явөсугай* и т.д.

PARTICLES IN MONGOLIAN AND ENGLISH

D.Batchuluun /Ph.D/. Professor
Khovd University

Key words: interrogative, negative, modal, focus particles, phrasal verb, preposition like words, adverb like words, separable and nonseparable phrasal verbs, adverbial particles, prepositional particles, “shade words”.

Particles are words that have no lexical meaning in themselves. The particles are usually uninflected. The Mongolian term for the particle is “сул үг” lit. vague words which indicates that they lack precise lexical meaning.

In Mongolian, particles are classified as follows: Interrogative particles: *бэ*, *вэ*, *уу* (*үү*), *юу* (*юү*).

Interrogative particles usually take end-position in a sentence: *Чи хэзээ ирсэн бэ?* *When did you come?* *Дорж явсан уу?* *Did Dorj leave?* *Та ирээ юү?* *Did you come?*

The interrogative particles *бэ*, *вэ* are used in sentences with interrogative words such as *хэн*, *хэд*, *хэзээ*, *ямар* etc.: *Таны нэрийг хэн гэдэг вэ?* *What's your name?* *Чи эгч дүү хэдүүлээ вэ?* *How many brothers and sisters do you have?* *Чи ямар өнгөнд дуртай вэ?* *What is your favorite color?*

Бэ is used after the final consonants *м*, *н*, *в* as *б* usually occurs within a word after them and *вэ* after other consonants and vowels.

In their pronunciation in a sentence the interrogative particles *бэ*, *вэ* admit two variants. In so-called full style of pronunciation where every word is pronounced clearly, vowel *э* is pronounced as corresponding long vowel with rising intonation: *Та хэзээ ирсэн бээ?* *Таны нэрийг хэн гэдэг вээ?*

But in informal colloquial speech vowel *э* reduces or drops, and thus *бэ*, *вэ* losing own stress, form phonetically one word together with the word preceding them: *Та хэзээ ирсэнб?* *Та хэзээ ирсэн (бэ)?* *Таны нэрийг хэн гэдэгэв?*

The particle *бэ*, *вэ* are also used for exclamations: *Яасан сайхан өдөр вэ!* *What a nice day!* *Би ямар азтай хүн бэ!* *What a lucky person I am!*

The interrogative particle *уу* (*үү*) is used after the words which end with consonants or short vowels and pronounced with rising intonation: *Тэр ирсэнүү?* *Did he come?* *Аав чинь дарга уу?* *Is your father a boss?*

The particle *юу* (*юү*) is used after words which end with long vowels or diphthongs and pronounced with falling intonation. A tone is higher in the word preceding *юу* (*юү*), namely, on the syllable with the long vowel or diphthong: *Чи ирээ юү?* *Did you come?* *Та чинь Дорж гуай юу?* *Are you Mr. Dorj?*

Negative particles: *биш*, *бус*, *-гүй* (*үгүй*), *алга*, *үл*, *эс*, *бүү*, *битгий*.

As negative words they have a general negative meaning of *no* and *not*.

While some of the negative particles (*биш*, *бус*, *-гүй* (*үгүй*)) follow after the words they negate, others (*алга*, *үл*, *эс*, *бүү*, *битгий*) precede them.

The negative particle *биш* is used with nouns, pronouns, adjectives, verbs, adverbs, and other word classes used as substantive: *Энэ миний ном биш.* OR *Энэ ном минийх биш.* *The book is not mine. Үзэг чинь номны дээр биш,*

харин дор нь байна. *Your pen is not on the book, but under it. Дорж энд биш, харин хөдөө суудаг. Dorj lives not here, but in the country. Энд долоо биш арван чоно байна! There are not seven but ten wolves! Түүний дутагдлыг хэлсэн чинь тэр над их уурлалаа. When I told him about his shortcoming, he got very angry at me.*

Although **биш** directly follows the words it negates, it can precede auxiliaries and sentence terminating particles such as **юм, билээ, шүү, биз, шив, дээ, -сан, (-сэн, -сон, -сөн)** in general negative statement to express different shades of meaning: *Дондог нэг л биш байна. OR Дондог нэг л биш дээ. There is something wrong with Dondog. Дондог нэг л биш болоод байна. Something wrong is happening with Dondog. Монгол Улс бол Орос Улс биш шүү! Mongolia is not Russia! Чоно бол гэрийн тэжээмэл амьтан биш юм. OR Чоно бол гэрийн тэжээмэл амьтан биш билээ. A wolf is a not domestic animal. Дулмаа бол Нараа бишсэн. Dulmaa is not Naraa indeed.*

It also can be used as a one-word sentence, especially in dialogues.

–Тэр чиний найз уу?

– **Биш.**

– *Is he your friend?*

– *No.*

Here, if the interlocutor wants to emphasize the negative answer, the **биш** can be doubled.

–Тэр чиний найз уу?

– **Биш биш. OR Бишээ биш.**

– *Is he your friend?*

– *No. No.*

The negative particle **бүс** has a meaning similar to the English negative prefixes and rarely used in informal colloquial speech: *Эмнэлэг бол ашигийн бүс байгууллага. A hospital is a non-profit institution. Түүний үйлдэл найрсаг бүс байв. His action was impolite. Ирэх баасан гаригт цаг агаар ямархуу байх нь тодорхой бүс байна. It is uncertain what the weather will be like next Friday.*

The **-гүй (үгүй)** is among the most commonly used particles in Mongolian and in most cases functions as negative affix which can occur with nouns and verbs.

When used with noun the **-гүй** has a general meaning of ‘to be without’ in contrast to the positive or affirmative suffix **-тай (-тэй, -той)** ‘to be with’: *сонирхолтой байх to have an interest, сонирхолгүй байх to have no interest. Дургүй ламыг дарж байгаад сахил хүртүүлэх (Цэцэн үг). To make by force the lama without any desire to perform an act of the sacrament (A Mongolian saying). Гэрэл машин худалдаж авах мөнгөгүй байв. Gerel has no money to buy a car. Оюутан хичээлд ямар ч сурах бичиггүй ирэв. The student came to the lesson without any textbooks.*

The particle **-гүй** occurs after verbs with the noun determining suffixes and usually expresses a general negative statement: *Бат өнөөдөр хичээлд ирсэнгүй. Bat didn't come to the class today. Би тамхи татдаггүй. I don't smoke.*

The **үгүй** is used as a separate unit rather than **-гүй** and is written separately. For **үгүй** it is not necessary to be used with verbs. If it used with verbs, it comes before them: *Бараан үүлс үгүй болов. The dark clouds disappeared. Аавын үгүй хойгуур ээж өвчилжээ. The mother got sick when the father was absent. Өрөөнд хэн ч үгүй байжээ. There was nobody in the room*

As a separate unit, **үгүй** is used as a complete sentence in dialogues.

– Дахиад жаахан кофе уухгүй юу?

– **Үгүй, баярлараа.**

– *Would you like any more coffee?*

– *No. Thanks.*

– Гунгаа хүндээр өвчилжээ.

– **Үгүй байлгүй. Би түүнтэй өнөө өглөө тааралдсан. Эв эрүүл байсан.**

– *Gungaa has gotten seriously sick.*

– *That can't be right. I met him this morning. He was completely fine.*

The particle **алга** has the same meaning as **-гүй (үгүй)**, and they are interchangeable as are other negative particles: *Багш өрөөндөө алга байна=Багш өрөөндөө байхгүй байна. The teacher isn't in his office. Таван төгрөгтэй байна гэдэг бол мөнгө алгатай адил = Таван төгрөгтэй байна гэдэг бол мөнгө үгүйтэй адил. To have only five tugriks means you have almost no money. Түүнд мөнгө алгыг би мэднэ=Түүнд мөнгө байхгүйг би мэднэ=Түүний мөнгөгүйг би мэднэ. I know that he has no money. Хөргөгчин дотор мах алга байна. = Хөргөгчин дотор мах байхгүй байна. There is no meat in the refrigerator.*

As we can see, the particles **алга, -гүй (үгүй)** like some particles can be declined contrary to the fact that in many languages, including English, particles are not declined.

The negative particles **үл, эс** are used before verbs with the noun determining, verb connecting and sentence terminating suffixes. In many, but not all cases, they are interchangeable. The particles **үл, эс** are mostly used in formal language: *Тэр биднийг үл тоомсорлов = Тэр биднийг эс тоомсорлов. He ignored us. Үл мэдэгчийн дүр бүү үзүүл. = Эс мэдэгчийн дүр бүү үзүүл. Don't pretend to be absent-minded.*

The **үл** is used in regulations: *Тамхи татаж үл болно! No smoking! Нэвтэрч үл болно! OR Нэвтрэхийг хориглоно! No trespassing!*

The *эс* occurs in conditional set expressions *эс тэгвэл, эс тэгвээс, эс тэгэх аваас, эс бөгөөс* if not, where pro-verb *тэг-* can substitute any verb. Among these expressions *эс тэгэх аваас* is a literary form and *эс тэгвэл* is more common in everyday speech: *Одоо чи орондоо орж унт, эс тэгвэл маргааш өглөө хичээлээсээ хожимдоно. If you don't go to bed now, you'll be late for your tomorrow morning class. Lit. Go to bed now, if you go to bed later, you'll be late for your class tomorrow morning. Тамхиа хая, эс тэгвэл наад ханиад чинь зогсохгүй. Give up smoking, if not this your coughs won't stop. Машин чинь 12 цагийн үед бэлэн байх ёстой, эс бөгөөс би чамд мэдэгдье. Your car should be ready by 12 o'clock, but if not I'll let you know.*

The particles *бүү, битгий* occur before verbs with the person-bound terminating suffixes and zero-suffixes. The *бүү, битгий* are mostly used in imperative sentences. They have similar meaning and in many cases can be interchangeable: *Тийшээ бүү яв. = Тийшээ битгий яв. OR Тийшээ бүү явагтун. = Тийшээ битгий явагтун. Don't go there. Бүү хөдөл! = Битгий хөдөл! Don't move! Над руу ингэтлээ битгий хараад байгаа ч дээ! Please don't look at me like that!*

Modal particles: *шүү, -даа (-дээ, -доо, -дөө), -аа (-ээ, -оо, -өө), -яа (-еэ, -ёо, -еө), юм, мөн, билээ, -сан, (-сэн, -сон, -сон), биз, бий/вий, шив, бол, байз, яахав, хөө(е).*

The modal particles express mood of the speaker, or a state of his/her feelings which always depend on the context or situation of the speech. So, they have wide range of meaning, and in some cases for their translation interjections and the “empty words” are used with some vague shade of meaning. See more in detail see (Tserenpil, Kulmann, 2008, pp. 335-344). All of them take end-position in a sentence or a *бол*-clause.

Here are some examples for the modal particles.

- *шүү*: *Би үүнийг л хүсэж байгаа шүү. I only want it. Чи худал ярьж байна шүү! You are lying! Дорж хичээлдээ явсан шүү болж байна. Dorj goes to school, but is not doing well.*

- *аа(-ээ, -оо, -өө)-яа (-еэ, -ёо, -еө)*: *Аав одоо ирвэл мөн сайхан аа! It would be really nice if Dad came now! Энэ жаахан охин мөн хөөрхөн өө! Wow, what a pretty little girl! Би чиний хүссэн болгоныг өгөө өгөө. Well, then I'll give you everything you want.*

- *байз*: *Одоо явъя байз. Well, I can go now. Чамайг би яая даа байз! OR Чамайг би яадаг билээ байз! What will I do with you?! За байз, хүлээж бай, хүнийг битгий яаруулаад бай. Man! Wait, don't hurry me. За байз, тэхлээр таны нэрийг хэн гэдэг билээ? Well, then, what's your name?*

- *Хөө(е)*: *Хөөе, чиний нэр хэн билээ? Hey, what's your name? Хөөеэ, энэ хүнийг хэн ч гэдэг билээ дээ? Hey, what's this person's name (I have forgotten it)? Одоо больё, хөөе. Hey, that's enough now.*

- *яахав*: *Яахав чи үүнийг хийвэл хий л дээ. Ok, if you want, you can do that. Яахав даа, тэр тэгж л байдаг юм, үүнд нэг их санаа зовоод байх хэрэггүй. Well, he usually says (does) such things, don't worry about it. Би чамд машинаа худалдсан ч яахав. Ok then, I can sell you my car.*

- *Чи ганц аяга кофе уухгүй юу?*

- *Яахав, яахав. Би одоо явахгүй бол болохгүй.*

- *Would you like a cup of coffee?*

- *No, thanks. I have to go now.*

- *даа (-дээ, -доо, -дөө)*: *Та одоо явдаа. You may go now. Чи юу хийчихэвдээ. What did you do! Чи миний номыг өг л дөө. Please give me that my book.*

- *сан (-сэн, -сон, -сон)*: *Одоо явахсан. I wish I could go now. Дотуур байранд суухгүй юмсан. I wish I didn't live in a dorm. Би таван хэлээр чөлөөтэй ярьдагсан бол Нэгдсэн Үндэстний Байгууллагад орчуулагчаар ажиллахсан. If I were fluent in five languages, I would work as an interpreter for the United Nations.*

- *бий / вий*: *Хүн харчих вий. I'm afraid people can see (us, it). Чи тэгсэн бий! Oh, wow, you didn't do that! Чимээгүй, аав сонсчих вий. Shh! Dad can hear us.*

- *бол*: *Тэр яах бол? What he would (say, do, think...)? Тэр ирсэн бол сайхансан. It would be nice if he came. Буттайсан бол анд явахсан. If I had a gun, I could go hunting. - шив: Тэр унтчихсан шив. I think, he has fallen asleep. Чи чинь турчихсан байх шив. I see, you have lost weight.*

- *биз*: *Тэр үнэнийг хэлнэ биз. I think, he will tell the truth. Энэ чиний малгай байна, тийм байгаа биз? This is your hat, isn't it? Тэр надаас уучлалт гуйна биз. I expect, he will apologize to me. Тэр одоо лав гэртээ ирчихсэн байгаа биз. I'm pretty sure, he has come home now.*

- *юм*: *Яасан жигтэйхэн юм! What a strange thing! Аав хөдөө төрж өссөн юм. My father was born and raised in the countryside. Энэ юу юм бэ? What's this? Түүний ээж нь багш хүн юм. Her mother is a teacher.*

- *мөн*: *Энэ чиний нөгөө яриад байсан хүн мөн байна. This is the man you were talking about. Энэ чиний ном мөн үү? Is that your book? Дорж бол сайн найз мөнөөс мөн. Dorj is a good friend indeed.*

The *мөн* can also take in a sentence not only end-position, but mid-position. *Дорж мөн ирлээ. Dorj also came. Тийм бол ч мөн гоёо! If so, that will be really nice! Дорж мөн хачин хүн шүү. Dorj is a really strange person. Хавар цагт хонины шинэ мах идэх нь мөн ч амттай шүү! Eating fresh mutton in spring is really delicious!*

- *билээ*: *Хадбаатар бол үнэхээр их тэнхээтэй бөх байж билээ. Hadbaatar was a wrestler of great physical strength. Миний аав инженер билээ. My father is an engineer. Энэ явдал гучин жилийн өмнө болж билээ. It happened thirty years ago. Таны алдар нэр хэн билээ? What's your name, sir?*

Focus particles: *бол, л, ч, нь.*

As the names suggests, focus particles help to focus our attention on an item as the central point of speech. They usually follow the words which call our attention to. Focus particles also can serve in a sentence as subject marker.

-**бол**: **Дорж бол** миний найз. *Dorj is my friend.* **Морь бол** малчин хүний сайн нөхөр юм. *A horse is a good friend of herdsmen.* **Дуусгасан бол** явцгаа. *Go, if you have finished.* **Тэр үүнийг хийж чадах юм бол** бугдийг хийж чадна. *If he can do that, he can do anything.* **Чадах юм бол** аавд хэлээд үзээрэй! *Tell Father if you dare!*

-**л**: **Дорж л** миний найз. *Only Dorj is my friend.* **Дорж л** үүнийг хийж чадна. *Only Dorj can do it.* **Намайг зүгээр байлга л даа.** *Please don't annoy me.* **Над битгий саад болоод бай л даа.** *Please don't disturb me.* **Чи одоо яв л даа.** *Please do go now.* **Энэ нөгөө аавын дандаа яриад байсан хүн биш л байгаасай.** *I do hope that he is not the person Father was talking about again and again.*

-**ч**: **Дорж ч** миний найз даа. *Indeed Dorj is my friend.* **Түүнд мөнгө огтхон ч байхгүй байлаа.** *He didn't have any money at all.* **Өөх ч биш, булчирхай ч биш.** *Not fat and not gland, nothing* (an set expression about half-done job). **Тэр юу ч хэлэлгүй гарч явав.** *He said nothing and went out.* **Гэрт хэн ч алга байна.** *There is nobody home.* **Хүүхэд ч үүнийг хийж чадна.** *Even a child can do it.* **Би тийшээгээ явсан ч яахав.** *Ok, I can go there.*

-**нь**: **Эднээс Дорж нь** миний найз байгаа юм. *Among them Dorj is me friend.*

Mongolian particles are mostly used in colloquial language and most of them are sentence terminating (**бэ, вэ, уу (үү), юу (юү), биш, биз, шүү, даа (дээ, доо, дөө), аа (-ээ, -оо, -өө), яа (еэ, ёо, еө), юм, мөн, билээ, -сан, -сэн, -сон, -сон), биз, бий/вий, байз.** *Энэ юун хүн бэ? Who is that person? Чи нөгөө номоо олсон уу? Have you find the book? Номыг минь буцааж өг л дөө. Please give my book back to me. Над ямар ч мөнгө алга. I don't have any money. Энэ бол ном юм. This is a book. Энэ миний ном мөн. This is my book. Та одоо яв даа. You may go now. Одоо явахсан. (I) wish (I) could go now. Тэр унтчихсан шив. I think, he has fallen asleep. Одоо гэртээ харья байз. Now, I have to go home. Монгол бол Хятад биш. Mongolia is not China. Тэр явъя гэвэл бидэнтэй хамт явна биз. If he likes, he can go with us. Монголын нэрт яруу найрагч Б. Явуухулан 1929 онд төрсөн билээ. Well-known Mongolian poet B. Yaviukhulan was born in 1929.*

The particles can come together to make compound construction. **Цагдаа нар түүнийг нисэх онгоцны буудал дээрээс баривчилсан юм билээ.** *The police picked him up at the airport.* **Гэрлийн хурдаас илүү хурдан аялана гэдэг бол бололцоогүй зүйл шүү дээ.** *It's impossible to travel faster than the speed of light.* **Цас бол өвөл цагт байдаг ерийн нэг үзэгдэл л дээ.** *You know, snow is a common phenomenon in winter.* **Чи чинь Баатарын хүү биш биз?** *Are you Baatar's son, aren't you? Тийм л юм бол тэг л дээ. If it is so, you can do it.*

Most Mongolian particles can be used as the equivalents of English auxiliary verbs, modal auxiliaries and sometimes interjections.

In English, a particle is defined as 'a word that combines with a verb to form a phrasal verb' (Kolln, 1994, p. 401): **make off** зугт-, **make off with** хулгайл-, **signoff** төгсгө-, **call off** хойшуул- (хурал, уулзалт г. м.), **cut off** тасла- буур-, мууд-, **be off** яв- чөлөөтэй бай-, хойшуул-, зогсоо- таср-(цахилгаан).

Actually, particles, as components of the phrasal verbs, are words overlapping with adverbs and prepositions with a changed meaning. More often phrasal verb is idiomatic and defined as 'a verb-particle combination that produces a meaning that cannot be predicted from the meaning of the parts' (Kolln, 1994, p. 402). So, it would be more accurate to call them not as adverbs or prepositions but as adverbial particles and prepositional particles.

In Mongolian particles also can combine with verbs. But the difference between participles that combine with verbs in the two languages is that in Mongolian particles combining with verbs cannot change their lexical meaning. **Дорж ирсэн шүү.** *Dorj has come.* In contrast to this, in English, particles forming phrasal verbs change their lexical meaning, making it idiomatic. There is a sharp distinction between participles in Mongolian and English: **I would like to give up smoking.** *Би тамхи татахаа болихыг хүсч байна. We must put off the meeting for another week. Бид хурлыг өөр долоо хоногт хийхээр хойшуулах ёстой. She takes after her mother. Тэр ээжтэйгээ адилхан.*

Phrasal verbs play important role in English speech. They are very common and widely used by English-speaking people, both in everyday speech and in writing, including the media – newspapers, magazines, television and radio. Speakers of English tend to invent new ones and to give new meanings to old ones. Besides this phrasal verbs provide many common and useful nouns and adjectives in everyday use such as *a breakthrough шинжлэх ухаанд гарсан эргэлт, үсрэлт, input оролт, төсөлд гаргасан хүч чармайлт, outburst дүрэлзэлт (сэтгэлийн хөдөлгөөн), a takeover хяналт тогтоох, go-ahead зөвшөөрөл, the outcome үр дүн, an outcry хүчтэй эсэргүүцэл, a feedback эгэх холбоо, a hangover хуучны үлдэгдэл, a pull-in замын дэлгүүр, гуанз, the intake шинэ оюутан, see-through blouse тунгалаг, a takeoff элэглэл, a send-up элэглэл* and so on.

Phrasal verbs consist of a simple verb followed by one or two particles, where the meaning of the construction is often different from the meaning of the individual words.

The three basic constructions are:

Verb + preposition *look after асрах, харах*

Verb + adverb *give away нууц задлах, урвах*

Verb + adverb + preposition *look forward to тэсэж ядан хүлээх.*

Note. The words **adverb**, **preposition** used in these constructions can be understood as adverbial particles and prepositional particles.

Understanding the phrasal verb can cause problems to non native speakers of English.

We can also admit that in some English textbooks, especially for those learning English as foreign language, in the phrasal verbs are included adverbs and prepositions with the literal or slightly changed meaning. If the parts of a phrasal verb have their literal meaning or only slightly changed, we can easily understand what they mean: Adverb. *He sat down* (literal meaning). *Тэр суув.* Adverb. *The prices are going down* (slightly changed). *Үнэ буурч байна.* *The river nearly dried up* (slightly changed). *Энэ гол бараг ширгээжээ.*

Adverb. *Take these plates away* (literal meaning). *Эдгээр тавгийг холдуул.*

Adverb. *Take three away from ten* (slightly changed). *Арваас гурвыг хас.*

Preposition. *Look into the microscope* (literal meaning). *Микроскопоор хар.*

Preposition. *Look into the matter* (slightly changed). *Асуудлыг судал.*

But as it was defined above, phrasal verbs have a meaning which we cannot easily understand from the meaning of the parts: *His mother did not like it and came down heavily on (upon) him.* *Энэ нь ээжийн нь сэтгэлд таалагдсангүй, тэгээд ээж нь түүнийг ухаан жолоогүй загнажээ.* *You should get down to work right away.* *Чи одоохон ажлаа эхлэх хэрэгтэй.* *It suddenly came over me that I had left the door open.* *Би хаалга онгорхой орхисноо гэнэт санав.* *How are you getting along with your work?* *Ажил чинь хэр урагштай байна вэ?* *I have just seen him. He must be somewhere about.* *Би дөнгөж саяхан түүнийг харсан.* *Тэр энүүхэнд хаа нэгтэй газар байх ёстой.*

Sometimes the structure: verb + prepositional phrase and phrasal verb have the same form, but the difference between them is that the structure: verb + prepositional phrase keeps its lexical meaning: *The boys ran into the street.* *Жаалууд гудамжинд гүйдэн гарлаа.* *Mr. Brown ran into an old friend yesterday.* *Браун гуай өчигдөр хуучин андтайгаа санаандгүй тааралдсан.* *Put the book on the table.* *Энэ номыг ширээн дээр тавь.* *I put on several kilograms while I was on holiday, so now I'm on a strict diet.* *Би амралтаараа хэдэн килограмм жин нэмсэн, ингээд одоо хоолны дэглэм хатуу сахиж байна.* *He looked up and saw a huge vulture circling overhead.* *Тэр дээшээ харж толгой дээгүүр эргэлдэж байгаа аварга том тас шувууг үзэв.* *Now that my application has been accepted, I think that things are really looking up.* *Одоо миний өргөдлийг хүлээж авснаар байдал үнэндээ нааштай тийшээгээ болж байна гэж би бодож байна.*

Sometimes a phrasal verb can have several meanings: *If you want to see things clearly, take your glasses off.* *Чи юмыг сайн харъя гэж бодож байгаа бол нүднийхээ шилийг ав.* *When does the plane take off?* *Онгоц хэзээ хөөрөх вэ?* *He was punished for taking off his teacher.* *Түүнийг багшийгаа элэглэн дуурайсны төлөө шийтгэжээ.* *Do you think this book will take off?* *Энэ ном амжилт олно гэж чи бодож байна уу?* *He could not take the paint off the table cloth.* *BritE. Тэр ширээний бүтээлгэний будгийн толбыг арилгаж чадсангүй.* *I'm taking a day off.* *Би нэг өдрийн чөлөөтэй байна.* *He wants to take off to the beach.* *Тэр машинаараа далайн хөвөө рүү явахыг хүсэж байна.*

Besides being as prepositional and adverbial the phrasal verbs can be divided into other two groups: transitive phrasal verbs and intransitive phrasal verbs.

Transitive phrasal verbs can take a direct object: *Find out whether they are coming.* *Тэд нар ирж байгаа эсэхийг мэдээдэх.* *He can't live down his mistake.* *Тэр алдаагаа мартаж чадахгүй байна.* *Ann is bringing up her brother's children.* *Ann ахынхаа хүүхдүүдийг өсгөн хүмүүжүүлж байна.* *I can't make out what he means.* *Би түүний юу хэлэх гэж байгааг ойлгохгүй байна.* *The dry soil drank up the rain in no time.* *Хуурай хөрс борооны усыг дорхноо шингээв.*

Intransitive phrasal verbs which can't take a direct object is very common in English: *Drink up quickly.* *Хурдан уугаад дуусга.* *The plane has now taken off.* *Онгоц хөөрчихлөө.* *Did he catch on?* *Тэр ойлгосон болов уу?* *He is playing around.* *Тэр хариуцлагагүй загнаж байна.* *He turned up unexpectedly.* *Тэр санаандгүй байтал гэнэт ирэв.*

The transitive phrasal verbs fall into two major groups: separable and nonseparable phrasal verbs.

In separable phrasal verbs the particles are separated from their verbs: *Steve looked it up in the directory.* *Стив үүнийг лавлахаас эрсэн.* *What they said and demonstrated brought him over.* *Тэдний хэлж харуулсан зүйл түүнийг бодлоо өөрчлөхөд хүргэжээ.* *I want to get my money back.* *Би мөнгөө эргүүлж авмаар байна.* *He runs his friends down.* *Тэр найз нараа тоодоггүй.* *Take your boots off.* *Гутлаа тайл.* *Don't turn my offer down.* *Миний саналаас бүү татгалз.*

In nonseparable phrasal verbs the particles must not be separated from the verbs: *Rita will stand by you, Jim.* *You know that. Жимээ, Рита чамд үнэнч байх болно.* *Chi үүнийг мэдэж байгаа.* *Roberto came across an old photograph of Laura in the desk drawer.* *Роберто ширээний нүдэн дотроос Лаурагийн хуучин гэрэл зургийг олжээ.*

Some phrasal verbs have three components: ordinary verb followed by a directional adverb and a preposition like particle. These verbs are all nonseparable phrasal verbs. They include the following:

<i>cut down on</i>	<i>бууруулах, багасгах</i>
<i>drop in on</i>	<i>ороод гарах (айлаар, хүн дээр)</i>
<i>get away with</i>	<i>хэргээс мултрах</i>
<i>go back on</i>	<i>тохиролцоог зөрчих</i>

<i>go through with</i>	дуусгах, төгсгөх
<i>keep up with</i>	хэл нийлүүлэх
<i>look down on</i>	дээрэнгүй хандах
<i>make up for</i>	хохирлыг барагдуулах
<i>put up with</i>	хүлцэх
<i>run out of</i>	дуусах
<i>run up against</i>	тулгарах (саад)
<i>stand up for</i>	хамгаалах, өмгөөлөх

Note that in English a term particle is the term that lacks precise lexical definition accepted by all. Some grammarians include in particles uninflected word classes: adverbs, conjunctions, interjections and silence fillers even possessive and demonstrative pronouns. As examples, the English infinitive marker *to* and negator *not* are usually considered particles. And among them we can find similar to the classification of the Mongolian particles. As we see above, in translation many of the Mongolian particles into English are used interjections, silence fillers and negator *no*.

All the above mentioned words including particle parts of phrasal verbs are short words which consist of one or two syllables, even of a single phoneme-words like Mongolian focus particles *л, ч, нь*. So these short words not contradict the term ‘particle’ which means ‘a very small piece of matter’.

By the way, in Mongolian, the term particle also needs a precise lexical definition. That’s why in recent works on Mongolian grammar the authors refused to use the term, including particles together with some other minor word-class words in so-called ‘shade words’ (Unurbayan, 1998, pp. 228-234, *Modern Mongolian Language*, 2010, p. 181). Earlier a well known Mongolian linguist Luvsanvandan Sh. in his textbook on Mongolian grammar, published in 1951, also used this term for some of the Mongolian particles but not for all of them and later in his work *The Modern Mongolian Language*, published in 1961 in Beijing, he didn’t use the term ‘shade words’, coming back to the traditional term “Сул үг, *weak words*” including in it particles *үл, эс, бүү, бумзуй, уу, үү, бэ, вэ*. We can also see that different authors offered different types of particles including even inflectional suffixes (Luvsanvandan, 1981, pp. 225-282).

But the prevailing view in English grammar is that of considering the preposition and the adverb like parts of phrasal verbs as particles. The authors call them as prepositional particles and adverbial particles. And the phrasal verbs are sometimes called verb-particle construction (combination).

REFERENCES

1. Allsop J. English Grammar. Cassel. 1986
2. Batchuluun D. A Contrastive Grammar of Mongolian and English. Second revised edition. Ulaanbaatar. 2013
3. Chalker S. Current English Grammar. Macmillan. 1984
4. Jacobs, Roderick A. A. Grammar for English language professionals. Oxford University Press, 1995
5. Kolln, Martha. Understanding English Grammar. Macmillian Publishing Company. New York, 1994
6. O’ Dowd, Elizabeth M. Prepositions and Particles in English. A discourse-functional account. New York University Press. 1998
7. Quirk R., Greenbaum S. A University Grammar of English. Longman. 1973
8. Tserenpil D., Kulmann R. Mongolian Grammar. Fourth revised edition. Ulaanbaatar. 2008
9. Лувсанвандан Ш. Монгол хэл шинжлэлийн асуудлууд. Улаанбаатар. 1981
10. Орчин цагийн монгол хэл. Улаанбаатар. 2010
генетическом родстве алтайских языков, во-вторых, получаем в свое распоряжение точный инструментарий для разграничения исконной общеалтайской лексики и межгрупповых заимствований, позволяющий также более точно определять направление лексических заимствований.

ЛИТЕРАТУРА

1. АмаржаргалБ., ЦолооЖ., ГантогтохГ. 1988 –Монголхэлнийаманаялгуунытольбичиг. т. 1, Уланбаатар,1988
2. Бетлингк О. 1989 – О языке якутов. Новосибирск, 1989.
3. Бурькин А.А. 1999 – Роль монгольских языков для алтаистических исследований // История развития монгольских языков. Улан-Удэ, 1999. С.19-42.
4. Бурькин А.А. 2000 – О месте тунгусо-маньчжурских языков в алтаистических исследованиях // Проблемы изучения дальнего родства языков на рубеже третьего тысячелетия. Доклады и тезисы международной конференции. М., 2000. С.12-16.
5. Бурькин А.А. 2008 – Морфологические варианты слова и проблемы фонетических соответствий в алтайских языках //AltaicaV, Уланбаатар, 2008. С.5-56.
6. Древнетюркский словарь. Л., 1969.
7. Захарова И.В. 1960 – Двенадцатилетний животный цикл у народов Центральной Азии // Труды Института истории, археологии и этнографии Академии Наук Казахской ССР. Т. 8. Алма-Ата, 1960. С. 32–65.
8. Исследование бурятских говоров 1965 – Исследование бурятских говоров (Труды БКНИИ. - Вып. 17, Сер. языковедческая). Вып. 1. Улан-Удэ, 1965.
9. Пекарский Э.К. 1959 – Словарь якутского языка. 2-е изд. Т.1-3. М., 1959.
10. ССТМЯ = Сравнительный словарь тунгусо-маньчжурских языков. т.1-2. Л., 1975, 1977.
12. Щербак А.М. 1959 – Об алтайской гипотезе в языкознании //Вопросы языкознания, 1959, № 6. С.51-63.
13. Щербак А.М. 1961 – Названия домашних и диких животных в тюркских языках //Историческое развитие лексики тюркских языков. М., 1961. С.82-172.
14. Щербак А.М. 1966 – О характере лексических взаимосвязей тюркских, монгольских и тунгусо-маньчжурских языков //Вопросы языкознания, 1966, № 3.С.21-35.
13. Щербак А.М. 1971– О морфологическом составе образных глаголов типа *baqir, caqir-, qajqir-*. // Советская тюркология, 1971, № 3. С.8-12.

ТОХИОЛДМОЛ ҮГ, ТҮҮНИЙ ОНЦЛОГ

Б. Бямбадорж ХИС. МХУЗ-ын тэнхим

1. Удиртгал

Хэл болон хэлэхүйн орчинд шинэ үг, хэллэг цаг үргэлж үүсэн бий болж байдаг бөгөөд энэ дагуу хэл шинжлэлд шинэ үг (неологизм), тохиолдмол үг (оказиональное слово, окказионализм), тохиолдмол утга (оказиональное значение), боломжит үг (потенциальное слово), зохиогчийн үг (авторское слово), зохиогчийн хувийн үг (индивидуально-авторское слово) зэрэг нэр томъёонууд хэрэглэгддэг байна. Энд бид тохиолдмол үгийн хүрээнд тодруулан үзэхийг зорьж байна.

Тохиолдмол үгс гэдэг бол хэлний системийн гадна орших, хэлний хэм хэмжээг эвдэж, тэгэхдээ зориудаар зөрчиж үүссэн үгс юм. Иймд тохиолдмол үгс нь хэлний бус хэлэхүйн баримт болох бөгөөд ердийн үгийн хэлбэртэй тохирдоггүй байна. Тохиолдмол үг нь авиазүй, бүтээвэрзүй, бүтээврийн авиабарзүй, үг бүтээх ёс, үгийн сан судлал, утга судлал, шүлэг судлал зэрэгтэй холбогддог өвөрмөц судлагдахуун билээ.

2. Шинэ үг ба боломжит үгтэй холбогдох нь

Тохиолдмол үгтэй нягт холбоотой ойлголтууд бол дээр дурдсанчлан шинэ үг, боломжит үг зэрэг бөгөөд эдгээр нь тус бүрдээ онцлогтой юм. Үүнд:

Шинэ үгс гэдэг нь нийгэм, хүний ухамсарт шинээр бий болсон юм үзэгдэл, ойлголтыг тэмдэглэсэн үгс юм. Шинэ үг бол тухайн цаг үедээ л шинэ сэргэг байдгаараа харьцангуй шинжтэй ойлголт юм. Жишээлбэл: *од, брэнд, чат, чарт, моргейж, амьд тоглолт, виза карт, хөгжлийн бэрхшээл, зорилтот бүлэг, жижиг дунд үйлдвэрлэл* гэхчлэнгээр одоогоор ихэвчлэн харь хэлний үг болон нийлмэл үгийн түвшинд шинэ үг, нэрлэлт бий болж байна.

Боломжит үгс гэдэг нь үгийн сангийн нэгж байж болохуйц, хэрэглээнд тогтвортой хэвшээгүй, бүтээц сайтай загвараар шинэ тугтам үүссэн үгс юм. Жишээлбэл: *эмэгтэйлэг, чуулаа-, хүүчил-, нарчлан, сарчлан, олхон* гэх мэт.

Харин **тохиолдмол үгс** гэж ер бусын буюу байх боломжгүй загвараар, эсвэл маш бага бүтээцтэй загвараар үүссэн зохиогчийн хувийн чанартай үгсийг хэлдэг байна. Тохиолдмол үгс нь тухайн зүйлийг шинэ үг шиг энгийн нэрлэх бус, харин гойд өвөрмөц янзаар нэрлэсэн байдгаараа онцлогтой. Тохиолдмол үгс бол өвөрмөц содон дүрслэлтэй, зөвхөн тухайн хам сэдэвтээ чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд дахин сэргээн хэрэглэгддэггүй ажээ. Өөрөөр хэлбэл, тохиолдмол үг нь шинэлэг чанараа хадгалсаар байхын сацуу тухайн эх сэдвийн хүрээнд “амьдарч” байдгаараа шинэ үгээс ялгаатай. Тэгвэл боломжит үгээс ялгаатай нь

тохиолдмол үг бол тодорхой зохиогчтой байх ба заримдаа “зохиогчийн хувийн үг” гэж нэрлэдэг нь санамсаргүй зүйл биш ажээ.

Боломжит үгийн талаар анхлан бичсэн хүмүүсийн нэг нь Г. О. Винокур бөгөөд “Маяковский – хэлийг шинэчлэгч” гэсэн өгүүлэлдээ дурдсан байдаг ажээ. Тэгвэл тохиолдмол үг гэх нэр томъёог анхлан Н. И. Фельдман “Тохиолдмол үг ба тользүй” өгүүлэлдээ гаргаж ирсэн гэж үздэг. Гэсэн хэдий ч судлаачдын дунд эдгээр нэр томъёог тайлбарлах хүрээнд нэгдсэн саналд хүрээгүй, янз бүрээр тайлбарласаар байна. Иймд хоорондынх нь ялгаа заагийг тодорхой болгохын тулд дараах үндсэн шалгууруудыг тавих ёстой гэж үзэж байна. Үүнд:

1. Хэл, хэлэхүйд хамаарагдах чанар

Шинэ үгийн боломжит болон тохиолдмол үгээс ялгарах гол ялгаа нь хэл ба хэлэхүйн эсрэгцэл дээр үндэслэдэг байна. Үүнд шинэ үг нь хэлний баримт болох бол, боломжит болон тохиолдмол үгс нь хэлэхүйн баримт болох ба хэлний системд ордоггүй ажээ.

2. Үг бүтээх чанар

Үг бүтээх чанарын асуудал нь шинэ үгэн дээр зайлшгүй байх ёстой зүйл биш бөгөөд өөрөөр хэлбэл, шинэ үг нь тухайн хэлний үг бүтээх хэрэглүүрээр үүссэн үүсмэл үг (*хот-ж-лт, цахь-м*) байхаас гадна үүсмэл бус хэлбэрээр (утга шилжих, харь үг) ч байж болно.

Тэгвэл тохиолдмол үгийн тухайд, судалгааны хоёр үндсэн хандлага байгаа нь үгийн сангийн болон үг бүтээхүйн хандлага болно. Үгийн сангийн талаас тайлбарлагчид, тухайн хэлний толь бичигт ороогүй үүсмэл хийгээд үүсмэл биш үгсийн аль алийг тохиолдмол үг гэж үздэг байна. Харин үг бүтээхүйн талаас тайлбарлагчид, тохиолдмол болон боломжит үгс нь ямагт үүсмэл байх ёстой, өөрөөр хэлбэл, үг бүтээх хэвшсэн загвараар үүсэж, толь бичигт тусгагдсан байдаг жирийн үүсмэл үгээс ялгардаг үгс буюу ямар нэгэн хэрэгцээ шаардлагын дагуу хэл ярианд бий болж байдаг хам сэдвийн чанартай үүсмэл үгс юм гэж үзэж байна.

3. Хэлний тогтолцоонд нийцэх эсэх

Энэ нь тохиолдмол үг хийгээд боломжит үгийг хооронд нь ялгах чухал шалгууруудын нэг юм. Үүнд, боломжит үгс гэдэг бол үг бүтээх бүтээц сайтай загвараар үүссэн үгс юм. Жишээлбэл: *узкобедрость, краснощекость* (Т. Толстая), *хариуу, буурайл-, сархиал-* (Д. Пүрэвдорж) гэхэд тэмдгийн нэрээс жинхэнэ нэр бүтээх хийсвэр шинж заасан утгатай *-ость* дагавар, үйлээс тэмдгийн нэр бүтээх *-уу* дагавар, нэрээс үйл үг бүтээх *-л* дагавар орсон байна.

Тэгвэл тохиолдмол үгийг бүтээхдээ үг бүтээх хуулийг зөрчих нь түгээмэл юм. Жишээлбэл: орос хэлэнд *-ость* дагавартай жинхэнэ нэр нь дайвар үгээс үүсдэггүй байхад, Т. Толстаягийн бүтээлд *кое-какность* гэж үүссэн байдаг байна. Энэчлэнгээр Д. Пүрэвдоржийн зохиолд үг бүтээх хууль дүрмийг зөрчсөн үгс цөөнгүй тохиолдож байна. Жишээлбэл:

Зуун ногоон

Шилмүүс намиаж

Зуны сардаа

Шивнэн найгавч (“Зуун мод”)

Энд *намиа* гэсэн нэр үгийн араас үйлийн тийн ялгалын *-ж* нөхцөл залгаж бүтээврийн байрыг зөрчиж шинэ хэлбэр үүсгэжээ.

4. Үүсэн хэрэглэгдэж буй байдал

Тохиолдмол болон шинэ үг нь хэл ярианд аль хэдийн үүсэн бий болсон, хэрэглэнд орсон үгийн сангийн бодит нэгжүүд гэж болно. Ялангуяа шинэ үг нь хэлний үгийн бүрэлдэхүүнд багтсан байдаг. Тэгвэл боломжит үгийн тухайд асуудал арай өөр байдаг бөгөөд дотор нь хоёр зүйлд ангилж болно. Үүнд:

1) Нэгэнт үүссэн хэдий ч хэлний хэрэглэнд хараахан идэвхтэй оролцоогүй байгаа үгс (*агаарла-, агаарж*)

2) Хэлэнд үүсээгүй байгаа буюу хэзээ нэгэн цагт үг бүтээх дүрэм журмын дагуу үүсэн хэрэглэгдэх боломжтой үгс

5. Хам сэдвээс хамаарч буй эсэх

Шинэ үг нь хэлний баримт болох учраас ямар нэгэн хам сэдэв (контекст)-ээс хамааралгүй бөгөөд биеэ даан салангид байдалд хэрэглэгдэж чадна. Тэгвэл боломжит үг нь хам сэдвээс бага зэрэг хамааралтай байх ба салангид хэрэглэнд ч ерөнхийдөө ойлгомжтой байдаг байна. Өөрөөр хэлбэл, боломжит үгс нь утгын хэлц чанаргүй учраас тухайн боломжит үгийг бүрдүүлж буй нэгж хэсгүүдийн утгын нийлбэрээс үндсэн утгыг нь мэдэж болдог онцлогтой ажээ.

Харин тохиолдмол үгийн хувьд тодорхой хам сэдэвтэй нягт уялдсан, хэлэхүйн тодорхой орчинд утга нь илэрч байдгаараа онцлог юм.

Дээр өгүүлснээс гадна, бүтээлч чанар буюу дахин дахин хэрэглэгдэх чадвар, толь бичигт тусгагдсан байдал, хувийн онцлогийг хадгалсан байдал, шинэлэг чанар, яруу дүрслэх чанар, үүссэн зорилго гэхчлэнгээр дээрх гурван янзын үгийг нарийн шалгуураар шүүн хэлэлцэх онолын судалгаанд чухал ач холбогдолтой болно.

3. Судалгааны тойм

Тохиолдмол үгийн талаарх судалгаа 1950-аад оноос эхэлсэн бөгөөд “тохиолдмол үг” гэх нэр томъёог хамгийн анх Г. Пауль “Хэлний түүхийн зарчмууд” бүтээлдээ хэрэглэсэн гэж үздэг ажээ. Г. Пауль уг бүтээлдээ, ердийн нөхцөлд үг олон утгатай байдаг бол, тохиолдмол үед үргэлж ганц утгатай байж, тэгэхдээ

энгийн үгээсээ илүү баялаг агуулгатай, илүү өргөн цар хүрээтэй болсон байдаг гэж бичжээ⁶⁴. Түүнээс хойш Е. Ханпира, Н. М. Шанский, Н. И. Фельдман, Е. А. Земская, В. Л. Лопатин, А. Г. Лыков, И. С. Улуханов нарын судлаачид анхаарал хандуулан тодорхой хэмжээнд санал дүгнэлтээ илэрхийлсэн байдаг ажээ. Үүнд мэдээж, тохиолдмол үгийн мөн чанарыг тодорхойлох болон ангилж ялгах, өвөрмөц шинжийг нь тодруулах тал дээр санал зөрөлдөөнтэй зүйлүүд байсаар байна. Оросын эрдэмтдээс үлгэр авч Словакийн эрдэмтэд ч энэ талбарт багагүй бүтээл гаргаад байна.

Харин манайд энэ сэдвээр дагнан судалгаа хийсэн зүйл харагдахгүй байгаа ба үг бүтээх ёсыг эрчимтэй судлах болсон өнөө үед хэлний энэхүү өвөрмөц үзэгдлийг олон талаас нь сайтар судлах хэрэгцээ шаардлага аяндаа бий болж байна. Судалгааны байдлаас тоймлон өгүүлье.

П. Бямбасан “Монгол хэлний шинэ үгийн тухай” өгүүлэлдээ: “Шинэ үгийн тухай бичсэн зарим зүйлд үгсийн сангийн идэвхтэй үгийн нөөцөд ороогүй буюу хэзээ ч орж чадахгүй үгийг шинэ үг гэнэ гэж ч тодорхойлсон байдаг. Үнэхээр үгсийн сангийн идэвхтэй нөөцөд орж чаддаггүй шинэ үг хааяа байдаг. Ийм үгс нь зарим яруу найрагч, хошин шог зохиолчдын зохиолд тохиолдоно. Зохиолчид дүрийг тодруулахын тулд хааяа шинэ үг зохиож хэрэглэсэн байх бөгөөд тийм үг ихэнхдээ үгсийн сангийн идэвхтэй үгийн нөөцөд орж чадахгүй тэр л зохиолдоо үүрд үлддэг тавилантай.

Уран бүтээлийн эрэл хайгуулд мордсон манай зарим зохиолчдын бүтээлд хааяа тохиолддог шинэ үгээс нэгийг жишээ болговол:

Гандаж байгаа

Өвс ногооны

Ганихраа юу,

Газар холын

Нүүдлийн шувуудын

Ганганаа юу?

(“Цог” №6. УБ., 1970)

Энд “ганихраа” гэдэг шинэ үг хэрэглэжээ. Зохиолчийн зохиож, өөрийн бүтээлд ашигласан иймэрхүү шинэ үгийг үгсийн сангийн судлалд байр эзлүүлсэн хэл шинжээчид хувийн шинэ үг гэж нэрлэж байна. Хувийн шинэ үг тун цөөн тоотой, бас нийтийн хүртээл болох нь маш ховор учраас үгсийн сангийн судлалд төдий л анхаарал татах зүйл биш юм⁶⁵ гэж бичсэн нь тохиолдмол шинжтэй бөгөөд найруулгазүйн судлах асуудал гэдгийг хэлсэн ажээ. Үүнд тодруулбал, яруу найрагч *ганганаа* гэдэгтэй сүүл холбон ижилсүүлж аналогичор *ганихраа* гэсэн шинэ үг үүсгэснийг судлаач тэмдэглэсэн байна. Тухайн үед хэвлэгдээд байсан Я. Цэвэлийн “Монгол хэлний товч тайлбар толь” (1966)-д *ганьхрах*, *гунихрах* гэсэн үгс байсан боловч үйлээс нэр үг үүсгэх *-аа* дагавартай *ганихраа* гэж үг байхгүй байсан ба яруу найрагч тодорхой зорилгын үүднээс шинээр бий болгосон гээд шинэ (тохиолдмол) үг гэж үзсэн байна.

Ц. Өлзийхутаг дунд сургуулийн сурах бичигтээ: “Хүний хэл ярианд огт ороогүй боловч гарч ирж болох үгийг боломжтой үг (нуугдмал үг) гэнэ”⁶⁶ гэж тодорхойлоод, *өлсгө-лөн* гэдэг бодиг үгтэй адилтган *даар-лан* гэж үг үүсэснийг дурдсан бөгөөд “Энэ бол боломжтой үг бодитой үг болж илрэн гарч байгаа хэрэг юм”⁶⁷ гэсэн байна.

Тэгвэл хэл шинжээч М. Базаррагчаа яруу найрагч Д. Пүрэвдоржийн зохиолд гардаг шинэ содон үг хэллэгийг цухас боловч анхааран судалж нэгэн тэмдэглэл бичсэн байдаг. М. Базаррагчаа “Яруу найрагчийн нэг увдис” гэх уг тэмдэглэлдээ: “Тухайн тохиолдолд шинээр үүссэн, юм үзэгдлийг хэлний норм ёс зүйгээс гажиж нэрлэсэн, зохиолчийн хэлний хувийн онцлогийг хадгалахуйц өвөрмөц яруу үгсийг тохиолдмол үг буюу шинэхэн үг гэдэг”⁶⁸ гэж нэрлэж тодорхойлжээ. Улмаар Д. Пүрэвдоржийн шүлэг, найраглал дахь утга, хэлбэрийн хувьд өвөрмөц гэж болохоор шинэхэн үгсийг түүвэрлэн авч авиалбар, бүтээвэр, холбоо үгийн түвшинд нягтлан тайлбарлажээ. Ингэхдээ тохиолдмол үг (оказиональное слово)-ийн зэрэгцээгээр боломжит үг (потенциальное слово) гэж байгааг ялгаж авч үзсэнээрээ чухал зүйл болсон юм. 1979 онд бичсэн М. Базаррагчаагийн энэ тэмдэглэл нь ажиглалт, тайлбар, санаа зэргээрээ хожмын судалгаанд аргагүйн ач холбогдолтой юм.

Г. Ловор оньсогод гардаг зарим содон үгийг ажиглан тэмдэглэсэн байна. Тэр бичихдээ: “Оньсогот юмс үзэгдлийн нэрийг нууцлан өөр зүйлээр төлөөлүүлэхдээ ихэвчлэн шинэ үг, нэр бүтээж хэрэглэдгээрээ үгийн санг баяжуулдаг нэг онцлогтой.

Чараадай бүсгүй

Чанга бүстэй

гэх юм уу,

Бээлэй бэлчив

Бэгсэргэ цомцров

Заадай зарлав

⁶⁴Пауль Г. Принципы истории языка. Учебное пособие. М., 1960. 93–139. талд

⁶⁵П. Бямбасан, Монгол хэлний шинэ үгийн тухай. // П. Бямбасан “Монгол хэлний онол, бүтцийн асуудал”, УБ, 2006. 336. талд

⁶⁶Ц. Өлзийхутаг, Монгол хэлний үгийн сангийн судлал. Дунд сургуулийн VIII ангид үзнэ. УБ, 1973. 59. талд

⁶⁷Мөн тэнд. 59. талд

⁶⁸М. Базаррагчаа, Яруу найрагчийн нэг увдис. // М. Базаррагчаа “Утгын чуулган”, УБ, 2002. 198. талд

Завхан хорив

гэсэн оньсогот шоргоолжийг “чараадай”, хонийг “бээлэй”, чоныг “бэгсэргэ”, нохойг “заадай”, хашааг “завхан” гэж нэрийдсэн байна.

Тэмээн дээр дэгжсий

Тэр модон дээр ягжсий

Бараан дээр багжсий

Барьсан хойноо ясан дугжсий

гэсэн оньсогот гэрийн модыг “дэг”, “яг”, “баг”, “дуг” мэтийн язгуурт “жий” гэсэн дагавраар хэлбэржүүлэн дүр илэрхийлсэн шинэ нэр үүсгэсэн байна. Ийм нэр нь монгол хэлний үг бүтэх зарчмыг баримталж зохиогдсон байдаг боловч тэдгээрийг үг ярианд тэр болгон өргөн дэлгэр хэрэглэдэггүй, ихэвчлэн оньсогын дүрслэлд л зориулагдсан байдаг ажээ. Иймэрхүү нэр нь авиа дуурайн хоршсон, жишээ нь,

Одлой модонд

Додлой шувуу

(Хуруувч)

Монсоогонд

Сонсоогон сууна

(Шүдэнд мах орох)

гэх мэт байх, мөн хос хосоор хэлэгдэх зүйл дээр зөвхөн эхнийх нь таах зүйлийн нэрийн ижил авиа бүхий “авгайлах” маягийн хоршоо үгээр зохиогдсон байх нь ажиглагдаж байна.

Ойн

Дойн хоёр

(Олгой, давсаг)

Боо

Цоо хоёр

(Богтос, шаант)

Оной

Доной хоёр

(Олом, жирэм)

Уухай

Туухай хоёр

(Уурга, ташуур)

гэх мэтчилэн уул үгийн утга нь тодорхойгүй боловч авиа дуурайн хорших зарчим дээр тулгуурласан тийм хялбар тайлагдахааргүй (харьцангуй цөөн) ийм оньсого нь анх хүүхдийн хэлд орох үед юмыг нэрлүүлж сургах, юмны хос харьцааг ойлгуулах үүднээс гарсан байж болох юм⁶⁹ гэжээ. Эндээс харахад, шинэ үг, үгийн хэлбэр бүтээхэд оньсого өргөн боломж олгодог нь тодорхой байна. Оньсого нь хүүхдийн аман зохиолын чухал нэгэн төрөл учраас хүүхдийн дүрслэн бодох, ургуулан бодох сэтгэхүйг хөгжүүлэх үүднээс дээрх мэт зохиомол үгийг ашиглах талаараа хязгааргүй их боломжтой ажээ. Судлаач Г. Ловорын ажиглалтаас сэдэв авч тохиолдмол үгийн бүтэх байдал, үүрэг хэрэглээний асуудлыг нарийвчлан судлах боломжтой байна.

Судлаачид тохиолдмол үгийг олон талаас нь тайлбарлахыг хичээж байна. Үүнд юуны өмнө, тэрхүү үгийн сангийн шинэ нэрлэлтийг өргөн ба явцуу утгын алианаар ойлгох вэ гэдэг асуудал болно. Өргөн утгаар, тохиолдмол үг гэдэгт боломжит үгийг багталцуулан, тохиолдмол үгийн нэгэн зүйл болгон үздэг бол, явцуу утгаар, тохиолдмол үгийг боломжит үгээс салгаж авч үздэг ажээ. Түүнээс гадна, хэлний хэв шинжийн ялгаа буюу тухайн хэлний онцлогоос хамаарч тайлбарлагдана гэдэг. Тухайлбал, нийлэг хэв шинжтэй хэлэнд үгс хоорондын өгүүлбэрзүйн харьцаа нөхцөлөөр илэрдэг аваас задлаг хэв шинжтэй хэлэнд туслах үгээр илэрдэг ажээ.

Судалгааны эх хэрэглэгдэхүүний хувьд юуны түрүүнд утга зохиолын зүйлийг авч үздэг бөгөөд учир нь зохиогчийн хувийн чанартай үг хэллэг нь их төлөв уран сайхны хэл яриагаар биеллээ олдог байна.

4. Тохиолдмол үг бүтээх аргууд

Тухайн хэлний бүтэц тогтолцооноос хамаараад тохиолдмол үгийг бүтээх арга харилцан адилгүй байж болно. Гэхдээ дараах нийтлэг аргууд байна. Үүнд:

Залгаврын арга. Монгол хэлэнд дагавраар үг бүтээх нь түгээмэл юм. Дагаврын тусламжтайгаар тохиолдмол үг бүтээхдээ үгийн язгуур буюу үндсэнд үг бүтээх хууль дүрмийг зөрчих замаар шинэ хэлбэр үүсгэдэг. Жишээлбэл:

Ургуул үндсийг тань хилсээр сэндэж

Уугуул үрсийн тань цусаар мандаж

(Д. Пүрэвдорж, “Чингис”)

гэх мэт. Дагавар залгахаас гадна тухайн үгийг үндэс хэлбэрээр нь хэрэглэж тохиолдмол үг бүтээж хэрэглэх явдал бас байдаг нь энэ аргад холбогдож болно. Жишээлбэл:

Наран буцахыг мартан чилсэн

⁶⁹Г. Ловор, Ц. Өлзийхутаг, Монгол ардын оньсого таавар. УБ, 1990. 18–19. талд

гэх мэт.

Үг нийлэх арга. Энэ бол хоёр буюу түүнээс дээш үг нийлж нэг нэрлэлтийг бий болгох арга бөгөөд орос, англи, герман зэрэг Европ зүгийн хэлнүүдэд тухайн хоёр үгийг хам бичих, эсвэл дунд нь богино зураасаар холбон нийлүүлж бичих бичлэгийн зарчимтай байдаг бол, монгол хэлэнд хам бичих нь тун ховор, ихэвчлэн салангид бичиж хэвшжээ.

Иймд монгол хэлний тухайд ойролцоо утгатай хоршоо үгсийн үүсэн бүтсэн байдлаас ажиглаж өвөрмөц содон жишээ баримтыг гаргах боломж бий.

Контаминацийн арга. Энэ аргын гол утга учир нь хоёр энгийн үгийг нэгтгэх замаар тохиолдмол үг бүтээхэд оршино. Ингэхдээ үгийн зарим хэсгийг хурааж товчлон өвөрмөц хэлбэр үүсгэдэг байна. Англи хэлэнд “blending” (холих, хутгах) гэж бас нэрлэдэг байна. Иймэрхүү үзэгдэл нь шинжлэх ухааны нэр томъёоны зүйлд хамгийн элбэг тохиолдож үг бүтээх нэгэн арга болдог ажээ.

Англи хэлэнд саяхнаас хэрэглэх болсон энэ сонирхолтой аргыг монгол хэлэнд хэдэн зууны өмнө ч чадамгай ашигладаг байсныг Г. Мижиддорж “Монгол, манж бичгийн хэлний харьцаа” хэмээх нэг сэдэвт бүтээлдээ өгүүлсэн байдаг байна. Э. Пүрэвжав үүнийг “холимгоор товчилсон үг” гээд, “түрүүчийн үгийн эхний хэсэг дээр дараачийн үгийнх нь төгсгөлийн хэсгийг нэмж, шууд залгалдуулан хураангуйлж шинэ нэр томъёо үүсгэсэн байна. Ингэж холимгоор товчилж шинэ нэр томъёо үүсгэх үед монгол хэлний эгшиг зохицох ёсыг сайтар баримталбал зохино. Холимгоор товчилсон үг нь нийтдээ 600 гаруй байна. Монгол хэлэнд хэрэглэгдэж буй холимгоор товчилсон үгийн ихэнх нь шинжлэх ухаан, техник, амьтан ургамал болон эрдэс чулуулгийн нэр томъёо юм. Ийнхүү урт нэрийг хураангуйлан шинэ үг үүсгэх явдал нь хэлний хэмнэлтийн зарчимд яв цав тохирох үзэгдэл болно”⁷⁰ гэж бичжээ. Дээрх хоёр эрдэмтний бүтээлд орсон болон өөрийн түүвэрлэсэн жишээнүүдээс дурдвал:

алтанхуа – алтан лянхуа

ураацай – уран хараацай

цардуу – цардуулын цавуу

цайван – цайрын байван

бархай – бар гахай

давчих – давхар чих

лүзэсгэлэн – луу үзэсгэлэн

түмэлзэй – түмэн өлзий

хулжуухай – хулгана бялуухай

царгуул – цагаан гургуул

наалтууз – наадаг тууз

тэчьядах – тэсч ядах

гэх мэтчилэнгээр утга зохиолын хэлний хэм хэмжээг тодорхой хэмжээгээр зөрчиж үүссэн байдаг онцлогтой. Мөн уран зохиолын найруулгад, тэр дотроо зөгнөлт зохиол, хүүхдийн зохиол зэрэгт зохих үүрэгтэйгээр оролцдог байна.

Дээрх аргуудаас гадна, тохиолдмол гэж болохоор товчилсон үг мэр сэр бий. Жишээлбэл: *ХААН банк* гэдэг нь *Хөдөө Аж Ахуйн банк* гэдгийн хураагдсан хэлбэр (ХАА-н банк)-ээс санаа авч зохиогдсон байна.

Сүүлийн үед ямар нэгэн зохиолчийн зохиол бүтээл дэх тохиолдмол үг хэллэгийг тусгайлан судлах судалгаа эрчимтэй хийгдэж байна. Жишээлбэл: А. А. Кузнецова, Е. А. Смирнова “Тохиолдмол үг ба тохиолдмол үг бүтээх аргууд (Ж. К. Роулингийн “Харри Поттер ба үхлийн төлөөс” романы жишээн дээр)” гэх мэт.

5. Тохиолдмол үгийн үндсэн шинж

Л. П. Терентьева нэг сэдэвт бүтээлдээ тохиолдмол үгийн энгийн үгээс ялгарах дараах шинжүүд байна гэжээ.

Үүнд:

1. Толь бичигт ороогүй байх
2. Хэрэглээний хэв хэмжээг зөрчсөн байх
3. Утгын тогтолцоот чанаргүй байх
4. Байгаагаар нь харилцаанд дахин хэрэглэх боломжгүй байх (тодорхой зохиогчид харьяалагдах)
5. Шинэлэг чанар нь мэдрэгдэж байх
6. Ер бусын хэрэглээтэй байх
7. Утга шилжсэн байх
8. Уран хурц илэрхийлсэн байх
9. Хам сэдвээс ихээхэн хамааралтай байх
10. Бичигт хашилтад бичих

⁷⁰Э. Пүрэвжав. Монгол хэлний товчилсон үгийн учир. // Э. Пүрэвжав “Монгол хэлний товчилсон үгийн толь”, УБ, 2012. 8. талд

гэжээ⁷¹. Гэхдээ эдгээр шинж нь зөвхөн тохиолдмол үгэнд л байдаг шинжүүд биш юм. Харь хэлнээс шинэвтэр зээлдсэн үгс болон хэлэнд шинээр үүссэн үгс толь бичигт ороогүй байж болно.

Тохиолдмол үг нь гол төлөв шүлэг, яруу найраг, оньсого, таавар зэрэг уран сайхны найруулгын зүйлд түгээмэл илэрдэг бөгөөд энэ нь толгой, сүүл холбох, айзам хэмнэл тааруулах үүднээс яруу найрагчийн уран сэтгэмжээр зохиогдсон байдаг. Тохиолдмол үгнээ зохиомол үгээс гадна, дуудлагын хувилбар үг, хэлзүйн өвөрмөц хувилал бүхий үг, аман ярианы болон нутгийн аялгууны зарим онцлог үг зэргийг хамруулж болох юм. Жишээлбэл:

*Хөмүүний баясгалан жавхуулан хөгжим дууны өрнөлтэй зээ,
Хөгөөрхөн аальт Тантайгаан найрлан сууж жаргая!*

(Ж. Бадраа, “Хуур магнай”)

*Хөдөө нутаг нь баян тарган
Хөрст дэлхий нь буян арвин
Хөнөг савт нь идээ халгиун
Хөрөнгө зоорь ихдээ тэлгүүн*

(Ж. Бадраа, “Оройн дээд эх орон минь”)

*Ган шиг иртэй залуусын гар зангирсан
Гавьяа цуутай баатруудын нэр тунгарсан*

(Ж. Бадраа, “Наран тухалсан орон”)

*Зээ хө,
Ээж шиг*

*Энхрэлсэнхэн
Элгэн Монгол орноо*

*Зээ хө,
Ээлтэй
Ээврэлсэнхэн
Эрдэнэт нарны туяанд...*

(Ж. Бадраа, “Юутай азтай вэ!”)

*Ярайх хотын маань тэнүүн магнай
Ямагт баярын совингоор гийгэх золтой!
Ай хө, зээ хө, ай хө, зээ хө,
Улаанбаатар минь баясаантай!*

(Ж. Бадраа, “Улаанбаатарын агаар”)

*Хэц цавчмыг ялаад,
Хэт давчлыг тэлээд,
Хээрийн салхийг зүсээд,
Хэлсийн алсыг эсгээд,
Мотор хурдийн эрчээр
Монголын замыг уужлан
Тэнгэр газрыг эдлэн давшсан
Тээврийн хөлгийн эзэн бид байна.
Цар барааг хөвчлөөд,
Цаг хэмийг товчлоод,
Цааргын бартааг буулгаад,
Цаадын давааг суулгаад,*

(Ж. Бадраа, “Хөлгийн эзэн бид”)

*– Овоо хүү болно! гэж урмалсны хүчинд
Одоо би энэ дайтай яваа юм...*

(Б. Лхагвасүрэн, “Өөдөөс нь тосон бүдчин гүйхдээ...”)

*Хялмаалсан олон одод миний
Алаг нүднээс аргамжаатай
Хязгааргүй их тоо бүхэн миний
Арван хуруунаас торгомжоотой*

(Б. Доржпалам, “Хөөрлийн шүлэг”)

*Хат сайт эрсийн хийморьт
Гат тэнгэрийн хаяа сэмэрнэ*

(Х. Эрдэнэбаатар, “Битүү аяз”)

*Ангир ганганахад үр хүүхдээ бодном
Айл саахалтаараа амирыг хүснэм*

(Г. Бямбаа, “Анхны бишүүрхүү хайраас минь илүү”)

⁷¹Л. П. Терентьева, Семантика и прагматика лексических окказионализмов. Автореф. дис. канд. филол. наук. М., 1983. 92. талд

Булбарай цагаахан охины
Бужмаг урсгал үсэнд
Баян хангайн салхин
Биеэ эгшээн шингэсэн байна

(Ж. Баяржаргал, “Чиний минь залуу нас”)

Үнэр тарна, хүртэх тоолонд
Үйл заяаны арц өөрөө уугиж
Үг болоод амьсгал эвлэрнэ
Үүрд цэнгэлийн **сэнхим** түгнэ

(Ж. Баяржаргал, “Дарь эхийн хичээнгүй мэдрэхүйн хангалга”)

Ам, хөл зөрөлдөх бүрийд
Арьс шир чимээлэх тоолонд
Азын цэнгэл минь бялхаж
Асруу бие эвэрч, дулаарал тарна

(Ж. Баяржаргал, “Дарь эхийн хичээнгүй мэдрэхүйн хангалга”)

Ялдам охид харилцуур наадуулж
Янагс мөрөөдлөө нээхгүй
Зурх тамлаад л...

(Ж. Баяржаргал, “Орь залуу мөрөөсөл”)

Энэ алиман сарны **асгарыг**
Ижий, аав чинь санаж байгаа

(Ж. Баяржаргал, “Хуримын шөнө”)

Цэцэглэн улирлын нарны дор
Цэлмэг амрагийн инээд бороотой

(Ж. Баяржаргал, “Цэцэгт улирлаар амрагийн тухай сэтгэгдэл”)

Энэ гоолиг модыг налан суухад
Эртээдийн бүсгүй шиг нэг л **гуниглуун**...

(М. Уянсүх, “Намрын ойд зүүрмэглээд...”)

гэх мэт.

Тохиолдмол үг гэдэг нь нэг цаг үед тохиолдлын шинжтэй байвч тодорхой хугацааны дараа өргөн хүрээтэй хэрэглэгдээд ирмэгц ердийн үгийн шинжтэй болон хувирч ч болох юм.

Эндээс, тохиолдмол үгийг бүтэц, үүссэн байдлаар нь дараах байдлаар ангилж болохоор байна. Үүнд:

- Авиазүйн тохиолдмол үг (Фонетические окказионализмы)
- Үгийн сангийн тохиолдмол үг (Лексические окказионализмы)
- Хэлзүйн тохиолдмол үг (Грамматические окказионализмы)
- Утгазүйн тохиолдмол үг (Семантические окказионализмы)
- Өгүүлбэрзүйн (холбоо үгийн) тохиолдмол үг (Синтаксические окказионализмы)

Авиазүйн тохиолдмол үг:

Энэ нь зохиогч ямарваа авианы цогцолборыг шинэ үг – утга бүтээх зорилгоор зохиосон үгс юм.

Жишээлбэл:

Уу ээ хаиш сарны цайвар үзэгдэл салхин явдлын дөхөмтэй
Усан боронгын алтлаг үнэр чаширт уулнаас салахгүй

(Х. Эрдэнэбаатар, “Ойрад аялгуу”)

Сөрийн эрэгт чамтай суум
Сөнө бүхэн зэлмэд шүлэг
Сөнтэй дарс – чиний ором
Сөгдөмгүй ч халуун шүү

(Х. Эрдэнэбаатар, “Сөгөтгөл”)

Зохиогч шүлэгтээ уу ээ хаиш гэсэн баруун монголчуудын уухайн түрлэгийг шүлгийн санаанд хүч оруулах зорилгоор ашигласан бол, *шөнө* гэдэг үгийг нутгийн аялгууны хэлбэрээр нь оруулсан нь санамсаргүй хэрэг биш юм.

Өөрийн оюуны **сөв** битүүрсэн
Өчүүхэн сөлөр барлаг намайг
Өнгөт орчлон тэгээд мартаг аа

(Д. Пүрэвдорж, “Өвлийн өвгөн бид хоёр”)

Өлгүүрийн шонд **сөвлөсөн**
Өргөст тороор хөвөрдөж

(Д. Пүрэвдорж, “Хорьдугаар зуун”)

Энд зохиогч *сүв*, *сүвлэ-* гэсэн утга зохиолын хэлний үндсэн хувилбарыг *сөв*, *сөвлө-* гэсэн дуудлагын хувилбараар нь авч хэрэглэсэн байна.

Үгийн сангийн тохиолдмол үг:

Үг бүтээх хуулийн дагуу, зарим тохиолдолд энэ хуулийг зөрчих замаар үгийн сангийн шинэ нэрлэлт бий болгож, зохиолд өвөрмөц өнгө аяс бүхий нэрлэлтийн нэгжийг бий болгосныг үгийн сангийн тохиолдмол үг гэнэ. Жишээлбэл:

Эрээгээ алдсан

Эрлэгийн зарц тэгээд

Эцсийн удаа

Эмсэгчээ болж

(Д. Пүрэвдорж, “Хорьдугаар зуун”)

Амьд хүнд бүрэлсэн

Араатан фашизмын

(Д. Пүрэвдорж, “Хорьдугаар зуун”)

Анд нөхөр чиний

Аян замыг өлзийлж...

(Д. Пүрэвдорж, “Дөрөөний үг”)

Эрмэг хүлгийн үүрсээн

Эгшигэртэл чавхалсан сүүлээр

Эзнийхээ сэтгэлтэй дэгдэж...

(Д. Пүрэвдорж, “Кыяга”)

“... буриад хорооны өндөр өндөр дүнзэн байшингуудын цонх хэдэн шөнөжин гэрэлтдэг нь буриадын өнөөх гол наадмын нэг мөрийтэй хэзэр буюу хаарталдаан болж тэр нь **архидаантайгаа** хамт л байх тул ...”

(С. Эрдэнэ, “Хойт насандаа учирна”)

Хэлзүйн тохиолдмол үг:

Үгийн сангийн утга болон хэлзүйн утгын зөрчил дээр тулгуурлан өвөрмөц хэлбэр үүсгэснийг хэлзүйн тохиолдмол үг гэж болно. Өөрөөр хэлбэл, хэлний системд боломжгүй үг зохиогчийн хам сэдэвт боломжтой болон хувирдаг гэсэн үг юм. Жишээлбэл:

Чилээдэн суухуйд

Чилгэрийн шаргал саран

Чиний тунил шиг

Чи шиг – ялгуум

(Х. Эрдэнэбаатар, “Гэлмэгт уулнаа нам суунам”)

гэх мэт. Энд *чам шиг* гэсэн хэлзүйн үндсэн хэлбэрийн оронд толгой холбох үүднээс *чи шиг* гэсэнэтгээд гаж хэлбэр зохион хэрэглэсэн байна.

Хэлний аль ч түвшинд хэлзүй, үгийн сангийн хэм хэмжээг зөрчиж бичсэн удаа нэг бус тохиолддог. Жишээлбэл:

Дорж ийм мухар сохор юмыг олж сонсож байгаадаа гав гайхна

(Д. Намдаг, “Цаг төрийн үймээн”)

гэх мэт.

Дээр өгүүлсэн зүйлүүдээс дүгнэж хэлбэл:

1) Тохиолдмол үг нь хэлний бус хэлэхүйн баримт болох бөгөөд хэлний түвшин бүрээр онцлог нь илэрдэг өвөрмөц судлагдахуун юм.

2) Аливаа утга зохиолын хэлийг арвижуулан баяжуулж байдаг эх ундаргын нэг бол зохиолч, яруу найрагчдын уран бүтээл юм. Иймд эх хэлнийхээ үгийн санд хэр зэрэг хувь нэмэр оруулснаар нь тухайн уран бүтээлчийн чанар чансааг тодорхойлж болох талтай. Эх хэлээ чадварлаг эзэмшсэн төдийгүй бүтээлчээр хэрэглэж чаддаг хүмүүсийг бичгийн их хүмүүс гэж хэлж болно. Зохиолчдоос гадна сэтгүүлч, нийтлэлчид ч хэлний үгийн санг баяжуулж болно.

3) Тохиолдмол үгийн үүсэн бүтсэн байдлыг хэлэлцэхэд өвөрмөц дагавар (уникальные аффиксы)-ын асуудал зайлшгүй хөндөгддөг бөгөөд энэ хоёр нь харилцан бие биеийн онцлогийг тодруулахад чухал холбогдолтой судлагдахуунууд болно.

Резюме

При изучении окказиональных слов и словосочетаний было выявлено, что наиболее часто встречающиеся способы образования окказионализмов – аффиксация и сложение, в то время как контаминация и составные окказиональные слова встречаются довольно редко.

Необходимо учитывать, что окказиональные слова не имеют эквивалентов в других языках и для полного понимания слова необходимо вникнуть в его состав, разложить на компоненты.

Из всего вышесказанного можно сделать вывод о том, что процесс создания окказионализмов является творческим и этот процесс направлен не на подчинение правилам и нормам языка, а является испытанием его возможностей.

НОМЗҮЙ

1. Базаррагчаа М. Яруу найрагчийн нэг удис. // М. Базаррагчаа “Утгын чуулган” УБ, 2002. (198–204. талд)
2. Бямбасан П. Монгол хэлний шинэ үгийн тухай. // П. Бямбасан “Монгол хэлний онол, бүтцийн асуудалд”, УБ, 2006. 336–342. талд
3. Дамбажав И. Оюун билгийн мэлмийг нээгч аялгуу сайхан монгол үгийн дээж (Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь бичиг). УБ, 2010.
4. Өлзийхутаг Ц. Монгол хэлний үгийн сангийн судлал. Дунд сургуулийн VIII ангид үзнэ. УБ, 1973.
5. Пауль Г. Принципы истории языка. Учебное пособие. М., 1960.
6. Пүрэвжав Э. Монгол хэлний товчилсон үгийн учир. // Э. Пүрэвжав “Монгол хэлний товчилсон үгийн толь”, УБ, 2012. (3–16. талд)
7. Терентьева Л. П. Семантика и прагматика лексических окказионализмов. Автореф. дис. канд. филол. наук. М., 1983.
8. Ханпира Э. И. Окказиональные элементы в современной речи. // Стилистические исследования. М., 1972. (с. 245–317)
9. Цэвэл Я. Монгол хэлний товч тайлбар толь. УБ, 1966.
10. Cerula V. Проблематика окказионального слова. // “Jazyk a kultura”, číslo 4/2010.

О ПРОЯВЛЕНИИ ИКОНИЗМА В ЗВУКОПОДРАЖАНИЯХ РАЗНОСИСТЕМНЫХ ЯЗЫКОВ

М. С. Власов, канд. филол. наук, доцент,
Алтайская государственная академия образования имени В.М. Шукшина, Бийск,
Т. Одончимэг, канд. филол. наук,
Ховдский государственный университет, Ховд, Монголия

Наряду со сложившимся традиционным мнением об условности языкового знака в лингвистике всегда бытовала и иная точка зрения – о мотивированности его плана выражения планом содержания. Вопрос об иконичности и конвенциональности в языке поднимался еще в работах древнегреческих философов (теории *thesei* и *physei*). Современное представление об иконичности языка сформулировано в трудах классиков В. фон Гумбольдта, Ч. Пирса, Р. Якобсона.

Сегодня множество научных школ по всему миру ведут исследования по данной проблематике. На базе Амстердамского и Цюрихского университетов реализуется крупнейший проект «Iconicity Research Project», служащий своего рода «площадкой» для обмена опытом по проблеме иконичности в языке и литературе [Ljungberg].

Последний симпозиум по проблемам иконизма в Токио (Ninth International Symposium on Iconicity in Language and Literature, 3-5 May 2013) обозначил такие наиболее актуальные вопросы, как взаимодействие формы и содержания в языке, а также их решения на материале разнотипных языков. Усилия ведущих мировых исследователей иконизма сегодня сконцентрированы на данном феномене как движущей силе в языке на всех его уровнях, открывающем путь к познанию процессов эволюции (language change) и освоения языка (language acquisition). В качестве языкового материала используются как конкретные иконические образы (iconic images), так и более абстрактные иконические диаграммы и метафоры (iconic diagrams and metaphors), представленные на разных уровнях текста (как повествовательного, так и поэтического), а также на разных уровнях дискурса (литературных, исторических, политических, рекламных, лингвистических текстах), а также в музыке, изобразительном искусстве и других областях) [Iconicity: East meets West].

Как отмечает К. Лjungберг [Ljungberg], интерес к проблеме иконизма (и ономастике в частности) и связанным с ними теориям коммуникации и речевого развития обусловлен открытием в области мировой нейронауки – зеркальных нейронов, возбуждаемых как при выполнении какого-либо действия, так и при наблюдении за его выполнением другим индивидуумом. Так, В. Рамачандран [Ramachandran] считает, что эти нейроны играют ключевую роль в процессах имитации и обучении языку. Зеркальные нейроны могут быть задействованы в эмпатии, в понимании действий других людей и в освоении навыков путём их имитации. Хотя на сегодняшний день не предложено конкретной вычислительной модели для описания того, как функционирование зеркальных нейронов воплощает такие когнитивные функции, как имитация, интерес со стороны представителей разных областей наук к ним возрастает.

Наше исследование выполняется в рамках указанной лингвистической парадигмы и существующих представлений о мотивированности языкового знака. Проект связан с продолжением изучения механизмов эволюционных преобразований в языке (на материале монгольского и русского языков). Основным методом исследования является психолингвистический эксперимент, направленный на окказиональную вербализацию неноминированных акустических (шумов) и визуальных сигналов (цвета и формы) носителями монгольского и русского языков, апробированный в ходе предыдущих исследований на материале русского и английского языков [Трофимова, 2009]. В настоящей работе привлекается новый

материал исследования. Особое внимание уделяется изучению периферийных явлений, в частности звукоподражаний монгольского и русского языков.

Результаты проведенных ранее исследований на материале разносистемных языков по окказиональной вербализации неноминированных сигналов и восприятию псевдослов демонстрируют следующее.

Современные носители русского, английского, китайского, алтайского языков, то есть языков, различных как по происхождению, так и по типологии, способны переводить недискретные единицы в дискретные, переключать неречевой код в речевой, перекодировать зрительные сигналы в звуковые.

Иконизм в искусственно созданных псевдословах, предназначенных для отражения свойств определенных объектов в вербальных формах, недостаточно выражен, преимущественно проявляется в форме звукоизобразительности, оставляя практически не задействованной звукосимволическую составляющую.

Окказиональная вербализация, с одной стороны, отражает общие свойства восприятия человека, а с другой – зависит от характера системы родного языка.

Расшатывание системы, построенной по принципу ядра и периферии, осуществляется на периферийных участках.

Темный (неприятный) цвет является более маркированным как для процесса окказиональной вербализации, так и для восприятия, что проявляется в достаточно высоком проценте опознавания псевдослов, обозначающих темный оттенок, по сравнению со светлым.

Процесс соотнесения готового псевдослова с объектом вызывает меньше затруднений у носителя языка, чем само порождение псевдоединицы.

В ходе такого рода исследования целесообразно анализировать не только окказиональный, но и узуальный языковой материал [Михалев, 1995], [Панькина, 2009].

С целью определения уровня иконичности звукоподражательных слов в разносистемных языках лабораторией антропоцентрической типологии языка АГАО им. В. М. Шукшина был проведен ряд психолингвистических экспериментов на материале звукоподражательных слов английского, алтайского и монгольского языка с привлечением 65 носителей русского и алтайского языков, не владеющих указанными языками. В качестве материала для эксперимента были выбраны 25 звукоподражаний различных тематических групп. Основным критерием отбора послужило различие в фонетическом оформлении звукоподражаний-стимулов от звукоподражательных слов родного языка информантов. С привлечением носителей указанных языков была сделана аудиозапись отобранных звукоподражательных слов.

В ходе эксперимента было установлено, что процент верного определения звукоподражаний разносистемных языков иноязычными носителями колеблется в пределах от 27 % до 39 %.

Анализ полученных данных позволяет предположить, что узнаванию звукоподражательных слов разносистемных языков иноязычными носителями способствуют два фактора:

1) наличие внешнего фонетического сходства между звукоподражаниями разносистемных языков. Это явление мы обозначим как *универсальный языковой иконизм*;

2) сохранение качества природных звучаний в звукоподражательной лексике неродственных языков, несмотря на различие фонетических средств, используемых для их обозначения, то есть *внутриязыковой иконизм* [Панькина, 2009].

Исследование процесса перекодировки неноминированных неречевых звучаний в речевые единицы на носителях русского и монгольского языков будет представлено в отдельных статьях.

ЛИТЕРАТУРА

1. Михалев А.Б. Теория фоносемантического поля: монография. - Пятигорск: Изд-во ПГЛУ. 1995. 213 С.
2. Панькина Е.В. Экспериментально – теоретическое исследование восприятия звукоподражаний в разносистемных языках иноязычными носителями (на материале русского, английского, алтайского и монгольского языков). Канд. дисс., Кемерово, - 2009.
3. Трофимова Е.Б. Окказиональная вербализация звуковых и зрительных сигналов разноязычными носителями: монография/ Е.Б. Трофимова, М.Э. Сергеева, Е.Ю. Филиппова. – М.: КРАСАНД, 2009. – 168 с.
4. Iconicity: East meets West: Ninth International Symposium on Iconicity in Language and Literature, 3-5 May 2013: http://www.iconicity.ch/en/conferences/index.php?subaction=showfull&id=1340974270&archive=&start_from=&u_cat=3&
5. Ljungberg C. Shadows, mirrors, and smoke screens: zooming on iconicity: <http://www.iconicity.ch>
6. Ramachandran V.S. Mirror Neurons and imitation learning as the driving force behind «the great leap forward» in human evolution: http://www.edge.org/3rd_culture/ramachandran/ramachandran_p1.html

СҮЛД,ЛОГО, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЭМДЭГИЙН ЯЛГАА

Д.Ганбаатар. ХИС. ДУД-ны тэнхим

Түлхүүр үг: Сүлд, лого, үйлчилгээний тэмдэгийг ялгах

Дэлхийн улс түмэн овгийн байгуулалтай байх үеэсээ эхлэн нэг овог нөгөөгөөсөө ялгарах тэмдэг бэлэгдэл хэрэглэх болжээ. Манай ард түмэн элдэв бэлэгдсэн тэмдэг тамга дүрсийг хэрэглэж ирсэн өнө эртний уламжлалтай орон билээ.

Тиймээс улсын сүлд тэмдэгээс эхлээд нийгэмд оршин буй ардын аж ахуйн салбар, пүүс компани, спортын нийгэмлэг болон бүх албан газар хувь байгуулагууд, тэмдэг бэлэгдэлийн ертөнцөд амьдарч байдаг юм.

Тэмдэгийн энэ ертөнцөд хийх судалгаа шинжилгээний эхний гарал нь семиотика/грек гаралтай SEMIOS-тэмдэглэгч ухааныг судлаж байж бүх бэлэгдэлийн дүрс хэлбэрийг тухайн орны зан заншилтай холбон гаргаж ирэх тэдний ялгааг мэдэрч ойлгох. Орчин үеийн урлагуудаас хамгийн ихээр хүмүүсийн

хүртээл болж байгаа урлаг бол үйлдвэрийн график дизайны урлаг юм. Энэ нь хүмүүсийн ахуйн хэрэгцээнд тулгуурлан хөгжсөөр ард түмний амьдралд ойр хэрэгцээг хүний сэтгэлгээтэй холбосон хамгийн хүчирхэг урлаг болтлоо хөгжиж байгаа билээ. Үйлдвэрийн график дизайны урлагт сав баглаа боодол, реклам чимгэглэл, бүх төрлийн бэлэгдэлийг илэрхийлсэн дүрс тэмдэг, хэвлэлийн график зэрэг төрөл зүйл ордог. Үүнийг хүний ухаан, дизайнер гоо сайхны мэдрэмжтэй хослуулан шингээн төгс хийвэл жинхэнэ хэрэглээний урлаг болон үлддэг.

Хэрэглээний урлагийн төрөл: Сүлд тэмдэг

Сүлд нь тухайн улсын эрхэмлэн үзэх албан ёсны тэмдэг юм. Тиймээс сүлдийг зурж бодохдоо хийц хэлбэрийн хувьд нарийн зурагдсан байхаар бодож улсын бэлэгдэлийг товч тодорхой хэнд ч ойлгогдохоор харуулах, утга санаа нь маш баялаг дүрслэл, ур хийц сайтайгаар зохиомжлон, өнгийн олон сонголтоос улс үндэсний бэлэгдэл болсон өнгийг шилж авсанаараа онцлог болдог.

Жишээ нь: Монгол Улсын сүлд хөх тэнгэр, Алтан шар өнгө зонхиолж монгол орон хөх тэнгэр, Алтан нарны орон гэх мэт бэлэгдэлийн дүрсийг үндэсний хээ угалзтай хослуулан зурсан байдаг. Энэ зарчмаар сүлд тэмдэг нь бэлэгдэл утга санааг илэрхийлэх. Уран нарийн хийцтэй, сайн зурагдсан бодит дүрслэл юм.

Зураач дизайнер Багш Д.Ганбаатарын зохиосон Ховд жаргалант сумын сүлд тэмдэг 2004 он


Хэрэглээний урлагийн төрөл : Лого, Барааны тэмдэг

Манай ард түмэн үсэг бичгийн зүйл үндэсний хээ угалз, геометрийн элдэв хэлбэр дүрстэй бэлэгдсэн тэмдэгийг мал сүргээ тамгалах зэргээр аж ахуйдаа уламжлал болгон хэрэглэсээр ирсэн билээ. Үүний нэг илэрэл уламжлалыг орчин үеийн лого, барааны тэмдэгийн ур хийц бэлэгдэлийн ухаанд шингээсэнтэй холбоотой.

Үйлдвэрлэлийн бараа бүтээгдэхүүн, худалдаа, спорт, хоршоо, пүүс компани бэлэгдэл таних тэмдэгийг бодож сэтгэх дээ уламжлалт ёсыг үйлдвэрлэлийн график дизайнтай хослуулан оруулж Монгол гэсэн санааг бүтээл дээ шингээж уралдаг болсон нь лого, барааны тэмдэгийн дүрсийг зохиохдоо үсэг үгээр илэрхийлэх, геометр дүрсийг оруулан хийсвэрлэн сэтгэх, шинэ сонин хэлбэр дүрсийг сонгох товч тодорхой хэллэгтэй сэтгэлгээний шаардлага хангах, зэрэг зохиомжийн шинлэг сонголтуудыг бодож хийдэг болжээ. Манай ард түмэн үсэг бичгийн зүйл үндэсний хээ угалз, геометрийн элдэв хэлбэр дүрстэй бэлэгдсэн тэмдэгийг мал сүргээ тамгалах зэрэг аж ахуйдаа уламжлал болгон хэрэглэсээр ирсэн билээ. Үүний нэгэн илэрэл уламжлалыг орчин үеийн Лого, Барааны тэмдэгийн ур хийц, бэлэгдэлийн ухаанд шингээсэнтэй холбоотой.



Өнгө: Лого, Барааны тэмдэгийн өнгө нь гоо сайхны таашаал өгөх үйлдвэр үйлчилгээний газрын бүтээгдэхүүний дүр төрхийг илтгэсэн аль болох цөөхөн өнгөөр хүний сэтгэлийг эзэмдэх, хүмүүсийн ухаан санаанд нийцэх, барааны тэмдэг, шриффт үсэгтэйгээ уялдан, бүтээгдэхүүний сав баглаа боодлын дүр төрхийг илтгэсэн, хосолмол өнгөөс бүрдсэн байвал жинхэнэ дизайны шийдэлтэй өнгийн мэдрэмжтэй болно. Логог зохиож буй зураач дизайнеруудаар өнгө зохиомжийг шийдүүлж байвал сайн болдог.

Ховд их сургуулийн ДУД-ны багш зураач дизайнер Д.Ганбаатарын зохион бүтээсэн барааны тэмдэг, логонууд



“Туушин” Co.Ltd / олон улсын тээвэр зуучлалын лого барааны тэмдэгүүд УБ хот 1989 он

Монголын урчуудын эвлэлийн хороо хэвлэл чимэглэлийн үйлдвэрийн лого, УБ хот 1989 он



“Есөн хүсэл” Co.Ltd савхин хувцасны үйлдвэрийн лого, барааны тэмдэг УБ хот 1992 он

“Ариун өндөрлөг” Co.Ltd үйлдвэр, үйлчилгээ лого, барааны тэмдэг УБ хот 1993 он
 “Чингис фильм” ХХК Монгол кино үйлдвэр лого, барааны тэмдэг УБ хот 1993 он

Хэрэглээний урлагийн төрөл, үйлчилгээний тэмдэг:

Үйлдвэрийн график дизайны нэг хэллэг хэлбэр болох дүрс бичээс Пиктограмм-ийг олон тооны хүмүүс цуглардаг хөл хөдөлгөөн ихтэй газаруудад ихэвчлэн хэрэглэдэг. Тухайлбал нисэх болон төмөр замын буудал, зочид буудал, худалдаа, үзвэр үйлчилгээний төв гэх мэт. Үйлчилгээний тэмдэгийг зохион бүтээхдээ энгийн хялбар элементүүдийг хялбаршуулан геометр дүрсээр зохиомжлон зурах, дүрс зургийг хүмүүст амархан ойлгогдохоор бүтээх.

Үйлдвэрийн график хэвлэлийн шрифт хот суурин, гудамжны нэр, байшингийн дугаар, тээвэрийн хэрэгсэл дэх янз бүрийн бичээс, зарлал, зурагт хуудас ордог эдгээр нь үйлчилгээний төрөл зүйлд хэрэглэддэг юм.

Жуулчны баазын үйлчилгээний тэмдэг



**ХИС-ийн Дүрслэх урлаг дизайны багш
Д.Ганбаатарын зохиосон үйлчилгээний тэмдэг**

Сүлд лого үйлчилгээний тэмдэгийн ялгаа орчин үед төрөл зүйлээр нь ялгаж салгаж ойлгохгүй таних тэмдэг бүрийг логотой адилтгаж бодох нийт хүмүүсийн дунд хэвшмэл болжээ. Үймээс лого үйлчилгээний тэмдэг зэргийг хүн болгон зохиодог юм шиг муйхар ойлголтоосоо салж мэргэжлийн дизайнеруудын түвшинд бодож хэрэглээний урлагийг хөгжүүлэх хэрэгтэй болжээ.

Дүгнэлт

Манай оронд хэрэглээний урлаг олон хэлбэрээр хөгжиж байгаа. Гагцхүү энэ төрөлийг урлаг уран сайхны төрөл зүйлд оруулдаггүй хэрэглээ талдаа байдагаар ойлгодог учир үүнийг ялгаж салгах ойлгох нь орчин үед хэрэгтэй болжээ.

НОМ ЗҮЙ

1. Ш.Цэвээндорж “График дизайн” УБ 2003 он
2. Н.Бавуужав “Дүрслэх урлагийн дээжис” УБ 2003 он
3. Jasabupokuwayama “Zelchin Marken and signets 3000 internationale Beispiele 1973by

ЭСГИЙ ШИРМЭЛИЙН БҮТЭЭЛ ДЭХ УРАН САЙХНЫ СЭТГЭЛГЭЭ

Д.Гантулга
ХИС-ийн ГХСС-ийн ДУД-ы тэнхим
E-tail:gantulga_0522@yahoo.com

Түлхүүр үг: **Хийсвэр, бодит дүр-хэмнэл, давтамж- тоон утга илэрхийлэл-арга билигийн шүтэлцэл.**

Амьтны дүрст урлагийн уламжлал дээр тулгуурлан “Хүннүгийн гар урчууд сонгодог бүтээлийг туурвиж байсныг Орхоны хөндийн соёлоос тухайлбал: Ноён уулын булшнаас олдсон уртаараа 2.6 өргөнөөрөө 1.95 см хэмжээний эсгий ширмэл /туурган хивсний/” дүрслэл, уран сайхны шийдэл арга технологиос харж болно./1-16/

Эсгий ширмэл бүтээлийн гол хэсэгт дан зураасаарнар зөв, буруу хөдөлгөөнийг гурван үет давхрага гарган үргэлжлүүлэн ширсэн эргүүлгэн угалзаар дүүргэж, түүнийг тойрсон өргөн хүрээнд 9 хос 18 араатан туурайтан амьтдын уран хэтрүүлэгт дүрслэлүүдийн дундуур саглагар ногоон модыг салаавчлуулан өнгө өнгийн зээгт ширмэлээр урлан хийсэн.

Түүнчилэн гол хээ, өргөн хүрээний дүрслэл хоёрын дундуур нарийн хүрээнд чагтан, босоо



тэгш өнцөгт дүрсүүдийг тодорхой давтамжуудаар байрлуулан чагтан дүрснийхээ хэвтээ чиглэлийн хоёр тэгш өнцөгтөөс /эсрэг харсан/ эх авхуулан эв нийлсэн тэгш өнцөгт дүрсүүд үүсгэн өнгө өнгийн зээгт ширмэл хийсэн байдаг.

Нэг дэх хос давьхиж яваа буга, түүн дээр эрчээрээ буун ноцож буй махчин шувууны дүрсүүд, нөгөө хосод саглагар савгатай сарлагны сэрвээн дээрээс дэлт бар хазаж буй, түүнийг доороос нь олин мөргөж байгаа, махчин амьтанд дайруулсан туурайт амьтдын амь тэмцэн тэмцэлдэж байгааг уран тод, ихэсгэл хэтрүүлэгтэй, сүрлэг ёгт байдлаар дүрслэн харуулсан дүрүүдийг давтамжинд оруулан хэмнэл үүсгэн харуулжээ.

Энэ бүгдийг тайлан уншвал гацуур, жодой модны дүрслэлийн эр үүтгэлийг төлөөлүүлсэн, агуйн зургийн уламжлал байхаас гадна, нар зөв, буруу хэмнэл гурван үет хөдөлгөөнөөр арга билигийг харуулах сэтгэлгээ, ерөөс амьдарлын эерэг сөрөг, нэгдэл тэмцлийг төв санаа болгон, түүнийг хоёр давхар



хүрээний дүрслэлүүдээр өдөөн баяжуулсан. Ингэхдээ гурван үет дүрслэл нь нөгөө талаараа ертөнцийн үүслийн /дээд, доод, дунд/ тогтоцийг харуулсан байх талтай.

Эхний хүрээний геометр дүрсүүд нь галыг илэрхийлдэг эр /босоо арга/, эм /тэвтээ билиг/ хоёр үрүүл, босоо дөрвөн өнцөгт /тэнгэр чиглэлийн эр дүрс/, хоорондоо эвссэн эр, эм газар байрлалтай хэвтээ дөрвөн өнцөгт /билиг/ дүрсүүдээр үржил хөгжлийн арга билигийн гүн ухааныг харуулсан уран сайхны сэтгэлгээ болдог.

Улмаар түүний гадуур байх өргөн хүрээний уран давтамжит дүрүүд нь тэнгэр, газрын төлөөлөл, тэмцэл нэгдлийн илэрхийллийг тэнгэр үзлийн 9-ийн тоон давтамжаар харуулан үндсэн утга санаагаа хөгжүүлж буй арга билигийн гүн ухааны сэтгэлгээ болдог. Хоёр давхар хүрээний утга санаа нь ерөнхий утгаараа өмнөх уламжлалд оршдог харагдах, үл харагдах ертөнцүүдийг илэрхийлсэн уран сэтгэмжийг тухайн үедээ шинэчлэлд оруулсан хэлбэр юм.

Дээр өгүүлсэн дүрсэн өгүүлэмжүүдийг нэгтгэн үгээр илэрхийлвэл “Сав шим ертөнц нь дэлхийн гадрага, агаар мандал, хөрснөөс дотогш орших ертөнц гэсэн гурван үет тогтоцийн харилцан шүтэлцэлд оршдог хийгээд хүн ба амьтан нэгэн адил түүнд хамрагдаж түүний жам ёсоор амьдрах ёстой” гэсэн гүн ухааны сургаал гэж үзэж болно. Энэ утга санаанаас асар олон салбар ухагдахуун салаалан түгэх болдог.

Туурган хивсний утга илэрхийлэл ийм байхад дүрийн боловруулалтын хувьд хөдөлгөөний аясаар шогших, хатирахыг, нисэх, нисэн буух, дээрээс доош дарах, доороос нь дээш өлгөх эрчмүүдээр үзүүлсэн нь хэмнэл хөдөлгөөн дахь арга билигийн шүтэлцэлийг зөв таацуулан тохируулж, тэр нь үзэгчийн сэтгэлд хүүрнэл бий болгосон дүрслэл харагддаг. Иймд Хүннүгийн үеийн ардын урлагт арга билигийн ухаанд суурилсан сэтгэлгээ зонхилж байсныг булшнаас гарсан хоёр ширдэг /нэг нь Санктпетербургийн эрмитажид/ бэлхэнээ харуулж байгаа бөгөөд энэ нь гар урлал, чимэглэлийн хүрээнээс хэтэрч бүхэл бүтэн гүн ухааны үүднээс амьдралыг тайлан өгүүлсэн урлагын сонгодог бүтээл болсон гэж үзэж болдог.

Ардын урлагт араатан, жигүүртнийг өвсөн идэшт амьтантай, номхон дөлгөөн амьтадыг догшин шүүрүүн ааштай махчин амьтантай нэгэн хавтгай дээр дүрслэх, ургамал цэцэг навчийг эрвээхэй, цог хорхойтой, хангарьдыг могойтой, дөрвөн хүчтэнийг элдэв дөлгөөн хэлбэрийн аль эсвэл утга санааг нь хөгжүүлсэн дүрсүүдтэй нэгтгэн хавтгайд хамт дүрсэлдэг уран сайхны сэтгэлгээний эхлэл, өрнөл эндээс эхтэй.

Ер нь ардын урлагийн чимэглэлд нэг дүрт хэрэглээ байдаггүй.

Дүгнэлт: Хүннүгийн гар урчуудын бүтээсэн туурган хивсний дүрслэлээр дэлхий ертөнцийн үүсэл тогтоц, тэдний шүтэн барилдлага, түүнтэй эвсэн амьдрах хүн төрлөхтний жам ёсны тухай арга билигийн гүн ухааныг бодит болон хийсвэр сэтгэлгээний дүрүүдээр илэрхийлсэн уран сайхны сэтгэлгээний сонгодог бүтээл юм.

НОМ ЗҮЙ

1. Цүлтэм Н. Монгол уран зургийн хөгжиж ирсэн тойм. УБ., 1988. х.16

УЛС ТӨРИЙН ЗҮЙРЛЭЛД ХИЙСЭН ЗАРИМ АНАЛИЗ (ӨНӨӨДӨР СОНИНЫ ЖИШЭЭН ДЭЭР)

Н.Давааболд Докторант,
ХИС-ийн ГХСС-ийн Англи Хятад хэлний тэнхим

ТҮЛХҮҮР ҮГ: Улс төр, зүйрлэл, танихуй, үзэгдэл, судлагдахуун, зохиох, орлуулах.

Зүйрлэх үзэгдэл эртний Герег, Ромын гүн ухаантнуудын анхааралд өртөж байсан тэр цагаас хойш он цаг улиран солигдож олон зууныг ардаа үдсэн ч өнөөг хүртэл түүнд хандах сонирхол буураагүйгээр барахгүй улам бүр олон талаас хандах болжээ. Хэдийгээр хэл судлаачид зүйрлэх үзэгдэл, зүйрлэлийг олон талаас судалж хэлний уг үзэгдэлтэй холбоотой олон асуудлыг шийдэж ирсэн ч улс орон, нийгмийн амьдралд болж буй үйл явдал, өөрчлөлт шинэчлэл хэлэнд мөн тусгалаа олж үгийн сан шинэ үг хэллэгээр баяжин байдаг зүй тогтолтой холбоотойгоор зүйрлэлд хандах шинэ шинэ гарц ч бий болсоор байдаг ба хэлний бөгөөд хэлэхүйн хэмжээний зүйрлэл ч мөн энд хувь нэмрээ оруулсаар буй. [5:27]

Зүйрлэл нь сүүлийн үед нилээн өргөн хөгжиж хэл шинжээчид эрдэмтэдийн анхаарлыг татсаар байна. Хэдий энэсэдэв нь монголд төдийлөн сайн судлагдаагүй ч орос болон англи хэлэнд аль хэдийн хэл шинжлэлийн түвшинд судлагдан ирсэн байна.

Бид энэхүү сэдвээ илүү өргөн судалж таньж мэдэхийн тулд орчин цагийн хэвлэлээс нийтдээ 300 “улс төржсөн” зүйрлэлийг түүвэрлэн ажиглалт хийхэд маш олон салбар чиглэлийн улс төрд огт хамааралгүй үг нийлэмжээр дамжуулан зүйрлэн илэрхийлсэн байна. Тиймээс бид чухам ямар үг нийлэмжээр түлхүү илэрч байгааг нь харгалзан дараах хэсгүүдэд хуваасан болно.

1. Монголчуудын ахуй амьдрал, мал аж ахуйтай холбоотой үгс
2. Эмнэлэгийн чиглэлийн
3. Харь хэлнээс орж ирсэн гадаад үгс болон үгийн нийлэмж
4. Спорт болон тоглоомонд хэрэглэгдэх үгс, үгийн нийлэмж
5. Хоол хүнстэй холбоотой гэх зэргээр ангилан үзсэн болно.

1. Монголчуудын аж амьдрал, мал аж ахуйтай холбоотой үгсээр зүйрлэсэн нь:

1. Засгийн газарт түүнээс өөр “*ташуур барих*” хүнгүй болоод байгаа өнөө цагт тун нүдээ олсон алхам байлаа.(Өнөөдөр 2013, 02сар, №038)

2. Кипрт Ерөнхийлөгчийнэхлэв. Консерватив намын Никос Анастасиадес энэ *сунгаанд* тэргүүлж буй бөгөөд хамгийн хүчтэй өрсөлдөгч Ставрос Маласаас 15 хувийн дээгүүр үзүүлэлттэй байгаа аж.(Өнөөдөр 2013, 02сар, №038)

3. Мөн *угшил нэгтэй* МАХН –ынхантайгаа үл ойлголцож сонгуульд 2 тусдаа орсон.(Өнөөдөр 2013, 02сар, №038)

4. Оюутолгой төслийн хөрөнгө оруулалтын гэрээг байгуулахдаа зардлыг “*чөдөрлөх*” цаашид нэмэгдүүлэхгүй байх талаар заалт оруулаагүй юм байна.(Өнөөдөр 2013, 02сар, №038)

Д/д	Аймгийн нэр	Дархан Цаазат Газар	Байгалийн Цогцолборт Газар	Байгалийн Нөөц газар	Дурсгалт газар	Ногоон бүсийн ой	100 га хүртэлх төгөл ой	30 хэмээс дээш налуу газрын ой	Улсын хилийн дагуух ой	Хориотой зурвасын ой	Орон нутгийн ТХГазар	Цармын буслуурин ой	Заган ой	Дүн
1	Архангай	Талбай / га / Нөөц /мян.шоометр/	121976 13403.4		2052 190.7	129291 14855.5	106137 11048.5	246133 22606.9		257776 26559				863365 88664
2	Булган	Талбай / га / Нөөц /мян.шоометр/	7400 39.4	16444 1626	1402 138.8	166208 12180.3	151976 10839	327451 30105.4	219486 16900.6	434583 33267.8				1324950 105097.3
3	Баянхонгор	Талбай / га / Нөөц /мян.шоометр/	20020 1734.4					3669 243.9						23689 1978.3
4	Баян-Өлгий	Талбай / га / Нөөц /мян.шоометр/	36548 2871.7	1970 37.2		1139 103.4		2209 137.8		24625 783.7		1592 141.3		68083 4075.1
5	Говь-Алтай	Талбай / га / Нөөц /мян.шоометр/	2031 220.9					2510 356.5				4304 495.2		8845 1072.6
6	Дорнод	Талбай / га / Нөөц /мян.шоометр/	16624 451.8	20579 1091.7	11027 30.1	24358 756.7	23798 626.3		79298 3752.2	13163 436.1				188847 7144.9
7	Завхан	Талбай / га / Нөөц /мян.шоометр/	13494 178.4	179743 6235.1		80789 8671.4	98706 9336.5	102030 6457.1	30747 2457.9	99021 8162.1		4503 319.6		609033 41818.1
8	Орхон	Талбай / га / Нөөц /мян.шоометр/				16144 1428.4					1648 157.7			17792 1586.1
9	Сэлэнгэ	Талбай / га / Нөөц /мян.шоометр/	88849 9004.4	58619 2338.3		142581 7587.9	26462 1894	26986 1563.6	41630 4341.3	252659 20554	92506 4292.4			730292 51575.9
10	Хөвсгөл	Талбай / га / Нөөц /мян.шоометр/	28868 3555.4	272511 34794.5	34056 3236.8	20245 2790.2	307186 33237.3	185067 19592.7	1375440 159091.2	153907 14988.9	975059 109551.9	191328 20666		3543667 401504.9

Тарвага

Дүрслэл №3 “Монгол орны тарваганы тархац нөөцийн өөрчлөлт”

График 6. Завхан аймгийн тарваганы тархалт болон нөөцийн өөрчлөлт

Завхан аймгийн тарвагатай газрын нийт талбай 1990 оныхоос 1,2 дахин, дунд болон элбэг нөөцтэй газрын талбай 1,6 ба 4.8 дахин ихэссэн байна. Харин бага нөөцтэй газрын талбай мөн оныхоос 6,4%-иар буурсан байна.



Зураг 12. Завхан аймгийн 1990, 2010 оны тарваганы нөөцийн өөрчлөлт

ОН	1990	2010	өөрчлөлт
Талбай	23,051.22	27,871.78	1.20 дахин нэмэгдсэн
Бага	15,663.23	14,661.41	6,4% буурсан
Дунд	6,897.86	10,852.68	1.57 дахин нэмэгдсэн
Элбэг	490.13	2,357.69	4.81 дахин нэмэгдсэн

Эх сурвалж: Монгол орны тарваганы тархац, нөөцийн мэдээллийн сангийн бүтэц, метадата Байгаль орчны мэдээллийн төвийн менежер Д.Булган

Бэлчээрийн нөөц

Хүснэгт №2 “Аймгуудын бэлчээрийн нөөц”

	Аймгууд	Нийт бэлчээрийн талбай га	Үүнээс					
			Нөлөөлөлгүй бэлчээр га		Нөлөөлөлд орсон бэлчээр га		Нөлөөлөлд ороогүй Алслагдсан бэлчээрлэх боломгүй талбай	
			Хэмжээ		Хэмжээ га		Хэмжээ	
	Завхан	61 05968	44329 32.8	2.6	1 239511.5	0.3	433523.7	.1
	Хөвсгөл	26 16345	17084 73.3	5.3	7 22111.2	7.6	185760.5	.1

Эх сурвалж: Монголын эдийн засгийн форум Малчдын ирээдүй судалгаа

2.2. Завхан аймгийн татвар, нөхөн сэргээлтийн төсөв, нөөцийн ашиглалтын уялдаа холбооны тооцоолол

Хүснэгт №3 “Завхан аймгийн татвар ба нөхөн сэргээлтийн төсөв”

БАЙГАЛИЙН НӨӨЦҮҮД	Х.Н	Нөөцөөс хэрэглэ ж буй хэмжээ	Нэгжид ногдуула х татвар /төг/	Татварын орлого	Нөөц ашиг ласн ы төлб өрөөс нөхөн сэргээ лтэд зарц уула х хувь	Нөхөн сэргээлтэд зарцуулах / төг /	2012 онд татварын орлого	Байгалийн нөөцийн хэрэглээ Татварт орж буй орлогын зөрүү /2012 он төг/	Төсвөөс нөхөн сэргээлтэд зарцуула х ёстой мөнгөний хэмжээ / төг /	Нөхөн сэргээлтэд зарцуулж буй хөрөнгө оруулалт / төг /
Ан амьтан										
Загас	кг	75000	700	52500000	50%	26250000				
Тарвага	толгой	3000	1000	3000000		1500000				
Зээр	толгой	100	6000	600000		300000				
Нийт төлвөл зохих				56100000		28050000	13200000	42900000	6600000	
Нэрс хэрэглэгчид										
ЗавханБ аялаг ХК	кг	12000	400	4800000	0%	1440000				
Мөнхөд мандаг ХХК	кг	5000		2000000		600000				
УБ- хотруу ачигддаг	кг	80000		32000000		9600000				
Иргэдий н түүж борлуулдаг хэмжээ	кг	5000		2000000		600000				
Нийт төлвөл зохих				40800000		12240000	0	40800000		
Чацаргана хэрэглэгчид										
ЗавханБ аялаг ХК	кг	3200	320	1024000	0%	307200				

	Мөнхөд мандаг ХХК	кг	1700		544000		163200				
	УБ- хотруу борлуулдаг	кг	50000		16000000		4800000				
	Зах дээр борлуулдаг	кг	1000		320000		96000				
	Нийт төлвөл зохих				17888000		5366400	0	17888000		
Хар суль, сульхир											
	Хар суль	кг	2000	300	600000		180000				
	Сульхир	кг	3000		900000	30%	270000				
	Нийт төлвөл зохих				1500000		450000	0	1500000		
Модны хэрэглэгчид											
	Түлш, хэрэглээний мод	шоо.метр	5333	30000	159990000	85%	135991500				
	Нийт төлвөл зохих				159990000		0	223300000		18980500 0	
Бэлчээр ашиглалт											
	Аймгийн малын тоо	хонин.толго й	3191536	50	159576815	30%	47873044.5	0	47873044.5		
	НИЙТ ТӨЛВӨЛ ЗОХИХ				435 854815		22 9970944.5	23 6500000	150961044.5	1 96405000	2 700000
	НӨХӨН СЭРГЭЭЛТИЙ Н ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫ Н ЗӨРҮҮ									1 93705000 төгрөг	

Эх үүсвэр: Судлаачдын тооцоолол

Тайлбар: Байгалийн нөөцүүдийн бодит хэрэглээг тооцоходоо Дөрвөлжин, Тосонцэнгэл, Идэр, Ургамал сумдын байгалийн орчны байцаагчидтай холбогдож нөөц ашиглалтын дөхөмтэй мэдээллийг авсан болно. Харин зарим мэдээллийг статистикийн эмхэтгэл ашиглав. Харин нөхөн сэргээлтийн норм, нөөц ашигласны татварын нормыг зохих холбоотой хууль, журмаас авлаа. Хуулиудын тодорхой хэсгүүдийг хавсралтад оруулав.

Завхан аймгийн тогтвортой хөгжлийг хангах өнөөгийн бодит байдлын гажуудал
Хүснэгт №4 “Завхан аймгийн байгалийн нөөцийн хэрэглээ болон татварын орлого”

Байгалийн нөөц	Байгалийн нөөцийн хэрэглээ / төг /	Байгалийн нөөцийн татварын орлого /төг/	Завхан аймгийн төсвөөс байгалийн нөхөн сэргээлтэд зарцуулж буй төсөв /төг/
Хязгаарлагдмал нөөц болох Амьтан, ургамал, мод	435854815	236500000	2700000

Нөөцийн нийт хэрэглээ татварын орлого 2-ийн зөрүү /төг /	Төсвөөс нөхөн сэргээлтэд зарцуулах ёстой мөнгөний хэмжээ, төсөвлөсөн мөнгөний хэмжээ 2-ийн зөрүү /төг/
199354815	193705000

ГУРАВ. ГАЖУУДЛЫН УЧИР ШАЛТГААН

3.1. Анкетийн аргаар байгалийн нөөцөөс орлого хүртэгчээс авсан судалгаа

Статистик судалгааны дүгнэлт

Нэг. Байгалийн нөөцийн хэрэглээний бодит түвшинг эх сурвалжуудаас тойм байдлаар тооцож үзэхэд татварын бүрдүүлэлттэй харьцуулахад 199 сая төгрөгийн алдагдал хүлээж байна.

Хоёр. Татварын бодит бүрдүүлэлтээр ойн ашиглалт, ан агнуураас 236 сая төгрөг хуримтлагдсан боловч аймгийн 2012 оны төсөв 2.7 сая төгрөгийн байгалийн нөхөн сэргээлтэнд зарцуулна гэж төсөвлөжээ. Хуулиар бол мод ашигласны татвараас олсон орлогын 85% ан амьтнаас олсон орлогын 50%-ийг нөхөн сэргээлтэнд зарцуулна гэж заасан байдаг. энэ хувиар бодоод зөрүүг тооцвол 193 сая төгрөгийг дутуу төсөвлөжээ.

Гурав. Эдгээр гажуудал нь байгалийн нөөцийг нөхөн сэргэхэд анхаарахгүй, нөөц багасах аюулд хүргэх юм.

ГУРАВ. ГАЖУУДЛЫН УЧИР ШАЛТГААН

3.1. Анкетийн аргаар байгалийн нөөцөөс орлого хүртэгчээс авсан судалгаа

Судалгааны гол гаргах ирэх санаа нь Байгалийн нөөцийг яагаад журмын дагуу ашиглахгүй байгааг тодруулах байсан бөгөөд нийтдээ 5 чухал асуултаар таамаглалаа бататгах, шалтгааныг олохыг зорьлоо.

Судалгааг зорилтот 210 хүнийг сонгон авч анкет, ярилцлага хосолсон аргаар явуулсан. Эдгээр судалгаанд оролцогчдоос 90 малчин, 40 мод бэлтгэдэг хүн, 80 жимс түүдэг хүнийг хамрууллаа. Эдгээр судалгаанд оролцогчдын 150-ийг Улиастай сумаас, 60-ийг Ургамал, Эрдэнэхайрхан, Тосонцэнгэл, Идэр, Яруу сумдын иргэдийг хамрууллаа.

Дээрх нөөцийг ашиглах, түүнээс орлого олохдоо аль үзэл бодлын үүднээс ханддаг вэ?

Нөөцийг дундын өмч байдлаар ханддаг	105
Нөөцийг миний эзэмшил, өмч гэж ханддаг	15
Нөөцийг сум орон нутаг, улсын өмч гэж ханддаг	90
Нийт	210

Дээрх байгалийн нөөцийг ашиглах, орлого олохдоо ямар зорилготой ажилладаг вэ?

Тухайн нөөцөөс илүү их орлого олох байдлаар	140
---	------------

Тухайн нөөцөөс хишиг хүртэх байдлаар	45
Тухайн нөөцийг урт удаан хугацаанд ашиглах	25
Тухайн нөөцийг ашиглаад нөхөн сэргээх байдлаар	0
Нийт	210

Ашиглаж буй байгалийн нөөцөө хамгаалах, нөхөн сэргээх ажлуудад гар бие оролцож ажилладаг уу.

Нөөц нь шавхагдашгүй учраас нөхөн сэргээлт хийх шаардлагагүй гэж боддог	80
Нөхөн сэргээх ажил хийгддэггүй учраас оролцдоггүй	110
Нөхөн сэргээх ажлыг сум орон нутгийн удирдлагууд хийдэг	15
Нөхөн сэргээх ажилд тодорхой хэмжээгээр оролцдог	210
Өөрийн хөрөнгө, хөдөлмөрөөр сэтгэл гарган нөөцийг нөхөн сэргээдэг	0
	210

Нөөцийн ашиглах, нөхөн сэргээх тал дээр таны мэдлэг хангалттай гэж боддог уу?

Нөөцийг ашиглах мэдлэг

Малчдад бэлчээр ашиглалтын мэдлэг нь өвс ногоо хаана их ургаж байна түүнийг даган малаа хариулах гэсэн ерөнхий дүгнэлт гарч байна.

Ихэнх хүмүүс ашиглалтын мэдлэг байхгүй. Шатсан мод, бүдүүн мод хөрөөдөхийг ашиглах мэдлэгээ гэж боддог.

Нэрс, чацаргана түүдэг хүмүүс нь жимсний өнгийг мэдлэгээ гэж үздэг, түүхдээ мөчирт нь гэмтэл учруулахгүй гэсэн цөөн хэдэн ойлголт байдаг.

Нөөцийг нөхөн сэргээх мэдлэг

Нөхөн сэргээх нь нөөц бүрээс хамаарч өөр өөр ойлголттой байна. Чацаргана нэрс түүдэг хүмүүс бол өөрөө их хэмжээгээр ургадаг учраас бидний оролцоо орохгүй гэж ойлголттой. Бэлчээр ашигладаг хүмүүс нь дэлхийн цаг ууртай холбоотой бидний хүч хүрэхгүй гэсэн ойлголттой. Модноос орлого олдог хүмүүс мод тарих ёстой. гэхдээ үүнийг орон нутгийн байгууллагууд тендерээр зохицуулдаг гэсэн ойлголттой байлаа.

Судалгааны дүгнэлт

Нэг. Нөөцөөс орлого хүртэгчид буюу ард иргэд нь нөөцийг өөрийн эзэмшил биш сум орон нутгийн дундын өмч гэж үздэг учраас илүү их орлого олохыг зорьж байдаг.

Хоёр. Энэ хууль бус байгалийн нөөцийг ашиглалт нь татварт хуримтлагдах мөнгөний хэмжээ багасдаг. Энэ нь Байгалийн нөхөн сэргээлтэд төсөвлөх мөнгөний хэмжээг багасгана.

Гурав. Иргэдийн үзэж байгаагаар ашиглаж буй нөөцийг нь нөхөн сэргээх ажил хийдэггүй учраас нөхөн сэргээх ажилд оролцдоггүй. Мөн шавхагдашгүй гэж боддог учраас нөхөн сэргээлт хийх талаар боддоггүй.

Дөрөв. Иргэдийн байгалийн нөөцийг ашиглах мэдлэг муу, мэдлэг байхгүй учраас түүнийс орлого олох талаар бодохоос түүнийг нөхөн сэргээх талаар боддоггүй.

Эрдэм шинжилгээний дүгнэлт

Нэг. Байгалийн нөөц түүний нөхөн сэргэх, сэргэгдэхгүй нөөц, түүнээс улиралын нөлөөлөл, нөлөөлөлгүйгээр орлого олдог ард иргэд, иргэдийн татвараар орлого бүрдүүлдэг орон нутгийн удирдлагын уялдааг холбоог судлахад Байгалийн нөөцийн хяналтгүй, хууль бус хэрэглээ нь байгаль орчныг сүйтгэх гол шалтгаан юм.

Хоёр. Орон нутаг нь байгалийн нөөцийг ашиглуулсанаа төлөө татвар авч түүнийхээ хуульд заасан хэмжээгээр эргээд байгалийн нөхөн сэргээлтэд зарцуулах ёстой байдаг. Гэтэл судалгаанаас харахад орон нутаг нь хуульд заасан хэмжээгээр төсөвлөдөггүй бөгөөд энэ нь байгалийн нөөцийг нөхөн сэргээх ажил явагдахгүй байх шалтгаан юм.

Гурав. Ард иргэдийн ухамсаргүй үйлдлийн шалтгаан нь тухайн нөөцийг өөрийн эзэмшил биш, бусдын өмч гэж боддог учраас илүү их орлого олохыг хүсдэг. Энэ эзэнгүй байдал нь татвараас нуугдах, хууль бусаар орлого олох хүслийг төрүүлдэг гэж дүгнэж байна.

Дөрөв. Ард иргэдийн нөөцийг ашиглах мэдлэг дутмаг, орон нутгаас нөхөн сэргээх ажил хийдэггүй учраас оролцдоггүй, нөхөн сэргээлтийн мэдлэг байхгүй нь эдийн засгийн микро түвшинд мэдлэгт суурилсан гэж яриад байгаа бодлого хүрч чадахгүй байна.

Санал зөвлөмж

Нэг. Байгалийн нөөцөөс хүртэж буй иргэдийн мэдлэгийг сайжруулахад анхааръя. Сургалт, судалгааны ажлыг нарийвчилж хийе.

Хоёр. Мэдлэгтэй болсон иргэдэд тухайн нөөцийг эзэмшүүлье. Яагаад гэвэл мэдлэгтэй болсон хүн эзэмшилтэй болохоор нөөцийг зөв зарцуулна. Нөхөн сэргээнэ.

Гурав. Эзэмшилтэй мэдлэгтэй иргэдтэй болсон орон нутаг татварын зөв бодлого явуулья. Татварынхаа хуульд заасан хэмжээг буцаагаад иргэдэд олгож нөхөн сэргээлтэд дэмжлэг үзүүлэх нь зөв юм.

Дөрөв. Энэ системийг нэвтрүүлж ажил болгож чадвал тухайн нөөцтэй хамааралтай бизнес, цаашлаад орон нутгийн эдийн засаг тодорхой хэмжээгээр өсөлт гарна гэж үзэж байна.

НОМ ЗҮЙ

1. Монгол Улсын Статистикийн эмхэтгэл /1989-2010 он/, Үндэсний Статистикийн хороо. УБ
2. Завхан аймгийн статистикийн хэлтэс. 2010 он. Статистикийн буллетинь . Завхан аймаг
3. Завхан аймгийн статистикийн хэлтэс. 2011 он. Статистикийн буллетинь . Завхан аймаг
4. Завхан аймгийн статистикийн хэлтэс. 2012 он. Статистикийн буллетинь . Завхан аймаг
5. Дэлхийн Эдийн Засгийн Форум. 2005 он. Дэлхий дахины өрсөлдөх чадварын тайлан. Женев., Швейцарь.
6. “Завхан Баялаг” ХК. 2009-2012 он. Санхүүгийн тайлан. Завхан аймаг
7. Завхан аймаг. Орон нутгийн төсөв. 2012 он
8. “Ногоон Тэс” ТББ. Ойг нөхөн сэргээх ажилд мониторинг хийсэн төслийн тайлан. 2009 он. УБ
9. Монголын Тарвага хамгаалах нийгэмлэг. Монгол орны зарим бус нутгийн иргэдийн оролцоотой тарваганы тархац, нөөцийг тогтоох судалгаа. 2010 он. УБ
10. Хөдөөгийн Хөдөлмөр хоршоо. Санхүүгийн тайлан. 2012 он. Завхан аймаг

Цахим эх сурвалжууд

1. www.wikipedia.org
2. www.zavkhan.gov.mn/files.php
3. <http://mne.mn/v3/?p=1680>
4. www.nso.mn/v3/index Хэрэглэгчийн мэдээллийн сан
5. www.forum.mn

СОНГОГЧДЫН ЗАН ҮЙЛД НӨЛӨӨЛӨХ УЛАМЖЛАЛТ ХҮЧИН ЗҮЙЛС БА УЛС ТӨРИЙН МАНИПУЛЯЦИ

Ц.Бямбачулуун
Магистр, ХИС-ийн НХУСийн НУ-ны тэнхимийн багш,
baymbaa_999@gmail

Түлхүүр үгс: Сонгогчдын зан үйл, улс төрийн сонголт, сонгуулийн кампани, улс төрийн манипуляци.

Товч хураангуй: Ардчилсан нийгмийн нэг онцлог нь ерөнхийлөгчийн таван, парламентийн зургаа, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагаа зургаа удаа өөрсдөө сонгож, төрийн болон орон нутгийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан үйл ажиллагаанд оролцдог улс төрийн тогтолцооны нэгэн

чухал үйл явц бол сонгууль билээ. Өнгөрсөн сонгуулиудын үйл явцаас харахад ардчилсан шудрага сонгууль явуулах нэрээр хууль дүрэм зөрчих, сонгуулийн кампаний үеэр сонгогчдыг мөнгөөр худалдан авах, төрийн албан хаагчдыг ашиглах, сонгогчдын өгсөн саналыг будлиантуулах, улс төрийн манипуляци хийх гэх мэт хууль зөрчсөн үйлдэл хийх нь олширсон. Харин эндээс сонгогчдын уламжлалт зан үйл дээр тулгуурлан тэднийг төөрөгдүүлэн олон нийтийн санаа бодлыг өөрт ашигтайгаар эргүүлэх бодлого аль нэг улс төрч болоод намын зүгээс ихээхэн хэрэглэх болсон. Энэ нь өнгөц харахад үл анзаарагдам, бидний өдөр тутмын амьдралд байдаг зүйл мэт боловч улс төрийн шийдвэр гаргах торгон мөч болох сонгуулийн санал хураалтын үеэр ямар их нөлөө үзүүлдэг талаар цөөн хэдэн баримтыг дурдья.

Иргэд чөлөөт сонгуульд оролцохдоо саналаа хэрхэн өгдөг, улс төрийн сонголт хийхэд юу нөлөөлж байдаг вэ гэх мэт асуудлууд сонгогчдыг үйл байдлаас ихээхэн шалтгаалж байдаг. Мэдээж хэрэг сонгогчдын сонголтонд тэднийн нас, хүйс, нийгмийн ямар бүлэгт хамаарагддаг зэрэг олон хүчин зүйлс нөлөөлдгийг олон тооны судалгааны үр дүнгээс харж болно. Тухайлбал, УТБА-аас явуулсан судалгаанаас үзэхэд судалгаанд хамрагдагсдын 5 хүний нэг нь бусдыг дагалдан санал өгдөг⁷⁷ гэдгээ хүлээн зөвшөөрснийг судалгааг явуулагчид “хэрэг дээрээ үүнээс олон байж болох бөгөөд, сонгогчдын боловсрол нэмэгдэх тусам багасна” гэсэн дүгнэлтийг хийсэн байдаг. Улс төрийн ийм үйл байдал нь сонгогчдын боловсрол, улс төрийн мэдлэгийн түвшинтэй холбоотой төдийгүй тэдний зан заншил, сэтгэл зүйн онцлогтой ихээхэн холбоотой. Иймээс сонгогчдын сонголтын учир шалтгааныг ойлгоход түүнд нөлөөлж буй хүчин зүйл нэг бүрийн гүйцэтгэх үүрэг, хоорондын харилцаа холбоо, хамаарлыг зөв тогтоох явдал нэн чухал. Сонгогчдын санал өгөх үйл байдлыг судлах салбарт нийгэм, сэтгэлзүйн хандлага нэвтэрч орж ирсэн нь чухал ололт юм. Сонгогчдын сонголтонд нөлөөлж буй үндсэн хүчин зүйлсийг:

1. Богино хугацааны хүчин зүйлс (улс төр, эдийг засгийн тухайн нөхцөл, улс төрийн лидерийн имиж, сонгуулийн кампани г.м)
2. Урт хугацааны хүчин зүйл (социал бүлгийн ялгаа, үзэл бодол, намын харьяалал, үнэт зүйлсийн баримжаа г.м) гэж ангилж үздэг.

Эндээс улс төрийн намыг дэмжих байдал Монголын сонгогчдын үйл байдалд хэр зэрэг нөлөөтэйг судалгаануудын дүнгээс харахад сонирхол татдаг. Судлаачдын нилээд хэсэг нь 1990 онд АИХ-ыг, 1992, 1996, 2000, 2004 онуудад УИХ-ыг сонгоход хэрэглэсэн мажоритар тогтолцоо хийгээд сонгуулийн хууль нь хувь хүний шинжийг гол шалгуур болгох тал руу сонгогчдод түлхүү нөлөөж байна. Сонгуулийн мажоритар тогтолцооноос үүдэн улс төрийн систем дэх олон намын үүрэг, ач холбогдлыг дутуу үнэлэх хандлага сүүлийн үед нилээд хүчтэй илэрч байна гэсэн дүгнэлтийг хийдэг.

Манипуляцийг нөхцөлдүүлэгч хүчин зүйлс Монголын өнөөгийн улс төрд манипуляци газар авахад дараах хүчин зүйлс нөлөөлж байна. Үүнд: 1. Соёл уламжлалын хүчин зүйл, ардчилсан бус соёлын нөлөө Монгол улс Өрнийн соёлын загвар бүхий суурьшмал амьдралд шилжээд нэгэн зууны нүүрийг үзэж буй хэдий ч амьдралын хэв маяг, олон нийтийн үнэлэмж, хандлагад уламжлалт буюу модерн бус нийгмийн шинж ажиглагдсаар байгаа юм. Зүүн Азийн Барометр төслийн эхний шатны судалгааны дүнгээс үзэхэд Хонконг, Өмнөд Солонгос, Хятад, Филиппин, Тайвань, Тайланд, Монгол⁷⁸ гэсэн найман улсаас манай олон нийтийн дунд төрийг дээдлэх, ах дүү, танил талын холбоог илүүд үзэх зэрэг уламжлалт хандлага хамгийн өндөр үзүүлэлттэй байна. «Ямар нэгэн зүйлийг өөр хүнээр хийлгэх шаардлага гарвал нарийн мэргэшсэн, гэхдээ танихгүй хүнийг хөлсөлснөөс хамаатан, найз нөхдөө хөлсөлсөн нь дээр» гэж судалгаанд оролцогчдын 75% хариулсан нь хамгийн өндөр үзүүлэлт юм [1: 175]. Мөн судалгаагаар хүмүүсийн 60 гаруй хувь нь «Баян чинээлэг, эсвэл ядуу байх, амжилтанд хүрэх, ялагдал хүлээх нь хүний заяа төөргөөс хамаарна» [1: 169] гэж хариулснаас үзэхэд харьцангуй идэвхгүй бие хүний дүр зураг өнөөгийн Монголын иргэдийн нийтлэг шинж болж байгаа аж. Хүмүүс нийгэм, улс төрийн болж буй үйл явц, эрх баригчдын үйл ажиллагааг идэвхгүй дагах биш, түүнд оролцож нөлөөлж чаддаг баймааж иргэний нийгэм бүрэлддэг. Харин иргэд нь идэвхгүй, төрдөө нөлөөлж чаддаггүй улс орнуудад эрх баригчид өөрийн дур зоргоор авирлаж, олон нийтийг залж удирдах явдал түгээмэл байдаг билээ. Энэхүү судалгааны хамгийн эмзэглүүштэй үзүүлэлт нь судалгаанд оролцогчдын 65% нь «Төрөөс хүмүүст юу ярихыг нь зааж өгөх ёстой» гэж үзсэн явдал юм. Өөрөөр хэлбэл монголчууд маань хуучны авторитар дэглэмийн адил төр бүхнийг шийдэж зохицуулах ёстой гэсэн сэтгэлгээнээсээ салаагүй байна. Монгол улс ардчилсан дэглэм рүү шилжилт эхлүүлээд 15 жил болж байгаа хэдий ч ардчиллын гол үнэт зүйлс, зарчмууд улс төрийн бодит амьдралд бүрэн утгаараа хэрэгжиж чадаагүй, олон нийт эдгээрийг өдөр тутмын амьдралдаа хэрэглэж сураагүй нь улс төрийн хүчнүүдийн явуулж буй манипуляцид өртөхөд хүргэж байгаа юм. Улс төрийн хүчнүүд олон нийтийн дунд хүчтэй хэвээр байгаа уламжлалт хандлага буюу зарим тохиолдолд «ардчилсан бус» гэж нэрлэж болохоор нутгархах, яс угсаа, шашин, итгэл үнэмшлээр баримжаалан санал өгөх явдлыг өөгшүүлж манипуляци хийхдээ ашиглаж байгаа нь улс төрийн үйл явцаас харагдаж байна. Монголын сонгуулиудад «нутгийн хүү», «нэгэн довныхон», «унасан газар угаасан ус», «би эндхийнх» гэх мэт үгс ихэнх нэр дэвшигчдийн гол нэрийн хуудас болсоор ирлээ. Мөн нэр дэвшигчийн гарал угсаанд олны анхаарлыг хандуулах, үндсэрхэх үзэл, эх оронч байдлыг нь өдөөх маягаар манипуляци бүхий мэдээлэл тараах явдал улам бүр нэмэгдэж байна.

⁷⁷УТБА “Зүүн Азийн Барометр” судалгааны тайлан.УБ.,2007. 42 тал

⁷⁸УТБА “Зүүн Азийн Барометр” судалгааны тайлан.УБ.,2007. 42-43 тал

2005 оны ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр нэр дэвшигчдийн заримыг «хятадын эрлийз» гэж ухуулах мессеж ихээхэн хүчтэй явагдсан билээ. Энэхүү мессеж сонгогчдын тодорхой бүлгийн санал өгөлтөнд хэрхэн нөлөөлснийг тодруулах үүднээс судлаач 2005 оны 05 сард 18-21 насны 64 оюутнаас санал асуулга, 48-67 насны тэтгэврийн 16 хүнтэй ярилцлага хийх замаар бэсрэг судалгаа явуулсан юм. Санал асуулгын дүнгээс үзэхэд Ардчилсан намаас нэр дэвшигч М.Энхсайханы талаарх «хятадын эрлийз» гэх мэдээлэлд оюутнуудын 41%, тэтгэврийнхний 52% нь итгэж байна, Бүгд найрамдах намаас нэр дэвшигч Б.Жаргалсайханы талаарх «хятадын эрлийз» гэсэн мессежид оюутнуудын 56%, тэтгэврийнхний 68% нь итгэж байна гэж хариулсан юм. Судалгаанд оролцогчид дээрх мессежид яагаад итгэх болсноо «Сонин дээр уг гарлыг нь маш тодорхой тайлбарлаад биччихсэн байсан», «Хүмүүс тэгж ярьж байгаа учраас үнэн байх», «Олны үг ортой» гэх зэргээр тайлбарлаж байв. Энэхүү дүнгээс үзэхэд 50-иас дээш насныхны санал өгөлтөд намуудын дээрх манипуляци хүчтэй нөлөөлсөн байж болох талтай. Олны анхаарлыг мөрийн хөтөлбөр, байр суурь гэсэн гол асуудлаас хөндийрүүлж үндэс угсаагаа дээдлэх, ижилсэн нэгдэх мэдрэмж дээр «тоглоон» өөр бусдыг үзэн ядах сэтгэгдэл төрүүлэх зорилготой дээрх ухуулга сурталчилгаа нь нэг талаас манипуляци, нөгөө талаас ардчиллын эсрэг шинж бүхий үйл ажиллагаа юм. Угтаа бол ардчилсан нийгэм олон янзын соёл, үзэл бодол, үндэс угсаанд хүлээцтэй ханддаг бөгөөд хэн нэгэн гарал угсаанаас үл хамааран нийгмийн бүрэн эрхт гишүүн байхын зэрэгцээ өөрийн хүч, авьяас чадвараа нийтийн төлөө зориулах бололцоо нээлттэй байдаг билээ.

Бидний судалгаанаас үзэхэд улс төрийн намууд олон түмний дунд хүчтэй байгаа соёл, уламжлалын дараах таван хүчин зүйлсийг сонгуулийн кампанидаа ашиглаж байна⁷⁹. Үүнд:

1. Төрийг дээдлэх үзэл. Монголчуудын сэтгэлгээ, төрийг үзэх үзэл нь олон зууны турш эрхэлж ирсэн мал аж ахуй, шашин шүтлэг, амьдралын хэв маягаар нөхцөлдсөн байдаг билээ. Дорнын бусад ард түмний адил төрийг дээдлэн шүтэж ирсэн юм. Өнгөрсөн 70 жилд авторитар төр дэглэмээ хадгалахын тулд үзэл суртлаар зэвсэглэн олон түмний дундах төрийг дээдлэх уламжлал хандлагыг улам бүр бэхжүүлсэн юм. Нийгмийн шударга хуваарилалтыг гол болгосон социалист үзэл санаа хөдөлмөр хийлгүй баялагт хүрэх нүүдэлчин сэтгэлгээг улам хөөргөдөг өгсөн юм. (А.Юндэндорж 2005) Төрийн түшээ, төрийн тэргүүнийг бурханчлан шүтэх явдал хүмүүсийн дунд хүчтэй хэвээр байна. Олон нийтийн төрөөс ихийг хүсэн хүлээдэг, төрийн “хайр хишгийг” горьдох сэтгэлгээг нь улс төрийн хүчнүүд сонгуулийн кампанидаа байнга ашиглаж ирсэн байна.

Өмнө дурьдсанаар УИХ-ын сонгуулийн хуульд сонгогчдыг худалдан авахад чиглэсэн аливаа үйлдэл, төрийн албыг сурталчилгаанд ашиглахыг хориглосон байдаг ч бодит амьдрал дээр эдгээр заалт хэрэгжихгүй байгаа юм. Улс төрийн намуудын нэр дэвшигчид орон нутгийн болон засгийн газрын өндөр албан тушаал хашдаг бол энэхүү албан тушаалаа ашиглан сонгуулийн кампанидаа бусад өрсөлдөгчдөөсөө илт давуу байдлыг бий болгодог. Тухайлбал, 2008 оны сонгуулийн кампанийн үеэр бидний хийсэн ажиглалтаас үзэхэд бүх шатны засаг дарга нар төсвийн мөнгөөр тойргийн иргэдэд эд материалын тусламж үзүүлэх, оюутнуудыг гадаадад сургах, сургалтын төлбөрийг даах, иргэдэд газар олгох гэх мэт сонгогчдыг хахуульдан авах явдал гарсан.

Мөн сонгогчдын дунд хийсэн фокус бүлгийн ярилцлагын дүнгээс харахад иргэдтэй нүүр тулж ажилладаг нутгийн удирдлагын анхдагч төлөөлөгч болох баг, хорооны засаг дарга нар өөрийг нь нэр дэвшүүлсэн улс төрийн намыг шууд сурталчлах, иргэдэд өөрийн намыг дэмжихээр дарамт үзүүлэх, эд материалын тусламж үзүүлэх маягаар хахуульдан авах явдал хамгийн их байдаг ажээ. (Д.Бадамдаш нар 2008) Иргэд төрийг дээдэлдэг, төрийн албан тушаалтныг хүндэтгэдэг учраас дарга нарын үгэнд автаж саналаа өгөх явдал түгээмэл юм. Энэ байдал нийслэл Улаанбаатар хотын Налайх, Багануур, Багахангай гэх мэт алслагдсан дүүргүүд болон хөдөө орон нутагт илүү хүчтэй илэрдэг.

2. Нутгархах үзэл. Монголчууд эртнээс хүн ам төвлөрсөн томоохон хот сууринд бус, тархай бутархай нүүдэллэн амьдарч ирсэн, орон нутгийн зохион байгуулалт хүчтэй, асуудлыг шийдэхэд нутгийн хүчин зүйл гол болж ирсэн. Улс орны нийтлэг асуудал гэхээсээ илүүтэй орон нутгийн асуудалд хүмүүс илүү анхаарал тавьдаг нь судалгаануудаас харагддаг. Ялангуяа нийслэл УБ хотоос бусад бүх газарт нутгархах хандлага хүчтэй байдаг. Тийм учраас улс төрийн намууд сонгуулийн кампанидаа дээрх онцлогийг харгалзан үздэг. Монголын сонгуулиудад «нутгийн хүү», «унасан газар угаасан ус минь», «би эндхийнх» гэх мэт үгс ихэнх нэр дэвшигчдийн нэрийн хуудас болсоор ирлээ.

Намууд нийслэл УБ хотоос бусад тойргуудад нэр дэвшигчдийг хуваарилахдаа зөвхөн тухайн газар төрж өссөн юмуу аав ээжийн аль нэг нь тухайн нутгийнх байх шалгуур барьдаг билээ. Жишээлбэл, 2008 оны сонгуульд улс төрийн 11 нам, 1 эвслээс нийт 356 хүн нэр дэвшсэний 190 нь хөдөөгийн 20 тойрогт өрсөлджээ. Хөдөөгийн тойрогт өрсөлдсөн нэр дэвшигчид бараг бүгд өөрийн төрсөн газар юмуу аав ээжийн нутагт нэр дэвшсэн байна. Сонгогчид ч мөн “Таньдаггүй бурхнаас таньдаг чөтгөр дээр” гэсэн уламжлалт хандлагаар нутгийн хүнийг илүүд үзэж сонголтгоо хийдэг нь судалгааны дүнгүүдээс харагддаг. Улс төрийн хоёр гол намын хүчтэй лидер л биш бол хөдөө орон нутагт тухайн газар төрж өсөөгүй хүн сонгогдох боломжгүй байна.

⁷⁹«Монгол дахь сонгуулийн үйл явц: онол, практик» эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл “Ц.Мөнхцэцэг, Г.Цогтбаатар, Д.Бадамдаш “Монголын сонгуулийн кампанийн хэв маяг, улс төрийн намуудын сонгуулийн стратеги” УБ., 2009

2008 оны сонгуулийн кампанийн үеэр бидний УБ хотод хийсэн цуврал судалгааны дүнгүүдээс үзэхэд нэр дэвшигчийн “нутаг орны амьдралыг сайн мэддэг байх” гэсэн шалгуур сонгогчдын санал өгөлтийн 5 дахь гол хүчин зүйл болж байв. (Д.Бадамдаш нар 2008) Улмаар намууд аймаг, сумын ой, тэмдэглэлт дарга хэмжээ зэргийг улс төрчид, УИХ-ын гишүүд тухайн орон нутагт нэр хүндээ бэхжүүлэх арга хэрэгсэл болгон ашиглах нь түгээмэл боллоо. Монголын бүх аймагт орон нутгийн хөгжлийг дэмжих зорилго бүхий нутгийн зөвлөл ажиллах бөгөөд үүний үйл ажиллагааг тухайн аймагас сонгогдсон юмуу ирэх сонгуульд нэр дэвшихээр бэлдэж буй улс төрчид голчлон санхүүжж дэмжиж байдаг.

3. Хамаатан садны хэлхээ холбоо. Өрнө дахинаа алдартай зохиолч Чинагийн Галсан “Монгол улс бол овгийн нийгэм, хүн бүр өөрийн овог, удмаа түрүүлж боддог” гэж бичсэн байдаг. Үнэхээр ч Монголын нийгмийн бүхий л салбарт хамаатан садны хэлхээ хүчтэй илэрдэг. Зүүн Азийн Барометр судалгаанд оролцогчдын 75 хувь нь «Ямар нэгэн зүйлийг өөр хүнээр хийлгэх шаардлага гарвал нарийн мэргэшсэн, гэхдээ танихгүй хүнийг хөлсөлснөөс хамаатан, найз нөхдөө хөлсөлсөн нь дээр» гэж судалгаанд оролцогчдын хариулсан нь хамгийн өндөр үзүүлэлт юм.⁸⁰

Монголчууд хүнийг үнэлж дүгнэх, нэр дэвшигчийг сонгохдоо удам угсааг ихээхэн харгалздаг. Тухайлбал, 2008 оны сонгуулийн кампанийн үеэр УБ хотод бидний хийсэн анкетын болон фокус бүлгийн ярилцлагын цуврал судалгаанаас улс төрийн намуудын нэр дэвшигчдийг сонгоход харгалзах хүчин зүйлсийн дотор эрэмбээрээ 6-рт гэр бүлийн хүмүүжил, удам угсаа орж байлаа. (Д.Бадамдаш нар 2008) Нийгэм дэх садан төрлийн хүчтэй хэлхээ холбоог улс төрийн намууд сонгуулийн кампанидаа олон янзаар ашигладаг. Тухайлбал, аль нэг улс төрч нас барсны дараа түүний залгамжлах хүнээр нь эхнэр, дүү, хүүхэд гэх мэт гэр бүлийн гишүүнийг тодруулж нөхөн сонгуульд нэр дэвшүүлдэг. Өөрөөр хэлбэл “улс төрийн үе залгамжлал” Монголд түгээмэл байна. 2008 оны сонгуульд нэр дэвшигчдийн нэлээд нь ямар нэг улс төрчийн хүү, дүү, гэр бүлийн хүн гэх мэт садан төрлийн холбоотнууд байлаа. Нэр дэвшигчдийн нэлээд нь сонгуулийн сурталчилгаандаа удам угсаа, аав ээжийн нэр хүндийг ашигласан. Жишээлбэл, “Аав нь төрийн зүтгэлтэн, ээж нь нэртэй дуучин, ах нь эх орон газар шорооныхоо төлөө цогтой тэмцэгч байсан тул энэ нэр дэвшигч тэдний үйл хэргийг үргэлжлүүлнэ” гэсэн мессеж сонгуулийн кампанийн үеэр олонтаа тараагдаж байлаа.

4. Үндсэрхэх үзэл. Коммунизмын үед хаан боогдож байсан үндэсний үзэл нь дэглэмийн уналтын дараа тэсрэлт гэмээр сэргэж нийгмийн бүхий л амьдралд хүчээ авч байна. Чингис хааны төрт ёсыг сэргээж хаант засаг бий болгохыг уриалагч нам, үндэсний үзлийг гол болгогч намууд бий болсон бөгөөд намуудын мөрийн хөтөлбөрт үндэсний соёл, уламжлалыг сэргээх явдал чухалд тавигдаж байна. Мөн улс төрийн намууд сөрөг сурталчилгаанд үндэсний үзлийг ашиглах болов.

Нэр дэвшигчийн гарал угсаанд олны анхаарлыг хандуулах, үндсэрхэх үзэл, эх оронч байдлыг нь өдөөх маягаар манипуляци бүхий мэдээлэл тараах явдал сонгуулийн кампанийн үеэр байнга гардаг нь 2008 оны сонгуульд ч мөн давтагдлаа. Энэ байдал эрх баригч МАХН-ын сөрөг сурталчилгаанд илүүтэй ажиглагддаг. Монголчууд түүхэндээ өмнөд хөрш Хятад улстай удаа дараа дайтаж ирсэн тул хүмүүсийн нэлээд нь хятад гаралтай хүнд төдий л таагүй ханддаг. Энэхүү хандлагыг улс төрийн намууд тэр дундаа эрх баригч МАХН өрсөлдөгч намуудын эсрэг сөрөг сурталчилгаандаа түлхүү хэрэглэдэг юм. Өрсөлдөгч намын нэр дэвшигчдийг “хятадын эрлийз”, эсвэл Хятадаас санхүүждэг хэмээсэн сурталчилгааг сонин хэвлэл, ухуулгын материал, ам дамжсан яриа ашиглан тараах явдал сонгууль бүрт гарч байна. Тухайлбал, 2008 оны УИХ-ын сонгуулийн 21-р тойрогт АН-аас нэр дэвшигч Лу.Болдыг Хятадаас санхүүждэг гэсэн тараах материалыг өрсөлдөгчдийн зүгээс айл өрхөд тараасан. (Д.Бадамдаш нар 2008) Олны анхаарлыг нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр, байр суурь гэсэн гол асуудлаас хөндийрүүлж үндэс угсаагаа дээдлэх, ижилсэн нэгдэх мэдрэмж дээр «тоглол» өөр бусдыг үзэн ядах сэтгэгдэл төрүүлэх зорилготой дээрх ухуулга сурталчилгаа нь нэг талаас манипуляци, нөгөө талаас ардчиллын эсрэг шинж бүхий үйл ажиллагаа юм.

5. Шашин. Коммунизмын дараах жилүүдэд Монголд хүчтэй сэргэж улс төрийн үйл явцад нөлөөлж буй нэгэн үзэгдэл нь шашин юм. Монгол улсын үндсэн хуулийн 9.1-д шашин төрийг заагласан байдаг ч сүүлийн жилүүдэд улс төрийн зорилгоор шашныг ашиглах явдал олширлоо. Шашин шүтлэг бол хүмүүсийн итгэл үнэмшлийн хамгийн хүчтэй хэлбэр, зан үйлийг чиглүүлэгч гол хүчин зүйлийн нэг билээ. Улс төрчид зан үйлийн иймэрхүү хэлбэрүүдийг олны таашаалыг хүлээх, сонгогчидтой ойр дотно харилцаа тогтоох зорилгоор хэрэглэж байна. Хэдийгээр парламентын сонгуулийн хуулийн 37.12-т сонгуулийн сурталчилгаанд шашны зан үйлийг ашиглахыг хориглосон боловч 2008 оны сонгуулийн кампаниас үзэхэд нэр дэвшигчид сонгуулийн сурталчилгаандаа шашны зан үйлийг хэрэглэх нь түгээмэл байлаа. Сурталчилгааны албан ёсны хугацаа эхлэх хүртэлх хугацаанд нэр дэвшигчид тойрог дахь уул овоог тахиx, ном уншуулах гэх мэтээр шашны ёслол зохион байгуулах, шашны баяр, арга хэмжээнүүдэд оролцох явдал байнга гарч байв. Мөн нэр дэвшигчид Далай лам гэх мэт шашны томоохон зүтгэлтнүүдтэй хамт авахуулсан зураг, календарь, шашны уншлага бүхий ном материал айллуудаар тараах явдал түгээмэл байлаа.

Эцэст дүгнэхэд сонгогчдын боловсролыг дээшлүүлэхийн тулд улс төрийн мэдээлэл хийх сургалт, семинар явуулах хэрэгтэй. Улс төрийн манипуляци хийхэд шинжлж ухааны үндэслэлтэй байх ёстой. Тухайлбал, тоо баримт цуглуулах гэх мэт. Улс төрчид төрийн байгууламжид улс төрийн манипуляци хийхдээ эрдэмтэн, мэргэдийн сургааль үгийг хэлж жишээ татаж байх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, монгол

⁸⁰УТБА “Шинэ толь” сэтгүүл.УБ.,2005. 87 тал

улсын засаг бол эрдэмтэн докторын үгсийг их иш татаж байх, учир нь гэвэл ард түмэн эрдэмтэй, ухаантай хүнийг үгийг их тусгаж ойлгогдог.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Баяраа С., Болдбаатар Б. “Сонгуулийн компанийн зохион байгуулалт стратеги” УБ.,2003
2. Мөнхцэцэг Ц. “Сонгуулийн компанийн коммуникаци” диссертацийн ажил УБ.,2009
3. Мөнхцэцэг Ц. “Политайнмент буюу цэнгээнт улс төр” УБ.,2010
4. “Монгол дахь сонгуулийн үйл явц: онол, практик” эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл “Ц.Мөнхцэцэг, Г.Цогтбаатар, Д.Бадамдаш “Монголын сонгуулийн компанийн хэв маяг, улс төрийн намуудын сонгуулийн стратеги” УБ., 2009
5. Туяачимэг Т. “Сонгуулийн кампани хичээл” лекцүүд УБ.,2012

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХАМРАГДАЛТ

Т. Батчимэг /Магистр/
ХИС, НХУС, НББ-ийн тэнхим
khongor2014@yahoo.com

Түлхүүр үгс: нийгмийн даатгал, сайн дурын даатгал, даатгуулагч, ажил олгогч

Товч агуулга: Нийгмийн даатгал нь хүмүүсийн амьдрах чадавхи эрсдэлийг оновчтой зөв тодорхойлж, түүнээс урьдчилан хамгаалах, нэгэнт эрсдэлд өртсөн тохиолдолд үр дагаврыг нь багасгаж арилгах, амьдралынх нь баталгааг хангахад чиглэсэн төрөөс хэрэгжүүлж байгаа бодлогын нэг хэсэг юм.

Энэхүү сэдвээр манай улсын нийгмийн даатгалын хамрагдалтын байдал өнөөдөр ямар түвшинд хүрсэн, нийгмийн хамгаалалд эдийн засгийн идэвхтэй хүн амын хичнээн хувь нь хамрагдах хүсэлтэй байгаа, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төр хариуцах иргэдийн тоо нь нийт хүн амын хичнээн хувийг эзэлж байгаа зэргийг 2008-2011 оны мэдээлэлд үндэслэл харуулахыг зорилоо.

Үндсэн агуулга: Нийгмийн даатгалын хамрагдалт нь нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэлтэнд чухал байр суурь эзэлдэг. Мөн даатгалын хэлбэрээс хамрах хүрээ, даатгуулагчдын тоо хамаарч байдаг.

Даатгалын хамрах хүрээ гэдэгт хүн амын шимтгэл төлөх хэсгийг хамруулан ойлгож, хуульчилж батлаж, мөрдөж байгаа нь иргэдийн нийгмийн хамгааллын асуудлыг нэг талдаа орхигдуулахад хүрдэг.

Нийгмийн даатгал нь дараах 2 хэлбэрээр даатгуулж болдог.

- Заавал даатгуулах
- Сайн дураар даатгуулах

Заавал даатгуулах хэлбэрт хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчид, төр, захиргааны ажилтнууд ихэвчлэн хамрагдах бөгөөд санг бүрдүүлэхэд даатгуулагчаас гадна ажил олгогч оролцож, төр хяналт тавих, санг эрсдлээс хамгаалах үүргийг гүйцэтгэдэг [5.тал.18].

Ажил олгогч даатгалын харилцаанд оролцсноор ажиллагсдын нийгмийн хамгааллын баталгаа бэхжих, ирээдүйд хуримтлуулах хөрөнгийн хэмжээ нэмэгдэж, эрсдлийг сааруулах хүчин зүйл сайжирдаг. Нөгөө талаар даатгуулагчийн тоо өсөж, нэг даатгуулагчид ногдох шимтгэлийн хэмжээ багасавч, олгогдох тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ нэмэгдэх бололцоотой болдог ороо нийгмийн эдийн засгийн ач холбогдолтой.

Сайн дурын даатгал нь сайн дураар, өөрсдийн санаачлагаар, нийгмийн даатгалд хамрагдах нь даатгалын төрлийг сонгох, тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг тогтоох, хугацааг тохиролцох нь эрх чөлөөтэй боловч өөрсдийнхөө төлөө өөрсдөө шимтгэл төлж хуримтлал бий болгодог онцлогтой[5.тал.93].

Энэ нь сайн дурын даатгалын санг бүрдүүлэхэд гагцхүү даатгуулагч л өөрийнхөө төлөө оролцох бөгөөд ажил олгогчийн хувь нэмэр гэсэн ойлголт байхгүй юм. Сайн дурын даатгалд ихэвчлэн компани, хоршоо, пүүсийн эзэд, бие даасан уран бүтээлчид, албан бус секторт ажиллагчид хамрагдах бололцоотой боловч тэд өөрсдийн төлөө анхаарал тавьдаггүйгээс олон жил нийгмийн хамгааллын системийн гадна явж ирсэн. Харин сүүлийн жилүүдэд нийгмийн хамгааллын гадна байсан хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус секторт ажиллагчид, цалин хөлс авдаггүй ч орлого олдог хүмүүс нийгмийн хамгааллын тогтолцоонд хамрагдах, өөрийн хүсэлтээр даатгалд хандах нь нэмэгдэж байна.

Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг хуримтлуулахад оролцогч талуудаас нэмэрлэх хөрөнгийн хэмжээг “нийгмийн даатгалын шимтгэл” гэж ихэнх оронд нэрлэдэг.

Заавал даатгуулах даатгалын шимтгэлийн хэмжээ

Төрөл	Даатгуулагч	Ажил олгогчоос
Тэтгэврийн	7	7
Эрүүл мэндийн	2	2
Тэтгэмжийн	0.5	0.5
Ажилгүйдлийн	0.5	0.5
ҮОМШӨвчний		1-3
Дүн	10	11-13

Сайн дурын даатгалын шимтгэлийн хэмжээ

- Тэтгэврийн даатгал -10%
- Тэтгэмжийн даатгал-1%
- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал-1%-аар тус тус даатгуулна.[Монгол улсын “Нийгмийн даатгалын тухай хууль”.УБ.1994 он.]

Энэ нь сайн дурын даатгалд хамрагдах иргэн өөрийн “орлого”-ын 12 хувьтай тэнцэх шимтгэлийг өөрөө төлж санг бүрдүүлэхэд оролцдог. Сайн дураар даатгуулагч өөрсдөө “орлогоо” тодорхойлох ёстой боловч ихэвчлэн хуульд заагдсан доод хэмжээ болох хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр даатгуулах нь элбэг. Ингэснээр тэдний даатгалын сангаас хүртэх тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ хамгийн багаар тогтоогдоно.

Судалгааны хэсэг: Энэхүү судалгааг 2008-2011 оны Нийгмийн даатгалын статистик мэдээлэлд үндэслэн хийсэн билээ. Үүнд

1. **Нийгмийн даатгалын хамрадалт**

2011 онд өмнөх оныхоос нийгмийн даатгалд заавал даатгуулагчийн тоо 72.7 мянган хүнээр, сайн дурын даатгуулагчийн тоо 13.3 мянган хүнээр нэмэгдэж, нийт даатгуулагч нь эдийн засгийн идэвхтэй хүн амын 61 орчим хувьтай тэнцэж байна.


Мөн 2009 оныг 2008 оныхтой харьцуулахад сайн дурын даатгуулагчийн тоо 10.9 мянгаар буурсан. Энэ нь 2008 оноос өмнө сайн дурын даатгуулагчид нь даатгуулах төрлөө тусгайлан сонгож даатгуулдаг байсан бөгөөд ихэвчлэн тэтгэврийн даатгалын төрлийг сонгодог байсан.

2009 оноос хойш төрөл тус бүрд нь буюу 12%-аар даатгуулах болсонтой холбоотойгоор сайн дурын даатгуулагчдын тоо буурсан гэж үзэж болно.

Хүснэгт 1. Монгол улсын нийгмийн даатгалын хамрадалт ба эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо

	2008	2009	2010	2011
Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо /мянхүн/	1071,5	1137,9	1147,1	1124,7
Ажил олгогчдын тоо	19,781	21,287	23,299	26,803
Нийт даатгуулагчдын тоо /мянхүн/	2,296.2	2,174.4	2,331.3	2,874.8
Заавал даатгуулагчдын тоо /мянхүн/	484.6	492.2	526.7	604.8
Сайн дурын даатгуулагчдын тоо /мянхүн/	62.6	51.7	63.7	81.6

Зураг 1. Эдийн засгийн идэвхтэй хүн ам ба даатгуулагчдын тоо



Нийгмийн даатгалын хамрадалт сүүлийн жилүүдэд өсч байгаа хэдий ч нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөж, сангийн орлогыг нэмэгдүүлэх боломж, арга замууд байсаар байна. Үүнд:

- ✓ Нийгмийн даатгалд бүртгүүлээгүй ажил олгогчдыг илрүүлэх, татварын албатай хамтран ажиллах
- ✓ Хувиараа бизнес эрхлэгчид болон малчдыг сайн дурын даатгалд хамрадалтыг нэмэгдүүлэх, сайн дурын даатгалын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах ажлыг эрчимжүүлэх
- ✓ Гадаад улс оронд ажиллаж байгаа иргэдийг тэтгэврийн даатгалд хамруулах

2. Нийгмийн даатгалд шимтгэл төлөгч ажил олгогчид


2011 оны нийт ажил олгогчдын тоо нь 2008 оноос 35.4%, 2009 оноос 26%, 2010 оноос 15%-иар тус тус өссөн үзүүлэлтэй байгаа бөгөөд энэ нь ажил олгогчдын төлөх шимтгэлийн хэмжээг бууруулсантай холбоотой гэж үзэж болно.

Өмнөх жилүүдэд ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээ хэт өндөр /19-21%/ байсан нь ажил олгогчдод ажлын байр нэмэгдүүлэх сонирхлыг хязгаарлаж, хөдөлмөр эрхлэгчдэд дотоод хуримтлал бий болгох бололцоог хомсотгож, шинээр байгуулагдсан аж ахуйн нэгжийг өр төлбөрт оруулах нөхцлийг зарим талаараа бий болгож байсан.

Хүснэгт 2. Нийгмийн даатгалд шимтгэл төлөгч ажил олгогчдын тоо /хариуцлагын хэлбэрээр/

	2008	2009	2010	2011
Улсын үйлдвэрийн газар: Төрийн өмчийн аж ахуйн тооцоот	522	438	384	359
Орон нутгийн аж ахуйн тооцоот	204	196	204	188
Төсөвт байгууллага	4188	4279	4308	4368
Үүнээс: Цэрэг цагдаагийн	270	279	289	287
Хувьцаат компани: Төрийн	138	113	100	99
Хувийн	642	550	518	620
Хамтарсан	135	102	113	123
Хязгаарлагдмал хариуцлагатай компани: Төрийн	89	117	117	120
Хувийн	10022	11345	13100	15950
Гадаадын хөрөнгө оруулалттай	1402	1559	1589	1817
Хоршоо	333	353	384	428
Нөхөрлөл: Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай	402	389	390	407
Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай	267	280	292	299
Хувиараа эрхлэх аж ахуй	79	55	63	73
Төрийн бус олон нийтийн байгууллага	1358	1511	1737	1952
Бүгд	19781	21287	23299	26803

Зураг 2. Нийгмийн даатгалд шимтгэл төлөгч ажил олгогчдын тоо /бүс, аймаг, нийслэлээр/



3. Эрүүл мэндийн даатгалын хамрагдалт

Монгол улсын нийт хүн амыг 2003 оноос хойш эрүүл мэндийн даатгалд заавал хамруулах болсон нь тэдний нийгмийн хамгааллыг сайжруулах зорилготой байсан.

2011 онд нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөж, эрүүл мэндийн даатгалын хамралтыг анх удаа 98.6 хувьд хүргэж нэмэгдүүлсэн.

2010 онд нийт хүн амын 47.3%, 2011 онд 48.2%-ийнхан нь эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төр хариуцсан байна.

Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төр хариуцах иргэдийн тоо жил ирэх тутам өсч байгаа нь нэг талаас хүн амын өсөлттэй нягт уялдаа холбоотой бөгөөд 2011 оны байдлаар өсвөр насныхан болон тэтгэврийнхэн нийт хүн амын 44.5%-ийг эзэлж байна.


Хүснэгт 3. Эрүүл мэндийн даатгалд хамрагдагсдын тоо



Хүснэгт 4. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төр хариуцах иргэдийн тоо /даатгуулагчийн төрлөөр/

	2008	2009	2010	2011
Бүгд	1353,1	1235,0	1306,5	1354,0
16 /ЕБСургуульд суралцаж байгаа бол 18/ хүртэлх насны хүүхэд	955,6	858,2	909,0	935,1
Тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэд	285,6	282,4	202,9	226,8
Хүүхдээ 2 /ихэр бол 3/ нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх /эцэг/	66,5	65,1	86,9	88,2
Нийгмийн халамжийн тухай хуулийн 12-р зүйлд заасан иргэн/ тахир дутуугийн I, II зэрэгтэй/	29,9	21,6	100,8	97,7
Хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч	15,5	7,8	6,9	6,2
Нийт хүн ам	2666,0	2716,3	2761,0	2811,6

Зураг 3. Нийт хүн ам ба өсвөр нас, тэтгэврийнхний тоо



Resume

Coverage of social insurance is important factor for gathering income of social insurance fund. Followings are opportunities that will raise level of social insurance coverage:

- To implement proper policy toward non- official workers, agricultural workers, and low income households.
- To enhance coverage of retirement insurance of people who live abroad.
- To disclose employers that didn't subscribe to social insurance and to cooperate with department of taxation.

About 61 percent of labor force has gotten involved of social insurance. Remainders didn't get involved social insurance because of their income. To consider problems of people who didn't get involved social insurance.

НОМ ЗҮЙ

1. “Нийгмийн даатгалын түүхэн замнал” УБ., 2012
2. “Нийгмийн даатгалын статистикийн эмхэтгэл” УБ., 2012
3. “Нийгмийн даатгалын холбогдолтой эрх зүйн актын эмхэтгэл” УБ., 2012
4. “Монгол улсын статистикийн эмхэтгэл” УБ., 2011
5. Эрдэнэ С., Давгадорж Ч. –“Нийгмийн даатгалын эдийн засаг ба шинэчлэлийн асуудлууд” УБ., 2007.-7
6. www.ndaatgal.mn

НИЙГМИЙН ОРОЛЦОО НЬ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨГЖИЛД НӨЛӨӨЛӨХ НЬ

Г. Гэрэлсүрэн
ХИС, НХУС
НББ-ийн тэнхимийн багш, магистр

Үндэслэл: “Эмэгтэйчүүд нь эрчтэй, хүчтэй, идэвхитэй байна гэдэг нь ардчилал амжилттай хөгжиж байгаа улс гэсэн үг”-ээр энэхүү илтгэлээ эхэлж буйдаа баяртай байна. 2013 оны эхний сарын байдлаар манай улсын нийт хүн амын 51 хувь, ажиллах хүчний 49 хувь, их, дээд сургууль төгсөгчдийн 51 хувь, мэргэжлийн болон техникийн албанд ажиллагчдын 58 хувь, багш нарын 79 хувь, эрүүл мэндийн салбарт ажиллагчдын 82 хувь нь эмэгтэйчүүд байна. Эмэгтэйчүүд бол улс орны, өрх гэрийн тулгуур нэг багана төдийгүй ирээдүйн Монгол иргэний, Монгол гэр бүлийн, Монгол улсын хөгжил дэвшилд хүрэх нөр их хариуцлага, үүргийг онцсайн биелүүлж яваа эрхэм хүмүүс билээ.

Иймд эмэгтэйчүүдийнхээ хөгжлийг дэмжиж нийгмийн харилцаанд эрх тэгш оролцуулах, нөгөө талаасаа эмэгтэйчүүдийн нийгэм дэх оролцоог сайжруулснаар хөгжлийн үзүүлтийг сайжруулах нь зүйтэй юм. Эдгээрт тулгамдаж буй олон хүчин зүйлээс тодорхой бүлгийг энэхүү илтгэлийнхээ хүрээнд судлахыг зорьлоо.

Ямарваа нэгэн зүйлийн хөгжлийг тооцохдоо тодорхой шалгуур баримтлан индексчлэн тооцдог. Үүний нэг жишээ бол хүний хөгжлийг тооцсон үзүүлэлт юм. Тухайн орны хүний хөгжлийг дэлхийн бусад улс оронтой харьцуулахын тулд Хүний хөгжлийн индексийг ашигладаг(ХХИ). Дараах 3 үзүүлэлтээр хэмждэг. Үүнд:

- Наслалт: Төрөлтөөс тооцсон дундаж наслалтаар
- Мэдлэг: Насанд хүрэгчдийн бичиг үсэг тайлагдалт
- Амьжиргааны түвшин: Нэг хүнд ногдох ДНБ
- Жендерийн хөгжлийн индекс: ХХИ-г хүйсээр ангилна
- Жендерийн эрх мэдлийн хэмжигдэхүүн: дараах 3 хүрээн дэх тэгш бус байдлыг авч үздэг.
 - Улс төрийн оролцоо ба шийдвэр гаргах эрх мэдэл: УИХ дахь эмэгтэйчүүдийн эзлэх жингээр
 - Эдийн засгийн оролцоо ба шийдвэр гаргах эрх мэдэл:
 - Эдийн засгийн эрх мэдэл: Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн орлогоор хэмжигдэнэ

Хүснэгт №1

Жендерийн хөгжлийн индексийн үзүүлэлтүүд (2000-2011)


	2000	2001	2002	2003	2004	2005
ХХИ	0.667	0.667	0.667	0.68	0.692	0.707
ЖХИ	0.667	0.666	0.667	0.679	0.693	0.707
ЖЭМХ	0.449	0.468	0.468	0.468	0.415	0.414

	2006	2007	2008	2009	2010	2011
ХХИ	0.725	0.731	0.745	0.75	0.756	0.769
ЖХИ	0.72	0.731	0.746	0.75	0.758	0.772
ЖЭМХ	0.423	0.425	0.4	0.393	0.391	0.4

Хүснэгт №1 –ээс бид дараахь дүгнэлтийг хийж болно. Хэдийгээр эмэгтэйчүүд хүн ам хагасаас илүү хувь, эдийн засгийн гол салбаруудад дийлэнх байр суурийг эзэлж байгаа хэдий ч эдгээр салбаруудынхаа шийдвэр гаргах түвшинд ажиллаж чадахгүй байгааг харуулж байна. Энэ нь цаагуураа мөн хөдөлмөрийн хөлсийг ч тодорхой хэмжээгээр илэрхийлж байгаа гэж үзэж болно.

2012 онд Жендерийн хөгжлийн индексийг 0.67 болгох зорилтыг дэвшүүлсэн байдаг.

График №1




Хүснэгт №2

УИХ-ын эмэгтэй гишүүдийн тоо (1996-2012)

1996	2000	2004	2008	2012
7	9	5	3	11

Хүснэгт №1-с харахад улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоо нь бага байгаа нь харагдаж байна.

График №2



2012 оны эцсийн байдлаар манай улсын хүн ам 2869521 бөгөөд үүний 51 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байна. Иймд эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт зайлшгүй үргэлж анхаарч, дэмжиж байх үндсэн асуудал юм. Улсын хэмжээгээр 35776 бүртгэлтэй ажилгүйчүүд байгаагийн 18766 буюу 52,45% нь эмэгтэйчүүд байна.

Хүснэгт №3

Бүртгэлтэй ажилгүй иргэн (боловсролын зэргээр)

Үзүүлэлт	Ажилгүй иргэн		Боловсролын түвшингээр							
	Нийт	Эм	Маг, док	Диплом, бакалавр	Тусгай мэргэжлийн дунд	Техникийн болон мэргэжлийн				
							Эм	Эм	Эм	Эм
Баруун бүс-Дүн	5511	2898	4	3	1292	914	220	115	279	147

Хангайн бүс-Дүн	8375	4227	19	14	1664	1147	290	140	324	148
Төвийн бүс-Дүн	5640	2976	9	6	1321	878	370	176	597	265
Зүүн бүс-Дүн	3439	1785	9	6	668	485	159	85	173	89
Улаанбаатар	12811	6880	107	79	4934	3271	950	464	918	384
Ховд	1720	797	1	0	267	187	47	20	67	34

Үзүүлэлт	Ажилгүй иргэн		Боловсролын түвшингээр							
	Нийт	Эм	Бүрэн дунд	Эм	Суурь	Эм	Бага	Эм	Боловсролгүй	Эм
Баруун бүс-Дүн	5511	2898	2343	1119	1009	452	315	127	49	21
Хангайн бүс-Дүн	8375	4227	3790	1826	1525	677	621	227	142	48
Төвийн бүс-Дүн	5640	2976	2020	1054	1044	492	205	85	74	20
Зүүн бүс-Дүн	3439	1785	1428	703	759	331	179	63	64	23
Улаанбаатар	12811	6880	4814	2256	849	352	173	56	66	18
Ховд	1720	797	908	367	353	160	70	26	7	3

Хүснэгт №3-с нас биед хүрсэн, үр хүүхдээ өсгөж байгаа эмэгтэйчүүд дотор бичиг үсэг бүрэн тайлагдаагүй эмэгтэйчүүд байна гэдэг нь маш харамсаар зүйл юм.

График №3

Шинээр ажилд орсон иргэд (бүсээр)




График №3-с харахад шинээр ажилд орогсдын дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь 50%-д хүрч чадахгүй байна.

Хүснэгт №4

Шинээр ажилд орсон иргэд (нийт дүн, эмэгтэй)

Улс	54,695	23,637
Ховд	999	314

Хүснэгт №4-с дүгнэхэд Ховд аймгийн хувьд шинээр ажилд орогсдын дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь бүсүүдийн дундаж түвшинд хүрч чадахгүй байна.

Хүснэгт №5

Өрх толгойлсон эмэгтэй (нийт дүн, эмэгтэй)

Нийт	3	5-с	6-с дээш
------	---	-----	----------

		хүртэлх		
Улс	81557	47 460	27 142	6955
Ховд	2367	27 142	810	328

Монгол 700 мянга гаруй өрх бүртгэгдсэнээстүүний 80 мянга гаруйг өрх толгойлсон эмэгтэйчүүд авч явж байна. Эдгээр эмэгтэйчүүдийн тэн хагас нь 5 буюу түүнээс дээш ам бүлтэй гэр бүлтэй өрх толгойлсон эмэгтэйчүүд байна.

Манай улсын дундаж наслалт 68.1, үүнээс эрэгтэй 64.9, эмэгтэй 72.3 байна. Манай орны хүн амын 43.4 хувь нь хөдөөд хагас суурин болон нүүдлийн хэвшлээр амьдарч байна.⁸¹ Хөдөөгийн эмэгтэйчүүдэд ажил эрхлэх хүсэл байвч төдийлөн ажлын байр олдоогүй. Тиймээс л цалин бага, үйлчилгээний салбарт ажиллах нь элбэг байдаг. Нөгөөтэйгүүр хөдөөгийн эмэгтэйчүүдийн 77 хувь нь мал маллан амьдарч байна. Тэгтэл малчин эмэгтэйчүүд хөдөө аж ахуйн салбарт голлох үүрэг гүйцэтгэж байгааг онцлох хүмүүс бий.

Тэд цалин өөрийн гэсэн орлого байхгүй, нийгмийн даатгалд хамрагдаж чаддаггүй зэрэг олон асуудал тулгарч байдаг.

Дүгнэлт

1. Манай улсын эмэгтэйчүүлийн хувьд нийгмийн оролцоонд эрх тэгш оролцох, цаашид хөгжих боломж нь дутмаг байна. Үүнийг бид хөдөлмөрийн зах зээлд эмэгтэйчүүдийн эзэлж буй хэмжээ, өрх толгойлсон эмэгтэйчүүлийн тооноос харж болно.
2. Эрэгтэйчүүдийн нийгэм, гэр бүлийн өмнө хүлээх хариуцлагыг нэмэгдүүлэх, боловсролын түвшинг дээшлүүлэх шаардлага ч тулгарч байна.
3. Шийдвэр гаргах түвшинд жендерийн тэгш байдлыг хангах
4. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагыг өргөжүүлж дэмжиснээр эмэгтэйчүүдэд хөгжих цаг бололцоог хангаж өгөх
5. Цөөн малтай өрх ялангуяа ганц бие болон өрх толгойлсон иргэд хамтран хоршоо байгуулах, хөдөлмөрөө хоршиход бүх талын туслалцаа үзүүлэх;
6. Хөдөөгийн эрэгтэй, эмэгтэйчүүд боловсрол, мэргэжлийн түвшингээ дээшлүүлэн хөгжих, мэдээлэл авах орчинг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлснээр дараахь үр дүнд хүрнэ;
7. Хөдөөгийн эмэгтэйчүүлийн ажил хөдөлмөрийн онцлог, ажлын ачаалал нь тэдгээр эмэгтэйчүүд нийгмийн хөгжлөс хоцроож байна. Хэдийгээр нүүдлийн уламжлалт соёлоо хадгалж үлдэх нь зүйтэй боловч хүний хөдөлмөрийг хөнгөвчлөх, эдийн засгийн гол сегментийг бүрдүүлж буй салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тодорхой болгох, хөдөөгийн эмэгтэйчүүдэд хөгжих нөөц, боломжийг нь бүрдүүлэх нь зүйтэй юм.
8. Хэдийгээр эмэгтэйчүүлийн дундаж наслалт эрэгтэй хүнийхтэй харьцуулахад өндөр байгаа хэдий ч тэдний авч буй дундаж тэтгэврийн хэмжээ бага байна.
9. Хөдөө, тэр тусмаа алслагдмал аймгийн эмэгтэйчүүлийн хөгжил, эрүүл мэндийн үйлчилгээнд онцгой анхаарах нь зүйтэй.
10. Эмэгтэйчүүлийн нийгмийн харилцаанд харилцах боомж, цаг зав, нөөц, эрхзүйн орчны дэмжлэгийг нэмэгдүүлсний үндсэн дээр хөгжлийн асуудал бүрэн утгаараа хэрэгжинэ. Товчхоноор бол хөгжих боломжийг нь нийгмийн оролцоогоор дамжуулан бүрдүүлэх нь зүйтэй юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

Ном, сурах бичиг, зөвлөмж

1. Үндэсний статистикийн хороо “Сарын бллютень” (2006-2012 II улирал)
2. Статистикийн эмхтгэл, тайлангууд
Жижиг дунд үйлдвэрлэлийн тухай хууль батлагдан хууль эрх зүйн орчин бүрдсэний зэрэгцээ ЖДҮ-ийг дэмжих зорилгоор хэрэгжүүлэх зээлийг олгох зорилгоор Монгол шуудан, Зоос, Хас банкуудтай гэрээ байгуулан, Үйлдвэрлэл худалдааны сайдын 2006 оны 198 тоот, 2007 оны 140 тоот тушаалаар төсөл шалгаруулах комисс, хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүн болон комиссыг ажиллах журмын баталсанаар 2006-2007 онд 110 төсөлд 2603.9 сая төгрөгийн зээл олгосон байна [3].

Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор улсын төсвөөс 2009 онд 30.8 тэрбум төгрөг, 2010 онд 29.6 тэрбум төгрөг, 2011 онд Засгийн газраас 280.0 тэрбум төгрөгийн бонд гаргаснаас 150.0 тэрбум төгрөгийг нь жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөнгөлөлттэй зээлд зарцуулсан байна [4].

Үйлдвэр худалдааны сайдын /хуучнаар/ 2008 оны 10, 158, 222 дугаар тушаалуудаар Улаанбаатар хотын Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэг, Говь-Алтай, Завхан, Дархан-Уул аймгуудад “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв”-үүдийг улсын төсөвт үйлдвэрийн газрын статустайгаар байгуулагдсан байна.

Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвүүдийг Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу байгуулаагүйгээс хөрөнгө, санхүүжилт дутагдаж, үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломжгүйгээс жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг зах зээлд бие даан ажиллах чадвартай аж ахуйн нэгж болгон төлөвшүүлэх, тэдний үйл ажиллагаа, үйлдвэр үйлчилгээгээ өргөжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд бодитой хувь нэмэр оруулж чадахгүй байна. Цаашид төвүүдийг хуулийн дагуу байгуулж, хөрөнгө санхүүжилтээр дэмжиж, өргөжүүлэх талаар анхаарч ажиллах шаардлагатай байна [5].

Орон нутагт 17547 аж ахуйн нэгж албан ёсны бүртгэлтэй байгаагаас 13496 аж ахуйн нэгж тогтвортой үйл ажиллагаа явуулж байна.

Жижиг, дунд үйлдвэрийн байршлын хувьд авч үзвэл нийт аж ахуйн нэгжийн 70 гаруй хувь нь Улаанбаатар, Дархан, Эрдэнэт зэрэг хот суурин газарт үйл ажиллагаа явуулдаг гэсэн тоо байгаа бөгөөд орон нутагт жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх боломж нөхцлийг бүрдүүлэхэд анхаарах хэрэгтэй байна. Монголын жижиг дунд үйлдвэрийн хөгжлийн чиг хандлага нь дараах байдлаар тодорхойлогдож байна.

Үүнд:

- Үйлдвэрлэл, Технологийн паркийг дагасан жижиг, дунд үйлдвэрүүд бий болгох
- Эрчимжисэн мал ахуй буюу Фермерийн аж ахуй бий болгох
- Том үйлдвэрүүдийн бүтээгдэхүүний эд ангийг үйлдвэрлэгч, түүхий эдийн бэлтгэн нийлүүлэгч, хангагч аж ахуйн нэгжүүд бий болгох

Өрхийн үйлдвэрлэлд суурилсан бичил үйлдвэрлэл жижиг дунд үйлдвэр эрчимтэй хөгжсөн олон улсын практикаас харахад аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаагаа явуулахдаа хорших, хамтарч түүхий эдээ бэлтгэх, хамтарч зах зээлд гарах зэрэг үзэгдэл түгээмэл байдаг. Мөн түүнчлэн том аж ахуйн нэгжийг дагасан тэдний сэлбэг хэрэгслэлийг үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгч эсвэл бэлтгэгч зэрэг үүргийг гүйцэтгэх нь эдийн засгийн хувьд хурдан хөгжих боломжийг олгодог байна.

2. Баруун бүсийн эдийн засагт жижиг дунд үйлдвэрлэлийн гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх боломж

2.1 Баруун бүсийн нийгэм эдийн засгийн ерөнхий мэдээлэл

Газар нутаг: Баруун бүс нь засаг захиргааны 5 аймаг, 91 сум, 466 багтайгаар төрийн болон хувийн хэвшлийн үйл ажиллагаа явуулж байна. Бүсийн дүнгээр 415,3 мянган км² нутаг дэвсгэртэй, 1км² нутагт 0,86 хүн ноогдож байгаа нь улсын дунджаас 0,91 хүнээр, хангайн бүсээс 0,51 хүнээр, төвийн бүсээс 0,10 хүнээр сийрэг нягтралтай байгаа ба зүүн бүсээс 0,20 хүнээр нягтралтай байна.


Хүн ам: Баруун бүсийн дүнгээр нийт 95,6 мянган өрхийн 361,0 мянган хүн ам амьдарч байгаа нь олонхи оноогоо 1,3% өгсөн байна. Баруун бүсийн нийт хүн амын 25%-ийг Баян-Өлгий аймаг, 14,8%-ийг Говь-Алтай аймаг, 17,8%-ийг Завхан аймаг, 20,4%-ийг Увс аймаг, 22%-ийг Ховд аймаг тус тус эзэлж байна.

Төсвийн орлого зардал: Баруун бүс нь хийт 50 тэрбум 90,6 сая төгрөгийн орон нутгийн төсвийн орлого төвлөрүүлж, 50 тэрбум 864,0 сая төгрөгийн төсвийн зарлагт хүрч, улсын төсвийн 16 тэрбум 799,4 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авсан байна.

Аж үйлдвэржилт, дотоодын нийт бүтээгдэхүүн: Баруун бүсийн аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл нь 2012 оны байдлаар 32 тэрбум 674,4 сая төгрөг болж өнгөрсөн оноосоо 6%-р буюу 2 тэрбум 80,6 сая төгрөгөөр буурсан ба 2009 оноос 30,6 %-р буюу 21 тэрбум 342 сая төгрөгөөр өссөн дүнтэй байна. Улс болон бусад бүсүүдтэй харцуулан авч үзвэл: Улсын хэмжээний аж үйлдвэрийн 0,53%-ийг эзлэж байгаа бөгөөд хангайн бүсээс 39,7 дахин, төвийн бүсээс 31,2 дахин, зүүн бүсээс 4,9 дахин бага байгаа нь баруун бүсийн аж үйлдвэржилтийг нэмэгдүүлж, тэр дундаас жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих нь зайлшгүй чухал болоод байна. 2012 оны эцсийн байдлаарх баруун бүсийн нийт аж үйлдвэрлэгчид аймаг бүрийн эзэлж байгаа хувь хэмжээг авч үзвэл Баян-Өлгий аймаг 3,2% -ийг Говь-Алтай 19,2%-ийг, Завхан аймаг 17,9%-ийг, Увс аймаг 26,6%-ийг, Ховд аймаг 13,1%-ийг тус тус эзэлж байна. 2012 оны байдлаар улсын хэмжээний дотоодын нийт бүтээгдэхүүний 4,9 хувийг баруун бүс эзлэж байна. Харин баруун бүсийн дотоодын нийт бүтээгдэхүүний 4,9 хувийг аж үйлдвэржилт эзлэж байгаа нь жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зайлшгүй болохын бататгаж байна.

2.2 Жижиг дунд үйлдвэрлэлийн зээлийн бодлогоор дэмжих нь

Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжиж буй байгуулагууд (аймгуудаар)



Улсын нийт иргэд, жижиг, дунд үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгжид олгосон зээл

Хүснэгт-1 /мянган төгрөгөөр/

Зээл	2012 II улирал	Зээлдэгчдийн тоо	2013 II улирал	Зээлдэгчдийн тоо	Зээлийн өсөлтийн хувь	Зээлдэгчийн өсөлтийн хувь
1. Иргэдийн зээл	2,756,420,829.00	608,357.00	3,783,137,698.70	664,853.00	37.2	9.29
1.1. Ипотекийн зээл	802,764,944.40	29,081.00	1,108,872,977.60	33,622.00	38.1	15.62
1.2. Жижиг, дунд үйлдвэрийн зээл	635,227,363.70	57,106.00	760,174,361.70	50,069.00	19.7	-12.32
1.3. Хэрэглээний зээл	179,027,582.80	105,657.00	194,379,270.60	96,081.00	8.6	-9.06
1.4. Цалингийн зээл	629,012,975.60	172,408.00	1,019,374,846.20	218,194.00	62.1	26.56
1.5. Тэтгэврийн зээл	141,549,084.10	145,858.00	243,293,536.80	160,715.00	71.9	10.19
1.6. Бусад	368,838,878.40	98,247.00	457,042,705.70	106,172.00	23.9	8.07
2. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч ААН-д олгосон зээл	549,853,164.70	3,528.00	777,597,572.70	3,676.00	41.4	4.20

Эх сурвалж: Mongolbank.mn

Өмнөх онтой харьцуулахад иргэдийн зээлийн хэмжээ өссөн боловч жижиг дунд үйлдвэр эрхлэгч иргэдийн тоо буурсан харин Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч ААН-д олгосон зээлийн хэмжээ болон зээлдэгчдийн тоо бага зэрэг өсөлттэй байна.

Хамгийн олон салбартай орон нутагт үйл ажиллагаа явуулж буй банкуудын санал болгож буй бизнесийн зээл

Хүснэгт-2

Дд	Зээлийн төрөл	Банк	ХААН банк	Төрийн банк	ХАС банк	Дүн
1	<u>Хөрөнгө оруулалтын зээл</u>		+	+	-	2
2	<u>Бизнесийн зээл</u>		+	+	-	2
3	<u>Бизнесийн зээлийн шугам</u>		+	+	-	2
4	<u>Санхүүгийн түрээсийн зээл</u>		+	-	-	1
5	<u>Импортын зээл</u>		+	-	-	1
6	<u>Хөдөө аж ахуйн зээл</u>		+	-	-	1
7	<u>Төслийн зээл</u>		+	-	+	2
8	<u>Гэрээ барьцаалсан бизнесийн зээл</u>		-	+	-	1

9	<u>Бизнесийн эргэлтийн хөрөнгийн зээл</u>	-	+	-	1
10	<u>Хөдөөгийн агробизнесийг дэмжих хөтөлбөрийн зээл</u>	-	+	-	1
11	<u>Богино болон дунд хугацаатай зээл</u>	-	-	+	1
12	<u>Урт хугацаатай зээл</u>	-	-	+	1
13	<u>Барилгын зээл</u>	-	-	+	1
14	<u>Уулуурхайн зээл</u>	-	-	+	1
15	<u>Эко бизнесийн зээл</u>	-	-	+	1
16	<u>Дүн</u>	7	6	6	19

Салбар банкууд нь иргэдийн болон бизнесийн зээлүүдийг санал болгож байгаа хэдий ч банк болгон хэрэглээний буй худалаа үйлчилгээний зориулалттай зээлийг олгох сонирхолтой харин бизнес, үйлдвэрлэлийн зээлийг олгох сонирхолгүй нь харагдаж байна.

Бизнесийн зээл

Хүснэгт-3

Дд	Банк	Зориулалт	Хэмжээ	Хүү		Хугацаа
				₮	\$	
1	Хаан банк	Жижиг дунд бизнес эрхлэгч аж ахуйн нэгжийн бизнесийн эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор бараа материал худалдан авах болон бизнесийн үйл ажиллагааны ашиг орлогоо нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээний чанараа сайжруулах зориулалтаар олгогдоно.	Зээлийн дээд хэмжээг бизнесийн цар хүрээ, хөрөнгө, санхүүгийн чадвараас хамаарч уян хатан тогтооно.	2.2%-1.5%	1.8%-1.1%	24 сар хүртэл
2	Хадгаламж банк	Бичил бизнесийн эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэхэд зориулан зөвхөн хөдлөх хөрөнгө барьцаалан олгогдох зээл юм. Үл хөдлөх хөрөнгийн барьцаа шаарддаггүй тул бусад зээлийн бүтээгдэхүүнээс онцлогтой	100,000-5,000,000 хүртэл төгрөг	2.3%-1.8%	-	12 хүртэл сар

банк бүр анхлан бизнес эрхлэгчидэд олгохгүй, үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгчдэд маш богино хугацаатай өндөр хүүтэй зээл санал болгож байна.


Завхан аймгийн зээлдэгч аж ахуй нэгжүүдийн зээл авах боломжинд хийсэн шинжилгээ

Нийт судалгаанд оролцсон 568 ААН-с хамгийн Завхан аймагт мал эмнэлгийн үйлчилгээ-9,68% , газар тариалангын үйл ажиллагаа- 6,51%, хүнс барааны дэлгүүр, Анхан шатны боловсрол олгох үйл ажиллагаа тус бүр 5,63%, хадгаламж зээлийн үйл ажиллагаа 5,46%-г эзэлж байна.

Судалгаанд хамрагдсан аж ахуйн үйл ажиллагааны чиглэл

Судалгаандаа зээлтэй аж ахуйн тайлан баланс, үйл ажиллагааны чиглэлд нь судалгаа хийхэд дараах үр дүн гарч байна.

График:1



Эх сурвалж: аймгийн статистикийн эмхэтгэл

Дээрх судалгаанаас харахад банк санүүгийн байгууллагаас дэлгүүр, барилгын салбар харьцангуй зээл авдаг мөн эмнэлэг, дулаан үйлдвэрлэл, бараа үйлдвэрлэл, эмнэлэг, гадаад дотоод худалдаа, мод үржүүлэх үйлдвэрлэл, цагаан архи үйлдвэрлэл зэрэг нь зээл авдаг нь харагдаж байна.

Үнэлгээ=3,5*(Ашгаар хүү төлөх харьцаа) + 10,0 х(Түргэн хөрвөх чадварын харьцаа)-25,0*(Өрийн харьцаа)+1,3*(Бизнес эрхэлж байгаа хугацаа)

Энэ үзүүлэлт 40-өөс бага гарвал зээл авах боломжгүй, 40-50 бол зээлийн дундаж рисктэй, 50-аас дээш тохиолдолд зээл авах таатай нөхцөл байгааг тус тус харуулдаг [7]

Аж ахуй нэгжийн зээлжих чадварын үнэлгээ /энхний 10 ААН/Хувиар

Хүснэгт:4

д.д	ААН нэр	ашигаар хүү төлөх чадвар	Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа	өрийн харьцаа	ажилласан жил	үнэлгээ
1	САНМИН	3,56	7,60	0,00	6	96,2
2	Нутгийн үйлсХХК	2,13	5,78	0,54	4	57,0
3	Жавхланта тур	4,93	2,94	0,12	6	51,4
4	Дооно -ойгон	10,10	0,76	0,16	4	44,2
5	Арбет ХХК	8,04	0,40	0,28	14	43,5
6	Эрчим хүч	3,22	2,96	0,28	7	42,9
7	Нутаг элч ХХК	1,07	3,18	0,03	6	42,8
8	Тэсийн гол	1,44	3,38	0,24	6	40,6
9	Батдэлгэр ХХК	11,80	0,04	0,36	6	40,5
10	Алтан харш	1,11	2,46	0,06	6	34,7

Эх сурвалж: аж ахуй нэгжүүдийн тайлан

Дээрх судалгаанаас харахад орон нутгийн аж ахуй нэгжүүдийн хувьд зээлжих чадвар нь сул байна. Энэ нь хөдөө орон нутгийн аж ахуйн санхүүгийн чадвар сул бараа бүтээгдэхүүний борлуулалт муу.

2.3 Жижиг дунд үйлдвэрлэл нь бүс нутгийн эдийн засагт нөлөөлөх нөлөөлөл

Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх нь бага буурай, хөгжилтэй болон хөгжиж байгаа орнуудын хувьд эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх, ажилгүйдлийг, ядуурлыг бууруулахад ашигладаг стратегийн арга хэрэгсэл. Улс орны орлогын түвшнээс хамааран жижиг, дунд үйлдвэр, албан бус секторын эдийн засагт гүйцэтгэж буй үүрэг, ач холбогдол нилээд ялгаатай байна.

Нэг хүнд оногдох орлого өндөртэй улс орнуудын дотоодын нийт бүтээгдэхүүний 60 гаруй хувь, ажил эрхлэлтийн 50 орчим хувийг жижиг, дунд үйлдвэр бий болгодог бол орлогын хэмжээ бага улс орнуудын дотоодын нийт бүтээгдэхүүний 50 гаруй хувь, ажил эрхлэлтийн 50 орчим хувийг албан бус сектор бий болгодог байна. Албан бус секторын ач холбогдол эдийн засгийн хөгжлийг дагаад буурах хандлагатай, албан ёсны бүртгэлтэй жижиг, дунд үйлдвэрийн ач холбогдол өсөх хандлагатай байна.

Харин манай орны хувьд жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр төсөвт сүүлийн үед ихээхэн хөрөнгө тусгаж тэдгээрийг санхүүжүүлж байна. Тухайлбал сумын хөгжлийн санд сум бүрт 50 сая төгрөг байршуулж түүгээр хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа жижиг дунд үйлдвэрийг санхүүжүүлж байна. Зээлийн чанар 98%-тай байгаа бөгөөд ихэнх нь аж ахуйн нэгжүүд дахин санхүүжилт авахын тулд ихээхэн анхаарч байгаа юм. Энэхүү санхүүжилт нь арилжааны банкаар дамжин байршиж байгаа бөгөөд үр ашиг нь төдийлөн харагдахуйц байж чадахгүй байна

Жижиг дунд үйлдвэр нь зах зээлийн нөхцөлд өрсөлдөөнийг бий болгож, эдийн засгийн өсөлтийг хурдасгахад гол үүрэг гүйцэтгэдэг. Өрсөлдөөний явцад том үйлдвэрүүд болон өсөж дэвжих, дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвартай үйлдвэр болон өргөжих үндэс суурь болдог учраас жижиг дунд үйлдвэр нь эдийн засагт ихээхэн үүрэг гүйцэтгэдэг.

Жижиг үйлдвэр, үйлчилгээ нь улс орны нийгэм эдийн засгийн бүтцийг сайжруулж, дунд болон том үйлдвэрүүдийн үйл ажиллагааг нөхөх чадвартай, бага хэмжээний хөрөнгө оруулалтаар үүсгэн байгуулагддаг, зах зээлийн эрэлт хэрэгцээг соргогоор мэдэрч, үйл ажиллагааны чиглэлээ өөрчилж уян хатан ажиллах чадвартай, ажлын байр шинээр бий болгож хөдөлмөр эрхлэлтийг дээшлүүлэхэд чухал түлхэц болдог.

Жижиг дунд үйлдвэрүүд нь улс орны олон тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд тухайлбал хүн амын өргөн хэрэглээний барааны үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэх, аймаг сумын төвийг хөгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг сайжруулах, дэд бүтцийг хөгжүүлэх, шинэ бүтээгдэхүүн ажил үйлчилгээ бий болгоход ихээхэн үүрэгтэй байдаг.

Жижиг үйлдвэрлэл нь зах зээлийн тухайн байдал, өөрчлөлт зэргийг шуурхай мэдэрч, ингэснээрээ эдийн засгийн зайлшгүй уян хатан байдлыг бий болгодог. Жижиг компаниуд нь хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг хурдан мэдэрч энэ үндсэн дээр хэрэглэгчдийн зах зээлийн тэнцвэрт байдлыг хангах чадвартай байдаг.

Жижиг бизнесийн хөгжил нь олон чухал давуу талуудтай:

- Эдийн засгийн идэвхитэй хүн амын хэсэг өссөнөөр иргэдийн орлого нэмэгдэж, нийгмийн янз бүрийн хэсгүүдэд олгодог тэтгэлэг тэтгэвэр нэмэгдэнэ.
- Жижиг бизнес нь цаашид өргөжин томоохон бизнесийн үйл ажиллагаа явуулах үндэс суурь нь болж өгдөг.
- Бага хөрөнгө зардлаар нэн ялангуяа үйлчилгээний салбарт шинэ ажлын байр бий болдог.
- Улсын сектороос /салбараас/ чөлөөлөгдсөн түүнчлэн хүн амын нийгмийн эмзэг хэсгийнхэн, залуучууд, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт нэмэгддэг.
- Тодорхой мэргэжлийн ажилчдыг сургах замаар ажилчид ажлын байрандаа мэргэжил дээшлүүлдэг.
- Шинэ технологи болон технологийн зохион байгуулалтыг нэвтрүүлэх явдал эрчимждэг.
- Жижиг бизнесийг нэвтрүүлснээр зөвхөн том компаниуд төдийгүй орчин үеийн үйлдвэрлэлийн оюунжсан салбарууд хүртэл өргөждөг.
- Үйлдвэрлэгчдийн монополийг устгаж өрсөлдөөний орчинг бүрдүүлдэг.
- Эдийн засгийн төрөл бүрийн секторуудын хоорондын уялдаа холбоог нэмэгдүүлдэг

Иймээс жижиг дунд үйлдвэрлэл нь орон нутгийн хөгжилд ихээхэн түлхэц өгөх хөшүүрэг болох юм.

Үүний тулд баруун бүсийн хөгжилд жижиг дунд үйлдвэрлэлийн гүйцэтгэх үүрэг чухал юм гэж үзэн ямар салбарт жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, тулгарч буй бэрхшээл юу болох, даван гарах арга зам хэрхэн байгаа зэргийг тодорхойлж санал болгож байна.

Орон нутаг дахь аж ахуй нэгжүүдийн хувьд санхүүгийн эх үүсвэр харьцангуй дутмаг байдаг. Энэ эх үүсвэрээ банкны салбараас зээлж бүрдүүлдэг. Өнөөг хүртэл арилжааны банкууд жижиг, дунд үйлдвэрүүдэд зориулан тусгайлсан бүтээгдэхүүн гаргаагүй байгаа бөгөөд орон нутаг дахь банкуудын зээлийн нөхцөл нь хот сууринтай ижил байгаа нь жижиг дунд бизнес явуулахад бэрхшээл учруулж байна.

Орон нутаг дахь салбар банкууд нь худалдаа, үйлчилгээний салбарт зээл их олгож байна. Энэ нь бараа бүтээгдэхүүнийг дамжуулан зарах, үнийн хөөрөгдөл болох хэрэгсэл болж байна. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид банкнаас зээл авч чадахгүй байгаа гол шалтгаан нь барьцаа байхгүй байгаатай холбоотой гэдэг нь хийгдсэн судалгаануудаас харагдаж байна.

Орон нутгийн жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд учирч буй бэрхшээлүүд:

- Орон нутгийн зах зээлийн багтаамж бага, хүн амын худалдан авах чадвар сул байдал
- Эрчим хүчний үнэ өндөр, төвийн нэгдсэн сүлжээнд холбогдоогүйгээс эрчим хүчний үнэ хот, суурин газрынхаас өндөр байдал
- Зам, тээвэр сул хөгжснөөс орон нутгийн үйлдвэрүүд төвлөрсөн зах зээлд бүтээгдэхүүнээ нийлүүлэх боломж хомс байдал
- Холбоо эрчимтэй хөгжиж, техник, технологийн дэвшил гарч байгаа боловч мэдээлэл хангамжийн нэгдсэн тогтолцоо хараахан бүрдэж чадаагүй байдал
- Зээлийн хүү өндөр, хугацаа богино, санхүү, зээлийн үйлчилгээ, хөрөнгө оруулалтын хүрээ хязгаарлагдмал байдал
- Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа тогтворжоогүй, бие даах чадвар сул
- Үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн менежментийн түвшин зах зээлийн шаардлагад нийцэхгүй байна гэсэн судлаачдын тооцоолсон бэрхшээлээс гадна

Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн төслийг шалгаруулж банкны зээлд хамруулдаг комиссын гишүүд дараах байдлаар жижиг дунд үйлдвэрлэгчдэд тулгарч буй бэрхшээлийг тодорхойлсон байна. . [8]

Бизнес эрхлэгчдийн дутагдал

- Төсөл шаардлага хангадаггүй
- Тооцоо судалгаагаа дутуу хийдэг
- Зах зээл болон тоног төхөөрөмж, технологи судалдаггүй
- Бизнесийн төлөвлөгөөгөө өөрсдөө ойлгоогүй байх
- Давхар зээлтэй, бизнесийн туршлагагүй
- Баримт бичгийн бүрдүүлэлт дутуу байх

- Татварын ачаалал

Арилжааны банкны дутагдал

- Бизнес эрхлэгчдээс хэт их материал шаарддаг
- Барьцаа хөрөнгийг зах зээлийн үнэлгээнээс доогуур үнэлдэг
- Жижиг зээл судлах сонирхол бага болсон /2011 оноос хойш/
- Үл хөдлөх хөрөнгө, барьцааг хэт шүтсэн сэтгэлгээтэй
- Ирээдүйд орох орлого болон шинэ бизнесийг ойлгодоггүй

Төрийн байгууллагын дутагдал

- Үйлчилгээний шат дамжлага их үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, гааль, татвар гэх мэт
- Хэрэгжүүлэгч байгууллагын эрх үүрэг нь хязгаарлагдмал
- Аудит, мэргэжлийн хяналт, цагдаа, орон нутаг агентлагаас давхардсан хяналт шалгалт хийдэг

Иймд бүтээгдэхүүн үйлчилгээ бий болгож буй салбарыг дэмжих бодлого баримтлах оновчтой гарц юм. Иймд банкууд нь орон нутгийн онцлог тохирсон зээлийн бодлого (хот, орон нутгийн зээлийн хүү, барьцаа, хэмжээ хугацааг ялгавартай тогтоох) барьж Баруун бүсийн хэмжээнд Мал аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах жижиг дунд, үйлдвэр, Газар тариаланг дэмжсэн зээл олголтгоо нэмэгдүүлсэнээр орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулж нийгэмд гүйцэтгэх үүргээ өсгөх боломж байна. Тухайлбал: Цаашид судлаач эрдэмтдийн хийсэн судлагаанд үндэслэн техник эдийн засгийн нөхцлийг тооцоолон гаргасан дараах чиглэлээр буюу байгалийн нөөц, мал аж ахуйн гаралтай түүхий эдэд суурилсан жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжиж хөгжүүлэх нь баруун бүсийн эдийн засагт таатай уур амьсгалын бий болгоно гэж үзэж байна.

1. Жимс, жимсгэнэ боловсруулах үйлдвэрлэлийг бий болгох /чацаргана,аньс,үхрийн нүд, төмс хүнсний ногоо / [9]
2. Мах үйлдвэрлэл нь хүн амын хүнсний хэрэглээ, боловсруулах үйлдвэрлэлийн болон үйлчилгээний салбарын түүхий эдийн хэрэгцээг хангахад чиглэгдэнэ. [10]
3. 30 тонны хүчин чадалтай хуурай сүүний /хуурай сүүг тослогтой, тослоггүй, цөцгийн тос, аарц / 4.2 сая долларын өртөгтэй 9.5 жилд өртөгтөө бүрэн нөхөх 40 хүний байнгын ажлын байртай үйлдвэрлэлийг байгуулах [11]
4. Түүхий эдийн нөөцөд тулгуурласан үйлдвэрлэлийг бүсчлэн байгуулах хэрэгтэй юм.

Цаашид баримтлах бодлогын чиглэл

- Зээлийг тодорхой бодлогоор тэргүүлэх чиглэлд олгох;
- ЖДҮ-ийн зах зээлийг хамгаалах, импорт хязгаарлах бодлого баримтлах;
- Борлуулалтын сүлжээ бий болгох;
- Өндөр болон тэргүүний технологи нутагшуулах
- Импорт орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг чадавхижуулах

Ингэж чадсанаар Жижиг дунд үйлдвэрлэл нь хөгжлийн гарц буюу түлхүүр нь байж чадна

НОМ ЗҮЙ

1. МУ-ын Засгийн газрын “ Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр” 2005-2010 он
2. МУ-ын “ Жижиг дунд үйлдвэрлэлийн тухай” хуулийн 8.1 заалт
3. “Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих” хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний тайлан. УБ.,2008. 1-2 х
4. Ц.Оюунчулуун. Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн улсын зөвлөгөөний илтгэлээс. УБ.,2012
5. Ц.Оюунчулуун. Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн улсын зөвлөгөөний илтгэлээс. УБ.,2012
6. www.google.mn
7. Л.Жаргал, Ж. Бат-Өлзий. **Санхүүгийн менежмент**. III хэвлэл. УБ., 2000. – 322 х.
8. Хөдөлмөрийн яамны мэдээлэл
9. Г.Пүрэвсүрэн. Бүс нутгийн хөгжлийг хөрөнгө оруулалтаар дэмжих нь. Ph.D хамгаалсан нэг сэдэвт бүтээл, 2012, -128х
10. М.Эрдэнэчимэг. Баруун бүсийн мах махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх арга зам. Ph.D хамгаалсан нэг сэдэвт бүтээл. УБ., 2011. – 50 х
11. Н.Батнасан. Сүүний үйлдвэрлэлийг байгуулах техник эдийн засгийн үндэслэл судалгааны ажил

BRIEF SUMMARY OF DISSERTATION ON THE 'SOCIAL PHILOSOPHICAL ANALYZE OF CONTEMPORARY STATE OF BELIEF OF THE WEST REGION PEOPLE OF MONGOLIA.

Ts.Purevsuren (Ph.D)

Novelty and theoretical significance of the study

This study is to evaluate the philosophical significance from different perspectives among the people, religion, belief and their devotees, negative and positive aspects of their intellectuals in their social life. Most of their religious works are rationalized by the governmental, non governmental and other local organizations so this study reflects upon those areas.

Object of research work: *The research studies is mainly focussing only on the western region of Mongolia. The research title itself describes the objectives.*

During XX century, till ninties the social scientists have studied critically and historically the religious field with a specialized research object. Therefore it is obvious that history of religion and theory must have had taken as an aesthetic view. The study was done by definite sociological method in certain areas such as monistic point of view, religious expression, character and their thinking itself was completely influence by the method. Slowly it led to develop sociology of religion. The history and theory of Buddhism have also occupied an important position in Mongolia during this time. Therefore it has become one important source for the people to introduce buddhist culture even though it was impleted as dogmatism.

In this dissertation philosophy of religion and religious philosophy is mentioned.

The aim of the research work: The aim and focus of this research work is to study how religion has spread throughout the western region of Mongolia. Given the point from social philosophical perspectives by empirical method.

The following aims are implemented:

1. To make sketch map, also do sociological and field study on the religious belief of regional population.
2. Set the spread map and do tradional and non traditional religious record on religious aspect regionally;
3. Assess the political, social and cultural consequence of traditional and nontraditional religion in the region;
4. To express the reason of coexistence of different religions in the region.

The method and methodology of the research work: empirical research methods such as field study, observation and generalization, individualization, comparison, nonhierarchical principle and logical methods are used in this research work.

Novelty of the research work: Following ideas and conclusions are considered to be practically significant:

- The first scientific study to set the spread map and record of religious organizations and present population in western region of Mongolia.
- Paid attention to bring out features and consequence of changes in the religious view of different social groups and communities in the region from the sociological point of view.
- Formulated some evidences of philosophy of religion.

Practical significance and scientific trial of the research work:

I performed the following works in terms of research work:

1. Performer of the 2 projects, Russian Humanitarian Fund and Science and Technological fund of Ministry of Education Culture and Science.

2. Coordinator of the 2 projects funded from Khovd University

3. 6 papers presented for international scientific conferences.

:I have made the following conclusion for the research dissertation.

- there are different monist approaches on philosophy and social thinking of cause or effect of the social change and religious factor. But in this work, I adhered the methodology of social change and religious factor both can be either be cause or effect of each other depend on functional situation.

- There are different types of people living on different region following different religions.

Here types of living formulated as religious being in terms of philosophy.

- In this dissertation it is formulated that 'humankind is religious being'. The first, on the one hand, religion is knowledge, on the another hand it is method of acting, so it becomes general background for change and deterrence upon the life of region and the country. Secondly, religion has influence directly or indirectly to social life especially into cultural life. Third, it is only the religion that carries out the behaviour and actions of its followers or devotees.

Fourthly, people have feelings and capability to accept religion as their foremost without interfering the education and profession.

- I would not say that the formulation of 'humankind is religious being' in terms of main form of existence of life of humankind. Action of humankind is many sided and types of knowledge which express its sides such as scientific, ethical, aesthetical and philosophical sides.

- The concept of religious function express that the religion is the philosophical concept which is most significant action to social life. The concept of 'Function' is used as obligation or duty. Religion is the most significant action to social life.

Religion is dogm and function to solve the problem of this material world and other world.

- There are both positive and negative definitions for the religion. Some of them rejects religion and some are exalted. Actually, defining elements which are acceptable for any religious person is important to overcome extreme view. I followed this definition based on such methodology that is called as synthetic and integral definition. From this point of view, I defined that 'the religion is the complex of the theory and belief that expresses the supernatural power as saviour of population and people of the region.

- This article has considered the classification of religious knowledge based on various evidences. First of all, religious knowledge divided into ordinary knowledge and theoretical knowledge based on how it concern with devotees. Ordinary religious knowledge is individual spontaneous knowledge from the micro world. But the theoretical knowledge is gradual knowledge learned from training.

I have considered following classification of theoretical knowledge of religion in this research work. It classifies as religious studies, philosophy of religion, religious philosophy and theology".

- There is rapid change happening within the religious relation and belief of people in the different regions of Mongolia. I conclude that the it is the result of functional relation of social change and influence of religion based on empirical research works.

- From the empirical research work on the western region, governmental and nongovernmental organizations need to rationalize policy on religion, its institutions and to engrain democratic principle to devotees. Here: apart from traditional religion, new religion and its institutions established at the region, devotees become young, educated and free to choose religion; pragmatic, utilitarian and such features might be risky for people with different religion.

Thus, concerning governmental and nongovernmental organizations they must take into account that devotees should be tolerant with different views, doctrines and accept coexistence, respect others right as their rights in the relational culture.

- Christian and islamic religion has already formed and started functioning with various religious training and social service. Also buddhists cooperate with local governmental and nongovernmental organizations while training and serving to society and searching new cooperative ways. Religious organizations must have some obligations to serve particular communities in the society and educate adolescents.

- to make a legal situation not to give privilege to any religious organizations and not to make competition between religions, non discrimination to belief or disbelief of religion and follow principle of tolerance and respectness for people.

ХОВД АЙМГИЙН ХҮН АМЫН ҮНДЭС УГСАА, ШАШИН ШҮТЛЭГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ*

(ХҮН АМ ОРОН СУУЦНЫ 2010 ОНЫ УЛСЫН ТООЛЛОГЫН НЭГДСЭН ДҮНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ)

Дунд шавь Ц.Пүрэвсүрэн
Доктор (Ph.D), ХИС, НХУС, НУ-ны тэнхимийн эрхлэгч
puujee75mn@yahoo.com

Товч утга. Энэхүү өгүүлэлд 2010 оны хүн амын улсын тооллогын үр дүнг ашиглан хүн амын үндэс угсаа, шашин шүтлэгийн төлөв байдалд дүн шинжилгээ хийхийг зорьсон болно.

Түлхүүр үг: Ховд аймаг, буддын шашин, христосын шашин, ислам шашин, эрэгтэй, эмэгтэй, ахмад, залуучууд, олон үндэстэн ястан, үндэс угсаа.

Ховд аймгийн хүн амын тоо 2010 оны 11 дүгээр сарын 10-ны байдлаар 76869 байна. Аймгийн хүн амын 51,1 хувь эрэгтэйчүүд, 49,9 хувь нь эмэгтэйчүүд байгаа болно. Хүн амын тоо 2000 оны тооллогоор 86,8 мянга байв. Хүн амын тоо 2000-2010 оны хоорондох 11 жил орчмын хугацаанд 10,0 мянга орчим хүнээр буурч, 1989 оны тооллогын үеийнхтэй ойролцоо байв. Дээрх хүн амын бууралтад нөлөөлсөн хүчин зүйл нь гадагшаа чиглэсэн шилжих хөдөлгөөнтэй холбоотой. 1990-ээд оноос эхлэлтэй Улаанбаатар болон төв рүү чиглэсэн шилжих хөдөлгөөн нь өнөө хэр үргэлжилсээр байгаа нь төвөөс алслагдмал байдал, улс төр, нийгэм, эдийн засгийн хөгжилтэй шууд хамааралтай.

Хүн ам орон сууцны 2010 оны улсын тооллогын нэгдсэн дүнгээр хүн амын 99,7 хувь нь Монгол Улсын харьяат, 0,3 хувь нь гадаадын харьяат иргэд байна. Аль нэг улсын харьяалалгүй нэг иргэн байна. Гадаадын харьяат иргэдийн дотор БНХАУ-ын иргэн нийт гадаадын харьяат иргэдийн 79,0 хувийг, ОХУ-ын

*Монгол Улсын Үндэсний Статистикийн хороо. Хүн ам орон сууцны 2010 оны улсын тооллогын нэгдсэн дүн (Ховд аймаг) УБ.,2012.

иргэл 9,0 хувийг, БНСУ-ын иргэд 3,0 хувийг, АНУ-ын иргэд 2,0 хувийг эзэлж байгаа нь бусад орнуудынхаас олон байгаа юм. Гадаадын иргэн харьяат Жаргалант суманд 34, Булган суманд 141, Цэцэг суманд 11 оршин амьдардаг. Тэд боловсролын төвшин нь дээд болон бүрэн дунд боловсролтой хүмүүс байна.

Тус аймагт Монгол Улсын харьяат иргэдийн дотор Захчингууд 26,1 хувь, Халхчууд 25,7 хувь, Казахууд 11,9 хувь, Торгуудууд 8,2 хувь, Урианхайчууд 8,2 хувь, Дөрвөдүүд 6,8 хувь, Өөлдүүд 6,5 хувь, Мянгадууд 4,9 хувь тус тус эзэлж байна. Дөрвөд, Урианхай, Захчин, Торгууд угсааны эзлэх хувийн жин өмнөх тооллогынхоос (1989 он) өсч, Халх, Өөлдүүдийнх буурчээ. Буриад, Барга, Харчин, Хотгойд, Элжигэн, Цаатан, Халимаг, Хамнигангууд сүүлийн 10 жилд тус аймагт шилжин суурьшжээ.

Байршилын хувьд Жаргалант сумын тухайд бүх үндэс угсаатнууд оршин амьдрахын зэрэгцээ Халхчууд Дарви, Цэцэг, Чандмань сумдад, Захчингууд Алтай, Зэрэг, Манхан, Уенч сумдад, Казахууд Ховд, Булган сумдад, Урианхайчууд Дууг, Мөнххайрхан сумдад, Торгуудууд Булган сумдад, Өөлдүүд Эрдэнэбүрэн суманд, Мянгадууд Мянгад сумдад голлон оршин сууж байна. Энэ нь тухайн нутаг дэвсгэр, засаг захиргааны байдалд тухайн үндэс угсааны ард түмний суурьшиж, идээшин амьдарч ирсэн анхны тархацад төдий л өөрчлөлт ороогүй дүр зураг харагдаж байна.

Цаатан, Сартуул, Халимаг, Хошууд, Баяд, Хотгойдууд голдуу аймгийн төвд, Чантуучууд Ховд, Буянт суманд, Тувачууд Жаргалант, Буянт сумдад голдуу амьдарч байна.

Хүн амын үндэс угсааны байдал нь зарим үндэс угсаатны хувьд шашин шүтлэгт нь зонхилох нөлөөтэй байдаг тул дээр уг асуудлыг авч үзсэн болно. Нөгөө талаар тус аймаг нь үндэс угсааны хувьд Монгол Улсын хамгийн олон үндэстэн угсаатан оршин амьдардагийн хувьд нэлээд онцлогтой болно.

Шашин шүтлэгийн талаар өмнөх хүн амын тооллогууд асууж байгаагүй. Харин хүн ам орон сууцны энэ удаагийн тооллогоор “Та шашин шүтдэг үү, шүтдэг бол ямар шашин шүтдэг вэ?” гэсэн асуултыг 15, түүнээс дээш насны хүн амаас асуусан нь тооллогын нэг онцлог байлаа.

Ховд аймагт өнөөдрийн байдлаар буддын 10, ислам шашны 6, христосын болон шинэ шашны хөдөлгөөн 5 сүм хийд үйл ажиллагаа явуулж байна⁸². 1990-ээд он гарснаар шашин шүтлэг нээлттэй болсон нь хуучин шашин шүтлэгийн хэв маягууд сэргэх, гадны шашнуудын нэвтрэн орж ирэх бололцоог бүрдүүлсэн. Аливаа нийгэмд хэт замбараагүй олон шашны урсгалууд хяналтгүй оршин байх нь цаанаа олон аюул дагуулж явдаг. Монголд өнөөдөр зөвшөөрөлтэй, зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулдаг шашны байгууллага аймаг, орон нутагт олноороо байх болсон. Үүнд аль ч шатны байгууллага ердөө анхаарахгүй байна. Эдгээр нөхцөл байдал иргэдийн шашин шүтлэгт тодорхой хэмжээгээр нөлөөлж байгаа нь энэ удаагийн судалгааны үр дүнгээс харагдах болсон.

Арван тав, түүнээс дээш насны нийт хүний 50,6 хувь нь ямар нэгэн шашин шүтдэггүй иргэд, 49,4 хувь нь буюу 24,7 мянган хүн шашинтан байгаагийн 37,1 хувь нь Буддын шашинтан байна.

Шашинтангуудын дотор эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдээс 6,4 хувиар илүү байгаагийн шашинтан эмэгтэйчүүдийн 39,7 хувь нь Будда, 2,3 хувь нь Христосын шашинтан байна.

Шашны төрөл	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	100,0	100,0	100,0
Шүтдэггүй	50,6	53,8	47,4
Шүтдэг	49,4	46,2	52,6
Будда	37,1	34,4	39,7
Христос	1,8	1,2	2,3
Ислам	8,8	8,9	8,8
Бөө	0,8	0,9	0,8
Бусад	0,9	0,8	1,0

Шашинтангуудын 8,8 хувь нь Исламын шашинтан байгаа нь тус аймагт Казахууд олноор суурьшдагтай холбоотой. Казахуудын дотор ислам шашин нь үндэстний шашин шүтлэг болох хувьдаа голлох байр сууриа өнөө хэр хадгалсаар байгаа болно. Харин монголчуудын тухайд будда хийгээд бусад шашныг шүтэх явдал түгээмэл болж байна.

Шашинтангууд нас ахих тусам уламжлалт Будда шашин илүү шүтэж байна. Тухайлбал, 15-19 насныхны 65,3, 50-59 насныхан 80,2, 60-69 насныхан 78,6, 70 түүнээс дээш насны 80,4 хувь нь Буддын шашинтан байна. Нөгөө талаар Христосын шашинтан нас ахих тусам буурч, харин залуучууд илүү шүтэж байна. Тухайлбал, 15-19 насны нийт хүний 7,6 хувь, 29-59 насныхны 2,0-оос дээш хувь нь Христосын шашинтан байна.

Эцэст нь дүгнэж үзэхэд Ховд аймгийн нутагт оршин суугаа хүн амын дотор Захчингууд 26,1 хувь, Халхчууд 25,7 хувь, Казахууд 11,9 хувь, Торгуудууд 8,2 хувь, Урианхайчууд 8,2 хувь, Дөрвөдүүд 6,8 хувь, Өөлдүүд 6,5 хувь, Мянгадууд 4,9 хувь тус тус эзэлж байна. Буриад, Барга, Харчин, Хотгойд, Элжигэн, Цаатан, Халимаг, Хамнигангууд сүүлийн 10 жилд тус аймагт шилжин суурьшжээ.

⁸²ХИС, НХУС-ийн НУТЭнхимийн номын сан. Иргэдийн шашин шүтлэгийн байдал, төлөв хандлага (Ховд, Увс, Баян-Өлгий аймаг). ХИС-ийн дотоод эх үүсвэрээс санхүүжих төслийн тайлан. Ховд.,2012.

Аймгийн хүн амын нас ахих тутам Будда шашин илүү шүтэж байна. Тухайлбал, 15-19 насныхан 75,0 хувь, 50-59 насныхан 80,2 хувь, 60-69 насныхан 78,6 хувь, 70 түүнээс дээш насныхан 80,3 хувь нь Буддын шашинтан байна. Казахууд олноор суурьшдагтай холбоотойгоор хүн амын 17,9 хувь нь Ислам шашинтан байна.

RESUME

Энэ өгүүлэлд Ховд аймгийн хүн амын үндэс угсаа, шашин шүтлэгийн асуудлыг Хүн ам орон сууцны 2010 оны улсын тооллогын үр дүнг ашиглан авч үзсэн болно. Ховд аймгийн Монгол Улсын хувьд хамгийн олон үндэстэн ястан оршин амьдардагийн зэрэгцээ, ойрадууд болон казахууд олноор амьдардаг нь шашин шүтлэгийн өвөрмөц нөхцөл байдлыг бий болгодог.

НОМ ЗҮЙ

1. Очир А. Монголын ойрадуудын түүхийн товч. УБ.,1993. тал.43.
2. Монгол Улсын Үндэсний Статистикийн хороо . Хүн ам орон сууцны 2010 оны улсын тооллогын нэгдсэн дүн (Ховд аймаг) УБ.,2012.
3. Курныкин О.Ю. Исламский фактор в Казахстане: исторический опыт и современные реалии // Россия – Центральная Азия: проблемы миграции и безопасности. Барнаул, 2002. с.109-117 Цэдэндамба С. Монгол улс дахь шашны нөхцөл байдал (XX-XXI зууны зааг үе) УБ.,2003 он.
4. Философи шашин судлал сэтгүүл. (Пүрэвсүрэн Ц. Баян-Өлгий аймагт явуулсан сүсэг бишрэлийн судалгааны зарим үр дүнгээс.) УБ.,2011 он. №354, тал 153-159.

УВС АЙМГИЙН ХҮН АМЫН ШАШИН, СҮСЭГ БАБИШРЭЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Дундшавь Ц.Пүрэвсүрэн
Доктор (Ph.D), ХИС, НХУС,
НУ-ны тэнхимийн эрхлэгч
puujee75mn@yahoo.com

Монголчуудын эрхэмлэн дээдэлж, шүтэн биширч ирсэн шашин шүтлэгийн үнэт зүйлсийн цөм нь эрт цагт байгаль дэлхий, газар нутгаа хайрлах уламжлалд тулгуурлаж бөө мөргөлийн хийгээд буддын шашны үзэл сэтгэлгээгээр, хожим түүхийн тохиолоор шашингүй үзэл, марксизмаар тодорхойлогдох болсон байна. XX зууны монголын нийгэм-эдийн засгийн хөгжлийн зам, загвар болж асан социалист нийгмийн үед марксист-ленинист онол номлол, интернационалист үзэл санаа, улсын өмч, хамтач хүмүүжил тэргүүтэн үзэл суртал давамгайлж байсан бол одоо ардчилал, хүний эрх, эрх чөлөө, хувийн өмч, олон ургальч үзэл бүхий ардчилсан нийгэмд дээдэлдэг хөгжлийн замаар явж байна. Энд социалист буюу намч, ардач шинж чанартай, нэг ишт үзлээс үндэсний хийгээд хүн төрөлхтний эрхэмлэж буй үнэт зүйл болох либерал үзэл санааг хүлээн авах, үндэсний үнэт зүйлийг нээлттэй нийгмийн нөхцөлд тохируулж, өрнөдийн нийгмийн үнэт зүйлтэй хослуулах, эсвэл дорны соёлын уламжлалаа сэргээн мандуулах уу г.м. олон ишт үзэл чиг хандлагууд төлөвших шатандаа явж байна. Нийгмийн орчинд бүрэлдэн бий болсон эдгээр хандлага монголчуудын амьдрал үйл ажиллагаа, шашин соёлын орчинд өөрийн нөлөө тусгалаа үзүүлсээр байгаа нь дамжиггүй юм.

Манай оронд улс төрийн ардчилал, эдийн засгийн либеральчлал, оюун сэтгэлгээний олон ургальч үзэл, нийгэм дэх бүлэг, нийтлэгүүдийн ашиг сонирхлын ялгарлын үйл явц идэвхитэй явагдаж байгаа нь нийгэм хүмүүнлэгийн ухааны янз бүрийн салбар тэр дундаа шашин судлалын хүрээнд судалгаа шинжилгээний шинэ арга хэрэгсэл, хандлага хэрэглэхийг зүй ёсоор шаардах боллоо.

Энэ удаа бид ХИС-ийн дотоод эх үүсвэрээс санхүүжүүлдэг төсөлт ажлын хүрээнд “Баруун бүс нутаг дахь шашин шүтлэгийн өнөөгийн төлөв байдал”/Ховд, Баян-Өлгий, Увс аймаг/ дотоод төслийн хүрээнд хээрийн судалгаа хийсэн болно. Судалгааны үр дүнд Увс аймгийн иргэдийн шашин сүсэг бишрэлийн төвшиний талаар явуулсан социологийн судалгааны үр дүнд дүн шинжилгээ хийхийг зорилоо.

Увс аймаг нь Монголын баруун хэсэгт ХанХөхий, Хархираа, Түргэний өндөр уулс, Увс нуурын хотгорын говийг хамран 69585км² нутгийг эзлэн оршино. Увс аймаг нь засаг захиргаа нэгжийн 18 сумтай, дөрвөд, баяд, хотон, халх ястнууд зонхилон амьдардаг, 2010 оны байдлаар хүн амын тоо 73328 байна.

Судалгааны явцад олж авсан үр дүнгээс санал асуулдаг оролцогчдын шашны баримжаалал, тэдний нас, боловсрол, жендерийн болон шашны байгууллагуудын зүгээс нийгмийн хүлээлт, ертөнцийг үзэх үзэл, үнэт зүйлсийн баримжаалал зэрэг асуудалтай холбоотой зарим зүйлийг энэхүү өгүүлэлд хөндлөө. Ингээд нийт хүн ам шашны байдлаараа хэрхэн хуваагдаж байгааг авч үзье.

Нийт асуулгад оролцсон 166 хүний 71,1% (118) нь шүтлэгтэй, 20,5% (34) нь шүтлэггүй, хариулмааргүй байна 8,4% (14 хүн) хэмээн өөрсдийн ертөнцийг үзэх үзлийн байр сууриа илэрхийлсэн

байна. Шүтлэгтэй хүмүүсийн ямар шашинд хамаарагдаж байгаа нь ч сонирхол татаж байна: буддистууд 60,2% (100 хүн), протестантууд 4,2% (7 хүн), бөөгийн шашинтнууд 6,6% (11 хүн), үнэн алдартнууд 1,2% (2 хүн), баптистууд 1,2% (2 хүн), христ 5,4% (9 хүн), шинэ зууныхан 1,2% (2 хүн), бусад 5,4% (9 хүн) нь ямар шашин шүтдэгээ илэрхийлээгүй байна. Асуулгад оролцогчдын шашинлаг байдлын зэрэглэл, хир зэрэг гүн шүтлэгтэй болохыг хөндлөнгийн байдлаар дагаж, үйлддэг шашны зан үйлийг өдөр бүр 7,2% (12), нэлээд идэвхитэй үйлддэг 21,7% (36), хааяа 38,6% (64), бараг хийдэггүй 13,9% (23) гэсэн хариулт өгснөөс үзвэл үндсэндээ 67,5% (112) орчим хувь нь шашны ямар нэг зан үйл үйлддэг, гүн шүтлэгтэй болох нь тодорхой байна. Харин ямар ч зан үйл үйлддэггүй 9,6% (16), хариулахад төвөгтэй байна 9% (15) хариулжээ. Мөн та сүм хийдийн хурал ном, цугларалт, хичээл, нийтийн мөргөл, лам хуврагт очдог уу гэсэн асуултад үргэлж очдог 13,3% (22), үе үе очдог 19,3% (32), хааяа л нэг очдог 30,7% (51), очихсон гэж боддог, гэвч тэр бүр очиж чаддаггүй 12% (20) хэмээн хариулснаас үзвэл судалгаанд оролцогчдын 75,3% (125) нь ямар нэг байдлаар шашин номын газар, сүм хийдээр орж гарч үйлчлүүлдэг нь тодорхой харагдаж байна. Харин огт очдоггүй 15,1% (25), хариулахад төвөгтэй байна 9,6% (16) хариулжээ. Ер нь шашин шүтлэгийн чухал эх сурвалж сүсэг ба бишрэлийн нэг чухал үзүүлэлт нь тухайн байгууллагад харьяалагдаж байгаагаар илэрхийлж буй хэлбэр нь сүм хийд шашны цугларалт хурал номын газраар үйлчлүүлэх явдал байдаг бөгөөд үүнийг ч шашны чиглэлүүд өөр өөрийн арга замаар шийдсэн байдаг. Дээрх асуултаас харахад иргэдийн дунд шашны зан үйлийг үйлдэх явдал түгээмэл тэр дундаа буддын болон протестант шашин шүтэгчдийн хувьд зонхилох байр суурьтай байгааг илтгэнэ.

Нийт асуулгад оролцогчдын жендерийн ялгааны хувьд гэвэл 51,8% (86) нь эмэгтэйчүүд, 80% (48,2) нь эрэгтэйчүүд байв. Шүтлэгтэй хүмүүсийн дундах насны шатлал тодорхой илэрсэн хэлбэртэй, цаашдаа шашны залуужих байдлын хувийг өсгөх чигтэй байна: 16–21 насныхан –24,1% (40), 22–35 насныхан – 31,3% (52), 36–45 насныхан – 24,7% (41), 46–60 ба түүнээс дээш насныхан 19,9% (33) нь уг судалгаанд хамрагдсан болно. Насны бүлгийг шашин шүтдэг, эс шүтдэг гэсэн ялгаагаар нь харьцуулан үзвэл шашин, сүсэг ба бишрэлийн төвшин нь залуужих чиг хандлагатай байхаас гадна уламжлалт бус шашинд хандах хандлага залуучуудын дунд зонхилох шинж чанартай байна.

Манайд шашин сэргэж байгаа болон хүмүүс шашинд хандах болсон шалтгааныг хүмүүс итгэж бишрэх зүйлээ шинээр эрж хайх болсон 16,9% (28), нийгэм хямралтай, хүмүүсийн сэтгэл санаа тайван бус байгаа явдал 24,1% (40), хүмүүс гэмээ ухаарч, ертөнцийн эзний хайр энэрэлийг (бурхан тэнгэр) мэдрэх болсон 6% (10), үндэсний уламжлал, ёс заншил сэргэж байгаа явдал 17,5% (29), ардчилал, эрх чөлөө, олон ургальч үзэл дэлгэрсэн 20,5% (39), шүтэж бишрэх эрх чөлөө хүнд зайлшгүй 12,7% (21) нь хариулсан байна. Хүн амын нэлээд олонхи хувь нь монголын нийгэмд чөлөөт сэтгэлгээний үр хөврөл, түүний оршин байх, илрэх зайлшгүй хэрэгцээг шашны хувьд боломжийн төвшинд ө.х. иргэд хуулиар олгогдож баталгаажсан уламжлалт хийгээд бусад шашныг шүтэх, эс шүтэх эрх чөлөөгөө бүрэн утгаар нь эдэлж, ойлгож, хүртэж байгаа эерэг үзүүлэлт дээрх судалгаанаас харагдаж байгаа боловч нийгмийн хямрал, сэтгэл санааны тайван бус байдалтай нэлээд их хувь нь дээрх шалтгааныг холбон тайлбарлаж байгаа нь анхаармаар асуудал юм.

Харин өнөөдөр манайд олон шашин зэрэгцэн орших болсон нь дараах зүйлсэд ямаар нөлөөлөх вэ гэсэн асуултанд: олон шашин зэрэгцэн орших цаашдаа ямар үр дагавартай бэ? сайн-12,7% (21), муугаар-43,4% (72), мэдлэг соёл боловсролд сайн-28,3% (47), муу-31,9% (53), үндэсний эв нэгдэл тусгаар тогтнолд сайн-14,5% (24), муу-44% (73), гадаад харилцаанд сайн-18,1, муу-28,9% (48), монгол зан заншилд сайн-13,9% (23), муу-56,6% (94), хүмүүсийн харилцан бие биенээ ойлгоход сайн-18,7% (31), муу-43,4% (72) гэсэн хариултуудыг тус өгчээ. Иргэдийн дунд гадны хэт олон шашин дэлгэрэх нь монголчуудын уламжлалт зан заншил, хүмүүс хоорондын харилцаанд муугаар нөлөөлнө гэсэн үзүүлэлтүүд бусад асуултаас өндөр хувьтай байхаас гадна сөрөг хандлагатай хариултууд бусад эерэг сонголтуудаасаа их байгаа нь нийгэм соёлын орчин, иргэдийн ухамсарт тийм ч таатай уур амьсгал бүрдээгүй байгааг илэрхийлэхээс гадна олон шашин эв найртай зэрэгцэн оршиж байгаа мэт боловч соёл ба иргэншлийн хөрс суурь нь тийм бат бөх бус, нийгэм нийтээрээ хүлээн зөвшөөрсөн байдал харагдахгүй байна. Энэ нь уламжлалт бус шашныг хүн амын дунд сурталчлах, дэлгэрүүлэх, түгээх, шүтэн бишрэгчдийн тоогоо нэмэгдүүлэх үйл ажиллагаа нь зонхилж харин нийгэмд эзлэх байр суурь, нийгмийн амьдралд гүйцэтгэх эерэг үүрэг нь ард иргэдэд илт мэдэгдэхүйц шинж чанартай бус байгаа явдал юм. Мөн гадны шашны дэлгэрэлтийн шалтгааныг гадаад орнуудын бодлоготой холбоотой 44% (73), улс төрийн хүчнүүдийн бодлого, үйл ажиллагаатай холбоотой 27,1% (45), дуртай шашнаа шүтэх хүний эрх 57,2% (95), зарим хүмүүсийн хувийн ашиг сонирхол 69,3% (51), мэдэхгүй 20,5% (34) нь хариулснаас үзэхэд өмнө хийсэн дүгнэлтүүдтэй уялдаж байна.

Сүм хийд шашны байгууллагын үйл ажиллагааны чиглэл нь шашин номынхоо үйл хэргийг эрхлэх нь зүйтэй 59% (98), улс төрийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцох 12% (20), мэдэхгүй 28,9% (48), УИХ-ын баталсан төр, сүм хийдийн харилцааны тухай хууль нь ямар дууль болсон бэ гэдэгт боломжийн-31,9% (53), өрөөсгөл-7,8% (13), мэдэхгүй-60,2% (100), шашин цаг үеэ дагаад шинэчлэгдэж байх ёстой юу тийм-37,3% (62), үгүй-35% (21,1), мэдэхгүй-28,9% (48), хариулахад бэрхшээлтэй-12,7% (21) нь хэмээн тус тус хариулсан байна. Монголчуудад төр шашныг хослон барих тухай хоёр ёсны үзэл сэтгэлгээ хэдийгээр эртний уламжлалтай боловч шинэ үе маань шашин, төрийн үйл хэрэг тус тусдаа байхыг сайшааж, мөн шашин цаг үеэ дагаад шинэчлэгдэж байхыг хүлээн зөвшөөрсөн байгаа нь магадгүй иргэдийн дунд уламжлалт шашныг зарим талаар шинэчлэгдээсэй гэсэн нийгмийн хүлээлт байж болох юм.

Иргэдийн шашны үнэлэмж баримжааллын хандлагыг судлах нь тэд юуг эрхэмлэн дээдэлдэг, нийгмийн шинэ нөхцөлд хэрхэн дасан зохицож байгаа болон улмаар тэдний эрхэмлэлийн залгамж, шинэчлэгдэн хувьсах чанар нь ямар байгааг тодруулах боломжтой. Иргэдийн шашны үнэлэмж нь нийгэм соёлын орчны ирээдүйн дүр төлөвшлийн үйл явц хэрхэн яаж явагдаж байгааг тодруулахад хэрэгтэй юм. Судалгаандаа бид залуучуудын үнэлэмж баримжааллын хандлагыг эсрэгцсэн хос бодомжуудаар тандахад дараах дүр зураг гарч байна. Үүнд:

а) *Үнэлэмжийн амьдралын утга учрын тогтолцоо*: бидний амьдарч байгаа цаг үе маань чөлөөтэй сэтгэн, өөдлөн дэвжих- 50% (83), хүн бүр дураар дургих-13,9% (23), уруудаж өгсөх-36,1% (60), монгол орон цаашдынхаа хөгжилд үндэсний онцлог, уламжлалаа хадгалах-72,3% (120), зах зээлийг хөгжүүлэх-12,7% (21), мэдэхгүй-15,1% (25), ирээдүйдээ итгэлтэй байдаг-62%, зарим талаар- 31,3%, гундуухан-3,6%, мэдэхгүй-3%, өөрийнхөө хувь заяаны төлөө өөрөө тэмцэх-73,5%, бурхан тэнгэрийн оролцоо-11,4%, төр засаг-12%, бусад-3%

б) *Үнэлэмжийн нийгэмшлийн тогтолцоо*: хэрвээ амьдралд хүний хүссэн бүхэн биелдэг бид шударга төр засаг-60,2%, эрүүл мэнд-56,6%, амьдралын хань-22,3%, мэргэжил-27,1%, олз омог-25,9%, таньд боломжийн хэмжээний мөнгө хуримтлагдсан байвал хувийн бизнест-31,9%, найздаа туслана-36,7%, буяны байгууллагад хандивлана-31,3%, сүүлийн жилүүдэд миний амьдрал их сайжирсан-26,5%, ер нь дээшилсэн-41%, хэвэндээ-25,9%, дордсон-3%

в) *Үнэлэмжийн хүмүүс хоорондын харилцааны тогтолцоо*: хүн угаасаа гэм нүгэлтэй амьтан-34,4%, хүний буруу үйл гэм нүгэл-52,4%, гэм нүгэл гэж үгүй-5,4%, уурлаж бухимдсан үедээ бүдүүлэг үг хэллэг нэг мэдэхэд хэлсэн байдаг-35,5%, заримдаа-28,9%, цээрлэдэг-32,5%, хүнд тус болсны хариуд шан харамж авна-24,1%, өгвөл авна, өгөхгүй бол авахгүй-36,1%, авахгүй-33,7%, өөрийг чинь үг хэлээр доромжилсон үед адилхан хариу барина-17,5%, эвээ олно-35,5%, хэрүүлийг цээрлэдэг тул орхиж явна-47%, настай хүмүүс ингэж ч болохгүй, тэгж ч болохгүй бидний үе тийм биш байсан хэмээвэл сургамж захиасыг нь дагана-66,9%, заримдаа дагана-22,3%, дагахгүй би өөрийнхөөрөө байх өөр цаг үеийн хүн-9,6%

г) *Үнэлэмжийн виталь тогтолцоо*: Таны амьдралдаа эрхэмлэдэг ажил төрөлдөө баримталдаг гол зарчим хууль журмыг баримтлах-51,8%, цаг хугацаа-44,6%, буян үйлдэж бусдад туслах-28,3%, арвич хямгач-28,3%, зорилготой байх-24,7%, нинжин сэтгэл-18,1%, өөрийн эрх чөлөө-12%, худал үл хэлэх-18,1%


Энд Н.И.Липан тэргүүтэй оросын судлаачдын үнэлэмжийг ангилсан⁸³ ангиллын дагуу амьдралын утга учрын, нийгэмшлийн, хүмүүс хоорондын харилцааны болон виталь тогтолцоогоор иргэдийн шашны үнэлэмжийн дүр төрхийг ялган авч үзлээ. *Амьдралын утга учрын тогтолцоонд* хүний амьдралын утга учир, хүний мөн чанар, эрх чөлөө, чөлөөтэй сэтгэн амьдрах, өөдлөн дэвжих, үндэсний онцлог, уламжлалаа хадгалах, ирээдүйдээ итгэлтэй байх өөрийнхөө хувь заяаны төлөө өөрөө тэмцэх, хүний ахуйн зорилгыг тодорхойлогч үнэлэмжүүд, *нийгэмшлийн тогтолцоонд*-шударга төр засаг, эрүүл мэнд, амьдралын хань, хүссэн мэргэжил, олз омог, найз нөхөддөө туслах, буян үйлдэх г.м. бие хүний төлөвшлийн процессыг тодорхойлогч үнэлэмж, үнэт зүйлс, *харилцан үйлчлэлийн буюу хүмүүс хоорондын харилцааны тогтолцоонд*-хүн хэлээр болон биеэр үйлдэх гэм нүгэлийг тэвчих, хэрүүл тэмцэлээс хол байх, өвөг дээдэс ахмад хүмүүсийн сургаалийг сонсох дээдлэх, сургамж захиасыг нь биелүүлэх, сайн харилцаа, амар тайван, нэр хүнд, эрх мэдэл, харилцан туслах, бие хүмүүсийн болон бүлэг хоорондын харилцаанд чухал зүйлсийн тухай бодол, үнэлэмж, *виталь тогтолцоонд*-хууль журам, цаг хугацааг баримтлах, бусдад туслах, арвич хямгач, зорилготой байх, нинжин сэтгэл, өөрийн эрх чөлөө, худал үл хэлэх, эрүүл мэнд, аюулгүй байдал, тав тух, өдөр тутмын амьдралыг дэмжих, хадгалахад чухал зүйлсийн талаарх үнэлэмжийг тус тус багтааж үзэж байгаа юм.

Шашин нь олон талт, нарийн нийлмэл үзэгдэл учраас нийгэм болон хувь хүний амьдралд мөн олон янзаар нөлөөлж, нийгэмд тодорхой үүрэгтэй байж, олон талын хэрэгцээг хангаж байдаг учраас л урт удаан хугацааны туршид оршин тогтнож, үйлчилж иржээ. Шашны нийгмийн үүрэг гэдэгт нийгмийн амьдралд шашны зүгээс үзүүлэх нөлөөллийг авч үздэг⁸⁴. Эрдэмтэн судлаач О.Конг, К.Маркс, М.Вебер нар шашин аливаа нийгэмд ертөнцийг үзэх үзлийн буюу үзэл суртал, ёс зүйн үүрэг гүйцэтгэдэг болохыг онцолсон байдаг. Бид иргэдийн шашны үнэлэмжийн хүрээнд тэдний гэм нүглийн талаарх ертөнцийг үзэх үзлийн мөн чанарыг тодруулан үзэхэд дараах дүр зураг харагдаж байна:


Диаграмм-1.

⁸³Ценности в кризисном социуме. //Ценности социальных групп и кризис – общество/отв.ред. Н.А.Лапин. М.,ИФАН, 1991

⁸⁴Яблоков И.Н. Социология религии. М.,1979, с.120.



Диграмм-2.



Эдгээр судалгааны үзүүлэлтүүдийг харьцуулан үзэхэд иргэдийн шашин шүтлэг, шашны ёс заншил, зан үйл гүйцэтгэх төлөв байдал өөрсдийнх нь дотоод ертөнцийн хүсэл зориг, ёс суртахуунаар нөхцөлддөг гэж үзэж болохоор байна. Учир нь, тухайн хүний ертөнцийг үзэх үзэл, шашны нөлөөнд автсан байдлыг хэлбэр талаас илэрхийлвэл сүсэг бишрэл, дотоод итгэл үнэмшил байж, шүтэж буй объектынхоо мөн чанарыг тодорхой төвшинд танин мэдэж, эрхэмлэх зүйлийнхээ салшгүй хэсэг болгосны үр дүнг шүтлэг томьёолдог болно. Харин зан үйл бол нийтийн заншлаар тогтсон үйл хөдлөлийн цогц бөгөөд нэгэнт хэвшсэн зуршил билээ. Тиймээс ч сүсэг бишрэл, шашин шүтлэг, зан үйлийн өөрчлөлт хувирал нь тухайн цаг үе, нийгмийн өөрчлөлт шинэчлэлийг ямагт тусган илэрхийлж байдаг байна. Буддын шашинд хүний амьдралын оршихуйн уг чанарыг үйлийн үр буюу тухайн хүний бие, сэтгэл, хэл\ өөрийн үйлдлийн эх сурвалжаас гэм нүглийн мөн чанарыг ухан тайлбарладаг нь энэ шашныг шүтэн бишрэгчдийн ертөнцийг үзэх үзэлд тодорхой илэрч байна. /Диграмм-1,2/ Харин христийн уламжлал бүхий шашны чиглэлүүдэд дээрх асуудлыг буюу гэм нүглийн уг чанарыг хүн угаасаа гэм нүгэлтэй амьтан, сайн сайхан бурхнаас, муу муухай хүнээс эх сурвалжтай хэмээн үздэгтэй холбоотой юм /Диграмм-1,2/.

Дээрхи бүхнийг эцэст нь дүгнэж үзвэл дараах гаргалгаануудыг хийж болохоор байна. Үүнд:

1. Увс аймгийн иргэдийн олонхийн ухамсарт шашны үүрэг өндөр түвшинд байна гэсэн төсөөллийг судалгааны материалууд харуулж байна. Учир нь асуулганд оролцогчдын тодорхой хувь нь хүний амьдрал дахь шашны эзлэх байр суурийг онцолсон нь нийгмийн оюун ухаан – зан суртахууны хүрээнд түүний үүрэг чухал байгааг батлан харуулж байна. Шашинлаг байдлын шинж чанар, түвшинг тогтоосноор Монголын уламжлалт шүтлэг дэх шашинлаг байдлын гүнзгийрэлт, хүчтэй болох байдлыг урьдчилан тооцоолж болно. Шашны практик үйл ажиллагаа, зан үйлийн эрхэмлэл, тэдгээрийг явуулдаг нөхцөл байдлын тухайд иргэдийн дунд шашны зан үйлийг үйлдэх явдал түгээмэл тэр дундаа буддын болон протестант шашин шүтэгчдийн хувьд зонхилох байр суурьтай мөн шашин сүсэг бишрэлийн төвшин нь залуужих чиг хандлагатай байхаас гадна уламжлалт бус шашинд хандах хандлага залуучуудын дунд зонхилох шинж чанартай байна.
2. Иргэд хуулиар олгогдож баталгаажсан уламжлалт хийгээд бусад шашныг шүтэх, эс шүтэх эрх чөлөөгөө бүрэн утгаар нь эдэлж, ойлгож, хүртэж байгаа эерэг үзүүлэлт байгаа боловч хэт олон шашны урсгал нийгэмд бий болж буйд тааламжгүй хандсан нь анхаармаар асуудал юм.
3. Буддистууд болон протестантуудын хувьд шашны ухамсарын /ертөнцийг үзэх үзэл/ байдал эрс ялгаатай байгаагаар тодорхойлогдож байгаа нь цаашдаа тэдний нийгмийн үнэлэмж, үнэт зүйлд ч эрс өөрчлөлт гарах урьдач нөхцөл буйг илэрхийлж байна.

RESUME

Based on the field research questionnaires taken among the people of Uvs province some problems such as religion, age, education and gender are described in this issue.

ДАЛД ЭДИЙН ЗАСАГ БА ТАТВАР

М.Сайханаа /магистр, МНБ/
ХИС, НХУС, НББ-ийн тэнхим
msaikhanaa@yahoo.com

Түлхүүр үг: Далд эдийн засаг, татвар, татварын бодлого

Далд эдийн засаг гэж юу вэ?

Далд эдийн засаг нь макро эдийн засгийн судалгааны нэг гол сэдэв бөгөөд олон эрдэмтэн судлаачид энэ чиглэлээр ажилладаг. Мөн олон улсын банк санхүүгийн байгууллагууд энэ талаар өргөн хүрээтэй судалгаа шинжилгээ хийдэг.

Далд эдийн засгийн талаар олон янзын тодорхойлолт байдаг. Олон Улсын Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа Хөгжил (ОУЭЗХАХ)-ийн байгууллага нь далд эдийн засгийг дараах байдлаар тодорхойлсон байна. “Далд эдийн засаг нь эдийн засгийн утгаараа үр өгөөжтэй бөгөөд хуулийн дагуу (тодорхой стандарт шаардлагуудыг хангасан) боловч дараах шалтгаануудын улмаас төрийн байгууллагуудаас санаатайгаар нуусан үйл ажиллагааг хэлнэ:

1. Орлогын, нэмэгдсэн өртгийн болон бусад татваруудаас зайлсхийх
2. Нийгмийн даатгалын шимтгэл төлөхөөс зайлсхийх
3. Цалингийн доод түвшин, ажлын цагийн дээд хэмжээ, аюулгүй байдлын болон эрүүл ахуйн стандартууд зэрэг хууль эрх зүйн шаардлагуудыг дагаж мөрдөхөөс зайлсхийх
4. Статистик мэдээ болон төрийн байгууллагуудад гаргаж өгдөг бусад мэдээ мэдээллүүдийг гаргахаас зайлсхийх

Авсралийн эрдэмтэн Фрайдрих Шнейдер далд эдийн засгийн талаар олон судалгаа шинжилгээний ажил хийсэн туршлагатай хүн бөгөөд тэрээр далд эдийн засгийг хамгийн энгийнээр дараах байдлаар тодорхойлжээ. Үйлдвэрийн ажилчин хүн оройн цагаар өөрийн машинаараа таксины үйлчилгээ үзүүлэх (зөвшөөрөлгүйгээр), гагнуурчин үйлчлүүлэгчийн эвдэрсэн усны хоолойг засаад бэлнээр төлбөрийг авсан боловч татварын байцаагчид тус орлогыг тайлагнаагүй зэрэг нь далд эдийн засгийн жишээ.

Далд эдийн засгийн нөлөөлөл

Далд эдийн засаг нь макро түвшинд дараах сөрөг үр дагавартай байдаг тул бүх улс орон өөрийн далд эдийн засгийг хянаж, хувь хэмжээг нь багасгах талаар ажилладаг.

- Далд эдийн засаг өсөхийн хэрээр албан ёсны статистик мэдээллүүд (ажилгүйдэл, ажиллах хүч, орлого, хэрэглээ) үнэн бодит байдлаа алддаг. Тийм статистик мэдээлэл дээр үндэслэн боловсруулсан бодлого хөтөлбөрүүд үндэслэлгүй бөгөөд хэрэгжих боломжгүй байдаг.
- Далд эдийн засгийн өсөлт нь эдийн засагт хор хөнөөлтэй тойргийг бий болгодог. Далд эдийн засаг дахь үйл ажиллагаанууд нь татварт хамрагддаггүй тул татварын орлогын түвшинг байх ёстой хэмжээнээс нь бууруулдаг. Татварын бааз суурь ийнхүү бодит бус байвал засгийн газар татварын хувийг нэмэгдүүлэх замаар хариу арга хэмжээ авч болох бөгөөд энэ нь татвар төлөгчдийг далд эдийн засаг руу түлхэж төсвийн орлогыг бууруулдаг.
- Далд эдийн засгийн өсөлт нь ажиллах хүчийг албан ёсны эдийн засгаас далд эдийн засаг руу орох сонирхолыг бий болгодог. Далд эдийн засагт ажиллаж буй ажиллах хүчний тоо өсөх тусам албан ёсны эдийн засагт ажиллаж буй ажиллах хүчний тоо буурдаг. Үүнтэй адил далд эдийн засагт ажиллах цагийн хэмжээ нэмэгдэх тусам албан ёсны эдийн засагт ажиллах цагийн хэмжээ буурдаг.
- Далд эдийн засгийн үйл ажиллагаанууд нь ихэнхи тохиолдолд бэлэн мөнгөөр хийгддэг. Далд эдийн засаг өсөхийн хэрээр бэлэн мөнгөний хэрэгцээ нэмэгддэг.

Далд эдийн засгийн эерэг нөлөөллийн талаар зарим эрдэмтэд судалж дараах дүгнэлтийг гаргасан байна.

Үүнд:

- Далд эдийн засаг нь албан ёсны эдийн засагтай харьцуулахад илүүерсөлдөөнтэй бөгөөд илүүер ашигтай байдаг тул далд эдийн засгийн өсөлт нь нийт эдийн засгийн өсөлтийг дэмждэг.
- Далд эдийн засагт бий болсон орлогын гуравны хоёр нь тэр даруй албан ёсны эдийн засагт зарцуулагддаг. Далд эдийн засагт бий болсон орлого 1960-1984 онд Англи улсын хэрэглээний зарцуулалтыг ялангуяа удаан хэрэглэгддэг бараа худалдан авалтыг эрс нэмэгдүүлсэн. Тус худалдан авалтын нийт эдийн засагт болон шууд бус татвараас орох орлогт үзүүлэх эерэг нөлөө нэлээд их байсан байна.

Далд эдийн засгийг хэрхэн хэмжих.

Далд эдийн засгийн хэмжээг тодорхойлдог олон аргууд байдаг бөгөөд тэдгээрээс хамгийн энгийн бөгөөд ойлгоход амар арга бол эрчим хүчний хэрэглээний арга. Албан ёсны ДНБ-ий өсөлтийн хувь, эрчим хүчний нийт хэрэглээний өсөлтийн хувь хоёрын зөрүүгээр далд эдийн засгийн өсөлтийг тооцдог. Энэ арга их энгийн хэдий ч зарим шүүмжлэлтэй талтай. Үүнд; бүх төрлийн далд эдийн засгийн үйл ажиллагаа нь зөвхөн ганц цахилгаан хэрэглэдэггүй, бусад эх үүсвэрийг (хий, тос, нүүрс г.м) ашигладаг байж болно.

Далд эдийн засгийг тооцох өөр нэг арга бол бэлэн мөнгөний гүйлгээний арга. Энэ аргаар бол албан ёсны тайлангаар гарсан дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт болон эргэлтэнд байгаа бэлэн мөнгөний гүйлгээний өсөлтийн зөрүү нь далд эдийн засгийн өсөлтийг харуулдаг.

Дэлхийн улс орнуудын далд эдийн засгийн хэмжээг тодорхойлсон судалгааг Фрайдрих Шнейдер 2004 онд хийсэн бөгөөд энэ судалгаагаар манай улсын далд эдийн засаг дотоодын нийт бүтээгдэхүүний 23 хувьтай тэнцэж нийт 145 улсын 34 дугаарт орсон байна. Энэ нь хөгжиж буй манайтай ойролцоо орнуудтай харьцуулахад манай улс харьцангуй дээгүүр буюу сайн түвшинд байгааг харуулсан.

Далд эдийн засгийг бий болгож буй хүчин зүйлүүд

Далд эдийн засагт нөлөөлж буй олон хүчин зүйлүүд байдаг бөгөөд тэдгээрийг ерөнхийд нь 2 хэсэгт хувааж болох юм.

1. Эдийн засгийн
2. Нийгмийн

Эдийн засгийн хүчин зүйлд татвар болон ниймийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ, төрийн байгууллагуудаас гаргаж буй стандарт шаардлагууд, харин нийгмийн хүчин зүйлд авилгал, хээль хахууль, хүнд суртал, ёс зүй, улс төрийн тогтворгүй байдал гэх мэт ордог.

Далд эдийн засагт нөлөөлж буй хүчин зүйлүүд тэр дундаа татварын хувь хэмжээ далд эдийн засагт хэрхэн нөлөөлж байгаа талаар эрдэмтэд олон судалгаа шинжилгээний ажлууд хийсэн байдаг. Тэдгээр судалгаа шинжилгээнүүд дараах дүгнэлтэд хүрсэн байна. Татварын хувь хэмжээний өсөлт нь далд эдийн засгийн өсөлтөд шууд нөлөөлнө. Гэхдээ татварын хувь хэмжээний бууралт нь далд эдийн засгийн хэмжээг төдийлөн бууруулж чадахгүй, харин түүний цаашдын өсөлтийг хязгаарладаг.

Далд эдийн засаг ба татвар

Далд эдийн засгийг татварын талаас нь дараах байдлаар тодорхойлж болох юм.

Далд эдийн засаг = Татвараас зайлсхийх + Татвараас зугтах
(Shadow economy = Tax avoidance + Tax evasion)

Татвараас зайлсхийх гэдэг нь хуулийн нүх цоорхой, боловсронгуй бус байдлыг ашиглан татвар төлөхгүй байх эсвэл татвараа багаар төлөхийг хэлэх бөгөөд үүнтэй хуулийн хүрээнд хариуцлага тооцох үндэслэл байдаггүй.

Харин татвараас зугтах гэдэг нь мөрдөгдөж буй хуулийн заалтыг санаатайгаар зөрчин татвараа төлөхгүй байх, эсвэл татвараа бага төлөхийг хэлэх бөгөөд үүнтэй тодорхой хуулийн хүрээнд хариуцлага тооцох боломжтой байдаг.

Татвараас зайлсхийх, татвараас зугтах явдлыг багасгаж далд эдийн засагтай тэмцэх боломжтой бөгөөд үүнийг 2 чиглэлээр хийж болох юм.

1. Татварын бодлогыг боловсронгуй болгох
2. Татварын албаны үйл ажиллагааг сайжруулах

Далд эдийн засаг ба татварын бодлого

Татварын бодлогыг боловсронгуй болгож татварын хуульд холбогдох өөрчлөлт оруулах замаар далд эдийн засагтай тэмцэх боломжтой.

2007 оноос хэрэгжиж буй татварын шинэ хуулийн дагуу Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хувь, Хувь хүний орлогын албан татварын хувь, Нэмэгдсэн өртгийн албан татварын хувь буурсан. Энэ нь хөрөнгө оруулалтын орчинг сайжруулж, бизнес эрхлэх таатай орчинг бий болгож, улмаар хуримтлал үүсэх нөхцлийг бий болгож байна. Татварын хуулийн өөрчлөлт нь зөвхөн хувь хэмжээг өөрчлөөд зогсоогүй татварын хуулийн нүх цоорхой, боловсронгуй бус байдлыг ашиглан татвараас зайлсхийх боломжийг олгож байсан зарим нөхцлийг хааж өгсөн. Үүнд: Харилцан хамаарал бүхий аж ахуйн нэгжүүд бараа бүтээгдэхүүнээ зах зээлийн үнээс хэт доогуур эсвэл дээгүүр бие биедээ борлуулж татвар ногдох орлогоо бууруулж байсан явдлыг хааж хуульд үнэ шилжүүлэлтийн (transfer pricing) талаарх заалтыг нэмж тусгаж өгсөнөөр энэ асуудлыг шийдвэрлэх эрх зүйн үндэсийг бий болгосон.

Татварын хуульд орсон зарим өөрчлөлтүүд татвараас зугтах шинэ боломжийг татвар төлөгчид олгож байна. Тухайлбал, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн “Татварын тайлангаар гарсан алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох” тухай 20 дугаар зүйлийн заалтыг ашиглан алдагдлын хэмжээгээ нэмж мэдүүлэн татвар төлөхгүй байх боломжтой. Иймд татварын алба энэ талаар анхаарч ажиллах шаардлагатай.

Далд эдийн засгийг бууруулах арга замууд

2012 онд Татварын байгууллага нь бодлогын хүрээнд татварын тогтолцоог орчин үеийн эдийн засгийн харилцаа, өөрийн орны онцлогт тохируулан улам боловсронгуй болгож, өөрчлөн шинэчлэх, мэдээллийн технологи, мэдлэгт суурилсан дэлхийн жишигт нийцсэн цахим татварын алба болох зорилгод хүрэх тогтолцоог бий болгон хөгжүүлэхээр ажиллаж байна. Татварын ерөнхий газраас татвар төлөгчийн бүртгэлийн системийг сайжруулах, бэлэн мөнгөний урсгалыг хянахтай холбогдуулан хууль эрх зүйн орчныг бий болгох, татварын эрсдлийн удирдлагын тогтолцооны эрх зүйн зохицуулалтыг бий болгон хөгжүүлэх, татвар ногдуулах, тайлагнах үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлэн, хэрэгжүүлэх ажлуудыг эхлүүлээ.

Эрсдэлтэй татвар төлөгчид болон татварт хамрагддаггүй аж ахуйн нэгж, байгууллага, орлого бүхий иргэдийг татварт хамруулах талаар олон улсад ашиглаж буй татварын хяналт шалгалтын арга, хэрэгслүүдийг судалж, нэвтрүүлэх ажлыг эхлүүлсэн.

Монгол Улсын төсвийн орлогыг нэмэгдүүлэх бололцоот эх үүсвэрийг бүрэн дайчлах, далд эдийн засгийн нөлөөллийг багасгах, судлах чиглэлээр 2012 оны эхнээс Татварын ерөнхий газарт далд эдийн засгийг бууруулах үйл ажиллагааг томоохон цогц хэлбэрээр хэрэгжүүлэх тусгай ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

ДЭВШҮҮЛЭХ САНАЛ:

Далд эдийн засгийг багасгах талаар зөвхөн татварын албаас төдийгүй төр, засгийн газрын бүхий л түвшинд онцгой анхаарах шаардлагатай бөгөөд мэдээлэл, суртчилгааны үйл ажиллагааг явуулах, тодорхой арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх. Үүний тулд:

- Хууль хэрэгжүүлэх заавар, журам, дүрмийг боловсронгуй болгох, тоог цөөрүүлэх;
- Иргэд, аж ахуй бизнес эрхлэгчдийг хуулийн хүрээнд бизнес эрхэлж байгаа эсэхэд нийгмийн хяналтыг сайжруулах зэрэг асуудлыг хамруулах нь зүйтэй байна.
- Татварын албаны олон нийтэд үзүүлэх үйлчилгээг татвар төлөгчдийг хууль дүрмээ биелүүлэхэд чиглүүлэн нийт ард иргэдэд татвараа сайн дураараа төлөх, үүрэг хариуцлагаа ухамсарлан биелүүлэх нь сайн иргэн хүний шинж чанар гэж ойлгуулахад чиглэгдсэн үйл ажиллагааг улам эрчимжүүлэх;
- Татварын албаны далд эдийн засаг дахь үйл ажиллагааг илрүүлж, далд эдийн засгийн үйл ажиллагааг таслан зогсооход чиглэсэн гол арга зам бол хүлээх хариуцлагыг чангатгах, өндөр торгууль, төлбөр төлөх механизмыг бүрдүүлэх;
- Далд эдийн засагтай тэмцэх, татвараас зайлсхийх гэсэн оролдлогыг олж илрүүлэх чадвартай чадварлаг ажиллах хүчийг бүрдүүлэх;
- Үндэслэлгүй хөрөнгөжих, илт тансаг хэрэглээг илрүүлэх, хяналт тавих, татвар төлөгчийн төлж байгаа татварын хэмжээ болон тэдний үрэлгэн хэрэглээ, амьдралын боломжтой харьцуулах, татварт бүрэн хамруулах арга хэмжээг эрчимжүүлэх.г.м.

Дүгнэлт:

Дэлхийн банкны судалгаагаар манай улсын далд эдийн засгийн хэмжээ дотоодын нийт бүтээгдэхүүний 30 орчим хувьтай тэнцэж байна гэсэн тооцоо гарчээ. 2012 оны дотоодын нийт бүтээгдэхүүнтэй /13.9 их наяд/үүнийг харьцуулбал, 4,2 их наяд төгрөг болж байна. Манайд бүртгэгдээгүй, албан бус секторын эзлэх хувь ихээхэн жин дарж байгаа гэдэг ч яг тодорхой тоог хэлэх боломжгүй гэсэн. Дээрх 30 хувиас дээш тоо хэлдэг судалгааны байгууллагууд ч бий. Наад зах нь манайд бүртгэлтэй 90 гаруй мянган аж ахуйн нэгжийн 50 орчим хувь нь Х тайлан буюу үйл ажиллагаа явуулаагүй тайлангаргадаг гэсэн тооцоо байгаа. Үйл ажиллагаа явуулаагүй мөртлөө оршин тогтноод байгаа нь эргэлзээтэй.

Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн өөрийгөө тодорхойлж төлдөг одоогийн татварын системд манайх төдийлөн шилжиж чадахгүй байгаагийн шинж байж ч болох. Татвараа төлөх нь иргэний үүрэг хэмээн Үндсэнхуульд тунхагласан ч энэ нь нийгмийн сэтгэлзүйд бүрэлдэн тогтож чадахгүйгээс хуулийн гадуур амьдрагсдын хүрээг тэлсээр байгаа юм. Удахгүй гар дамжсан бэлэн мөнгөний худалдааг бүртгэлжүүлэх эрх зүйн орчныг бий болгох гэнэ. Энгийнээр тайлбарлавал, бид өдөр тутам дэлгүүр, үсчин, такси, ресторан, кинотеатрт мөнгөө үрдэг хэрнээ үйлчилгээ үзүүлж буй аж ахуйн нэгж, хувь хүмүүсээс ямар нэгэн баримт авдаггүй. Тэд татвар төлдөг ч юм уу, бүү мэд. Тэгвэл энэ харилцааг зохицуулах нэгэн хуулийг санаачлаад буй ажээ.

БНСУ дөрвөн жилийн өмнө бэлэн мөнгийг хянах тогтолцоонд шилжсэнээр бэлэн мөнгөнийггүйлгээнийхээ 95 хувийг бүртгэлжүүлж үр дүнд хүргэж чадсан гэнэ. Ийнхүү далд эдийнзасгийг ил гаргах гэсэн зорилго үр дүндээ хүрэх эсэх нь хууль батлагдан гарсны дараа л тодорхой болно.

Resume

Shadow economy andtax

Shadow economy which is the important issue of macro economics. The factors of the economic and society influence in shadow economics. Scholars doing a research how does thetax influence in shadow economics reach in such a result which the tax's percent increase influences in economics.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Док. Проф. Фредрих Шнейдер. Судалгааны материал
2. Док. /рh/Проф.Д.Цэрэнпил. Далд эдийн засаг түүнийг ил болгох арга замын зарим асуудал
3. Док. /рh/.Ч.Энхбаяр. Далд эдийн засгийн татварын зохицуулалтын асуудал
4. Б.Баярхүү. Далд эдийн засаг
5. Нээлттэй Нийгэм Форум <http://www.forum.mn>

БАРУУН БҮСИЙН АЙМГУУДЫН ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ИНДЕКСИЙГ БУСАД БҮСҮҮДТЭЙ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Т.Эрдэнэцэцэг
Магистр, ХИС-ийн НХУС-ийн
НББ-ийн тэнхимийн багш,
shootoo19780621@yahoo.com

Товч утга: НҮБ нь 1990 оноос хүний сайн сайхан амьдралыг дэмжих хүний хөгжлийн олон янзын индекс үзүүлэлтүүдийг боловсруулан улам бүр боловсронгуй болгосоор байна. Эдгээр индекс үзүүлэлтүүдээс хүний хөгжлийн индекс нь хамгийн гол титэм үзүүлэлт юм. Манай улсын хувьд НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөрийн техник санхүүжилтийн дэмжлэгтэйгээр 1997 оноос эхлэн 3 жил тутамд /1997, 2000, 2003, 2007/ үндэснийхээ хүнийг хөгжлийн илтгэлийг бэлтгэн гаргаж байгаа бөгөөд илтгэлийн ач холбогдол улам бүр өссөөр байна. Монгол улс 2003 оны илтгэлдээ 2000 оноос эхлэн хүний хөгжлийн индексийг аймгуудаар задлан тооцжээ.

Түлхүүр үг: Хүний хөгжлийн индекс, хүн амын дундаж наслалтын индекс, хүн амын боловсролын түвшний индекс, нэг хүнд ноогдох ДНБ-ий индекс

Сэдвийн үндэслэл:

НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрөөс 1990 оноос эхлэн жил бүр дэлхийн хүний хөгжлийн илтгэлийг, 1992 оноос улс орнууд үндэснийхээ хүний хөгжлийн илтгэлийг бэлтгэн гаргаж байгаа бөгөөд уг ажил улам бүр өргөжин тэлсээр байна. Дэлхийн олон улсын орнууд үндэсний хүний хөгжлийн илтгэлээ боловсруулан түүгээр дамжуулан засгийн газрууд бодлогын сонголт хийх шинжилгээний хэрэгсэлээ болгон ашиглаж байна.

НҮБ нь 1990 оноос хүний сайн сайхан амьдралыг дэмжих хүний хөгжлийн олон янзын индекс үзүүлэлтүүдийг боловсруулан улам бүр боловсронгуй болгосоор байна. Эдгээр индекс үзүүлэлтүүдээс хүний хөгжлийн индекс нь хамгийн гол титэм үзүүлэлт юм. Манай улсын хувьд НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөрийн техник санхүүжилтийн дэмжлэгтэйгээр 1997 оноос эхлэн 3 жил тутамд /1997, 2000, 2003, 2007/ үндэснийхээ хүнийг хөгжлийн илтгэлийг бэлтгэн гаргаж байгаа бөгөөд илтгэлийн ач холбогдол улам бүр өссөөр байна. Монгол улс 2003 оны илтгэлдээ 2000 оноос эхлэн хүний хөгжлийн индексийг аймгуудаар задлан тооцжээ. Аймгуудаар задлан тооцож байгаа нь бүс нутгийг хөгжүүлэхэд ямар үзүүлэлтүүдийг харгалзан үзэх талаар төр засгийн удирдлагуудад шийдвэр гаргахад шаардлагатай мэдээлэлээр хангахад чухал нөлөөтэй юм. Гэвч хүний хөгжлийн индексийн үзүүлэлт нь хүний хөгжлийг бүрэн илэрхийлж чадах үзүүлэлт биш бөгөөд энэ нь зөвхөн дундаж төдий л үзүүлэлт юм. Энэхүү судалгаа нь хүний хөгжлийн гол титэм үзүүлэлт буюу хүний хөгжлийн индексд хийгдсэн судалгаа бөгөөд гэдгийг цохон тэмдэглэмээр байна.

Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд аль бүс нутаг цаашлаад тухайн орон нутагт хүний хөгжлийг дэмжих үйл ажиллагааг ямар чиглэлээр хийж гүйцэтгэх вэ гэдэгт хүний хөгжлийн индексийн судалгаа зохих хариулт болж чадна гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл удирдлагыг мэдээлэлээр хангах шинжилгээний нэг төрөл болж байна. Хүний хөгжлийн үзүүлэлтийг зөвхөн хүний хөгжлийн индексээр хязгаарладаггүй гэдгийг цохон тэмдэглэмээр байна.

Баруун бүс нутаг нь Монгол орны нутаг дэвсгэрийн 26,6 хувь буюу 415,3 мянган км квадрат газар нутагтай, нийт хүн амын 14,9 хувь буюу 407,9 мянган хүн амтай, улсын мал сүргийн 24,7 хувь буюу 10,8 сая толгой малтай, түлш эрчим хүчний арвин нөөцтэй, МАА газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэхэд таатай үржил шимт өргөн уудам нутаг дэвсгэртэй, байгалийн баялаг арвинтай бүс нутаг юм. Иймд энэ бүс нутгийг хөгжүүлэх асуудал төр засгийн анхаарлын төвд ямагт байх ёстой юм. Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд Баруун бүс нутагт Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд аймгуудыг хамруулж Улиастай, Ховд хотуудыг баруун бүсийн тулгуур төв болгосон төрийн бодлого хэрэгжиж эхлээд 10 гаран жил болж байна. Иймд энэ бүс нутгийн хөгжлийн үзүүлэлтийг тодорхойлогч хүний хөгжлийн индексийг бусад бүс болон Улаанбаатар хоттой харьцуулсан судалгаа хийж дүгнэлт өгөх нь бүс нутгийн хөгжлийн өнөөгийн байдлыг тодорхойлох, бүс нутгийг хөгжүүлэхэд ямар асуудалд анхаарлаа хандуулах шаардлагатай байгааг тодруулах зүй ёсны хэрэгцээ шаардлага байна. Дээрх хэрэгцээ шардлага нь энэхүү сэдвийг судлах гол үндэслэл болж байна.

Онолын хэсэг

Хүн төрөлхтөн хязгааргүй хэрэгцээгээ хангахаар цаг хугацаатай уралдан хөдөлмөрлөхийн хирээр хүний хөгжил, хөгжлийг тодорхойлогч бусад үзүүлэлтүүд өсөн нэмэгдсээр байна.

Хүний хөгжлийн тухай ойлголт нь маш өргөн хүрээтэй ойлголт бөгөөд эцэстээ хүмүүсийн сонголтыг өргөжүүлэхтэй холбоотой бүхий л асуудлыг авч үзэж болдог.

НҮБ нь 1990 оноос хүний сайн сайхан амьдралыг дэмжих хүний хөгжлийн олон янзын индекс үзүүлэлтүүдийг боловсруулан улам бүр боловсронгуй болгосоор байна. Эдгээр индекс үзүүлэлтүүдээс хүний хөгжлийн индекс нь хамгийн гол титэм үзүүлэлт юм.

Хүний хөгжлийн илтгэлийг анх хэвлэн гаргасан тэр цагаас дэлхийн улс орнуудын хүний хөгжлийн түвшинг хүний хөгжлийн индексээр хэмжиж ирсэн.

Хүний хөгжлийн индексийг доорх 3 үзүүлэлтэд тулгуурлан тооцдог.

Нэг. Хүний эрүүл энх, урт удаан амьдралыг дундаж наслалтын үзүүлэлтээр

Хоёр. Хүний боловсрол, мэдлэгийг насанд хүрэгчдийн бичиг үсэг тайлагдалт /2/3/, анхан, дунд, дээд боловсролд хамрагдалтын /1/3/ хувь гэсэн 2 үзүүлэлтээр

Гурав. Амьжиргааны түвшинг нэг хүнд ноогдох ДНБ /ам доллараар/-ээр

тус тус төлөөлүүлэн авч үзэж тооцдог.

Хүний хөгжлийн индекс - ХХИ

ХХИ-ийг тооцохын өмнө дээрх үзүүлэлт бүрд харгалзах индексийн утгыг тооцоолдог. ХХИ бол хүн амын боловсрол, эрүүл мэнд, орлогын индексүүдийн арифметик дундаж юм. Аливаа юмс үзэгдлийг хэмжих хэмжүүр нь тухайн юмс үзэгдлийнхээ бүх талыг бүрэн дүүрэн харуулж чаддаггүйн адилаар хүний хөгжлийн индекс нь хүнийг хөгжлийн түвшинг бүх талаар нь бүрэн дүүрэн илтгэн харуулж чадахгүй.

Хүний хөгжлийн түвшинг илүү өргөн хүрээнд нарийвчлан авч үзэхийн тулд хүний хөгжлийн бусад үзүүлэлтүүдийг ашигладаг. Үүнд жендерийн хөгжлийн индекс, жендерийн эрх мэдлийн хэмжигдэхүүн, ядуурлын индекс, ядуурлын хамралтын хүрээний индекс, улс төрийн, эдийн засгийн, эрх чөлөөний индекс гэх мэт индексүүдийг тооцоолдог.

Дэлхийн хүний хөгжлийн илтгэлүүдийг товчхон байдлаар авч үзвэл хүн төрөлхтөний өмнө тулгарсан бэрхшээлтэй асуудлуудыг тухайн цаг хугацаанд нь тайлбарлан, түүнээс гарах арга замуудыг тодорхойлсон байдаг.

Хүний Хөгжлийн Индексийн үзүүлэлт өндөр байх тусмаа сайн байдаг бөгөөд энэ индексийг өсгөхөд түүнийг тооцож байгаа 3 индексийг өндөр байлгахад анхаарах хэрэгтэй бөгөөд индексийг тооцоолон гаргасанаар улс орон, төр засгийнхаа бодлого чиглэлийг юунд хандуулах вэ гэдгээ шийдэхэд нь чухал мэдээлэл болж өгдөгөөрөө өндөр ач холбогдолтой юм. Сүүлийн жилүүдэд хүний хөгжлийг хүний сэтгэл ханамжийн хэмжээгээр тооцдог болох талаар сонирхолтой судалгааг ч хийсэн байдаг байна.

Сэдвийн судлагдсан байдал

Манай улсын хувьд НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөрийн техник санхүүжилтийн дэмжлэгтэйгээр 1997 оноос эхлэн 3 жил тутамд /1997, 2000, 2003, 2007/ үндэснийхээ хүнийг хөгжлийн илтгэлийг бэлтгэн гаргаж байгаа бөгөөд илтгэлийн ач холбогдол улам бүр өссөөр байна. Монгол улс 2003 оны илтгэлдээ 2000 оноос эхлэн хүний хөгжлийн индексийг аймгуудаар задлан тооцжээ. 2000 оноос эхлэн индексийг 3 жил тутамд бус, жил бүр гаргаж дэлхийн улс орнуудтай харьцуулан хэддүгээр байранд явж байгаагаа тодорхойлох болсон. Монгол улсын статистикийн эмхтгэлд хүний хөгжлийн индексийн тооцоо судалгааг оруулдаг болоод байна.

Хүний хөгжлийн индексийг орон нутгийн онцлогыг тусгасан байдлаар харуулах талаар эрдэмтэд судалгаа шинжилгээ хийсээр байна. Сүүлийн 10 жилийг хооронд нь харьцуулсан судалгаа байхгүй байна. Харин 2000-2006 оны судалгааг хүний хөгжлийн илтгэлд оруулж зохих дүгнэлтийг хийсэн байна.

Сүүлийн жилүүдэд хүний хөгжлийг хүний сэтгэл ханамжийн хэмжээгээр тооцдог болох талаар сонирхолтой судалгааг ч хийсэн байдаг бөгөөд Монгол улсад одоогоор энэ чиглэлийн судалгаа хийгдээгүй байна. Дан ганц эдийн засгийн өсөлт нь хүний сэтгэл ханамжийг төгс нэмэгдүүлнэ гэсэн үг хараахан биш юмаа гэдгийг дээрх судалгаа харуулсан байдаг.

Судалгааны зорилго

Монгол улсын хүний хөгжлийн индексийн сүүлийн 10 жилийн үзүүлэлтэд судалгаа хийж, баруун бүс нутгийн хүний хөгжлийн индексийг бусад бүс болон Улаанбаатар хоттой харьцуулж дүгнэлт өгсөний үндсэн дээр тус бүс нутгийг хөгжүүлэхэд төр засаг, орон нутгийн удирдлагуудад хүний хөгжлийн индексийг ашиглан шийдвэр гаргахад нь шаардлагатай мэдээлэлээр хангах явдал юм.

Судалгааны арга зүй

Судалгаанд хоёрдогч мэдээлэлийн эх үүсвэр ашигласан. Монгол улсын статистикийн эмхтгэл 2003-2012, Статистикийн эмхтгэл дэх хүний хөгжлийн индексийн үзүүлэлтүүдийг нэгтгэн дүгнэх замаар боловсруулалт хийж, дүгнэлт гаргасан

Мөн монголын хүний хөгжлийн илтгэлүүд /1997, 2000, 2003, 2007,2011/

Судалгааны дүн

Судалгааг дараах чиглэлүүдээр хийж, дүгнэлт өглөө. Дүгнэлтийг өгөхдөө хамгийн өндөр болон хамгийн доогуур үзүүлэлтэд тулгуурлан дүгнэлт өгсөн болно. Гол баримтлах зарчим нь доогуур байгаа үзүүлэлтэд илүүтэй анхаарал тавих шаардлага байгааг тодруулж байгаа явдал юм.


Судалгааны хамрах хүрээ 2003-2012 он буюу 10 жил

Нэг. Хүний хөгжлийн индекс /бүсүүдээр, бүрдүүлэгч индексүүдээр, улсын хэмжээнд/

1.1 Хүн амын дундаж наслалтын индекс /бүсээр/

№	Бүсүүд	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	Дундаж	2012 оныг 2003 онтой харьцуулсан байдал
1	Төвийн бүс	0.665	0.673	0.684	0.692	0.702	0.714	0.726	0.727	0.745	0.757	0.708	0.092
2	Улаанбаатар	0.668	0.671	0.682	0.689	0.697	0.708	0.721	0.722	0.741	0.754	0.705	0.086
3	Баруун бүс	0.640	0.651	0.661	0.670	0.680	0.691	0.704	0.705	0.724	0.736	0.686	0.096
4	Хангайн бүс	0.631	0.643	0.657	0.667	0.676	0.688	0.700	0.701	0.713	0.725	0.680	0.094
5	Зүүн бүс	0.622	0.637	0.653	0.663	0.674	0.685	0.698	0.699	0.718	0.730	0.678	0.108
	Улсын дундаж	0.645	0.655	0.667	0.676	0.686	0.697	0.716	0.718	0.722	0.728	0.691	0.083

Хүн амын дундаж наслалтын индекс /бүсээр/




Дүгнэлт: Улсын хэмжээнд төвийн болон Улаанбаатарын бүсийн хүн амын дундаж наслалт улсын дунджаас өндөр байна. Харин бусад бүсүүд улсын дунджаас доогуур байгаа бөгөөд үүнээс зүүн бүсийн аймгуудын дундаж наслалт хамгийн доогуур байна. Гэвч 2012 оныг 2003 онтой харьцуулсан наслалтаас харахад зүүн бүсийн аймгуудын дундаж наслалт бусад бүсээс хамгийн өндөр буюу 10,8 жилээр өссөн байдал харагдаж байгаа нь сайшаалтай юм. Баруун бүс нутаг нь Улаанбаатарын болон төвийн бүсээс дундаж наслалтаар доогуур байгаа хэдий ч 10 жилийн хугацаанд дундаж наслалтын өсөлтөөрөө уг хоёр бүсээс 0,4-1 жилээр илүү байна. Нийт бүсүүдэд 10 жилийн хугацаанд дундаж наслалт 8,6-10,8 жилээр өссөн байдал харагдаж байна.

1.2 Хүн амын боловсролын түвшний индекс /бүсээр/

№	Бүсүүд	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	Дундаж	2012 оныг 2003 онтой харьцуулсан байдал
1	Улаанбаатар	0.926	0.923	0.927	0.930	0.926	0.916	0.922	0.929	0.940	0.947	0.929	0.021
2	Баруун бүс	0.896	0.915	0.924	0.915	0.929	0.936	0.937	0.942	0.947	0.949	0.929	0.053
3	Төвийн бүс	0.912	0.915	0.923	0.921	0.928	0.922	0.920	0.924	0.934	0.942	0.924	0.030
4	Хангайн бүс	0.895	0.901	0.907	0.903	0.915	0.910	0.914	0.918	0.914	0.920	0.910	0.025
5	Зүүн бүс	0.889	0.901	0.912	0.896	0.906	0.903	0.907	0.909	0.914	0.916	0.905	0.027
	Улсын дундаж	0.903	0.911	0.919	0.913	0.921	0.917	0.921	0.928	0.933	0.940	0.921	0.037

Хүн амын боловсролын түвшний индекс /бүсээр/




Дүгнэлт: Улсын хэмжээнд 10 жилийн дунджаар Улаанбаатар болон төвийн мөн баруун бүсийн хүн амын боловсролын түвшний индекс улсын дунджаас өндөр байна. Харин хангайн болон зүүн бүсийн индекс дунджаас доогуур үзүүлэлттэй байна. 2012 оныг 2003 харьцуулахад Баруун бүс нутагт боловсролын индекс хамгийн өндөр өсөлттэй байна. Харин Улаанбаатар хотод энэ өсөлт хамгийн доогуур үзүүлэлттэй байна. 2007 оноос эхлэн Баруун бүсийн боловсролын түвшний индекс тасралтгүй өссөн ба бусад бүсүүдтэй харьцуулахад хамгийн өндөр байна.

1.3 Нэг хүнд ноогдох ДНБ-ий индекс /бүсээр/

№	Бүсүүд	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	Дундаж	2012 оныг 2003 онтой харьцуулсан байдал
5	Улаанбаатар	0.572	0.571	0.595	0.607	0.612	0.632	0.666	0.678	0.709	0.720	0.636	0.148
2	Хангайн бүс	0.401	0.441	0.472	0.505	0.540	0.565	0.617	0.623	0.633	0.656	0.545	0.255
3	Төвийн бүс	0.407	0.426	0.433	0.469	0.479	0.528	0.551	0.553	0.575	0.599	0.502	0.192
4	Зүүн бүс	0.414	0.417	0.439	0.497	0.524	0.511	0.522	0.511	0.535	0.579	0.495	0.165
1	Баруун бүс	0.362	0.382	0.417	0.432	0.458	0.481	0.469	0.445	0.468	0.510	0.442	0.148
6	Улсын дундаж	0.431	0.448	0.471	0.502	0.523	0.543	0.614	0.623	0.649	0.667	0.547	0.236

Нэг хүнд ноогдох ДНБ-ий индекс /бүсээр/




Дүгнэлт: Улсын хэмжээнд Улаанбаатар хотын ДНБ-ий индекс хамгийн өндөр байгаа бөгөөд энэ нь хүн амын болон аж үйлдвэрийн төвлөрөлтэй шууд холбоотой юм. Харин бусад бүсүүд улсын дунджаас доогуур байгаа бөгөөд хамгийн доогуур үзүүлэлттэй бүс нь баруун бүс нутаг юм. Иймд баруун бүс нутагт ДНБ ийг нэмэгдүүлэх талаар анхаарах хэрэгтэй байна. 2009 онд баруун бүсийн ДНБ өмнөх жилүүдээс буурсан байгаа нь тус бүс нутгийг хамарсан байгалийн хүндрэл бэрхшээлтэй холбоотой юм. Учир нь бүс нутгийн ДНБ-ий ихэнх хувийг ХАА- н салбар эзэлдэгтэй холбоотой юм. 2012 оныг 2003 онтой харьцуулахад нэг хүнд ноогдох ДНБ-ийн индексийн өсөлтөөр баруун бүс нутаг нь Улаанбаатартай адилхан байгаа хэдий ч бусад бүстэй харьцуулахад хамгийн доогуур байна. Улаанбаатарын бүсэд өсөлт бага байгаа нь хүн амын шилжих хөдөлгөөнтэй зохих хэмжээгээр холбоотой юм.

1.4 Хүний хөгжлийн индекс /бүсээр/

№	Бүсүүд	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	Дундаж	2012 оныг 2003 оной харьцуулсан байдал
1	Улаанбаатар	0.722	0.722	0.735	0.742	0.745	0.752	0.770	0.776	0.797	0.807	7.567	0.085
2	Хангайн бүс	0.642	0.662	0.679	0.692	0.710	0.721	0.744	0.747	0.753	0.767	7.116	0.125
3	Төвийн бүс	0.661	0.672	0.680	0.694	0.703	0.721	0.732	0.735	0.751	0.766	7.115	0.105
4	Зүүн бүс	0.642	0.652	0.668	0.685	0.702	0.700	0.709	0.706	0.722	0.742	6.927	0.100
5	Баруун бүс	0.632	0.649	0.667	0.672	0.689	0.703	0.702	0.689	0.703	0.702	6.808	0.069
	Улсын дундаж	0.660	0.671	0.686	0.697	0.710	0.719	0.750	0.756	0.768	0.778	7.195	0.118

Хүний хөгжлийн индекс /бүсээр/



Дүгнэлт: Улсын хэмжээнд Улаанбаатар хотын хүний хөгжлийн индекс улсын дунджаас өндөр, харин баруун бүс нутаг хамгийн доогуур үзүүлэлттэй байна. Зүүн бүс нутаг нь боловсрол болон дундаж наслалтын үзүүлэлтээрээ хамгийн доогуур байгаа боловч ДНБ-ий өсөлтөөрөө өндөр байгаа нь тус бүс нутагт уул уурхайн ордыг ашиглах болсонтой холбоотой юм.

Дүгнэлт

Баруун бүс нутаг нь боловсролын индексээрээ бусад бүсүүдээсээ хамгийн өндөр, мөн 2007 оноос эхлэн энэ индекс тасралтгүй өсөж байгаа нь сайн хэрэг юм. Харин дундаж наслалтын хувьд улсын дунджаас доогуур байгаа явдал нь энэ бүс нутагт хүн амын эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг харуулж байна. Нэг хүнд ноогдох ДНБ-ий индексээрээ бусад бүсүүдээсээ хамгийн бага байгаа нь тус бүс нутгийн ДНБ-ий 70 орчим хувийг ХАА-н салбар эзэлдэгтэй холбоотой бөгөөд бүс нутагт тохиолдсон байгалийн ган зуд зэрэг аюул нь ДНБ-ийн хэмжээнд чухал нөлөө үзүүлдэгтэй холбоотой юм. Эрчим хүчний хангалтгүй байдлаас үүдэн тус бүс нутагт үйлдвэрлэл үйлчилгээний салбар харьцангуй доогуур хөгжилтэй байсан бөгөөд одоо тус бүс нутагт энэ салбар эрчимтэй хөгжиж байна. Хүний хөгжлийн индексээрээ баруун бүс нутаг нь Монгол улсын хэмжээнд хамгийн доогуур үзүүлэлттэй байгаа бөгөөд үүнд дундаж наслалтын болон нэг хүнд ноогдох ДНБ-ий индекс гол нөлөө үзүүлсэн байна. Иймд энэ бүс нутгийн хүний хөгжлийн индексийг өндөр байлгахын тулд тус бүс нутагт ДНБ-ийг нэмэгдүүлэх талаар арга хэмжээ авах, иргэдийн эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах шаардлагатай байна.

Резюме

Западный регион занимает самую низкую позицию в стране по индексу человеческого развития и индекс ВВП для средней возрастности населения и на душу населения оказывают занимательное влияние на это. Поэтому надо улучшить качество здоровительных услуг для населения и предпринимать разные мероприятия для повышения индекса человеческого развития в данном регионе.

НОМ ЗҮЙ

1. Монгол улсын статистикийн эмхтгэл /2003-2012/
2. Монголын хүний хөгжлийн илтгэл /1997, 2000, 2003, 2007, 2011/

СОДЕРЖЕНИЕ

ПРОБЛЕМЫ АРХЕОЛОГИИ И ЭТНОГРАФИИ.....	3
АРХЕОЛОГИ, УГСААТНЫ ЗҮЙ.....	3
КАМЕННЫЕ СОСУДЫ ЭПОХИ РАННЕЙ БРОНЗЫ ЦЕНТРАЛЬНОЙ АЗИИ.....	3
К ВОПРОСУ О СОЦИАЛЬНЫХ ФАКТОРАХ, ПОВЛИЯЮЩИХ НА ПЕРЕКОЧЕВКУ СКОВОДОВ	7
ОТРАЖЕНИЕ В ФОЛЬКЛОРЕ ОБРЯДОВ О КОЧЕВКЕ И ПАСТБИЩЕПОЛЬЗОВАНИИ МОНГОЛОВ.....	12
“ЦАГААН ХУДАГ”-ИЙН ТҮРГИЙН ТАХИЛГЫН БАЙГУУЛАМЖ	15
НЭГЭН ХҮРЭЛ ЭЭМЭГНИЙ ТУХАЙ.....	21
«ВЕЛИКОЛЕПНЫЕ» КАТАФРАКТАРИИ ХАР-ХАД.....	27
ДӨРВӨДИЙН УЛАМЖЛАЛТ ШАГАЙН ТОГЛООМ	36
ИЗУЧЕНИЕ АРХЕОЛОГИЧЕСКИХ ПАМЯТНИКОВ ГОРНОГО АЛТАЯ СОТРУДНИКАМИ СИБИРСКОГО ОТДЕЛЕНИЯ АКАДЕМИИ НАУК СССР В 1960- Е ГГ.....	40
БАРУУН МОНГОЛЧУУДЫН ТҮҮВЭРЛЭХ АЖ АХУЙН УЛАМЖЛАЛ	42
БУХ НООЛДААН	44
ИСТОРИЯ НАРОДОВ РЕГИОНА.....	51
БҮС НУТГИЙН АРД ТҮМНИЙ ТҮҮХ.....	51
ЦЕННОСТЬ РОССИЙСКИХ ПОДРОСТКОВ В РОССИЙСКО-МОНГОЛЬСКОМ ПРИГРАНИЧЬЕ В СОВРЕМЕННЫХ УСЛОВИЯХ	51
ЗАХЧИН ХОШУУНЫ НУТАГТ БАЙГАА БУРХНЫ ШАШНЫ СҮМ ХИЙДҮҮДИЙН ТУУРИУД	57
ДОЛООН ХОШУУ УРИАНХАЙН БАРУУН АМБАНЫ ДАРХАН БЭЙСИЙН ХОШУУНЫ НОЁН, ДА ЛАМСАМБУУ ОВОГТОЙ ЧҮЛТЭМИЙН НАМТАР ТҮҮХЭЭС.....	68
ЖА ЛАМ ДАМБИЙЖАНЦАН–ҮНДЭСНИЙ ФРОНТЫН УДИРДАГЧ	74
БУЛГАН ГОЛЫН ХОШУУДЫН УГСАА ГАРАЛ, ТҮҮХИЙН ЗАРИМ АСУУДАЛ..	89
БАЯДЫН ДУНДАД ӨМНӨД ХОШУУНЫ НОЁДЫН УГ ЭХ	95
XX ЗУУНЫ ЭХЭН ҮЕИЙН МОНГОЛ-АМЕРИКИЙН ХАРИЛЦААНЫ ТҮҮХЭНД ХОЛБОГДОХ НЭГЭН БАРИМТ БИЧИГ	99
МОНГОЛЫН БАРУУН ХЯЗГААРЫН ЯЗГУУР УРЛАГИЙН ӨВИЙН ТӨВ НЬ ХОВДЫН ХӨГЖИМТ ДРАМЫН ТЕАТР МӨН	102
К ВОПРОСУ О СЛУЖИТЕЛЯХ КУЛЬТА У РАННЕСРЕДНЕВЕКОВЫХ ТЮРОК ЦЕНТРАЛЬНОЙ АЗИИ (ПО ПИСЬМЕННЫМ И АРХЕОЛОГИЧЕСКИМ ИСТОЧНИКАМ)	105
ЭТНИЧЕСКАЯ ИДЕНТИЧНОСТЬ И МЕЖНАЦИОНАЛЬНЫЕ ОТНОШЕНИЯ У НАРОДОВ СЕВЕРО-ЗАПАДНОЙ МОНГОЛИИ[1.]	108

ВОПРОСЫ ЭТНОГЕНЕЗА СРЕДНЕВЕКОВОГО МОНГОЛЬСКОГО НАРОДА	115
ПОДГОТОВКА КАДРОВ ДЛЯ МОНГОЛИИ И ТУВЫ НА КУРСАХ ХОШУННЫХ РАБОТНИКОВ В КОММУНИСТИЧЕСКОМ УНИВЕРСИТЕТЕ ТРУДЯЩИХСЯ ВОСТОКА	117
THE PREPAREDNESS FOR NATURAL DISASTERS: “DZUD” MONGOLIA	120
ГЛОБАЛИЗАЦИЯ И ЕЕ ПОСЛЕДСТВИЯ	123
ЭТНОКУЛЬТУРНЫЕ ОБЩНОСТИ ГОРНОГО АЛТАЯ И СОПРЕДЕЛЬНЫХ ТЕРРИТОРИЙ В XVII-XVIII ВВ.	128
РАБОТА ГОРОДСКОГО ОТДЕЛА ЗДРАВООХРАНЕНИЯ Г. БИЙСКА АЛТАЙСКОГО КРАЯ В ГОДЫ ВЕЛИКОЙ ОТЕЧЕСТВЕННОЙ ВОЙНЫ.	132
ПРОБЛЕМЫ ОБРАЗОВАНИЯ И ДИДАКТИКИ.....	138
БОЛОВСРОЛ СУДЛАЛ, ДИДАКТИКИЙН АСУУДАЛ.	138
ЭЭЛЖИТ ХИЧЭЭЛИЙГ ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР ЯВУУЛАХ НЬ.....	138
О РОЛИ ТУВИНСКИХ НАРОДНЫХ ИГР В ДУХОВНО-ПРАВСТВЕННОМ ВОСПИТАНИИ ДЕТЕЙ ДОШКОЛЬНОГО ВОЗРАСТА	141
НЭГДҮГЭЭР КУРСЫН ОЮУТНЫ ШАЛГАЛТЫН ӨМНӨХ БОЛОН ДАРААХ ҮЕИЙН ТҮГШҮҮРИЙН ТҮВШИНГ СУДАЛСАН ДҮНГЭЭС	143
ХАРИЛЦААНЫ НИЙЦЭН ЗОХИЦОХ БАЙДАЛД ЗОНХИЛОХ ХҮРТЭХҮЙН ИЛРЭХ НӨЛӨӨЛЛИЙГ ТОДОРХОЙЛОХ	147
PRONUNCIATION PROBLEMS OF ENGLISH LEARNERS IN ETHNIC GROUPS OF MONGOLIA	149
ХҮҮХДИЙН ХАЛАМЖИЙН ХУВИЛБАРТ ҮЙЛЧИЛГЭЭ.....	150
ТИПЫ ТЕСТОВ ДЛЯ ПРОВЕРКИ ЗНАНИЯ АНГЛИЙСКОГО ЯЗЫКА.....	152
РАЗВИТИЕ РЕЧИ УЧАЩИХСЯ НА СОВРЕМЕННОМ ЭТАПЕ ОБУЧЕНИЯ РУССКОМУ ЯЗЫКУ	155
INTRODUCING ENGLISH TO YOUNG LEARNERS.....	158
THE CURRENT SITUATION OF TEACHING OFFICIAL LANGUAGE TO KAZAKH ETHNIC MINORITIES IN MONGOLIA	160
ЯЗЫК И КУЛЬТУРА НАРОДОВ РЕГИОНА.....	167
БҮС НУТГИЙН АРД ТҮМНИЙ ХЭЛ, СОЁЛ.....	167
МОНГОЛ ХЭЛНИЙ АВГАЙЛГА НЭРИЙН ҮҮСЭЛ ГАРВАЛ	167
МОНГОЛ ХЭЛНИЙ НЭГЭН БҮТЭЭВРИЙН ТУХАЙ	172
PARTICLES IN MONGOLIAN AND ENGLISH	176
ORDER OF NOUN MODIFIERS IN ENGLISH.....	183
CROSS-TRANSLATION PECULIARITIES OF ADJECTIVE INTENSIFIERS AND DOWN-TONERS IN ENGLISH, MONGOLIAN AND KAZAKH LANGUAGES.....	185
ПОЖЕЛАНИЕ В РЕАЛЬНОМ ОБЩЕНИИ	187

МОНГОЛ ХЭЛЭН ДЭХ ҮГИЙН ТОВЧЛОЛ.....	188
ЗАИМСТВОВАНИЯ В РУССКОМ ЯЗЫКЕ, КРАТКИЙ ИСТОРИЧЕСКИЙ ЭКСКУРС	191
ОБРАЗ АЛТАЯ В РУССКОМ И МОНГОЛЬСКОМ ПЕЙЗАЖЕ XX ВЕКА: СРАВНИТЕЛЬНЫЙ АНАЛИЗ РАБОТ	196
СООТНОШЕНИЕ ЗАГОЛОВКА И СОДЕРЖАНИЯ ТЕКСТА	199
О НЕКОТОРЫХ КУЛЬТУРНЫХ ТЕРМИНАХ, СВЯЗАННЫХ С ТРАДИЦИОННЫМ ХОЗЯЙСТВОМ, В АЛТАЙСКИХ ЯЗЫКАХ	204
ТОХИОЛДМОЛ ҮГ, ТҮҮНИЙ ОНЦЛОГ	206
О ПРОЯВЛЕНИИ ИКОНИЗМА В ЗВУКОПОДРАЖАНИЯХ РАЗНОСИСТЕМНЫХ ЯЗЫКОВ	214
СҮЛД,ЛОГО, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЭМДЭГИЙН ЯЛГАА.....	216
ЭСГИЙ ШИРМЭЛИЙН БҮТЭЭЛ ДЭХ УРАН САЙХНЫ СЭТГЭЛГЭЭ	218
МОНГОЛ БИЧИГ БОЛОН ТОД ҮСЭГТ ЗАРИМ ДАГАВРЫГ ТЭМДЭГЛЭСЭН НЬ	224
СУЩЕСТВИТЕЛЬНЫЕ, УКАЗЫВАЮЩИЕ НА КОЛИЧЕСТВО ПРЕДМЕТОВ В МОНГОЛЬСКОМ И ЯПОНСКОМ ЯЗЫКАХ.....	226
К ТАЙНАМ СЛОВА. «ЛЮБОВЬ» В ЭНЦИКЛОПЕДИИ НАЦИОНАЛЬНО- СПЕЦИФИЧЕСКИХ РЕАЛИЙ РОССИИ И МОНГОЛИИ.....	229
МОРИНХУР И БАЛАЛАЙКА КАК НАЦИОНАЛЬНЫЕ РЕАЛИИ МОНГОЛИИ И РОССИИ.....	231
АЛТАЙСКИЙ ГОСУДАРСТВЕННЫЙ УНИВЕРСИТЕТ, г.Барнаул ИЛЬИН ДЕНЬ В ЯЗЫКОВОЙ КАРТИНЕ МИРА РУССКОГО НАРОДА	233
Б. БАЯРСАЙХАН “ЭРТНИЙ ЯВДАЛ” ӨГҮҮЛЛЭГИЙН ТУХАЙД	235
МОНГОЛ, АНГЛИ ХЭЛНИЙ ЭЭРҮҮЛЛИЙН ОНЦЛОГ	237
УРБОНИМЫ В СОЗНАНИИ РЕГИОНАЛЬНОЙ ЯЗЫКОВОЙ ЛИЧНОСТИ (НА МАТЕРИАЛЕ УРБОНИМА ЛЕНИНСКИЙ ПРОСПЕКТ)	239
К ТАЙНАМ СЛОВА. «ЛЮБОВЬ» В ЭНЦИКЛОПЕДИИ НАЦИОНАЛЬНО- СПЕЦИФИЧЕСКИХ РЕАЛИЙ РОССИИ И МОНГОЛИИ.....	242
АЛТАЙСКИЙ ГОСУДАРСТВЕННЫЙ УНИВЕРСИТЕТ, г.Барнаул МОТИВ УКРОЩЕНИЯ ДИКОГО КОНЯ В МОНГОЛЬСКОМ ТЕКСТЕ РУССКОЙ КУЛЬТУРЫ	244
ОБРАЗ МОНГОЛИИ В РОССИЙСКИХ И ЗАПАДНЫХ СМИ: ЛИНГВО- КОНЦЕПТУАЛЬНЫЙ АНАЛИЗ	247
МОНГОЛ, АНГЛИ ХЭЛНИЙ ЗЭРЭГЦҮҮЛЭХ ХОЛБООГООР ХОЛБОГДСОН ХОЛБОО ҮГ	252

ОЙРАТСКИЕ (КАЛМЫЦКИЕ) ФОЛЬКЛОРНЫЕ И ИСТОРИЧЕСКИЕ МАТЕРИАЛЫ, КАК СРЕДСТВО ВОСПИТАНИЯ МОЛОДЕЖИ НА НАРОДНЫХ ИДЕАЛАХ	256
БОГАТСТВО В КИТАЙСКОЙ И КАЛМЫЦКОЙ ЛИНГВОКУЛЬТУРАХ	257
АЛТАЙН УРИАНХАЙН БААТАРЛАГИЙН ТУУЛЬ ДАХЬ ЗҮЙРЛЭСЭН УР МАЯГ	261
ОРОС, МОНГОЛ ХЭЛНИЙ ЭХИЙН ӨГҮҮЛБЭРҮҮДИЙГ ХОЛБОХ ХЭРЭГСЛҮҮД	265
БУДДИЙСКАЯ КУЛЬТУРА – СВЯЗУЮЩАЯ НИТЬ МЕЖДУ КАЛМЫЦКИМ И МОНГОЛЬСКИМ НАРОДАМИ В СИСТЕМЕ ЕВРАЗИЙСКОЙ ЦИВИЛИЗАЦИИ .	268
МОНГОЛ ЯВГАН ҮЛГЭРИЙН СУДАЛГАА БУЮУ ХЭВШМЭЛ ҮГ ХЭЛЛЭГ	272
ETYMOLOGY OF FOREIGN WORDS AND TRANSFERRING WAYS INTO MONGOLIAN	277
О ХАРАКТЕРЕ МОНГОЛЬСКО-КАЗАХСКИХ ЛЕКСИЧЕСКИХ ПАРАЛЛЕЛЕЙ..	279
ПРИЧИНЫ И УСЛОВИЯ ЗАИМСТВОВАНИЯ АНГЛИЦИЗМОВ В СОВРЕМЕННОМ РУССКОМ ЯЗЫКЕ	281
КОБДОСКИЕ ТУВИНЦЫ МОНГОЛИИ. ЯЗЫК И ДУХОВНАЯ КУЛЬТУРА (МАТЕРИАЛЫ ПОЛЕВЫХ ИССЛЕДОВАНИЙ)	282
ШИНЖААНЫ ХАСАГ УЙГУР ХЭЛЭНД ОРОС ХЭЛНЭЭС ЗЭЭЛДЭГДЭЖ ОРСОН ҮГС	283
ЭВОЛЮЦИОННЫЕ ПРОЦЕССЫ В ЯЗЫКЕ КАК ОТРАЖЕНИЕ ЕГО ПРИНАДЛЕЖНОСТИ К СИНЕРГЕТИЧЕСКИМ ОБЪЕКТАМ	292
СЛУЖЕБНЫЕ СЛОВА ЯЗЫКЕ ДЕРБЕТОВ КАЛМЫКИИ И МОНГОЛИИ*	296
ХҮНИЙ НЭРИЙН ЭХНИЙ АВИАНЫ УТГЫН АСУУДАЛ.....	297
УСИЛИТЕЛЬНЫЕ ЧАСТИЦЫ В АЛТАЙСКОМ ЯЗЫКЕ.....	300
ПЕРЕВОД ТЕРМИНОВ.....	303
SOME PECULIARITIES OF ENGLISH GERUND USE	307
СЛОВООБРАЗОВАТЕЛЬНЫЕ ЕДИНИЦЫ И ИХ ЛЕКСИЧЕСКАЯ РЕАЛИЗАЦИЯ: ПРОБЛЕМА СООТНОШЕНИЯ ПОТЕНЦИАЛЬНЫХ И РЕАЛЬНЫХ СЛОВ В РАМКАХ СЛОВООБРАЗОВАТЕЛЬНОЙ ПАРАДИГМЫ.....	309
СИСТЕМНЫЕ СВОЙСТВА КИНЕМАТИЧЕСКИХ РЕЧЕНИЙ РУССКОГО ЯЗЫКА	314
КИНЕСИЧЕСКИЕ СРЕДСТВА КОММУНИКАЦИИ И МЕЖКУЛЬТУРНАЯ КОММУНИКАЦИЯ.....	320
ФРАЗЕОЛОГИЗМЫ РАЗГОВОРНОГО СТИЛЯ КИТАЙСКОГО ЯЗЫКА	323
СОЦИАЛЬНО-ЭКОНОМИЧЕСКОЕ РАЗВИТИЕ РЕГИОНА	325
БҮС НУТГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ	325
БАРУУН БҮСИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ СУДАЛГАА	325

ЗАВХАН АЙМГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ БА НӨӨЦИЙН СУДАЛГАА	331
СОНГОГЧДЫН ЗАН ҮЙЛД НӨЛӨӨЛӨХ УЛАМЖЛАЛТ ХУЧИН ЗҮЙЛС БА УЛС ТӨРИЙН МАНИПУЛЯЦИ.....	340
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХАМРАГДАЛТ	344
НИЙГМИЙН ОРОЛЦОО НЬ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨГЖИЛД НӨЛӨӨЛӨХ НЬ ..	348
ХҮМҮҮН КАПИТАЛ БА БҮС НУТГИЙН ХӨГЖИЛ	352
К ВОПРОСУ О РОЛИ АГРОПРОМЫШЛЕННОГО КЛАСТЕРА В РЕГИОНАЛЬНОЙ ЭКОНОМИКЕ: ПРОБЛЕМЫ И ПЕРСПЕКТИВЫ РАЗВИТИЯ	355
РЕГИОНАЛЬНЫЕ ОСОБЕННОСТИ ВЗАИМОДЕЙСТВИЯ ГОСУДАРСТВА И БИЗНЕСА В РЕАЛИЗАЦИИ СОЦИАЛЬНОЙ ОТВЕТСТВЕННОСТИ.....	358
ЭКОЛОГИЧЕСКАЯ МИГРАЦИЯ И ЭКОНОМИЧЕСКОЕ РАЗВИТИЕ АВТОНОМНОГО РАЙОНА ВНУТРЕННЯЯ МОНГОЛИЯ НА СОВРЕМЕННОМ ЭТАПЕ.....	362
БҮС НУТГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХЭД БАНКНЫ ГҮЙЦЭТГЭХ ҮҮРГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ.....	365
БҮС НУТГИЙН ХӨГЖИЛД ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ	373
BRIEF SUMMARY OF DISSERTATION ON THE ‘SOCIAL PHILOSOPHICAL ANALYZE OF CONTEMPORARY STATE OF BELIEF OF THE WEST REGION PEOPLE OF MONGOLIA	381
ХОВД АЙМГИЙН ХҮН АМЫН ҮНДЭС УГСАА, ШАШИН ШҮТЛЭГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ	382
УВС АЙМГИЙН ХҮН АМЫН ШАШИН, СҮСЭГ БА БИШРЭЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ.....	384
ДАЛД ЭДИЙН ЗАСАГ БА ТАТВАР	389
БАРУУН БҮСИЙН АЙМГУУДЫН ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ИНДЕКСИЙГ БУСАД БҮСҮҮДТЭЙ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА.....	392